KJ1TAEYC-CAA5IT

НАМАЗИЙН
НОМ

ХАСАН 5IBAIII

«HAKIKAT KITABEVI»
Dari.i;;;;efeka Cad. No: 53 P. K.: 35 34083
Tel: (+90 212) 523 45 56 - 532 58 43 Fax: (+90 212) 523 36 93
Fatih /Istanbul/ TURKIYE E-Mail: info@hakikatkitabevi.com

YAAAH6AATAP 2009
OH

АГУУЛГА

Агуулга....2
Намааз агуу их захирамж мөн....7

Нэгдүгээр бүлэг

Имаан ба намааз....12
Хүн бүр юуны өмнө итгэн сүсэглэлтэй байх хэрэгтэй....12
Имаан үнэн байх хэрэгтэй....13
Эхл-и Сүннэт итгэл бишрэл....15
Эхл-и сүннетэд итгэн бишрэхүйн шинж тэмдэг....16
Имааны зургаан болзол....18
1. Аллаахд итгэх....18
Сыфат-и – Затий....19
Сыфат-и-Сүбүтиййе....19
2. Сахиусан Тэнгэр нарт итгэх....20
3. Ном сударт итгэх....21
4. Пейгамбаар Элч нарт итгэх....22
Манай Пейгамбаар МҮХАММЕД Алейхисселам....24
Асхаб-и Кирам....26
Дөрвөн мезхебийн имам ба бусад мэргэд....27
5. Хойд ертөнцөд итгэх....29
6. Хувь заяанд итгэх....30

Хоёрдугаар бүлэг

Ибадет мөргөл ба намааз залбирал....32
Ибадет мөргөл гэж юу вэ?....32
Мүкеллеф гэж хэн бэ?....33
Эфал-и-Мүкеллефин /Ахкам-и-Исламийе/....33
1. Фарз....34
2. Уажиб....34
3. Сүннет....34
4. Мустахаб....35
5. Мубах....35
6. Харам....35
7. Мекрүх....36
8. Муфсид....36
Исламын дайснууд....37

Исламын болзолууд 37
1. Келиме-и Шехадет авчрах 37
2. Намааз үйлдэх 38
3. Зекят өгөх 38
4. Мацаг барих 39
5. Хаж явах 39

Гуравдугаар бүлэг

Намааз үйлдэх 40
Намаз Хэнд фарз вэ?Хүүхдийн хүмүүжил 41
Намааз үйлдэгчийн төлөв байдал 42
Үлгэр: Шоронгоос чөлөөлсөн намаз 42
Үлгэр: Гэр нь шатсан байв 44
Үлгэр : Саван дахь Ус 44
Үлгэр : Хөлөнд орсон сум 44
Үлгэр: Ухаан алдуулах эм 45
Үлгэр : намаазын төлөө золиослох 46

Дөрөвдүгээр бүлэг

Намаазын төрөл Нафиле намаз 47
Таван удаагийн намааз 47
Намаазын фарз 49
Намаазын гаднах фарзууд 49
Намаазын доторх фарзууд 50
Намаазын болзол 51
1. Абдест буснисныг цэвэрлэх 51
Абдест авах 51
Абдестийн фарз 52
Авдест хэрхэн авах вэ? Абдестийн дуга уншлага 52
Абдестийн сүннет 55
Абдестийн адеб 56
Абдест авах үед хориглох зүйлс 57
Мисвак ба шүд цэвэрлэгч хэрэглэх 58
Абдест авахад анхаарах зүйлс 59
Абдестийг бусниах зүйлс 60
Абдестийг үл бусниах зүйлс 61
Абдестийн хөнгөлөлт /Мест ба Шархны боолт дээр мэсх/ 62
Гүсл /Биеийн абдест/ 63
Гүслын фарз, гүслын сүннет 64

Гүсл абдест хэрхэн авах вэ? 65
Тайлбар /Шүдний ломбо хаалттай шүдтэй хүмүүсийн тухайд/ 65
Эмэгтэйчүүдийн Хайз нифас байдал өөр мезхэбийг даган мөрдөх 67
Тееммүм 68
Тееммүмийн фарз 69
Тееммүмийн сүннет 69
Тееммүмд анхаарах зүйлс 69
Тееммүмийг хэрхэн үйлдэх вэ? 71
Тееммүмийг бусниах зүйлс 72
Абдест гүсл тееммүмийн ач тус 72
2. Хир буртгийг цэвэрлэх 73
Хүнд бохир буртаг 74
Хөнгөн бохир буртаг 74
Истинжа буюу цэвэрлэгээ 75
Истибра 76
3. Сетр-и аврет/Ичимхий газар ба эмэгтэйчүүдийн хучих нөмрөх ёсон/ 76
4. Истикбал-и Кыбле /Кыбле рүү чиглэх/ 79
5. Намаазын цаг хугацаа 80
Өглөөний намаазын цаг 80
Үдийн намаазын цаг 80
Оройн намаазын цаг 80
Үдшийн намаазын цаг 81
Шөнийн ба витр намаазын цаг 81
Тайлбар/ Туйл ба намааз, мацаг/ 81
Азаан ба камет 82
Тайлбар /Азааныг өсгөгчөөр уншиж болох уу?/ 84
Азаан унших 85
Азааны Дуга уншлага 85
Азаан хэмээх үгийн утга 86
6. Нийет 86
7. Тахриме Текбир 87
Намаазын Рүкн/Доторхи фарз/ 87
1. Киам 87
2. Кырат 88
3. Рүкү 88
4. Сажде 89
5. Каде-и Ахире 89
Намааз хэрхэн үйлдэх вэ? 90
Намаазын важиб 92
Сехү сажде / Эндүүрэн мартах/ 93

Намааз мустехабууд 96
Намаазын мекрүх 97
Намаазын гаднах мекрүх болох зүйлс 98
Намаазыг бусниах зүйлс 99
Намааз бусниахд мубах болгох зүйлс 99
Намааз бусниахад фарз болох зүйлс 100
Хүй бүлэг ба намаз 100
Имаамын ёсны шарт 101
Имаамд зохихын шарт 103
Месбукын намааз 104
Ифтитах Текбирийн Фазилет 105
Үлгэр: Ордонд хийгдсэн месжид 106
Жума намааз 107
Жума намаазын фарз 108
1. Эда болзол 109
2. Вүжүб болзол 109
Жума намаазыг хэрхэн үйлдэх вэ? 110
Жума өдрийн Сүннет ба Эдебүүд 110
Баярын намаазууд 111
Баярын намаазыг хэрхэн үйлдэх вэ? 112
Тешрик Текбир 112
Үхэлд бэлтгэхүй 112
Үхэл гэж юу вэ? 113
Үхэл бол үнэн мөн 114
Оршуулгын намааз 115
Оршуулгын намаазын фарз 115
Оршуулгын намаазын сүннет 115
Оршуулгын намаазыг хэрхэн үйлдэх вэ? 116
Тарауих намааз 116

Тавдугаар бүлэг

Аян замын намааз 118
Өвчтэй үеийн намааз Каза намаазууд 121
Тайлбар /Сүннетүүдийн оронд каза үйлдэх үү?/ 126
Каза намаазыг хэрхэн үйлдэх вэ? 127

Зургадугаар бүлэг

Намааз үл үйлдэгчид 129
Намааз үйлдэгчдийн ач буян 131

Намаазын үнэн чанар 139
Намаазын давуу тал 141
Намаазын Эсрар буюу нууцлаг 148
Намаазын дараах Дуга 153
Намаазын цэцэн мэргэн /Намаз ба бидний эрүүл мэнд/ 155

Долдугаар бүлэг

Намааз искат /Меййитийн тулд искат ба девр/ 157
Искат ба девр хэрхэн хийгдэх вэ? 160

Наймдугаар бүлэг

Гучин хоёр ба тавин дөрвөн фарз 165
Гучин хоёр фарз 166
Тавин дөрвөн фарз 167
Күффрийн тухай 169
Томоохон нүгэл 185

Есдүгээр бүлэг

Суре ба дуаг латин үсгээр уншиж болох уу? 192
Дуаны агуулга 194

НАМАЗ БОЛ АГУУ ИХ ЗАХИРАМЖ МӨН

Адаам алейхисселамаас авахуулаад шашин болгонд өдрийн нэг удаагийн намааз буюу мөргөлтэй байв. Эдгээр шашны бүх мөргөлийг нэг дор цуглуулан хурааж Мухаммед алейхисселамд итгэгчдэд фарз болгов. Намааз мөргөл үйлдэх нь имааны болзол биш харин намаазыг фарз хэмээн итгэх нь имааны болзол юм.

Намааз нь шашны тулгуур, багана юм. Намаазыг байнга зөв бүрэн гүйцэтгэдэг хэн боловч шашнаа бий болгож Ислаамын ордноо бүтээж босгосон гэж үнэлэгдэх атал намааз мөргөл хийдэггүй хүн шашин суртал ба Ислаамын ордноо нураасанд тооцогдно. Бидний Пейгамбаар (салл Аллахү алейхи уе селлем): “Манай шашны үндэс бол намааз мөргөл юм” хэмээжээ. Толгойгүй хүн байхгүйтэй адил намаазгүй шашин гэж үгүй.

Намааз нь Ислаамын шашинд имааны дараа орох хамгийн эхний фарз болгох захирамж юм. Аллаах боол нараа зөвхөн өөрт нь ибадет залбирал үйлдэхийн тулд намаазыг фарз болгосон. Кураан-и керимд зуу давсан айет-и керимед “Намааз үйлдэгтүн !” хэмээн зарлиг болгож байна. Хадис-и шерифт “Аллаах өдөр бүр таван удаа намааз үйлдэхийг фарз болгов. Үнэлэмж өгч нөхцөлд зохицон өдөр бүр таван удаа намаз үйлдсэнийг Диваажинд илгээнэ гэж Аллах амласан” хэмээн айлдсан байна.

Намааз манай шашинд хийж үйлд хэмээн зарлиг болгоосон ибадет залбирлын хамгийн үнэ хүндтэй нь билээ. Нэгэн Хадис-и шерифт “Намааз үйлддэггүй хүн Ислаамтай хамаагүй” хэмээн айлдсан байна. Өөрөөр хэлбэл, “Мүмин намааз мөргөл гүйцэтгэх бол кафир тэрслүү намааз эс үйлднэ”. Мунафик нар заримдаа мөргөж заримдаа мөргөхгүй. Мунафик нар тамд маш гашуун зовлонд унах болно. Бидний Хүндэт Ресүлуллах саллахю алэйхи вэ селлем “Намааз эс үйлдэгчид шүүгдэх өдөр Аллаахыг уур хилэнтэй байхыг харна” хэмээн айлдсан билээ.

Намааз үйлдэх нь Аллаахын агуу ихийг бодож өөрийнхөө өчүүхэн бага болохыг ухаарах гэсэн үг. Үүнийг ойлгосон хүн үргэлж сайн сайхныг үйлдэж муу муухайг огтоос хийхгүй. Өдөр бүр таван удаа Эзэн Тэнгэрийнхээ оршихуй мөн чанарт байгаа хэмээн бодон итгэгчийн зүрх сэтгэл үнэн хайраар бялхна. Намааз хийх хэрэгтэй хэмээн захирамжлагдсан үйл хөдлөл бүр зүрх сэтгэл

бие махбодод ач тус авчирна.

Жами буюу ислаамын сүмд олон түмний хамт намааз үйлдэх нь муслмаанчуудын сэтгэл зүрхийг нэг нь нөгөөтэй нь холбож байдаг. Муслмаанчуудын хооронд хайр энрэлийг бий болгоно. Бие биеэ ахан дүү гэдгээ ойлгоно. Ахас ихэс нь хүүхэд залуусаа нигүүлсэн багачууд өтгөс настнаа хүндлэ болно. Баячууд ядууст, хүчтэй нь сул доройдоо туслана. Эрүүл хүмүүс өвчтэй ахан дүүсээ жамид харахгүй бол үгүйлнэ. “Шашин нэгт ах дүүдээ туслагчийн шадар дэмжигч нь Аллаах болно”. Хадис-и шериф дэхь ер бусын мэдээтэй золгохоор уралдацгаана.

Намааз хүмүүсийг муухай өөдгүй муу хориотой зүйлээс татаж зайлуулах бөгөөд гэм нүглээс цагаатгах болно. Хадис-и шерифт “Өдрийн таван удаагийн намаз та нарын хэн нэгний хаалганы өмнүүр урсах гол мэт. Аливаа нэгэн тэрхүү голын уснаа таван удаа орж биеэ угааваас огт хир буртаггүй болохын адил өдөрт таван удаа намааз хийгчдийн нүглүүд өршөөгднө” хэмээн айлджээ.

Намааз Аллаах ба Ресул элчид итгэн сүсэглэснээс хойно бүхий л үйл залбирлаас илүү дээд зэрэг бишрэл мөргөл юм. Иймээс намаазыг фарз /гарцаагүй үүрэг/, важиб /зайлшгүй үүрэг/, суннет /уламжлалт үүрэг, /мустехаб /сайшаагдах үүрэг/ ийг хүндлэн үйлдэх хэрэгтэй. Бидний Пайгамбаар элч Саллаллаху алейхи уе селлем нэг хадис-и шерифт өгүүлрүүн “Аяа сүслэн дагагч Асхаб минь: Үйлдэл хөдлөл нь бүхлээрээ хүндлэл болсон намааз Аллаахын таалах бүх үйлдлийн хамгийн дээд охь нь юм, Пайгамбаар Элч нарын сүннет болно. Сахиусан тэнгэр нарын хайрладаг зүйл юм. Мэдлэг эрдмийн газар орон тэнгэрийн гэрэл гэгээ юм. Бие лагшингийн хүч чадал юм. Хүнс тэжээлийн элбэг дэлбэг нь юм. Дуа уншлагын хүлээн авах шалтгаан юм. Мелек-үл –мевте /үхлийн сахиус тэнгэрт/ зуучлан өмгөөлөгч юм. Булшинд гэгээ гэрэл шашны тэрслэгч үгүйсгэгчдэд хариу юм. Шүүгдэх өдрийн халуунд сүүдэр болно. Тамын галаас хамгаалагч бамбай юм. Сиратын гүүрээр аянга цахилгаан мэт хөтлөгч юм. Диваажингийн оньс юм. Диваажинд толгойн титэм юм. Аллаах мүминд намаазаас илүү чухал зүйл хайрлаагүй билээ. Хэрвээ намаазаас илүү үнэт ибадет байсан бол хамгийн түрүүнд мүмин нарт түүнийг зарлиг болгох байлаа. Яагаад

гэвэл зарим сахиус тэнгэр үргэлж кыйамд /зогсоо намааз/ зарим нь рүкүд /бэлхүүсээр мэхийх/ зарим нь сеждед/ сөгдөн мөргөх/ зарим нь тешеххүдээр /сууж мөргөх / байдалтай мөргөн байдаг. Эдгээрийг бүгдийг нь нэг рекат намаазд цуглуулж мүминчүүдэд бэлэг болгон өгсөн билээ. Учир нь намааз имааны эхлэл, шашны тулгуур багана, ислаамын хэл, мүминчүүдийн өргөмжлөл магтаал юм. Тэнгэр огторгуйн гэрэл мөн Тамаас аврагч юм”

Нэг өдөр гэгээн Али радыйаллахү анх ве керрем аллахү вежх оройн намазыг үйлдэлгүй өнгөрсөнд харамсан гуниснаас нэг хадан хясанаас үсэрчээ. Цурхиран уйлжээ. Манай Пайгамбаар Мүхаммед Мустафа саллаллахү алейхи ве селлем түүний энэ байдлыг мэдэнгүүтээ Асхабтайгаа хамт Али радыйалахү анхийн хажууд ирэв. Байдлыг нь хараад энэ орчлон ертөнцийн Эрхэм болох Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем ч уйлж эхлэв. Дуа уншив. Нар дахин мандаж хүндэт Ресүллүллах сал Аллахү алейхи ве селлем “Аяа Али толгойгоо өндийлгө, нар одоо ч харагдаж байна”хэмээв. Гэгээн Али радиаллахү анх үүнд ихэд баярлаж намаазаа үйлдэв.

Гэгээн Абу Векр-и Сыддык радыаллахү нэгэн шөнө ихэд ибадет хийснээс шөнийн төгсгөлд нойронд дарагдав. Витр намаз өнгөрчээ. Өглөөний намаазанд бидний Хүндэт Пайгамбаарыг дуурияж жамийн үүдэнд хажууд нь ирж гунихрав. Йа Ресулаллах Надад туслаач, витр намаазаа үйлдэлгүй өнгөрөөчихлөө би хэмээн уйлж гуйв. Манай хүндэт Ресүллүллах ч уйлж эхлэв. Үүний дээр Жебрайл алейхиселлам ирж “Йа Ресулаллах Сыддыкт хэлэгтүн Аллах түүнийг өршөөлөө”хэмээв.

Ариун номч /Эвлийа/ нарын томоохон нь болох Байезид-и Вистами куддисе сиррух нэгэн шөнө нойронд дарагдаж өглөөний намаазаа үйлдэж чадсангүй. Ихэд уйлж гашудсан тул нэгэн дууг сонссон нь Аяа Бейазид Энэхүү осол алдааг чинь өршөөлөө. Энэхүү уйлсны аз хишгээр чамд үүнээс гадна далан мянган намаазын буян өглөө хэмэн айлдав. Хэдхэн сарын дараа дахиад л нойронд дарагдчихав. Чөтгөр ирж түүний хөлнөөс нь чангааж сэрээв. Бос, намаазаас хоцрох гэж байна чи хэмээв. Гэгээн Вайезид-и Бистами өгүүлрүүн Ээ хараал идэгч чи ийм үйлийг яаж хийнэ вэ? Чи бүгдийн намаазыг өнгөрөөж цаг нь өнгөрөөсэй хэмээн хүсдэг

биз дээ Намайг яах гэж сэрээнэв? Чөтгөр өгүүлрүүн: Өглөөний намаазаас хоцорсон өдөр уйлаад далан мянган намазын буян хураасан, Өнөөдөр түүнийг бодоод чамайг сэрээв нэг удаагийн намазын буян олог гэж Далан мянган намаазын буянг авхуулхгүйн тулд гэжээ.

Их Вели багш гэгээн Жүнейд-и Багдади өгүүлрүүн "Энэ ертөнцийн нэг цаг нөгөө ертөнцийн мянган жилээс илүү сайн юм. Учир нь энэ цагт номын ёст хүлээн авахуйц нэг үйл үйлдэж болно. Тэр мянган жилд юу ч үл хийнэ. Ресулуллаах саллаллахү алейхи ве селлем өгүүлрүүн "Хэн нэгэн нэг намаазыг өнгөрч буйг мэдсээр байж нөгөө намааз тай золговол наян хүкбе Тамд түлэгдэнэ"Нэг хүкбе наян нөгөө ертөнцийн жил юм. Нөгөө ертөнцийн нэг өдөр дэлхийн мянган жил юм.

Тиймийн тул шашны ах дүү нар минь Цаг хугацаагаа хоосон ашиггүй зүйлээр бүү өнгөрөө. Цаг хугацааны үнэ цэнийг мэдэгтүн Цагаа хамгийн сайн зүйлд зарцуул. Бидний хайрт Пайгамбаар "Хамгийн том гарз бол цагаа ашиггүй зүйлээр нөхцөөх явдал" гэж айлдсан байдаг. Намаазаа цаг хугацаанд нь үйлдэгсэд шүүгдэх өдөр гэмшилгүйгээр үлэмж их буянд хүрэх болно.

Хадис-и шерифт айлдахдаа : "Нэг намаазыг цагт нь үл үйлдэж каза нөхвөрт үлдэн төлөөс төлж намааз үйлдэхээсээ өмнө нас нөгчигчийн булшинд Тамаас далан цонх онгойж энэ ертөнцийн төгсгөл хүртэл зовон тарчилна" хэмээжээ.

Нэг намазын хугацааг мэдсээр байж үл үйлдэгч өөрөөр хэлбэл цаг хугацаа нь өнгөрөхөд намааз үйлдээгүйдээ үл харамсагч шашнаас гарах ба үхэхдээ имаангүй үхнэ. Харин намаазыг үл тоогч нар, намазыг үүрэг хэмээн үл үзэгч нар хэрхэх вэ? Намазыг үл хүндлэн үүрэг гэж үл үзэгчдийг (Муртед) өөрөөр хэлбэл кафир тэрслүү болно гэдгийг дөрвөн дэгийн бүх мэргэд үг дуу нэгтэйгээр мэдэгдсэн байна. Намаазыг мэдсээр байж үл үйлдэж каза хийхийг үл бодогч үүний тул зовж тарчлахаас үл эмээгч хүмүүс ч (Муртед) өөрөөр хэлбэл кафир болохыг гэгээн Абдулгани Наблусиийн Хадикатун недиййе хэмээх номын Хэлний осол гамшгууд хэмээх бөлөгт бичээстэй байна.

Гэгээн Имма-и Раббани Мектүбат номын 1 боть 275 захиандаа айлдруун: "Та нарын энэ хувь хишигтэй золгосон нь ислаамын ёсны мэдлэгийг зааж сургаж хууль журмын хууль эрхийн бодомж

дүгнэлтүүдийг дэлгэрүүлснээр буй болсон . Тэнд харанхуй үл мэдэхүй суурьшиж бидат буруу үзэл үйл түгэн тархсан байв. Аллаах хайртай хүмүүсийнхээ хайрыг та нарт өргөл болгов. Ислаамын ёсыг түгээхээр та нарыг зуучлуулав. Тийм бол шашны мэдлэгийг заах сургах хууль эрхийн дүрэм ёсыг дэлгэрүүлэхийн тулд чадлаа дуустал зүтгэгтүн, энэ хоёр нь бүхий л аз жаргалын эхлэл, дээшлэхийн хэрэглүүр, чөлөөлөгдөхийн шалтгаан юм. Ихэд зүтгэгтүн. Шашны зүтгэлтэн болж гарч ирэгтүн. Тэднийхэнд шашны сайн гэснийг захирамжлан муу гэснийг хорьж /эмр-и маруф ба нехй-и мүнкер/ зөв замыг үзүүлэгтүн. Мүзземмил сүрегийн 19-р айетыг утгачлавал “Эзэн Тэнгэрийнхээ зөвшөөрөлд хүрэхийг хүсэгчдийн хувьд энэ нь мэдээжээр нэг сургаал сургамж юм” хэмээжээ.

Алив намааз үйлдэе сэтгэлийн зэв хирээ арилгая
Намаз залбиралгүй бол Аллаах руу дөхөхгүй

Намаз мөргөх газар нүгэл үргэлж хоосроно.
Намаз үйлдэхгүйгээр хүн төгөлдөршихгүй

Кураан-и кэримд Эзэн Тэнгэр намаазыг ихэд магтсан
Намаз үл мөргөгч нэгнийг таашаахгүй гэж айлдсан

Нэг хадис-и шерифээс ажвал, хүний иманы тэмдэг
Намаз мөргөхгүй бол тодрохгүй гэнэ.

Нэг намаз хийхгүй байх нь хамгийн их нүгэл юм.
Нөхвөрөө хийхгүй бол наманчлаад өршөөл олохгүй

Намаазыг үл тоогч имаанаас шууд ангижрана
Намаазаа мөргөхгүй бол мусылмаан болж үл чадна.

Намааз зүрхийг цэвэрлэж муу муухайгаас хорино
Намааз мөргөөгүй цагт гэгээрэл ирэхгүй.

Нэгдүгээр бүлэг

• ИМААН БА НАМААЗ •

Хүн бүр эхлээд Имаан (итгэл) тай байх хэрэгтэй

Аллаах хүмүүсийн зовлонгүй тайван амьдарч нөгөө ертөнцөд ч хязгааргүй аз жаргалтай учрахыг хүсдэг билээ. Иймээс Аллаах аз жаргалын шалтгаан болох ашиг тустай үйл үйлдэхийг тушаан зарлиглав. Гай гамшгийн учир шалтгаан болох хор хөнөөлт зүйлийг хорьсон бөлгөө. Аллаахын анхны захирамж нь итгэн бишрэх буюу иман хийх явдал юм. Имаан хүн бүрийн хувьд зайлшгүй юм.

Имааныг толь бичигт хэн нэгнийг бүрнээ зөв үгтэй хэмээн таньж, түүнд итгэх гэсэн утгатай юм. Ислаам шашинд итгэн сүслэнэ гэдэг нь: Мухаммед алейхисселамын Аллаахын Пайгамбаар элч болохыг, Аллахын зүгээс сонгогдсон мэдээ түгээгч (Наби) болохыг нь зөв мэдэх ба итгэн үнэмшиж хэлэх, Аллаахын зүгээс товч гэж тооцдогт нь товч итгэх өргөн хүрээтэй гэдэгт нь тал бүрээс итгэх хүч чадал нь хүрвэл (Келиме-и шехадет)-ыг хэлэх явдал юм. Хүчтэй итгэл сүсэг нь гал түлж, могой хордуулж хөнөөдөг гэдэгт эргэлзээгүй итгэж зугатдагтай адилаар зүрх сэтгэлээсээ бүрэн бүтнээрээ Аллаахыг, түүний шинж чанаруудыг агуу их хэмээн бодож, Түүний хүсэлт сайхан дүр нягуурд шийдвэртэй зүтгэх, уур хилэнгээс нь зугатах иман буюу итгэл бишрэлийг гантиг чулуун дээрх бичээс мэт бат бөхөөр зүрх сэтгэлдээ байршуулах явдал билээ.

Имаан Мухаммед алейхисселамын хэлсэн бүгдийг нь таалж зүрх сэтгэлээ баталгаажуулах өөрөөр хэлбэл итгэх гэсэн үг. Ийнхүү итгэсэн хүмүүсийг (Мүмин) буюу (Мусылмаан) гэнэ. Мусылмаан хүн бүр Мухаммед алейхисселамд захирагдаж түүний заасан замаар замнах ёстой. Түүний зам нь Кураан-и-керимийн заасан зам

юм. Энэ замыг Ислаам шашин гэнэ. Түүнд нийцэхийн тулд эхлээд

Итгэх, дараа нь Ахкам-и исламийег өөрөөр хэлбэл, мусылмааны шинж ёсыг сайтар сурах, дараа нь фарзуудыг гүйцэтгэн хараам цээрээс зайлсхийх дараа нь сүннетүүдийг хийж мекрүхүүдээс зайлсхийх хэрэгтэй билээ. Үүний дараа мубахыг /нүгэл үл болох үйл/ үйлдэхдээ ч Түүнд зохицохыг оролдох хэрэгтэй. Манай шашны үндэс бол имаан билээ. Имаан байхгүй хүмүүсийн ямар ч ибадет залбирал сайн үйлийг Аллаах таалж хүлээж авахгүй. Мусымаан болохыг хүссэн хэн нэгэн эхлээд итгэн сүсэглэх, дараа нь гүсл абдест буюу бүх биеийн угаал мөн намаазыг хэрэгтэй бол бусад фарз хараамуудыг сурах хэрэгтэй.

Имаан үнэн зөв болох хэрэгтэй

Мэдрэх эрхтнүүдийн болоод оюун ухааны хүлээж авах мэдлэгүүд имаанд хүрэхэд тусалдаг. Байгалийн ухаан ертөнцийн дэг журам эмх цэгц санааандгүй бий болоогүй ба нэг бүтээгч байгааг ойлгож мэдэх нь имаан сүсэгт хүрэх шалтгаан юм. Имаан хэмээх нь сүүлчийн Пайгамбаар элч алейхиселламын Аллаахаас авч ирсэн мэдлэгийг сурч итгэх гэсэн үг. Итгэх ёстой мэдлэгийг зөвхөн оюун ухаанд минь тааран зохицвол итгэнэ гэх нь элч нарт ч үл итгэх гэсэн үг юм. Шашны мэдлэг нь оюун ухааантан нарын нээлт биш. Бидний Пайгамбаар Мухаммед алейхиселламын айлдсан зүйлүүд (Эхл-и суннетийн эрдэмтэн) нарын номуудаас сурч тийнхүү итгэх хэрэгтэй. Зөв хүлээж авахуйц имантай болохын тулд үүнээс гадна доорх нөхцөл болзолд зохицох хэрэгтэй.

1. Итгэл сүсэг үргэлжийн тогтмол байх хэрэгтэй. Нэг хором ч гэлээ хөндийрөхийг бодохгүй байх хэрэгтэй. Гурван жилийн дараа мүслүмааны ёс суртлаас гарна хэмээн хэлсэн хэн нэгний хувьд тэр мөчөөс эхлэн иман нь холдон зайлж мусылманы шашин номоос ангижрах болно.

2. Мүминий итгэл сүсэг айдас ба найдварын хооронд байх хэрэгтэй. Аллаахын шийтгэлээс айх хэрэгтэй, гэхдээ нигүүлслээс нь нэг хором ч болов итгэл найдвар тасалж үл болно. Нүгэл болгоныг үйлдэхээс зайлсхийн нүглээсээ болж итгэл сүсэг нь холдохоос мөн бүх нүглийг үйлдсэн ч гэлээ Биднийг Эзэн Тэнгэрийн өршөөнө гэдгээс огт найдлагаа тасалж болохгүй. Нүглээ наминчлах хэрэгтэй. Яагаад гэвэл наманчлагч огт нүгэл хийгээгүй

МЭТ.

3. Амь буюу сүнс хоолойнд орохоос өмнө итгэж сүсэглэсэн байх ёстой.

Амь хоолойд ирэнгүүт хойд ертөнцийн бүх нөхцөл байдал харагдна. Тэр цагт бүх кафирчүүд имаан хийхийг хүснэ. Гэтэл имааны гайб /үл үзэгдэх ертөнц үл мэдэгдэх юмс/ байх хэрэгтэй. Үзэлгүйгээр итгэх хэрэгтэй. Үзсэн зүйлд имаан гарч ирэхгүй. Гэхдээ энэ мөчид мүминчүүдийн наманчлал хүлээн зөвшөөрөгднө.

4. Нар баруун зүгээс гарахаас өмнө итгэн сүсэглэх хэрэгтэй. Шүүгдэх өдрийн томоохон шинж бошгын нэг нь нар баруун талаас гарах юм. Үүнийг үзсэн хүмүүс итгэн сүслэх болно. Гэхдээ эдгээр хүмүүсийн итгэл сүсэг хүлээн зөвшөөрөгдөхгүй. Наманчлалын хаалга хаагдсан байх болно.

5. Аллаахаас өөр хэн нэгний гайб болоод нууцлаг зүйлийг мэдэхгүй гэж итгэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл гайбыг зөвхөн Аллаах мэднэ. Түүнчлэн Түүний мэдүүлсэн хүмүүс мэднэ. Сахиусан тэнгэр, жинни (онго), нар чөтгөр тэр бүү хэл Пайгамбаар нар ч үл мэднэ. Гэхдээ Пайгамбаар нар болоод номын ёст кул (боол) нарт гайбаас мэдлэг оногдож болно.

6. Шашны имаан ба ибадетэд хамаарах нөлөөг шаардлагагүй санаатайгаар үгүйсгэж болохгүй. Ахкам-и исламиег өөрөөр хэлбэл, ислаам ёсны тушаал хорионоос нэгийг нь хөнгөлөн үзэх Кураан-и керимээр сахиус тэнгэр нар ба Пайгамбаар нараас хэн нэгнийг шоолон адлах эдгээртэй хамт өгүүлж мэдүүлснийг шаардлага байхгүй байхад үгүйсгэх кафир буюу үл итгэн тэрслэхүй болно. Аллаахын оршихуйг сахиус тэнгэр нар гүсл ба намаазын фарз /гарцаагүй үүрэг/ болохыг үхлээр айлгах гэх мэтийн зайлшгүйгээр үгүйсгэсэн хүн кафир болохгүй.

7. Ислаам шашин ил тодорхойгоор мэдүүлсэн зайлшгүй мэдлэгийг эргэлзэн тэээнгэлзэхгүй байх хэрэгтэй. Намааз үйлдэгчийн фарз дарс ба бусад согтууруулах ундаа уух, мөрийтэй тоглох, хүү ногдол ашгийн харам болохыг эргэлзэх эсхүл олны мэдэх ямар нэг хараамыг /шашнаар хорьсон бузар юм/ арикун гэх, халаал /шашнаар зөвшөөрсөн ариун юм/ зүйлийг хараам гэх нь имаан зайлах шалтгаан болно.

8. Имаан Ислаам шашны мэдүүлсэнчлэн байх хэрэгтэй Оюун ухааны ойлгосон философчид ба шинжлэх ухааны дууриагчдын

мэдүүлэхийг дагаж итгэвэл имаан болохгүй. Мухаммед алейхисселамын өгүүлсэнчлэн итгэх хэрэгтэй.

9. Итгэгч нь зөвхөн Аллаахын төлөө хайрлах хэрэгтэй. Зөвхөн Аллаахын төлөө дайсагнах хэрэгтэй. Аллаахын төлөө найз нөхөд болох мусылмаан нарыг хайрлах. Ислаамын ёсонд гар хөл болоод үзгээрээ дайсагнагчдыг үл хайрлах хэрэгтэй. Энэ дайсагналын зүрх юм.

/Мусылмаан нь мусылмаан бус иргэд, жуулчдад сайхан сэтэглэээр зөөлөн хэл үгээр хандах хэрэгтэй. Сайхан ёс суртахуунаар шашнаа бид бүхэн тэд нарт хайрлуулах хэрэгтэй./

10. Манай Пайгамбаар болоод Асхабынх /Мүмин байхдаа Гэгээн Мухаммедийг харж мүмин байгаад нас нөгчсөн мусылмаан нар/ нь заасан зөв замаас үл салагч жинхэнэ мусылмаан нар иман хийсэн адилаар итгэх ёстой. Зөв итгэхийн тулд Ахл-и сүннет хүй бүлгийн итгэл бишрэлд зохицон сүслэн итгэх хэрэгтэй. (Ахл-и сүннет мэргэд)-ийн бичсэн жинхэнэ шашны номонд дагагч нарт зуун шахидын буян ногдоно. Дөрвөн мезхебээс аль нэгний мэргэдийн Ахл-и сүннет /Мухаммедийн замаар замнагч сүнни нар/ мэргэн гэнэ. Ахл-и сүннет мэргэдийн ахлагч нь Имам-и азам Эбү Ханифе юм. Эдгээр мэргэд Асхаб-и кирамаас сурснаа бичсэн бөлгөө. Асхаб-и кирам ч гэсэн энэ мэргэн багш нарт Ресюлүллахаас сонссоноо ярьж хэлсэн бөлгөө.

• ЭХЛ-И СҮННЕТИЙН ИТГЭЛ БИШРЭЛ •

Мусылмаан болохын анхдагч болзол нөхцөл нь итгэн сүслэх явдал юм. Зөв имаан нь Ахл-и Сүннетийн итгэл бишрэлд таарч итгэхтэй холбоотой. Оюун ухаан бүтэн идэр насанд хүрсэн эр эмэгтэйн анхны үүрэг нь Ахл-и сүннет номч мэргэдийн номноо бичсэн итгэл сүсгийн мэдлэгийг сурах мэдэх үүнтэй даган зохицон итгэх явдал юм. Шүүгдэх өдөр Тамын зовлонгоос ангижрах нь тэдний мэддэг зүйлдээ хэр итгэхээс шалтгаална: Тамаас аврагдах хүмүүс зөвхөн тэдний замаар замнагчид юм. Тэдний замаар явагчдыг (Сүнни) буюу (Ахл-и Сүннет) гэнэ. (Ислам и Ахлак) ёс суртахуун 553 т 46 дугаар өгүүллээс үзнэ үү.

Нэг хадис-и шерифт “Миний нэгдэн итгэгчид 73 бүлэгт хуваагдна. Үүнэээс зөвхөн нэг хэсэг нь Тамын аюулаас

чөлөөлөгдөх ба бусад нь Тамд унана" Энэ далан гурван бүлгээс нэг бүр нь ислаамын ёсонд зохицон дагадаг хэмээгээд Тамаас аврагдах бүлгийг нь манай бүлэг хэмээж байна. Мүминий сүрегийн 54, Рүм сүрегийн 32 айет-и керимед утгачлавал: "Бүлэг бүр зөв замд байгаа гэж бодон баярлаж байна" гэж айлджээ. Гэтэл энэ янз бүрийн бүлэг дотроос аврагдах бүлгийн шинж тэмдэг Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем ийнхүү үзүүлж байна: "Энэ бүлэгт багтагчид миний болоод Асхабийн замд байгчид юм" гэжээ. Асхаб-и-кирамаас нэгийг нь ч атугай үл хайрлах Эхл-и Сүннетээс салсан болно. Эхл-и Сүннет итгэл бишрэлд үл оршигч кафир буюу Бидат \эхли шашин номд үгүй боловч хожим бий болсон зүйлийг дагач \нар гажигч болно.

Эхл-и сүннетэд итгэн бишрэхүйн шинж тэмдэг:

Аллаах Эхл-и Сүннет итгэн бишрэхүйд /итикат/ зохицон итэгсэн мусылмаанчуудад талархана. Ийнхүү итгэсний олон шарт буюу болзол нөхцөл байдаг. Эхл-и сүннетийн мэргэд эдгээрийг доорх байдлаар тайлбарлаж байна.

1. Имааны зургаан нөхцөл болзолд өөрөөр хэлбэл Аллаахын оршихуй цорын ганц гэдэгт, Сахиус тэнгэр нар болоод Ном сударт нь, Пайгамбаар элч нарт, Хойд ертөнцийн амьдралд мөн хайр ба дайсагнал сайн мууг Аллах бүтээсэн гэдэгт итгэх ёстой. (Эдгээр нь (Аментү) д заагдсан байна).
2. Аллахын сүүлчийн судар ном болох Кураан-и Керим нь Аллахын келам үг хэмээн итгэх хэрэгтэй
3. Мүмин өөрийн итэгэлд огт эргэлзэхгүй байх
4. Пайгамбаар Элч саллаллахү алейхи ве селлемд итгэж амьд байхдаа Түүнийг харах хувь заяа тохиосон Асхаб-и кирамын бүгдийг нь ихэд хайрлах хэрэгтэй. Түүний дөрвөн халифе болоод ойр ах дүүс болох эхл-и бейтид /Гэгээн Мүхаммедийн гэр бүл ах дүү/ ариун дээд эхнэр гэргийнүүдийн алинд нь ч хэл үг чулуудаж үл болно.
5. Ибадетүүдийг имааны нэг хэсэг гэж бодохгүй байх хэрэгтэй. Аллаахын тушаал хориод итгэж залхууран үл үйлдэгч мүминчүүдийг кафир гэж үзэхгүй байх хэрэгтэй. Хараамуудыг чухалд тооцоогүйчүүдийг хөнгөлөн үзэгчдийн исламын ёсыг

гоочлон тоглогчдын имаан нь холдоно.

6. Эхл-и кыбле /Каабегийн зүгт хамаатай/ болохоо хэлж Аллаах Түүний Пайгамбаар элч Мүхаммед алейхиселамд итгэдэг гэх мөртлөө буруу итгэл бишрэлд автагчдыг тэрсүүд гэж бодох ёсгүй. Кафир гэж хэлж хэрэггүй.

7. Ил тодоор нүгэл үйлддэг нь үл мэдэгдэх имаан бүрийн ард намааз хийж болно. Энэ дүрэм Жума өдрийн ба баярын намаазыг хийлгэх ноён сайдад ч хамаатай болно.

8. Мусылмаанчууд удирдан байх ноёд захирагчдыг эсэргүүцэн босож болохгүй. Тэмцэх буюу тулан босгох нь үймээн хямрааныг дуудна. Янз бүрийн муу үйлийн шалтгаан болно. Дарга ноёдын буянт үйл хийхийн төлөө дуа унших хэрэгтэй нүглийн үйлээс татгалзахын төлөөнөө эелдэг зөөлөн үгээр сургах хэрэгтэй.

9. Абдест авахдаа хөлийг угаахын оронд ямар ч шалтаг зайлшгүй шаардлага байхгүй ч гэлээ нойтон гараараа нэг удаа дан гутлыг дээгүүр нь илж арчих /местийн месх/ нь эрэгтэй эмэгтэй аль алинд нь зөвшөөрөгдсөн зүйл юм. Нүцгэн хөл оймстой илж арчихгүй.

10. Манай Пайгамбаар Элчийн саллаллахү алейхи ве селлем мираж буюу Аллаахын урилгаар 7 давхар огторгуй ба түүний ертөнцөөр аялсан шөнө нь санаа сэтгэл болоод бие махбодод нь хэрэгжсэн хэмээн итгэх хэрэгтэй. /Өргөмжлөл нь нэг байр байдал ба өөрөөр хэлбэл зүүдэнд болсон/ гэж хэлэгчид эхл-и сүннетээс салж хагацна.

Диваажинд мүминчүүд Аллаахыг харах болно. Кыйаметын өдөр Пайгамбаар нар ба үнэн ёст сайн хүмүүс өмгөөлөн зуучлах болно. Булшны асуулт гэж байдаг . Булшин дахь гэсгээл нь сэтгэл санаа ба биенд илэрнэ. Ариун номчийн гайхамшиг нь Үнэн юм. Гайхамшиг нь Аллаахын хайрт зүтгэгч нарт гарч үзэгдэх ер бусын нөхцөл байдал бөгөөд Аллаахын хууль дүрмийн гадна өөрөөр хэлбэл физик хими биологи хуулийн гаднах өглөг бэлэг буянт үйл бөгөөд үгүйсгэгдэж болохгүй хэмжээнд олон тоотой байдаг. Булшинд сүнс амьд хүмүүсийн хийсэн, хэлснийг сонсно. Кураан-и керим унших, өглөг өгөх тэр бүү хэл бүхий л ибадетүүдийн буянг үхэгсдийн сүнс рүү илгээх тэд нарт ач тус өгснөөрөө зовлон хөнгөрч арилах шалтгаан болно. Эдгээрийн бүгдэд итгэх нь Эхл-и сүннетийг итгэн биширч байгаагийн шинж тэмдэг болно.

• ИМААНЫ ШАРТ БУЮУ ИТГЭЛИЙН БОЛЗЛУУД •

АМЕНТҮ: Аментү биллахи ве Мелайкетихи ве Күтүбихи ве Рүсүлихи вел-йевмил-ахири ве бил кадери, хайрихи ве шеррихи мин Аллаахи теаля вел-ба-сү бадел-мевти хаккүн, Эшхедү эн ла илахе иллаллаах ве Эшхедү энне Мухаммеден авдүхү ве ресулүхү.

Нэгдэх болзол
АЛЛААХД
ИТГЭХ

(Аментү биллахи) гэдэг нь: Аллаахын оршихуй цор ганц гэдэгт итгэж итэгэлээ зүрх сэтгэлээрээ нотолж хэл үгээрээ давтлаа гэсэн үг. Аллаах оршин байгаа бөгөөд цор ганц юм. Нэг хэмээх үгийн толь бичигт хоёр утга байдаг. Нэгдэх нь тооны талаас хоёрын хагас болох ба тооны эхлэл юм. Нөгөө нь хамтрагч хийгээд адилгүй гэсэн талаасаа нэг юм. Ийнхүү Аллаах нь тооны талаас бус адил ижил үгүй хосгүй гэсэн талаас нэг юм. Өөрөөр хэлбэл хувь оногдол болоод шинж чанарын талаас түүнд Хамтрагч үгүй юм. Бүтэн бүтэгчдийн бод бие ба шинж чанарууд өөрийг нь бүтээгчдийн бод бие шинж чанартай адилсдаггүйн сацуу бүтээгчийн бод бие ба шинж чанар нь бүтэгчдийн алиных нь ч бод бие ба шинж чанартай ижилсэхгүй. Бүхий л бүтэгчдийн эрхтэн бүр эс эд болгоныг үүсгэж оргүй хоосноос бүтээгч нь зөвхөн агуу Аллаах билээ. Аллаахын бод биеийн үнэн мөнийг хэн ч мэдэж эс чадах ба оюун ухаан ба төсөөлөлд орж илрэх бүхнээс илүү өндөр дээд юм. Аллаах Тэнгэрийг оюун ухаанаар төсөөлөх нь хориотой юм. Гэхдээ Кураан-и-Керимд өгүүлсэн шинж чанаруудыг нэрийг нь цээжилж агуу ихийг нь үүгээр нотолж давтах хэрэгтэй. Түүний бүх шинж тэмдэг нэр нь үүрд мөнхийн билээ Мөн чанар болохын хувьд өөрөө аль ч газар оршин байхгүйн сацуу мэдэгдэх зургаан зүгээс ч анги тасархай юм. Өөрөөр хэлбэл урд хойно баруун зүүн, дээд доод талд оршихгүй. Түүний тул Тэнгэр Эзнийг зөвхөн Бүхий л газар оршиж бүхнийг харагч (хазир, назир) гэж хэлж болно.

Аллаахын арван дөрөв шинж тэмдэг байдаг. Зургаад нь Сыфат-и затиййе, наймд нь (Сыфат-и сүбүтиййе) гэнэ. Эдгээрийн утгыг нь

мэдэх, цээжлэх машид хэрэгтэй юм.

Сыфат-и-затиййе

1. Вүжуд Аллаах оршин байна. Оршихуй нь үүрд мөнхийн болно. Важиб-үл- вүжүдд болно. Өөрөөр хэлбэл оршихуй нь зайлшгүй юм.

2. Кыдем Аллаахын ахуйгаас эхлэл гэж үгүй.

3. Века Аллаахын оршихуйд төгсгөл үгүй. Хэзээ ч үгүй болохгүй. Түүний хамтрагч болох нь боломжгүй төдийгүй бод бие ба шинж чанарын хувьд ч хоосон байх боломжгүй юм.

4. Вахданиййет Аллаахын бод бие шинж чанар ба үйл хэрэгт нь хамтрагч ижилдэгч үгүй юм.

5. Мухалефетүн-лил хавадис Аллаах бод бие ба шинж чанарын хувьд ямар ч бүтэгчийн бие махбод шинж чанартай адил бус юм.

6. Кыйам би-нефсихи Аллаах бод биеэрээ байнгын үргэлж юм. Орон зайг шаардахгүй. Юм бодис орон зай байхгүй байхад Тэрээр оршиж байв. Яагаад гэвээс бүх хэрэгцээнээс ангид юм. Энэхүү орчлонг хоосон оргүйгээс ахуй болгохоосоо өмнө мөн чанар нь ямар байсан үүрд мөнх ийм байх болно.

Сыфат-и сүбутиййе

1. Хайат Аллаах амьд юм. Түүний Амьдрал бүтэгчдийн амьдралтай адил бус бөгөөд түүний биед тохирох хамаарах амьдрал үүрд мөнх юм.

2. Илм Аллаах бүгдийг мэднэ. Түүний мэдэх нь боол нарын мэдэхтэй адил бус билээ. Харанхуй шөнө шоргоолж хар чулуун дээр явахыг үзнэ мэднэ. Хүний дотор бодсоныг, зорилгыг ч мэднэ. Мэдэхэд нь өөрчлөлт гарахгүй. Үүрд мөнхийн юм.

3. Сем Аллаах сонсно. Зууч хэрэгсэлгүйгээр сонсно. Сонсох нь боол нарын сонсохтой адилгүй. Энэ шинж ч гэлээ бусад шинж чанар лүгээ адил үүрд мөнхийн юм.

4. Басар Аллаах үзнэ. Хэрэгсэл болзолгүйгээр харна. Нүдээр харахгүй.

5. Ирадет Аллаах хүснэ. Хүссэнээ бүтээн бий болгоно. Бүх зүйл Түүний хүссэнээр бий болдог. Зориг хүсэлд нь саад болох ямар ч хүч байхгүй.

6. Кудрет Аллаах бүх зүйлд хүч нь хүрнэ. Юу ч түүн лүгээ хүч тэнцэхгүй.

7. Келам Аллаах хэлэгч, яригч юм. Хэлж ярих нь хэрэглүүр үсэг авиа хэлээр бус юм.

8. Теквин Аллаах нь бүтээгч юм. Түүнээс өөр бүтээгч байхгүй билээ. Юм бүрийг Тэрбээр бүтээнэ. Аллаахаас өөр хэнийг ч бүтээгч гэж хэлэх ёсгүй.Аллаахын болзлуудын үнэн гэдгийг ойлгох нь чухал юм. Хэн ч юу ч Аллаахын шинж чанарыг хамтрагч ижилдэгч болж чадахгүй.

Хоёр дахь болзол
САХИУСАН ТЭНГЭРҮҮДЭД ИТГЭХ

Ве мелаикетихи: Аллаахын сахиусан тэнгэрт итгэсэн гэсэн үг. Сахиусан тэнгэрүүд нь Аллаахынн боол нар болно. Бүгд Аллаахын тушаалыг дагана, Нүгэл үл үйлднэ, Эр эм гэж яалгагдахгүй,. Гэрлэхгүй, Амьд ба идэж уухгүй, унтахгүй. Туяанаас бүтсэн ба оюун ухаантай юм. Хамгийн дээд сахиус тэнгэр дөрөв байна.

1. Жабрайл алейхисселам. Үүрэг нь Пайгамбаар нарт вахий мэдээ авчрах зарлиг, цээрийг нь мэдэгдэх үүрэгтэй.

2. Исрафил алейхисселам. Сүр (дохио) үлээх үүрэгтэй. Нэгдэх үлээлтэнд үүсэн гарч ирэх дуу авиаг сонсогч Аллаахаас гаднах амьд болгон үхэх ба хоёр дахь үлээлтэнд дахин амилна.

3. Микайл алейхисселам. Байгал цаг уурын юмс үзэгдлийг хариуцдаг сахиусан тэнгэр юм.

4. Азрайл алейхисселам. Хүмүүсийн сүнсийг авах үүрэгтэй. Үүнээс гадна дөрвөн давхаргын сахиусан тэнгэр нар байдаг. Хамеле-и Арш /Аршыг тээгчид/ гэх сахиусан тэнгэр дөрөв байна. Эзэн тэнгэрт /Хузур-и илахи/ үйлчлэгч сахиусан тэнгэрүүдийг Мукарребин гэнэ. Азаб сахиусан тэнгэрүүдийн томоохоныг нь (Керубийан), нигүүлслийн сахиусан тэнгэрийг Руханыйан гэнэ. Диваажингийн сахиусан тэнгэрийн томоохныг нь Рыдван, Тамын сахиусан тэнгэрүүдийн томоохоныг нь Малик гэнэ Тамын сахиусан тэнгэрийг Зебайни хэмээнэ. Хамгийн олон тоотой бүтээгдсэн нь сахиусан тэнгэрүүд юм.
Тэнгэр огторгуйд сахиусан тэнгэрүүд ибадет хийхгүй хоосон газар үл оршино.

Гурав дахь болзол

НОМ СУДРУУДАД ИТГЭХ

Ве кютюбихи: Аллаахын илгээсэн ном сударт итгэсэн гэсэн үг. Аллаах эдгээр судруудыг зарим Пайгамбаарт Жебрайл нэрт сахиусан тэнгэрээр вахийн замаар /Тэнгэрийн мэдээ/ өөрөөр хэлбэл уншуулж заримд нь самбар хуудас дээр бичээстэйгээр ,заримд нь сахиус тэнгэргүйгээр илгээжээ . Бүгд Аллаахын үг / келам/ юм. Мөнх үүрдийн юм. Бүтээгдээгүй болно. Бүгд үнэн шударга юм. Тэнгэрийн номуудаас бидэнд мэдүүлэгдсэн нь зуун дөрөв юм. Эдгээрээс 10 хуйлмал Адаам алейхисселамд, 50 хуйлмал Шит алейхисселамд, 30 хуйлмал Идрис алейхисселамд, 10 хуйлмал Ибрахим алейхисселамд, Теврат Муса алейхисселамд, Зебүр Давуд алехисселамд, Инжил Иса алейхисселамд, Куран-керим Мухаммед алейхисселамд илгээгдсэн билээ.

Аллаах хүмүүсийг энэ дэлхийд амар тайван амьдрах, нөгөө ертөнцөд мөнхийн аз жаргалд умбуулахын тулд анхны хүн, анхны Пайгамбаар болох Адаам алейхисселамаас сүүлчийн Пайгамбаар болох Мухаммед алейхисселамыг хүртэл олон тооны Пайгамбаар нарын тусламжтайгаар ном судар илгээжээ. Энэхүү ном сударт имаан ба ибадетийн уг үндэсийг тайлбарласан ба хүмүүсийн хэрэгцээтэй бүхий л асуудлаар мэдээ мэдлэг өгсөн.

Эдгээрээс Кураан-и керим сүүлчийн ариун судар юм . Кураан-и керим илгээгдсэний дараа бусад бүх илахи ном судрын заалт зарлигууд /хүкм/ татан буугдсан юм. Жебрайл алейхисселам Күран-и керимийг Мүхаммед алейхисселамд хорин гурван жилд авчирсан билээ. Куран-и керим нь 114 сүре /бүлэг/, 6236 аят /өгүүлбэр/ юм. Энэхүү тоо зарим номд өөрөөр бичигддэг нь нэг урт аят хэд хэдэн аят хэмээн тооцолсноос тэр юм. Яагаад гэвэл, Кураан-и керим илгээгдэж дууссанаас авахуулаад ямар ч өөрчлөлт ороогүй ба үүнээс хойш ч гэсэн өөрчлөгдөхгүй. Кураан-и керим Аллаахын үг хэл юм. Иймэрхүү ном судрыг хүн бүтээх боломжгүй . Нэг аятыг дөхүүлээд хэлэх ч боломжгүй байдаг.

Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем хойд ертөнцөд заларснаас хойш нэгдүгээр халифе болох Эбү Бекр-и Сыддык радыаллахү анх Куран-и керимийн аятуудыг нэг дор цуглуулсан. Ийнхүү нэг Мусхаб /Курааны бичвэрийн анхны хувилбар/

бүрэлдсэн. Асхаб-и кирам бүгдээрээ энэхүү мусхаб Аллаахын үг хэл гэдгийг санал нэгтэйгээр мэдэгдсэн юм. Гуравдугаар халифе Осман радыаллахү анх энэ мусхабаас зургаан хувийг дахин бичүүлсэн. Зарим муж орон руу илгээсэн.

Күраан-и керимийг уугуул эхийг нь унших хэрэгтэй. Арабаас бусад үсгээр бичсэнийг Кураан- керим гэж хэлэхгүй.

а/ Кураныг гараараа барихдаа абдесттэй байх хэрэгтэй, кыблегийн зүгт хандан сууж анхааралтай унших хэрэгтэй

б/ Удаанаар айх даруугаар унших

в/ Мүсхаф /хуйлмал/ руу хараад аят бүрийг хүндэтгэлтэйгээр унших хэрэгтэй.

г/ Кураан судрыг унших дүрмийн дагуу/Тежвид кайде/ унших хэрэгтэй.

д/ Уншсанаа Аллаахын үг болохыг нь бодох хэргэтэй.

е/ Куран-и керимийн тушаал цээрт зохицон дагах хэрэгтэй

Дөрөв дэхь болзол
ПАЙГАМБААР ЭЛЧ НАРТ ИТГЭХ

Ве Русулихи: Аллаахын Пайгамбаар Элч нарт итгэлээ гэсэн үг. Пайгамбаар Элч нар Аллаахын болгоосон замд хүргэх, үнэн зөв мөр замыг заахын тулд сонгогдсон билээ. Бүх Пайгамбаар Элч нар нэгэн адил итгэл сүсгийг зааж номлосон байдаг. Пайгамбаар Элч нарт алейхимүселлам 7 шинж тэмдэг байдагт итгэх хэрэгтэй.

1. Исмет : Нүгэл үл үйлдэх. Пайгамбаар элч нар ямар нэгэн шашинд хараам /хориотой/ болсон хийгээд болох жижиг том ямар ч нүглийг эс үйлднэ.

2. Эманет : Пайгамбаар Элч нар Бүх талаар итгэл найдвартай хүмүүс юм. Хэзээ ч найдвар итгэлээсэ тэрслэн урвахгүй.

3. Сыдк : Пайгамбаар Элч нар үг хэл, үйл хэрэг, бүх төрлийн зан үйлдээ зөв үнэнч шударга хүмүүс юм.

4. Фетанет: Пайгамбаар Элч нар маш ухаалаг, маш ойлгох чадвартай, тэвчээртэй хүмүүс юм. Сохор, дүлий гэх мэт тахир дутуу хүмүүс, эмэгтэй хүн Пайгамбаар Элч болоогүй билээ.

5. Теблиг: Пайгамбаар Элч нар хүмүүст мэдэгдэж тайлбарласан бүхнээ Аллаахаас ирсэн вахйгээр /Аллах Эзний мэдээ Түүнээс Пайгамбаар нарт ирэх мэдээлэлийг сурсан байна. Заасан тушаал

цээрээс аль нь ч тэдний үзэл бодол биш юм. Тэдэнд зарлиглалсан бүх зүйл Аллаахынх юм.

6. Адалет: Пайгамбер Элч нар ямар ч хэрцгий дарлал шударга бус байдлыг үүсгэхгүй, хэн нэгнээс болж шударга ёсноосоо няцахгүй.

7. Эмнүл-азл: Пайгамбаарын үүргээсээ мятрахгүй. Энэ ертөнц ба хойд ертөнцөд үргэлжид Пайгамбаар Элч юм.

Шинэ шашин суртал авчирсан Пайгамбаар Элч нарыг Ресул /элч буухиа/ гэнэ. Шинэ шашин суртахуун авчрахгүйгээр хүмүүсийг урьдын шашинд урин дуудах Пайгамбаар Элч нарыг Неби /мэдээлэгч/ гэнэ. Пайгамбаар Элч нарт имаан хийх гэдэг нь тэднийг ямар ч алагчлалгүйгээр бүгдийг нь Аллаахын сонгосон үнэнч зөв үгтэй хүмүүс хэмээн итгэнэ гэсэн үг. Тэднээс нэгэнд нь үл итгэх хүн бүгдэд нь үл итгэсэнд тооцогдно.

Пайгамбаарын үүрэг нь их ажиллаж хөдөлмөрлөн өлсөж зовсноор бас их бясалгал үйлдэснээр бий болохгүй. Зөвхөн Аллаахын соёрхон таалсан сонголтоор бий болно. Тэднийй тоо нь тодорхойгүй байдаг. Зуун хорин дөрвөн мянгаас олон гэж алдартай. Үүнээс гурван зуун арван гурав эсвэл гурван зуун арван тав нь Ресүл юм. Эдэн дундаас зургаа нь илүү өндөр дээд Элч юм. Эднийг агуу их (үлүл-азим) Пайгамбаар нар гэнэ. Нэр нь Адаам, Идрис, Шыт, Нух, Худ, Салих, Ибрахим, Лут, Исмайл, Исхак, Йакуб, Йүсүф, Эййүб, Шуайб, Муса, Харун, Хыдыр, Йуса бин Нун, Илйас, Элйеса, Зүлкифл, Шемүн, Ишмойл, Йунүс бин Мета, Давуд, Сүлейман, Локман, Зекерийя, Йахйа, Үзейир, Иса бин Мерйем, Зүлкарнейн ба Мүхаммед алейхи ве алейхимүссаллатү весселам болно.

Эднээс зөвхөн хорин наймынх нь нэр Кураан-и Керимд нэрлэгдсэн байдаг. Зүлкарнейн, Локман, Үзейр, Хыдыр нарын Пайгамбаар Элч мөн эсэх талаар санал маргаантай байдаг. Мүхаммед Масум назрет 2 дугаар боть 3 дахь өгүүлэлд Хыдыр алейхисселамын Пайгамбаар Элч болохыг заасан мэдээ хүч төгөлдөр болохыг бичиж байна. 182 дугаар хэсэгт Хыдыр алейхисселамыг хүн төрхтэй үзэгдэж харагдсан хийгээд зарим ажил үйл хийсэн тэргүүтэн нь Түүний амьд гэдгийг айлдаагүй. Аллаах Түүний болон олон тооны Пайгамбаруудыг Асрамжлагч багш /Вели/ нарын сүнс хүний төрхөөр үзэгдэхийг зөвшөөрсөн. Тэднийг харагдаж үзэгдэх нь амьд

гэдгийг батлахгүй гэж байна.

Манай Пайгамбаар МҮХАММЕД Алейхисселам

Мухаммед Аллаахын Расул Элч нь юм. Пайгамбаар Элч нарын хамгийн дээд, хамгийн сүүлчийнх нь юм. Эцэг нь Абдуллах юм. Манай эриний 571 онд 4 сарын 20 таарах Ревиул-эввел сарын 12 ны бүтэн сайн өдрийн шөнө үүрээр Меккед мэндэлсэн бөлгөө. Эцэг нь түүнийг эхийн хэвлийд 7 сартай байхад нь нас нөгчсөн байв. Зургаан настайд эх нь, найман настайд нь өвөө нь нас нөгчжээ. Дараа нь авга ах Эбү Талибийн халамжинд өсч торнижээ. Хорин зургаан настайдаа Хадиже-түл-күбра тай гэрлэжээ. Түүнээс 4 охин, 2 хүүтэй болжээ. Ууган хүүгийн алдар Касим гэдэг байв. Тиймээс Мухаммедийг Эбүл –Касим ч хэмээнэ. Дөчин настай байхад бүх хүмүүс ба жин /онго/ нарт Пайгамбаар Элч болгожээ. Гурван жилийн дараа хүн бүрийг имаан /итглэл/-д дуудаж эхэлсэн. Тавин хоёр насандаа нэг шөнө Меккегээс Кудус рүү, тэндээсээ огторгуй руу хүргэгдээд буцаж иржээ. Энэ явдлыг Мираж гэнэ. Миражд диваажин, там, Аллаахыг үзжээ. Түүхчдийн үзэж буйгаар манай эринийй 622 онд Аллаахын зарилгаар Меккегээс Медине рүү нүүжээ. Энэхүү аяллыг Хижрет гэнэ. Мекке балгадын Куба тосгонд ирсэн Реби-үл–эввел сарын найм дахь даваа гаригийг тохиох Европын тооллын есдүгээр сарын хорьдугаар өдөр мусульмаан нарын Хижри шемси тооллын эхлэл болов. Мүслүманчуудын Хижри камери жилүүд ч тэр жилийн Мухаррем сараас эхлэх ба тэнгэр дэх сар дэлхийг тойроод арван хоёр удаа тойрсон нэг сарны /камери/ жил болно. Хижри 11 /манай эриний 632/ онд Реби-ул - еввел сарын арван хоёрдугаар өдөр ням гараг үдээс өмнө тэнгэрт халив. Мягмар гарагийг Лхагва гарагтай холбох шөнө /Лхагва гарагийн шөнө хагаст нас нөгчсөн өрөөнд нь оршуулсан байна. Нас зүг болохдоо камери 63, шемси жилээр 61 настай байв.

Мухаммед алейхисселам цагаан арьстай байв. Бүх хүмүүсийн хамгийн сайхан үзэсгэлэнтэй нь байв. Сайхнаа хүн бүрт мэдэгддэггүй байв. Түүний сайхныг нэг удаа харагч тэр бүү хэл зүүдэндээ харагчийн амь нас нь амт шимт баяр баясалтай өнгөрнө. Тэрээр хэзээ ямагт энэ ертөнцийн газар бүрт байгаад бий болж төрж гарах хүмүүсээс бүхий л талаараа илүү дээд юм. Оюун ухаан үзэл бодол сайхан зан ааш, бүхий л эрхтний хүч чадлаараа бүх хүнээс ангид нэгэн байв.

Хүүхэд ахуйдаа хоёр удаа наймаачидтай Дамаск руу явсан ба Бусра гэгдэх газраас буцав. Өөр ямар ч цаг үед хаашаа ч яваагүй. Бичиг үсэг үл мэдэгч /Үмми/ байв. Өөрөөр хэлбэл ямар ч сургууль сураагүй билээ. Гэхдээ бүхнийг мэддэг байв. Өөрөөр хэлбэл юуг бодно юуг мэдэхийг хүснэ Аллаах түүнд бүхнийг өгүүлж байв. Жебрайл алейхисселам нэрт сахиус тэнгэр ирээд Түүнээс хүссэн болгоныг нь хэлж байв. Ариун зүрх сэтгэл нь нар мэт туяа цацруулж байлаа. Түүний гялбаат эрдэм ухаан цэцэн мэргэний гэрэл гэгээ гэрлийн долгио мэт газар тэнгэр огторгуй бүхий л газар түгэн дэлгэрч байв. Одоо шарил бунхнааас нь ч түгэн тархаж байнам. Цахилгаан соронзон долгио хүлээн авахын тулд хүлээн авагч хэрэгтэй болох лугаа адил Түүний гэрэл гэгээг хүлээн авахын тулд Түүнд итгэн хайрлах, заасан замаар нь замнаж цэвэрших зүрх сэтгэл хэрэгтэй. Ийм зүрх сэтгэлтэй хүн энэ гэрэл гэгээг хүлээн авах ба энэ эргэн тойрноо тарах дэлгэрнэ. Ийм агуу хүмүүсийг Асрамжлагч (Вели) гэнэ. Энэхүү велиг таньж итгэх хайрлах хүн үүний талд зүй ёсоор сууж эсвэл алсаас хайрлан бодвол энэ хүний зүрх сэтгэл гэрэл гэгээ шим тэжээл авахаар цэвэрлэгдэж боловсорч төлөвшиж эхэлнэ. Аллаах бие махбод эд зүйлсийг үүсгэхийн тулд нарны энергийг шалтгаан болгосны адил бидний сүнс санаа, сэтгэл зүрхийг төлөвшүүлэх хүний чанарт өргөхийн тулд Мухаммед алейхисселамын зүрх сэтгэлийг, түүнээс оргилон булгилах гэрэл гэгээг шалтгаан болгожээ. Хүнийг тэжээн тэтгэн бүтэц хүчийг нь хангагч бүхий л тэжээлийн зүйлс нарны энергийг уусгаснаар үүсэн бий болох лугаа адил зүрх сэтгэл, сүнс санааны хүнс тэжээл болох Ариун номчын хэл хэлмэр үг бичвэр ч гэсэн бүхэлдээ Ресүллүллахын ариун зүрх сэтгэлээс нь оргилон ундарсан гэрэл гэгээгээр төрж гарсан бөлгөө.

Аллаах Жебрайл алейхисселам нэрт сахиусан тэнгэрээр Мухаммед алейхисселамд Кураан-и керимийг илгээсэн бөлгөө. Хүн төрөлхтөнд энэ болоод хойд ертөнцөд хэрэгтэй ач тустай зүйлийг үүнд зарлигласан билээ. Хор хөнөөлтэйг хорьж цээрлэсэн билээ. Энэхүү захирамж тушаал хорио цээрийн бүгдийг нь Ислаам шашин эсвэл Ислаамын ёс суртал , Ахкам-и илахиййе гэнэ.

Мухаммед алейхисселамын бүх үг зөв үнэ цэнэтэй ач тустай юм. Ийм гэдэгт итгэх хүнийг Мүмин буюу Мусылман гэнэ. Мухаммед алейхисселамын сурган номолсноос аль нэгнээ үл итгэх үл таалах

хүнийг Кафир гэнэ. Аллаах мүмин бологчийг хайрлан энэрнэ. Ийм хүнийг төгсгөлгүйгээр Тамд орхихгүй. Эсвэл Там руу огтоос унагахгүй эсвэл буруугаас нь болоод унагалаа ч дараа нь Тамаас гаргана. Кафир хүн Диваажинд очихгүй. Шууд Тамд орох ба тэндээс огтоос ангижрахгүй. Түүнд итгэх Ресүллалахыг хайрлах нь бүхий л аз жаргал амар тайван сайн сайхны эхлэл бөлгөө. Ресүлүллах саллаллахү алейхи ве селлемийн эрдэм мэдлэг оюун ухаан үнэнч итгэлтэй, оюун ухаан, өгөөмөр шинж, даруу төлөв зан, хурц зөөлөн, хүлцэнгүй нигүүлсэл тэвчээр, шаргуу зүтгэл, үнэнч, эх оронч зан, найдвартай байдал хатан зориг бишрэм сүрдэм дүр байдал, уран үг яриа, хурц оюун санаа, гоо сайхан, нүглээс хол ариун шударгуу явдал, нинж нигүүлсэл, хүнлэг чанар, даруу төлөв зан, хатуужил даяан нь бүхий л Пайгамбаар Элч нараас илүү их байв. Найз нөхөр ба дайснаасаа үзэх хохирол хэлмэгдлийг өршөөн хүлцдэг байв. Аль нь ч хариу барьдаггүй байв. Ухудын дайнд кяфир нар ариун хацрыг нь цус болгож шүдийг нь хугалах үед энэ үйлийг хийгчдэд Аяа Эзэн Тэнгэр минь Эд нарыг өршөөн хүлцэгтүн! Үл мэдэхүйн харанхуйг нь өршөөгтүн! хэмээн залбирсан билээ.

Мухаммед алейхисселам олон сайхан зан аашыг өөртөө агуулжээ. Мусылман хүн бүр эдгээрийг сурч сайхан аашаар нь суртахуунжих хэрэгтэй юм. Ийнхүү энэ ертөнц болоод нөгөө ертөнцөд гай гамшиг, зовлон зүдгүүрээс ангижирч хоер ертөнцийн эзэн саллаллахү алейхи ве селлемийн өмгөөлөл ивээлд орно. Яагаад гэвэл, хадис-и шерифт : “Аллаахын ёс суртахуунг дагаж ааш зангаа ол!” хэмээн зарлигласан байна.

Асхаб-и Кирам

Манай хүндэт Пайгамбаар Элчийн өлзийт дүрийг үзэж амтат үгсийг сонсох хувь ерөөл тохиосон мусульмаан нарыг Асхаб-и кирам гэнэ. Пайгамбаар Элч нараас дараа өнгөрсөн ирээдүй бүхий л хүн төрөлхтний хамгийн буянтай, хамгийн дээдийн хүмүүс нь Эбү Бекр-и Сыддык радый Аллаахү анх бөлгөө. Үүнэээс хойш хүн төрөлхтний хамгийн дээд нь Фарук-и азам хоёрдох халифе Омер бин Хаттаб, дараах хамгийн дээд нь Ресуллахын гуравдахь халифе нь иман ба сүсэг, даруу хүнлэг гэгээрэл мэдлэгийн эх ундарга болсон гэгээн Осман бин Аффан радый Аллахү анх, дараах нь хамгийн тус

буянтай нь дөрөвдөх халифе гайхамшигт дээд шинжийг эзэмшигч Аллаахын арслан Али бин Эби Талиб радыйалахү анх бөлгөө. Хадис-и шерифээс үзвэл, гэгээн Фатима, гэгээн Хатиже, гэгээн Айше, гэгээн Мерйем, гэгээн Асийе энэ ертөнцийн эмсийн хамгийн дээд нь юм. Хадис-и шерифт "Фатима Диваажингийн хатагтай нарын хамгийн дээд нь юм. Хасан ба Хусейн ч гэсэн Диваажингийн залуусын хамгийн дээд нь" хэмээн айлдсан байдаг.

Үүнээс хойш Асхаб-и кирамын хамгийн сор сондор нь Ашере-и мүбешшере юм. Диваажинд залрана хэмээн гайхамшигт мэдээ ирсэн 10 хүн байсан. Эдгээр нь гэгээн Эбү Бекр-и Сыддык, Өмер-үл-Фарук, Осман бин Аффан, Али бин Эбү Талиб, Эбү Убейде бин Жеррах, Талха, Зүбейр бин Аввам, Сад бин Эби Ваккас, Сайд бин Зейд, Абдүррахман бин Аф рыдвануллахи теаля алейхим ажмаин" дараа нь Бедрийн дайн, дараа нь Ухудад, дараа нь Би-ат-үр-рыдванд байлцагчид болно. Рсулулаахын замд амь бие, эд хөрөнгөө золиослон Түүнд туслан Асхаб-и кирамын бүгдийнх нь нэр алдрыг хүндлэн хайрлаж хэлэх нь бидэнд зайлшгүй үүрэг билээ. Тэдний агуу ихэд үл тохирох үг хэлэх нь бидний хувьд огтоос зохимжгүй. Нэрийг нь харлахгүйгээр хүндлэн хэлнэ.

Расулуллаахыг хайрлагч хүн түүний Асхабыг бүгдийг нь хайрлах хэрэгтэй. Яагаад гэвэл, хадис-и шерифт айлдахдаа: "Асхабыг нь хайрлагч намайг хайрладаг болохоор хайрлана. Тэд нарыг үл хайрлах хүн намайг үл хайрласанд тооцогдно. Тэд нарыг гомдоогч намайг ч гомдоосонд тооцогдоно. Намайг гомдоогч Аллаахыг ч гомдоосонд тооцогдоно. Аллаахыг гомдоосон хүн мэдээжээр зовлонд унана" хэмээжээ. Өөр нэг хадис-и шерифт: "Аллаах миний хамт бишрэн сүслэгч нараас нэг боолд сайн үйл хийхийг хүсвэл түүний зүрх сэтгэлд Асхабын минь хайрыг оршооно. Тэд бүгдийг нь амь шигээ хайрлана" хэмээн зарлиг болов. Манай Пайгамбаар нас нөхчөн өдөр Медине хот дахь 33 мянган Сахаба /Гэгээн Мүхаммедийн найз нөхөд/ байв. Бүх Сахаба зуун хорин дөрвөн мянгаас илүү олон байв.

Дөрвөн мезхебийн имам ба бусад мэргэд

Шүтлэг бишрэлийн /Итикад/ мэдлэгт зөв гэх цор гагц зам байдаг. Энэ нь (Эхл-и Сүннет вел-жемаат) Гэгээн Мухаммедийн

замаар явагч үнэнч сүсэгтэн нарын хүй бөлөг мезхеб буюу дэг сургууль болно. Дэлхий ертөнцөд амьдрах бүх мусылмаан нарт зөв зам зааж Мүхаммед алейхи ве селлемийн замыг өөрчилж бусниан сарниалгүйгээр мэдэж сурах шалтгаан болох дөрвөн томоохон эрхэм юм. Эдгээрээс эхнийх нь Имам-и азам Эбү Ханифе Нуман бин Сабит бөлгөө. Ислаамын номч мэргэд нарын хамгийн том нь болно. Эхл-и сүннетийн рейс ахлагч юм. Хоёрдох нь Имам-и Малик бин Энес, гуравдахь нь имам-и Мухаммед бин Идрис Шафий, дөрөвдөх нь Имам-и Ахмед бин Ханбел рахметуллахи алейхим эжмаин" билээ.

Өнөөдөр дөрвөн имаамаас аль нэгнийг нь үл дагах хүн ихэд аюулд өртөнө. Зөв замаас гажсан гэсэн үг. Бид энэхүү номондоо Ханефи мезхебийн дагуу намазтай холбогдох асуудал тэрхүү мезхебийн томоохон мэргэдийн номноос авч хялбаршуулан өгүүллээ.

Энэхүү дөрвөн имаамын /хамба/ шавь нараас хоёр нь имаамын мэдлэг эрдэмд ихэд товойн шалгарав. Ийнхүү итгэл бишрэлийн хоёр мезхеб үүсэв. Куран-и керим ба хадис-и шерифүүдэд зохих имаан нь энэ хоёр эрхэмийн өгүүлсэн имаан юм. Фирка-и хажиййе /Авралын замаа олсон хүмүүс/ болох Эхл-и сүннетийн имаан мэдлэгүүдийг дэлхий дахинд түгээгч нь энэ хоёр эрхэм юм. Нэг нь Эбү Мансүр-и Матуриди, нөгөө нь Эбүл Хасен ли Эшари юм. Энэ хоёр имаам нэг имааныг өгүүлсэн юм байх, зарим ялгаа чухал биш бөлгөө. Үнэндээ адил юм. Нэгэн аят и кэримийг утгачилвал "мэдлэгтнүүд ба эс мэдэгчид огтоос ижилсэж чадна гэж үү?"хэмээжээ. Ислаамын мэргэд Кураан-и керим ба хадис-и шерифүүдэд магтагддаг. Нэг аят-и керимэд утгачлавал, "Аяа Мусылмаан нар аа Мэдэхгүйгээ мэдэг нараас асуугтун" хэмээн зарлиглажээ.

Хадис-и шерифүүдэд: "Аллаах ба сахиусан тэнгэр нар амьд амьтан бүр хүмүүст сайн сайхныг заах мусульмаан нарт Дуа хийдэг. Шүүгдэх өдөр эхлээд Пайгамбер нар, дараа эрдэмтэн мэргэд, дараа нь шехид /шашныхаа төлөө амь үрэгдсэн мүслүман хүн/ нар өмгөөлөн зуучилна. Аяа хүмүүс ээ эрдмийг мэргэдээс дуулж сурдаг гэдгийг мэдэгтүн. Ном эрдэм сурагтун. Ном эрдэм сурах нь ибадет юм. Ном эрдэм сурагчид жихадын /шашны төлөөх дайн/ буян байдаг. Эрдэм ном заах нь садака өглөг өгөхтэй адил. Багш мэргэдээс эрдэм ном сурах нь шөнийн / техежжюд/ намааз

үйлдэх лугаа адил. Эрдэм ном сурах нь бүхий л

нэмэлт намазаас илүү буян бөлгөө. Яагаад гэвэл өөртөө ч заан сургах хүмүүст ч ач тустай бөлгөө. Бусдад заан сургахын тулд сурч буй хүнд Сыддыкчуудын буян ногдоно.

Эрдэм ном бол эрдэнэсийн сан юм. Түлхүүр оньс нь асууж сурах явдал юм. Эрдэм номыг сур сурга. Бүх зүйл эх сурвалжтай байдаг. Хатуужлын эх үндэс нь гэгээрсэн мэргэдийн зүрх сэтгэл болой. Ном эрдэм сургах нь нүглийн цагаатгал юм.

Тав дахь болзол

ХОЙТ ЕРТӨНЦӨД ИТГЭХ

Вел йевмил ахири: Хойт ертөнцийн өдөрт итгэлээ гэсэн үг. Энэ цагийн эхлэл хүний үхэх өдөр юм. Энэ ертөнцийн төгсгөл хүртэл үргэлжилнэ. Сүүлчийн өдөр гэдэг нь хойно нь шөнө үл болох учраас тэр юм. Эсхүл дэлхийн амьдрал дууссаны дараа ирдэг тул тийм бөлгөө. Энэ ертөнцийн төгсгөл хэзээ болохыг тодорхой товлон заагаагүй. Гэхдээ Манай Пайгамбаар элч саллаллахү алейхи ве селлем олон бэлгэ тэмдгийг мэдэгдсэн билээ. Гэгээн Мехди ирнэ. Иса алейхисселам Шам Дамаскд эргэж заларна. Дежжал / Мүхаммедийн эсрэг тэмцэл/ гарч ирнэ. Йежүж Межүж гэх хүмүс газар бүрийг хольж булхана. Нар баруун зүгээс гарна. Газар ихээр хөдлөнө. Шашны ном эрдэм мартагдна. Нүгэл муу муухай ихсэнэ. Хараамыг газар сайгүй үйлднэ: Йемэнд гал гарна. Тэнгэр огторгуй уул нурууд задран хуваагдна. Нар саран харанхуйлна гэх мэт.

Булшинд асуулга болно. Булшинд Мүнкер ба Некр сахиус тэнгэрүүдэд хариу болгож эдгээрийг цээжлэх ёстой ба хүүхдүүддээ ч гэсэн цээжлүүлэх хэрэгтэй. Эзэн Тэнгэр минь Аллаах,, Пайгамбаар минь Мухаммед алейхисселам, шашин минь ислаам, судар минь Кураан-и керим, кыбле минь Каабе-и шериф , итгэл бишрэл дэхь мезхеб минь Эхл-и сүннет вел-жемаат, үйл үйлдлийн мезхеб минь Имам-и аазам Абу Ханифе мезхеб. Аймшигт шүүлтийн өдөр хүн бүхэн амьдарна. Шүүгдэх газар цугларна. Номын ёсоор амьдрагчдын үйл үйлдлийн дэвтрүүд баруун талаас, муу хүмүүсийн хойд ба зүүн талаас ирнэ. Олон тэнгэртэй байх ба тэрслүү буюу кафирээс өөр бүх нүглийг Аллаах хүсвэл өршөөнө нэг бол бага нүглийн төлөөнөө ч биднийг гэсгээнэ.

Үйл үйлдлийг жигнэн хэмжихийн тулд Мизан /жинлүүр/ байна. Сиратын гүүр Аллаахын зарлигаар Тамд татагдна. Хүндэт Мухаммед Мустафа саллаллахү алейхи ве селлемд зориулагдсан Кеусерийн цөөрөм байна.

Шафагат ба өмгөөлөл үнэн юм. Наманчлалгүйгээр нас нөгчсөн мүминчүүдийн бага их нүглийг өршөөхийн тулд Пайгамбаар, Вели нар номын ёсч нар, мэргэд болоод сахиусан тэнгэр нар, шехид нар Аллаахын зөвшөөрөн хүлцсэн зуучлал өмгөөллийг хийх ба хүлээн зөвшөөрөгднө.

Диваажин Там одоо байна. Диваажин долоон давхар тэнгэр огторгүйн дээр байна. Там бүхний доор байна. Диваажингийн найман хаалга бий. Хаалга бүрээр нэг Диваажинд орно. Там долоон давхар юм. Нэгдэх давхраас долдугаар давхар хүртэл зовлон хүчирхэгжинэ.

Зургаа дахь болзол
ХУВЬ ТАВЬЛАНД ИТГЭХ

Ве бил-кадери, хайрихи ве шеррихи миналлахи теаля: Хувь тавилан дахь сайн ба муу Аллаахаас ирэлтэйд итгэлээ гэсэн үг. Хүнд ирэх сайн ба муу ач тус ба хор хохирол ашиг хохирол бүгдээрээ Аллахын таалсанчлан болно.

Аллаахын нэгэн зүйлийн оршихуйг ерөөн болгоосныг хувь ерөөл гэнэ. Хувь ерөөл өөрөөр хэлбэл ахуйг болгоосны зүйл оршин буй болохыг каза гэнэ. Хувь ерөөл ба каза гэх үгс нэг нь нөгөөгийнхөө оронд ч хэрэглэгднэ.

Аллаах боол нартаа зориг эрмэлзэл (ираде) өгсөн ба энэхүү зориг эрмэлзлэлээ ерөөн болгоолтоо үйл хэргийг бүтээх шалтгаан болгожээ. Нэг боол нэг зүйл хийхийг хүсч улмаар Аллаах хүсвэл тэр үйлийг бүтээнэ. Боол хүсэхгүй бол Аллаах хүсэхгүй ба тэр зүйлийг бүтээхгүй.

Энд хүртэл товч өгүүлсэн Эхл-и сүннет итгэл бишрэлийг илүү өргөнөөр сурахыг хүсэгчид чин үнэн хэвлэлийн хорооны хэвлэсэн ислаам мэргэдийн оройн чимэг Их Вели Мевлана Халид Багдадийн перс хэлээр Итикаднаме хэмээх номыг Кемахли Фейзүллах ноёны орчуулга Хүн бүхэнд хэрэгтэй иман хэмээх номыг уншигтун. Машид ач тустай маш гайхалтай сайхан бүтээл

бөгөөд шим тэжээллэг элбэг хангалуун байдал нь хоёр ертөнцийн аз жаргалд хангалттай хүрэлцэх юм.

Аллаах хүн бүрт хувь тавиландаа хангалуун байхыг захирамжилсан бөлгөө. Хувь тавиландаа хангалуун байхыг (тевеккюл) нь имааны болзол утгачлавал айет-и кериме нь энэхүү захирамжийн нэг нь бөлгөө. Сүре-и Майдед (Хэрвээ итгэн сүслэж байгаа бол та бүхэн Аллаахд итгэгтүн!) Сүре-и Али имранд (Аллаах хувь тавиландаа хангалуун байгчдыг мэдээжээр хайрлна). Сүре-и Талакд хэн нэгэн (Аллаахд өөрийгөө даатгавал түүний хувьд хангалттай) юм. Сүре-и Зүмерд (Аллах боолдоо хангалттай биш гэж үү ?) гэх ойлголтоор илүү олон айет-и кериме байдаг.

Расуллуллаах саллаллахү алейхи ве селлем айлдаруун: “Миний сүслэн дагагчдаас нэг хэсгийг нь надад үзүүллээ. Уул цөлийг дүүргэсэн байв. Ийм олон байгаад гайхаж баярллаа. Баярлав уу? гэхэд нь тиймээ гэлээ. Эднээс зөвхөн далан мянга нь тооцоогүй диваажинд орно гэж хэлцгээв тэд нар. Эд аль вэ хэмээн асуув. Үйлдээ ид шид мэргэ төлөг үзмэр үл хутгаж Аллаахаас бусдад нь өөрийгөө даатгаж итгэдэггүй хүмүүс үл итгэгчид хэмээ”. Сонсогчдын дунд Үхаше радиаллахү анх босоод /Аяа Рсуллаллаах дуа айлдагтун, тэдний нэг нь болоё хэмээнгүүт (Аяа Эзэн Тэнгэр минь үүнийг тэдний нэг болго!) хэмээв. Нэг хүн босч тэрхүү Дуаг хүсэнгүүт (Үкаше чамаас авхаалжтай байлаа) гэв.

Тевеккүл нь шалтгаанд хандаж илүү дутуу зүйлийн төлөө сэтгэхүйгээ ядраахгүй байх явдал бөлгөө.

Хоёр дугаар бүлэг

• ИБАДЕТ БА НАМАЗ •

Ибадет гэж юу вэ?

Ибадет мөргөл биднийг ба бидний байгаа байдлыг оргүй хоосноор бий болгогч мөч хором бүр ахуйд байлгагч үзэгдэх, үл үзэгдэх осол аюул, гай гамшигаaас хамгаалах мөч агшин бүр төрөл бүрийн буян хишиг /нимет/ сайн үйл өгөөд хүмүүжүүлэгч Аллаахын зарлиг хорио цээрийг биелүүлэх явдал юм. Аллаахын хайр энхрийлэлтэй золгосон Пайгамбаарууд, ариун номч нар мэргэдийг тэмүүлэн дуурайх явдал юм.

Хүний өөрт нь тоо томшгүй олон тооны буян хишиг илгээсэн Аллаахд хүч нь хүрэх хэмжээнд талархах /шүкр/ нь хүний ёсны үүрэг юм. Оюун ухаанаас тушаасан үүрэг төлөөс болно. Гэвч хүмүүс өөрийн дутагдалтай оюун ухаан богино бодлоороо Аллаахд хандсан талархал хүндэтгэл болох зүйлийг олж чадахгүй. Талархаж хүндэтгэл үзүүлэхэд тохирох үүргүүдийг Аллаах заагаагүй бол магтаал гэж санагдах зүйлс туушаал болж байна.

Ийнхүү хүмүүсийн Аллаахд зүрх сэтгэл, хэл, биеэрээ хийх итгэх хэрэгтэй зүйлс шүкрийн өр боолын үүргийг Аллаах заасан ба Түүний хайрт Пайгамбаар гаргаж тавьсан болно. Аллаахын үзүүлсэн тушаасан боолын даалгавар үүргийг Ислаамын ёс гэнэ. Аллаахд талархахуй нь Түүний илгээсэн Пайгамбаарын зам мөрийг даган зохицсоноор бий болно. Энэ замд нийцээгүй, үүний гадна үлдэх ямар ч шүкр ямар ч ибадетийг Аллаах хүлээн зөвшөөрч таалахгүй. Яагаад гэвэл хүмүүсийн сайн сайхан гэж боддог олон зүйл байх ба Ислаамын ёс үүнийг таалдаггүй ба муухай гэж хэлж байна.

Ийнхүү эрүүл ухаантай хүн Аллаахд талархан ибадет хийхийн

тулд Мухаммед алейхисселамд зохицон дагах хэрэгтэй. Мухаммед

алейхисселамд зохицон дагах хүн мусылмаан байх ёстой. Ислаамын ёс хоёр хэсгээс тогтоно.

1. Зүрх сэтгэлээрээ итгэн бишрэх хэрэгтэй зүйлс
2. Бие сэтгэлээрээ хийх залбирал мөргөлүүд.

Биеэрээ үйлдэх ибадетийн хамгийн дээд нь намааз юм. Мүкеллеф болох муслумаан хүн бүр өдөрт таван удаа намааз үйлдэх нь фарз юм.

Хэнийг мүкеллеф гэх вэ?

Эрүүл ухаантай идэр насанд хүрсэн эрэгтэй эмэгтэй хүнийг мүкеллеф /үүрэгтэн/ гэнэ. Мүкеллеф болсон хүн Аллаахын тушаал хорио цээрийг хүлээн авч хариуцлага үүрэх болно. Манай шашинд мүкеллеф хүнд эхлээд итгэн сүслэх дараа нь ибадет хийхийг зарлигласан байна. Үүнээс гадна цээрлэж хорьсон хараам болоод мекрүх үйлээс зайлсхийх ёстой.

Оюун ухаан нь эрүл саруул байх нь ойлгох хүч болно. Ач тустайг хор хөнөөлтэйгээс ялгахын тулд бүтээгдсэн юм. Оюун ухаан нь хэмжих багаж мэт. Хоёр сайн зүйлээс илүү сайныг нь хоёр муу зүйлээс илүү мууг нь ялгана. Ухаантай хүн зөвхөн сайн мууг ялгах төдийгүй сайныг харангуут түүнийг авч мууг үзэнгүүт түүнийг хаяж гээнэ. Оюун ухаан нүд адил. Ислаамын суртахуун гэрэл мэт. Гэрэл үгүй бол нүд харахгүй.

Идэр нас гэдэг нь шилжилтийн нас гэсэн үг. Эрэгтэй хүүхдийн шилжилтийн нас 12 насанд хүрэхэд эхэлнэ. Эрэгтэй хүүхдийн идэр насанд орж буйг заах шинж тэмдэг байдаг. Энэ шинж тэмдэг үзэгдэхгүй бол арван таван нас хүрсэн бол идэр насанд хүрсэн хэмээн тооцно. Эмэгтэй хүүхдийн идэр нас 9 нас хүрэх үед эхэлнэ. Есөн настай эмэгтэй хүүхдийн шилжилтйн насанд хүрснийг заах ямар ч тэмдэг бэлгэ огтоос үзэгдэхгүй бол арван таван нас гүйцэд дуусахтай зэрэг шилжилтийн насанд орсон хэмээн үзнэ.

Мүкеллефчүүдийн үйл үйлдэл ба /Ефал-и Мүкеллефин/ /Ахкам-и Исламиййе/

Ислаам шашны заасан захирамж хориог (Ахкам-и шериййе) буюу (Ахкам-и исламийе) гэнэ. Эдгээрийг (Ефал-и мүкеллефин)

ч гэнэ. Эфалин Мүкеллефин найм байна. Фарз /гарцаагүй/, уажиб /зайлшгүй/, сүннет /уламжлалт/, мустехаб /сайшаагдах/, мубах / зөвшөөрөгдсөн/, харам /цээрлэгдсэн/, мекрүх /бузар бөөдий/ муфсид
/жигшүүртэй/ болно.

1. ФАРЗ: Аллахын хийхийг аят-и керимегээр ил тод батлан захирамжилсан зүйлсийг фарз гэнэ. Фарзыг орхих нь хараам юм. Фарзад үл итгэж хийхийг чухал гэж үл үзэх хүн кафир болно. Хоёр төрөл фарз байна.

2. УАЖИБ: Хийх нь фарз мэт зайлшгүй тушаамжийг хэлнэ. Энэхүү захирамжийг Күран-и керим дэх нотолгоо шиг ил тодорхой бус байна. Эргэлзээтэй нотолгоогоор тогтмол байна. Витр намаз ба Баярын намаазыг үйлдэх баян чинээлэг болбол курбаан төхөөрөх фитре/садака-и фитр/ өгөх нь важиб болно. Важибын заалт фарз мэт болно. Важибийг хааяа орхих нь хатуу буюу тахримен мекрүх юм. Важиб болоход үл итгэгч кяфир болохгүй. Гэхдээ үл хийгч Тамын зовлонд унана.

3. СҮННЕТ: Аллах ил тодорхойгоор заахгүй ч гэлээ зөвхөн Хүндэт Пайгамбаарын хийхийг магтаж эсхүл өөрийнх нь байнга үргэлжид хийж байсан эсвэл бусдын хийхийг хараад таалсан зүйлийг сүннет хэмээнэ. Сүннетийг таалахгүй байх нь кафир болно. Таалах боловч таслан зогсоогоогүй бол зовлонд хүн үл унана. Гэхдээ шалтгаагүйгээр үргэлжид хаяж орхих хараагдах, зовлонд орж буянаа алдахад хүрнэ. Жишээ нь азаан унших, камет унших, хүй бүлэгтэй цуг намааз үйлдэх, абдест авахдаа шүд цэвэрлэгч / мисвак/ хэрэглэх, гэрлэсэн шөнөө бусдыг хооллох, хүүхдийнхээ хөвчийг тасдуулах гэх мэт. Сүннет хоёр төрөл байна.

Сүннет-и Мүекке: Бидний Хүндэт Пайгамбаарын үргэлж хийдэг маш цөөн удаа орхиж байсан хүч нөлөөтэй сүннетүүд болно. Өглөөний намаазын сүннетүүд, үдийн намаазын анхны ба сүүлийн сүннетүүд, үдшийн намаазын сүннет, шөнийн намаазын сүүлийн хоёр рекат сүннетүүд юм. Эл сүннетүүдийг шалтаггүйгээр хаяж огтоос болохгүй. Үл таалагчид кафир болно.

Сүннет-и Гайри Мүеккеде: Бидний Хүндэт Пайгамбаар ибадетийн зорилгоор хааяа хийж байсан үйлдэл юм. Оройн болоод шөнийн намаазын дөрвөн рекат анхны сүннетүүд ийм юм. Эд ихэнхдээ олон удаа орхилоо ч ямар нэг зүйл хэрэгтэй болохгүй.

Шалтаггүйгээр бүхэлд нь хаявал өмгөөлөл зуучлалаа алдах

шалтгаан болно.

Тав арван хүнээс нэг нь үйлдвэл бусад мусылмаан нар гүйцэтгэхгүй байх сүннетийг Сюннет-и алел-кифайе хэмээнэ. Мэндлэх итгэн шүтэх гэх мэт болно. Авдест авах идэх уух ариун үйл болгоныг эхлэхдээ Бисмиллаа унших нь сүннет бөлгөө.

4. МУСТАХАБ: Үүнийг мендүб /зарлиглаагүй боловч хийх үйл/, адаб /ёс зүйн дүрэм/ ч гэнэ. Сүннет-и гайри мүеккеде заалттай байна. Хүндэт Пайгамбаарынн амьдралдаа нэг хоёр удаа ч болов хийж хийхийг хүсч таалдаг байсан зүйлс юм. Шинэ төрсөн хүүхдэд нэр өгөх, хүү, охиндоо зориулж акика /шинэ төрсөн хүүхдэд Аллаах Эзэнд талархан мал төхөөрөх/, сайхан хувцаслах, сайхан үнэртэн түрхэх нь мүстехаб юм. Эдгээрийг хийгчдэд их буян ногдно. Үл хийгчид зовлонд орохгүй. Өмгөөлөл зуучлалаа ч алдахгүй.

5. МУБАХ: Үйлдэхийг тушаагаагүй бас хориогүй зүйлсийг мубах гэнэ. Өөрөөр хэлбэл нүгэл ба мөргөн залбирах нь өгүүлж мэдүүлээгүй зүйлс болно. Сайн санаагаар үйлдвэл буян, муу санаагаар үйлдвэл зовлон болдог. Унтах, шашинд зөвшөөрөгдсөн янз бүрийн хоол идэх бас халаал болох янз бүрийн хувцас өмсөх тэргүүтэн үйлдэл мубах юм. Энэ нь Ислаамын ёсонд зохицох тушаал зарлигт тойрох зорилгоор хийгдвэл буян болно. Эрүүл энх байж ибадет хийхээр нийет /санаа зорин/ хийж идэх уух ч мөн ийм юм.

6. ХАРААМ: Аллаахын Кураан-и керимд хийхийг цээрлэн хориглосон зүйлс болно. Хараамыг хийх хэрэглэхийг хөдөлшгүй лавтайгаар хориглон цээрлэсэн байдаг. Хараамыг халал хэмээгчийн халаалыг хараам гэгчийн имаан нь зайлж кафир болно. Хараам болох зүйлсийг орхин гээх тэднээс зайлсхийх нь фарз бөгөөд их буян юм. Хараам нь хоёр төрөл байна.

Харам ли-айнихи Хүн хөнөөх, буруу хурьцах, бандидан шуумарлах, мөрийтэй тоглох, дарс болоод бүх төрлийн согтууруулах ундааг уух, худал хэлэх, хулгай хийх, гахайн мах идэх, цус , сэг идэх, эмс охид толгой түрүү гар хөл гуя хас задгайгаар гадагш гаргах хараам бөгөөд үлэмжийн нүгэл юм. Хэн нэгэн эдгээр нүглийг үйлдэхдээ Бисмиллаа уншвал эсвэл халаал гэж итгэн биширвэл өөрөөр хэлбэл, Аллаахын хараам гэсэн зүйлийг чухалд тооцвол кафир /тэрслүү/ болно. Эдгээрийн хараам гэдгийг итгэж

эмээж гэлмэж хийвэл кафир болохгүй. Гэхдээ Тамын зовлонд

унана. Хэрвээ зориудаар гэмшилгүй нас барвал итгэл сүсэггүй таалал төгсөх шалтгаан болно.

Хараам ли-гайрихи Эдгээр нь уг чанартаа халаал боловч бусдын эрхээс болоод хараам болсон зүйл юм. Жишээ нь нэг хүний цэцэрлэг рүү орж эзний зөвшөөрөлгүйгээр жимсийг нь таслан авч идэх, гэрийн эд хогшил мөнгийг нь хулгайлан хэрэглэх, даатгал итгэлд урван тэрслэх, хээл хахууль, мөнгөний хүү болон мөрийн бооцоогоор эд хөрөнгө мөнгө хожих гэх мэт. Эдгээрийг хийгч хүн хийхдээ Бисмиллаа уншвал эсвэл халаал гэвэл кафир болохгүй. Яагаад гэвэл тэр хүний эрх бөгөөд буцааж авна. Тав хагас арвай /нэг данг/ жинтэй мөнгөний үнэ хүрэх эрхийн төлөө маргааш шүүгдэх өдөр хүй рүгээ хамт үйлдсэн долоон зуун рекат хүлээн зөвшөөрөгдсөн намаазын буянг Аллаах буцаан авч эрхтэй хүнд нь өгнө. Хараамаас дөлөх ибадет хийхээс илүү их буян юм. Тиймийн тул хараамыг мэдэж зайлсхийх хэрэгтэй.

7. МЕКРУХ: Аллаахын ба Мухаммед алейхисселамын үл таашаадаг ибадетийн буянг нь үгүй хийдэг байсан зүйлийг мекрүх гэнэ. Мекрүх хоёр төрөл байна.

Тахримен мекрух : Хараамд ойрхон мекрүх юм. Эднийг хийгч зовлонд унана. Нар мандах үед буюу яг уулан дээр байхад нар шингэхэд намаз хийх гэх мэт. Үүнийг зориуд хийгч тэрслэн босогч кафир болно. Тамын зовлонд унана. Намаазд важибуудыг орхигч тахрими мекрүхийг үйлдэгчийн тэрхүү намаазыг дамжуулан өгөх нь важиб болно. Хэрвээ мартаад алдаа хийвэл намаазын дунд сежде-и сехв хийнэ.

Тензихен мекрүх: Мубах өөрөөр хэлбэл халал болох үйлд ойр байх өөрөөр хэлбэл, хийхгүй байх нь хийхээсээ илүү сайн байх үйл хэрэг болно. Гайри мүеккед сүннетүүд эсвэл мустехабуудыг үл хийх гэх мэт.

8. МУФСИД: Манай шашинд зөвшөөрөгдсөн нэг үйл хэрэг эсвэл эхэлсэн ибадетийг бусниан сарниах зүйлс. Имаан ба намааз, сүй, хаж явах, зекят өглөг, худалдан авах зарахыг бусниан зогсоох гэх мэт. Жишээ нь Аллаахын судрыг хачлан хараах нь күфир бөгөөд имааныг зайлуулна. Намааз хийх үедээ инээх нь абдест, намаазыг бусниана. Мацаг барьж байхдаа мэдсээр байж идэж уувал мацаг буснина.

Фарз, уажибууд, сүннетүүдийг хийгчдэд мөн харам мекрүхаас

болгоомжлогчдод төлбөр өөрөөр хэлбэл буянтан болно. Хараам, мекрүхыг хийж фарз важибуудыг үл хийгчид нүгэлтэн болно. Нэг хараамаас болгоомжлохын буян нэг фарз хийхийн буянаас хэд дахин олон юм. Нэг фарзын буян нэг мекрүхээс болгоомжлохын буянаас их юм. Мекрүхээс болгоомжлохын буян нь сүннетийн буянаас илүү юм. Мубахын дотор Аллаахын дуртай байсныг нь Хайрет ба Хасенат гэнэ. Эдгээрийг хийгчдийг буян ногдох ч энэ буян сүннетийн буянаас бага юм.

• ИСЛААМЫН ДАЙСНУУД •

Ислаамын дайснууд ислаамын ёсыг үгүй хийхийн тулд Эхл-и сүннет,сударт довтолж дайрч байна. Кураан-и керимын Майде сүред зургаадах бүлгийн сүүлчийн хуудсанд (Ислаамын хамгийн том дайсан бол жүүд нар болоод мүшрикүүд хэмээн зарлигдаж байна). Мүшрик нь онгон болоод хөшөө барималд тахин шүтэх кафир нар юм. Христийн шашинтан нарын дийлэнх нь мүшрик болох нь тодорхой юм. Йемений Абдүллах бин Себе нэрт жүүд Эхл-сүннетийг үгүй хийхийн тулд Ший урсгалыг/тарикат/ үүсгэжээ. Ший нар өөрсдийгөө Алеви гэнэ. Ислаам шашны дайсан Англичууд эзэнт улсын хүчээрээ Энэтхэг хийгээд Африкаас цуглуулан хураасан алтаараа цуст дайн тулаанаараа Веххабын ёс хэмээн нэрлэсэн худал хуурмагаар дүүрэн номуудаараа Эхл-и сүннет рүү дайран довтолж байна. Дэлхийн газар орон болгонд мөнхийн аз жаргалд хүрэхийг хүсэгчид ший болоод ваххаби номонд үл мэхлэгдэн Эхл-и сүннетийн эрдэмтэн мэргэдийн ном сударыг тойрон хүрээлэхийг бид бүхэн зөвлөж байна.

• ИСЛААМЫН БОЛЗЛУУД •

Ислаам шашинд орогч нарт өөрөөр хэлбэл мусылмаан нарт фарз болох зайлшгүй хийх хэрэгтэй таван үндсэн үүрэг байдаг.

1. Ислаамын шартуудаас эхнийх нь Келиме-и шехадетийг хэлж, итгэх явдал мөн. Келиме-и шехадет хэлэх гэдэг нь Ешхедү эн ла илахе иллаллах ве эшхедү енне Мүхаммеден абдүхү ве ресулүх гэж хэлэх гэсэн үг. Өөрөөр хэлбэл оюун ухаантай

идэр насанд хүрсэн ярьж чадах хүн Тэнгэр газарт Аллаахаас өөр ибадет хийх эрх бүхий тахин тавиглах ёстой хэн ч юу ч байхгүй. Жинхэнэ тахилах нь зөвхөн Аллах юм гэж хэлнэ. Тэрбээр важиб-юл вужуд юм. Бүхий л дээд чанар түүнд байна. Түүнд ямар ч алдаа дутуу үгүй. Түүний алдар Аллаах юм хэмээж тууштайгаар итгэх хэрэгтэй. Түүнчлэн тэрхүү сарнайн өнгөт цагаан улаан гилгэр дулаахан царайтай хар хөмсөг хар нүдтэй ариун магнай нь тэнэгэр сайхан аашт сүүдэр нь газарт үл тусах зөөлөн амтат үгт Араб нутагт Меккед төрсөн тул Араб гэгдэх Хашимийнхны үр Абдүллахын хөвгүүн Мүхамммед алейхисселам, Аллаахын боол расул өөрөөр хэлбэл Пайгамбаар Элч юм. Вехебин охин болох гэгээн Аминегийн хөвгүүн бөлгөө.

2. Ислаамын таван болзлын хоёрдох нь фарзтай зохицон өдөр бүр таван удаа цаг нь болоход намааз үйлдэх явдал мөн. Мусылмаан хүн болгон өдөр бүхэн цаг хугацаа нь болохуйд таван удаа намааз үйлдэж бүгдийг нь цаг хугацаандаа хийдгээ мэдэх нь фарз юм. Намаазын фарз, уажиб, сүннетийг анхаарч зүрх сэтгэлээ Аллаахд өгч цаг хугацаа нь өнгөрөөгүй байхад хийх хэрэгтэй. Кураан-и керимд намааз нь /Салат/ хэмээгднэ. Салат нь толь бичигт хүний дуа унших сахиусан тэнгэр нарын Аллах Эзнээс өршөөл хүсэх / истигфар/ Аллах өршөөн нигүүлсэхүй гэсэн үг юм. Ислаамын ёсонд Салат гэх нь исламын үндсэн мэдлэгийн ном сударт заасан байдлаар тодорхой үйл хөдлөлийг хийх тодорхой зүйлсийг унших гэсэн үг юм. Намаз үйлдэхэд Ифтитах текбирээр эхэлнэ. Өөрөөр хэлбэл эрэгтэйчүүд гараа чих тийш аваачиж хүйсний доод талд буулгахад Аллааху акбаар гэж хэлж эхэлнэ. Сүүлчийн суултанд толгойгоо баруун ба зүүн мөрөнд буулгаж мэндчилж дуусгана.

3. Ислаамын таван болзлоос гуравдахь нь эд хөрөнгийн зекят ба өргөл өгөх явдал юм. Зекятын толь бичгийн утга нь цэвэрлэх магтах сайн сайхан байдалтай болох гэсэн үг. Исламын ёсонд зекят гэх нь хэрэгцээнээсээ илүү их мөн Нисаб гэгдэх тодорхой хязгаарын хэмжээнд Зекятын эд хөрөнгөтэй байх хүн эд хөрөнгийнхөө тодорхой хэсгийг салгаж Кураан-и керимд заасан ядуу мусылмаан нарт өгнө гэсэн үг. Зекятыг долоон төрлийн хүмүүст өгнө. Дөрвөн мезхебд ч гэлээ дөрвөн төрлийн зекят эд

таваар байна. Алт ба мөнгөн зекят , худалдааны эд таваарын зекят, жилийн хагасаас нь илүүтэй хөдөө талд бэлчсэн дөрвөн хөлт нядалгааны малын зекят, тариалангийн талбайгаас авсан ургацын зекят юм. Энэ дөрөв дэх зекятыг Үшир гэнэ. Газраар ургац авангуут үшрийг өгнө. Бусад гурван зекят нисабын хэмжээ болох тул нэг жилийн дараа өгнө.

4. Ислаамын дөрвөн болзлоос дөрөв дэхь нь Рамазаан-и шериф сард өдөр бүр мацаг барих явдал юм. Мацаг барихыг Савм гэнэ. Савмыг толь бичигт нэг зүйлийг нөгөө зүйлээс хамгаалах гэсэн утгатай. Ислаамын ёсонд болзлыг ажиглан Рамазаан сард Аллаах зарлигласан тул өдөр бүр гурван зүйлээс өөрийгөө хамгаалах гэсэн үг. Энэ гурван зүйл нь идэх, уух, хурьцал үйлдэх юм. Рамазан сар тэнгэрт тухайн сарын шинэ сар үзэгдсэнээр эхэлнэ. Хуанлигаар урьдаас тооцоо хийснээр эхлэхгүй.

5. Ислаамын таван болзлын тавдахь нь чадал боломж байвал амьдралдаа нэг удаа хаж явах явдал юм. Зам найдвартай бие махбод эрүүл байж Мекке-и мүкерреме хотод явж ирэх хүртэл хойноо үлдээсэн үр хүүхдээ амьдрахад хүрэлцэх эд хөрөнгөнөөс илүүд үлдсэн мөнгөөр тийшээ явж ирж чадах хэн нэгэн амьдралдаа нэг удаа хажын хувцастайгаар Кабе-и муаззамаг тойрч, Арафат ууланд зогсох нь фарз юм.

Дээр заасан ислаамын таван болзлоос хамгийн дээд нь Келиме-и шехадет хэлэх, утганд нь итгэх явдал юм. Үүний дараах ариун дээд үйл нь намааз үйлдэх юм. Дараа нь мацаг барих, хаж хийх юм. Хамгийн сүүлд нь зекят өгөх бөлгөө. Келиме–и шехадетийн хамгийн дээд болох нь үг санал нэгтэйгээр заагдсан. Үлдсэн дөрвийн дээдийн зэрэг нь эрдэмтэн мэргэдийн олонхийн үг хэл дээр бидний өгүүлсэн мэт бөлгөө. Келиме-и шехадет мусылмааны ёсны эхлэлд хамгийн анх фарз болсон. Таван удаагийн намааз бисетийн буюу Пайгамбаар илгээгдсэний арван хоёрдох жилд хижретээс нэг жил хэдэн сарын өмнө мираж шөнө фарз болов. Рамазан-и шериф мацаг хижретийн хоёрдох жилд Шабан сард фарз болов. Зекят өгөх мацагийн фарз болдог жил Рамазан сарын дундуур фарз болов. Хаж аялал хижретийн ес дэхь жил фарз болов.

Гуравдугаар бүлэг



• НАМААЗ ҮЙЛДЭХ •

Манай шашинд имааны дараа хамгийн хүндтэй ибадет бол намаз билээ. Намаз нь хамгийн дээд ибадет мөн. Ислаамын хоёрдох шарт /болзол/ юм. Араб хэлээр намаазыг Салат гэнэ. Салат нь угтаа дуа залбирал, нигүүлсэл ,өршөөл хүсэх гэсэн үг. Намаазд энэ гурван утга цөмөөр багтах тул салят гэжээ.

Аллахын хамгийн ихээр таалж дахин дахин захирамжлан тушаадаг зүйл бол таван удаагийн намааз юм. Аллаахын мусылмаанчуудад итгэн сүслэсний дараах хамгийн чухал тушаал нь намааз үйлдэх юм. Манай шашинд анх тушаагдсан фарз ч намааз байдаг. Шүүгдэх өдөр ч имааны дараа анхны асуулт намаазын талаар байх болно. Таван удаагийн намаазын тайланг өгсөн хүн бүхий л бэрхшээл сорилоос чөлөөлөгдөж диваажинтай золгох нь намаазыг зөв үйлдэхтэй холбоотой.

Зөв намааз үйлдэхйн тулд эхлээд алдаагүй абдест авах хэрэгтэй ба хайхрамжгүй үлбэгэр байлгүйгээр намаазаа эхлэх хэрэгтэй. Намаазын үйл хөдлөл бүхнийг хамгийн сайн хэлбэрээр хийхийг оролдох хэрэгтэй.

Бүхий л ибадетүүдийг өөртөө агуулж хүнийг Аллаахд хамгийн ихээр ойртуулан хөтлөгч буянт сайн үйл нь намааз юм. Бидний хайрт Пайгамбаар элч саллаллахү алейхи ве селлем айлдруун: “Намааз нь шашны тулгуур багана юм. Намааз үйлдэгч хүн шашнаа хүчирхэгжүүлнэ. Намааз эс үйлдэгч мэдээжээр шашнаа бусниана” Намаазыг зөв хийж хүндлэл хүртэх хүн муухай муу зүйл хийхээс аврагдах болно. Анкебут сүрегийн дөчин тавдугаар аятад утгачилбал “Зөв хийсэн намаз хүнийг муухай өөдгүй муу хориотой үйл хийхээс хамгаална” хэмээн зарлигласан байна. Хүмүүсийг муу муухайгаас үл холдуулах намаз үнэн зөв намаз биш

билээ. Өнгөц гүехэн намааз болно. Үүний хамтаар зөв намаз хийх хүртлээ өнгөн гүехэн намаазыг ч орхихгүй байх хэрэгтэй. Ислаамын мэргэд /нэг зүйлийг бүгдийг нь хийхгүй байлаа гэхэд бүхлээр нь алдахгүй байх хэрэгтэй/ хэмээн айлдсан байдаг. Хязгааргүй буян хишгийг эзэгнэгч бидний Эзэн Тэнгэр /Рабб/ янагуух үзэгдлийг үнэн хэмээн зөвшөөрч болно. Ийм буруу намааз хийхээр огтоос үл хий гэж хэлж болохгүй. Ийнхүү буруу үйлдсэнээс зөв үйлд гэж хэлж бурууг нь засах хэрэгтэй. Энэ нарийн шинжийг зөв ойлгох хэрэгтэй.

Намаазыг хүмүүстэй цуггаа хийх хэрэгтэй. Хамтаар үйлдэх нь ганцаар үйлдхээс илүү буянлаг юм. Намаазд хүний эрхтэн бүр даруу байх зүрх сэтгэл ч гэсэн Аллаахаас эмээж байх хэрэгтэй. Хүнийг энэ ертөнц ба нөгөө ертөнцөд гай гамшиг бэрхшээлээс аврах нь зөвхөн намаз хийснээр болно. Аллаах Мүминун сүрегийн эхэнд утгачлавал “Мүминчүүд мадаггүй аврагдна. Тэд намаазаа хайр айдас хослуулж үйлдэгчид болно” хэмээн зарлигласан байна.

Аюул занал, айдас хүйдэстэй газар үйлдэх ибадетийн үнэ хүнд олон дахин нэмэгднэ. Дайсан довтлох үед цэргийн өчүүхэн зүтгэл маш их хүндтэй болно. Залуусын ибадет хийх нь ийм учир илүү үнэ цэнэтэй болно. Яагаад гэвэл хүсэл тачаалын муу хүслээ таслан ибадет хийхгүй байх хүслээ сөрж дайтаж байна.

Залуу цагт хүнтэй сөргөлдөх гурван дайсан түүний ибадет хийлгэхийг хилсдэггүй. Энэ нь чөтгөр хүсэл тачаал ба муу нөхөр болно. Бүхий л муу муухайн эхлэл нь муу нөхөр байна. Залуу хүн эдгээрэс муу хүсэлд баригдалгүйгээр намаазаа үйлдэж ибадетээ орхихгүй бол их үнэ хүндтэй болно. Настай хүний хийх ибадетээс хэд дахин илүү буян хураана. Цөөн тооны намаазаар их хэмжээний шан харамж хүртнэ.

• НАМААЗ ХЭНД ФАРЗ БОЛДОГ ВЭ? •

Намаз үйлдэх нь ухаан бүтэн идэр насанд хүрсэн бүх эрэгтэй эмэгтэй мусылмаанд фарз юм. Намааз фарз буюу гарцаагүй болохын тулд гурван болзол нөхцөл байдаг

- Мусылман байх
- Ухаан саруул байх
- Идэр насанд хүрсэн байх

Манай шашинд ухаан бүрэн бус шилжилтийн насанд хүрээгүй бага балчир хүүхэд намаз үйлдэх үүрэг хүлээхгүй. Гэхдээ ээж аав хүүхэддээ шашны мэдлэгийг зааж ибадет үйлдэхэд дасган сургах хэрэгтэй. Манай Пайгамбаар элч саллАллахү алейхи ве селлем айлдаруун: “Та нар бүгдээрээ мал сүргийн эзэн мэт Хоньчин сүрэг малаа хамгаалдаг шиг та нар гэртээ тушаал зарлигийн тань доор байх хүмүүсийг тамаас хамгаалах хэрэгтэй Тэдэнд мусылмааны ёсыг заах хэрэгтэй. Зааж сургахгүй бол буруутан болох болно” өөр нэг хадис-и шерифт “Бүх хүүхэд эхээс төрөхдөө мусылмааны ёсонд тохирч таарч байдаг. Эднийг хожим нь ээж аав нь христ жүүдийн шашинтан эсвэл шашингүйн үзэлтэн болгодог” хэмээжээ.

Иймд мусылмаан хүн бүрийн анхны үүрэг нь хүүхдүүддээ Кураан-и Керимийг зааж намааз үйлдүүлж имаан болоод ислаамын болзол нөхцлүүдийг сургах явдал юм. Хүүхдээ мусылмаан болж энэ ертөнц болоод хойт насны амьдралдаа амар тайванд хүрэхийг хүсэх эцэг эх эхлээд энэхүү үүргээ биелүүлэх хэрэгтэй.

Эцэг өвгөд маань “зулзган мод нугларна” хэмээжээ. Модыг хуучирч өтөлж хатсан байхад нь нугалах гэж оролдвол хугарах аюултай.

Ислаамын мэдлэг, сайхан ёс суртахууныг сурч эзэмшээгүй хүүхэд өөдгүй муу хүмүүсийн заль мэхэнд хурдан автна. Ээж аав төр улс ард түмэндээ гай түйтгэр тарина.

• НАМААЗ ҮЙЛДЭГЧДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ •

Үлгэр: Шоронгоос аварсан намааз

Хорасаны амбан захирагч Абдүллах бин Тахир маш шударга нэгэн байв. Цагдаа нар хэдэн хулгайчийг бариад амбан захирагчдаа мэдэгджээ. Нэг хулгайч оргон зайлжээ. Хиратын нэг төмөрчин Нишапур руу яваад хэсэг хугацааны дараа шөнө гэр лүүгээ буцаж явахад нь түүнийг барьжээ. Хулгачидтай хамт амбан захирагчид хүргэв. Түүнийг шоронд хорь гэж тушаав. Төмөрчин шоронд абдест авч намааз хийжээ. Гараа сунгаад Аяа Аллаах минь! Намайг авар, нүгэл хийсэнгүй гэдгийг минь зөвхөн чи л мэднэ. Намайг энэ гяндангаас зөвхөн чи л аварна. Аяа Эзэн

Тэнгэр минь! Намайг чөлөөлж хайрла хэмээн залбирав. Амбан захирагч тэр шөнө зүүдэндээ дөрвөн хүчтэй хүн ирж суудлыг нь хөнтрөх гэж байхад сэрээд хоёр рекат намаз үйлдэв. Дахин унтав. Дахиад л тэр дөрвөн хүн суудал олбогийг нь сүйтгэх гэж байхад нь үзээд сэрэв. Өөрт нь хамаатай нэг хэлмэгдэн зовогчийн зүдгүүр оршиж байгааг ойлгов.

Эцэст нь шүлэг:

Мянга илүү бөмбөг буу хэзээ ч
Нүдний нулимс үүр гийхийн цагт хийснийг хийж үл чадна
Дайсан алдсан жадыг олон удаа
Нэг мүминий дуа тоос мэт үгүй хийнэ

Аяа Эзэн Тэнгэр минь зөвхөн чи агуу их шүү. Ихэс өчүүхэс хэцүүдэхдээ зөвхөн чамаас л залбиран гуйдаг тийм л агуу шүү. Чи, чамд залбиран гуйгч зөвхөн аз жаргалд хүрнэ.

Амбан захирагч тэр даруйдаа уг шөнө шоронгийн захирагчийг дуудаж нэгэн хилсээр шийтгүүлэгч үлдэж үү хэмээн асуув. Захирагч “би мэдэхгүй гэхдээ нэг хүн намааз үйлдэж дуа уншиж байна. нулимс асгаруулж байна” гэхэд түүнийг авчруулав. Уучлал гуйж түүнд мянган мөнгөн бэлгийг минь хүлээн авагтун хэмээн өгөв. Ямар нэг хүсэх зүйл гарвал над руу ир хэмээв. Төмөрчин: Өршөөлөө. Бэлгийг чинь хүлээн авлаа. Гэхдээ ажил үйлс хүслээ чамаас хүсэхээр ирж чадахгүй хэмээв. Яагаад? Гэхэд нь , Яагаад гэвэл над мэт ядуугийн хувьд чам мэт султан хааны хаан ширээг хэд хэдэн удаа унагасан эзнээ орхиж хүслээ бусдад хандуулах нь боолын ёсонд зохино гэж үү. Тэрбээр намаазын дараа үйлдсэн дуагаар минь намайг үлэмж олон зовлонгоос гэтэлгэв. Би их аз жаргалтай золгов. Яасан гэж бусдад хоргодох билээ? Эзэн Тэнгэр минь төгсгөлгүй нигүүлслийн сан хөмрөгийн хаалгыг нээж төгсгөлгүй сайхан ширээг хүн бүрт дэлгэсэн байхад бусад руу хэрхэн явах вэ? Хэн хүсэн гуйгаад өгөөгүй билээ? Хүсэхээ мэдэхгүй бол авч чадахгүй. Түүнд сайхан ёс суртахуунаар хандахгүй бол нигүүлсэлд нь үл багтна гэв.

Шүлэг:

Ибадетийн босгонд хэн боловчиг нэг шөнө толгой мэхийнэ
Нөхрийн сайн буян түүнд мэдээжээр мянга нэгэн хаалга нээнэ

Ариун номчдын томоохон нь болох Рабиа-и Адвиййе рахметүллахи алейха нэгэн хүн залбирахдаа Аяа Эзэн Тэнгэр

минь Надад нигүүлслийн хаалгыг нээгээч гэж хэлэхийг сонсоод Хөөе Үл мэдэгч минь Аллахын нигүүлслийн хаалга одоог хүртэл хаалттай байсан болоод чи одоо нээхийг хүсч байна уу? хэмээжээ./ Нигүүлслийн гарах хаалга үргэлж нээлттэй ч гэлээ орох хаалга болох зүрх сэтгэл хүн бүхэнд онгорхой байдаггүй.

Энэ хаалгыг нээхийн тулд дуа хийх хэрэгтэй юм бид бүхэн .

Эрхт тэнгэр минь Хүн бүрийг зовлонгоос аврагч нь чи билээ. Биднийг энэ ертөнц болоод нөгөө ертөнцөд зовлон дунд бүү орхи. Энэ болоод нөгөө ертөнцөд буянтай ач тустай зүйлсийг бидэнд илгээгээч. Энэ болоод нөгөө ертөнцөд биднийг хэнд ч үл захируулаач Аминь.

Үлгэр: Гэр нь шатсан байжээ

Эвлийа-и Кирамаас Хамид-и Тавил өөрийн намаазын газартаа намааз үйлдэж байв. Гэрт нь гал гарчээ. Хүмүүс цуглаж түймрийг унтраав. Эхнэр нь гүйж хажууд нь ирээд уурлаж “Гэр чинь шатаад хүмүүс цуглаж байна. Хийх ажил их байна. Чи болохоор хуруугаа ч хөдөлгөхгүй юм хэмээв. Аллаахд андгайлая. Энэ явдлыг огт мэдээгүй байсан юм” гэв. Аллаахын нөхөд Түүнд буянаар шадарлахуйн дээд зэрэгт хүрч нөхөр ёсны залбирал мөргөлийн амтанд орчихсон байсан тул өөрсдийгөө мартсан байжээ.

Үлгэр: Савтай ус

Асхаб-и кирамаас Абдүллах бин Шехир радыйаллахү анх ийнхүү өгүүлрүүн би Ресүллүллах салллаллахү алейхи ве селлемийн хажууд намааз үйлдэж байв . Ариун цээжнээс нь гал дээр буцлах савтай ус мэт дуу сонсож байв хэмээжээ.

Үлгэр: Хөлд орсон сум

Ресүллуллахын хайртай хүргэн гэгээн Али радыйаллахү анх ве керемүллхаү вежхехү намааз үйлдэж байхад ертөнцийг ч умартдаг байжээ .

Ийнхүү өгүүлэх нь бий: Нэг тулаанд гэгээн Али радийаллахү анхын ариун хөлөнд нь сум тусан ясанд нь хүртэл оржээ. Сумыг

гаргаж авч чадсангүй Эмчид үзүүлэв. Эмч /Чамд ухаан алдуулах эм өгөх хэрэгтэй, зөвхөн тэр цагт сумыг хөлнөөс чинь гаргаж авна. Үгүй бол, өвчиндөө тэсч үл чадна хэмээжээ . Эмр-юл мүминин гэгээн Али радыйаллахү анх : Ухаа алдуулах эм хэрэггүй. Бага зэрэг хүлээ, намаазын цаг болог. Намааз үйлдэх үед гаргаж ав хэмээжээ. Намаазын цаг болов. Гэгээн Али намаз үйлдэж эхлэв. Эмч ч гэсэн Алигийн хөлийг нь зүсч сумыг нь гарган авчээ.

Шархыг боов. Гэгээн Али радыйаллхү анх : Огтоос анзаарсангүй хэмээн айлдав.

Эдгээрт гайхах юу байна. Эцэстээ Юсуф алейхисселамын гоо сайхныг хараад Миссирийн эмс өөрсдийгөө мартсан бөгөөд гараа нь огтлоходоо ч мэдээгүй бус уу.

Хэрвээ Аллаахын лагшин түүний хайрт нарыг өөрийгөө үл мэдэх байдалд хүргэвэл үүнд юунд гайхна гэж? Мүминчүүд ч гэсэн нас нөгчих үедээ Ресүллүллаах эзнийг үзэж үхлийн зовлонг үл мэдрэх болно.

Үлгэр: Унтуулах эм

Ислаамын мэргэн багш Амир-и Кайсийн хөлний хуруунд нойтон хамуу өвчин тусав. Үүнийг тасдан авах хэрэгтэй гэв. Амир шийдвэрт бууж өгөх нь боол ёсны болзол гэв. Хэрчив. Хэдэн өдрийн дараа өвчин гуянд нь халдаж ташаанд нь хүрсэн болохыг үзэв. Энэхүү хөлийг хэрчих хэрэгтэй. Манай шашин үүнийг зөвшөөрч байна хэмээцгээлээ. Мэс засалч авчрав. Мэс засалч мэдээ алдуулах хэрэгтэй учир нь хүнд өвчинг Үл мэдрэг. Үгүй бол тэсвэрлэхгүй. Амир ийм их яршиг төвөг удаад хэрэггүй. Сайхан дуугаар Куран-и Керимийг уншдаг нэг хүн авчир. Күран-и керимийг уншиг. Нүүр царайд минь хувирал гарахыг үзээд хөлийг минь тасал юу ч үл мэдэрнэ гэв. Түүний хэлсний дагуу хийв. Нэг хүн ирж сайхан дуугаар Кураан-и керимийг уншиж эхлэв Амирийн царайн өнгө өөрчлөгдөв. Мэс засалч ташааны дундуур хөлийг нь тайрав. Хайрч түлээд боов. Кураан-и керим уншиж байсан хүн уншихаа болив. Амир ухаа ороод тайрсан уу? хэмээн асуув. Тиймээ тайрлаа гэцгээв. Хөлийг нь тайрч ,хайрч боосон бөгөөтөл тэр юуг ч анзааралгүй байв. Дараа нь тайрсан хэсгийг минь надад өгөгтүн хэмээв. Өгөв. Хөлөө дээш нь бариад: “ Аяа Эзэн Тэнгэр минь өгөгч

нь чи билээ.

Би чиний боол билээ. Заавар тушаал чинийх билээ. Каза нөхвөр чинийх билээ. Энэ хөлний тухайд хэрвээ шүүгдэх өдөр тушаал зарлиг ирж ямар ч цаг үед нүгэл рүү нэг алхам алхаагүй биз? гэхэд чиний тушаал захирамжгүйгээр нэг ч алхам алхаж нэг ч амьсгаа аваагүй гэж хэлэв.

Үлгэр: Намаазын төлөө амь биеэ үл хайрлах

Бурса хотыг Османчууд эзлэн авахаас өмнө хотод суух нэг рүм хүн нууцаар мусылмаан болжээ. Маш ойр дотно нэг найз нь тэр грекээс үүний учрыг асуув.

Эцэг өвгөдийнхөө шашныг юу болсон гээж орхив? гэж түүнийг зэмлэн буруутгав. Рүмийн хариулт утга төгөлдөр болжээ. Найздаа энэ байдлыг өгүүлрүүн:

-Нэг удаа олзлогдсон нэг мусылмааныг миний хажууд орхив. Нэг өдөр харахад хоригдол хоригдсон өрөөндөө тонгойж босоод байхаар нь хажууд очоод юу хийж буйг нь асуув. Үйл хөдөлгөөнөө дуусангуут гараа нүүрэндээ хүргээд надад намааз үйлдсэнээ хэрвээ хүлээн зөвшөөрвөл намааз болгоны төлөө нэг алт өгнө гэж хэллээ. Би ч гэсэн шуналд автагдав. Өдөр хоног өнгөрөх тусам үнэ хөлсийг нэмэв. Нэг цаг бүрт арван алт хүсэх байдалд аваачив. Тэр ч хүлээн зөвшөөрлөө. Би ибадетийнхээ төлөө хийж буй уужуу сэтгэлд гайхаж байсан юм. Нэгэн өдөр би түүнийг чөлөөлнө гэхэд ихэд баярлаж гараа өргөөд миний төлөө ийнхүү дуа хийв.

Аяа Аллаах минь энэхүү боолыг итгэл сүсгээр баясга. Яг тэр мөчид зүрх сэтгэлд минь мусылмаан болох хүсэл төрж ихсэн тэр даруйдаа Келиме-и шахадетийг хэлж мусылмаан болсон билээ би хэмээжээ.

Дөрөв дүгээр бүлэг

• НАМААЗЫН ТӨРӨЛ •

Мусылман нарт үйлдэх нь зарлиг болсон намаазуудыг фарз, уажиб, нафилэ гэж гурав хуваана.

1. ФАРЗ НАМААЗ: таван удаагийн намааз, жума намазын хоёр рекат фарз ба оршуулгын намааз фарз намазууд /Оршуулгын намаз фарз-и кифаеэ юм/

2. ВАЖИБ НАМААЗ: Витр намааз, баярын намааз, тахилгын намааз, эхлээд дундаа үлдээсэн нафиле намааз, казад үлдэгч нь витр намаазыг ч каза /нөхөж/ хийх нь важиб юм.

3. НАФИЛЕ НАМААЗ: таван удаагийн намаазын сүннетүүд теравих намааз/ рамазаан баярын цагт оройн намаазын дараа үйлдэх намааз/ буян олох зорилгоор хийх тежеххүд техыййетүл-месжид ишрак духа, эввабин, истихаре, тесбих намааз гэх мэт намаазууд нь нафиле намаз юм. Өөрөөр хэлбэл үйлдэх нь тушаал биш юм. Фарз болон орой йатси өглөөний цагт хэрэгтэй буюу важиб болох намаазаас өр зээлгүй хэн нэгэн нафиле ибадетэнд ч гэсэн буян хураана.

• ТАВАН УДААГИЙН НАМААЗ •

Намааз Аллаахын захирамж юм. Аллаах Кураан-и Керимд зуу гаруй газар Намааз үйлдэгтүн! хэмээн айлдаж байна. Ухаантай шилжилтийн насанд хүрсэн мусылмаан хүн бүр өдөр болгон таван удаа намаз мөргөл үйлдэхийг Кураан-и керим ба Хадис-и шерифт захирамжилсан байна.

Рүм сүре 17,18 аят-и керимед утгачилбал “орой болоод өглөө цагт Аллаахд тесбих унш. Тэнгэр эрхэс болооод дэлхий дээр оршигчдын хийдэг оройн ба үд цагт хийх магтаалууд Аллаахд

зориулагдна” хэмээн айлджээ. Бакара сүрэ 239 аятэд “Намааз болоод оройн намаазыг хамгаалагтун”өөрөөр хэлбэл намаазыг цаг үргэлжид үйлдэгтүн хэмээн зарлигласан билээ. Аят и керимед гарах тесбих /намаазын дараа субханаллаах гэх ба магтаал нь намааз гэсэн утгатай болохыг тайлбар номнуудад өгүүлж байна. Худ сүре 114 аятэд утгачлавал /Өдрийн хоёр талд /үд ба оройн цагт / шөнөд ойр гурван өөр хугацаанд хэрэгтэй тул намааз үйлд, үнэндээ энэ сайхан зүйлс /таван удаагийн намаазын буян/ нүглийг үгүй хийнэ. (Энэ нь тунгаан бодогчид сургамж болно) хэмээн зарлигдаж байна.

Бидний Пайгамбаар элч Мухаммед алейхисселам айлдахдаа: Аллаах боол нартаа өдөр бүр энэхүү таван намаазыг цаг хугацаанд нь үйлдэж рүкү ба сеждег хийгчдийг Аллаах өршөөн нигүүлснэ хэмээжээ.

Таван удаагийн намааз 40 рекат юм. Эднээс арван долоон рекат нь фарз юм. Гурван рекат нь уажиб юм. Хорин рекат нь сүннет юм. Энэ нь:

1. Өглөөний намааз: Дөрвөн рекат юм . Эхлээд хоёр рекат сүннет дараа нь хоёр рекат фарзыг үйлднэ. Энэхүү сүннет хүч нөлөөтэй билээ. Важиб хэмээгчид ч бий

2. Үдийн намааз : Арван рекат юм. Эхлээд дөрвөн рекат анхны сүннет дараа нь дөрвөн рекат фарз, фарзын дараа хоёр рекат сүүлчийн сүннет үйлднэ.

3. Оройн намааз: Найман рекат юм. Эхлээд дөрвөн рекат сүннет дараа нь дөрвөн рекат фарз үйлднэ.

4. Үдшийн намааз: Таван рекат юм. Эхлээд гурван рекат фарз дараа нь хоёр рекат сүннет үйлднэ.

5. Шөнийн намааз: Арван гурван рекат юм. Эхлээд дөрвөн рекат сүннет дараа нь дөрвөн рекат фарз дараа нь хоёр рекат сүүлчийн сүннет. Үүний хойно ч гэсэн гурван рекат Витр намаазыг үйлднэ.

Оройн ба шөнийн намаазуудын анхны сүннетүүд нь Гайр-и мүеккеде юм. Эдгээрийн хоёр дахь рекатд суухад Эттэхыййатүгийн дараа Аллахүмэ сали, дараа нь Аллахүме барик Дуаг дуустал нь уншина. Босч зогсонгуутаа гуравдахь рекатдаа эхлээд Бесмеле уншилгүйгээр Субханеке уншина. Гэтэл үдийн намаазын анхны сүннет нь Мүеккед юм. Өөрөөр хэлбэл, хүчтэйгээр зарлигдсан бөлгөө. Анхны суултанд фарзд байдагтай

адилаар зөвхөн Эттэхиатү уншиж дараа нь гурав дахь рекатыг хийхдээ шууд босч зогсно. Босч зогсонгуутаа эхлээд Бесмелег уншиж шууд Фатиха уншина.

Үдийн болоод шөнийн фарзаас нь хойш дөрвөн рекат ба оройн фарзын дараа зургаан рекат илүү үйлдэх нь мустехаб бөгөөд их буянтай билээ. Бүгдийг нь нэг мэндчилгээгээр эсвэл хоёр рекатд нэг нэг мэндчилгээгээр үйлдэж болно. Энэ хоёр хэлбэрийн аль алинд нь хоёр хоёр рекат сүүлчийн сүннетийн оронд тооцогдно. Энэхүү мустехаб намаазуудыг сүүлийн сүннетийн дараа тусад нь үйлдэж ч болно.

Эхний рекатд намаазд зогсмогц бусад рекатууд босч зогсонгуут эхлэх ба дахин босч зогсох хүртэл үргэлжилнэ. Сүүлийн рекат нь мэндчлэх хүртэл үргэлжилнэ. Хос рекатуудад хоёрдох сеждегийн дараа сууна.

Рекат бүрд намаазын фарзуу, важибууд ,сүннетүүд, муфсидүүд, мекрүхүүд байдаг. Хойно энэ бүгдийг Ханефи мезхебийн үзэл номлолын дагуу бид өгүүлэх болно.

• НАМААЗЫН ФАРЗУУД •

Фарз нь Аллаахын хийхийг тушаасан зарлиг юм. Нэг ибадетийн фарзыг биелүүлэхгүй бол тухайн ибадет жинхэнэ үнэн зөв болохгүй. Намаазыг үйлдэхэд арван хоёр болзлыг биелүүлэх нь фарз юм. Эдгээр фарзын долоо нь намаазын гадна, тав нь намаазын дотор байна. Гаднах фарзыг шарт /болзол/ доторхыг нь рүкн гэнэ. /зарим эрдэмтэд тахриме текбирийг намаазд багтна хэмээсэн юм. Эднийг үзэхээр намаазын шарт болоод рүкн аль аль нь зургаа юм.

А/ Намаазын гаднах фарзууд

1. Хадес тахарет /Угаалга/ Абдестгүй хүн абдест авах жүнүб буюу бохирдсон хүн гүсл угаал хийх

2. Нежасет тахарет /Бохир буртагыг цэвэрлэх/ Намаазыг үйлдэгч бие махбод, хувцас болоод намааз үйлдэх газрыг,өтгөн шингэнээс өөрөөр хэлбэл бохир заваан тооцогдох зүйлсээс цэвэрлэх явдал мөн. /Жишээ нь цус, шээс, архи мэт бодис манай шашинд бохирт тооцогдно/

3. Сетр-и аурет /Ичимхий газрыг нуух/ Ичимхий газрыг хучих гэсэн үг. Ичимхий газраа хучих нь Аллаахын захирамж юм. Мүкеллеф өөрөөр хэлбэл оюун ухаантай насанд хүрсэн хүн намааз үйлдэхдээ задгайлах өөрөөр хэлбэл цаг ямагт бусдад харуулах бусад хүн ч гэсэн харах нь цээр болох биеийн хэсгийг Аврет махалли буюу ичимхий газар гэнэ. Эрэгтэйчүүдийн ичимхий газар нь хүйснээс өвдөгний доод хэсэг хүртэл бол эмэгтэйчүүдийн хувьд нүүр, гарын бугуйнаас бусад бүх биеийн хэсэг ичимхий юм.

4. Истикбал-и кыбле /Кыбле тийш хандах/ Намааз үйлдэхдээ кыбле рүү хандах гэсэн үг. Мусылмаан нарын кыбле нь Ариун Мекке хотод байх Каабе юм.

5. Вакт /Цаг хугацаа/ Намаазыг цаг хугацаанд нь үйлдэх. Өөрөөр хэлбэл намаазын хугацаа нь болсныг мэдэж үйлдэх.

6. Нийет /Зорин хүсэх/ Намаазд зогсохдоо зүрх сэтгэлээрээ зорин хүсэх гэсэн үг. Зөвхөн амаараа хэлэхийг зорин хүсэх гэж үзэхгүй. Намаазд зорин хүснэ гэдэг нь нэр алдар, цаг, кыблег хүй бөлөгтэй хамт үйлдвэл имаамыг дагахыг зүрх сэтгэлдээ болгоох гэсэн үг. Зорин хүсэх нь эхлэх текбирийг хэлэхэд хийгдэнэ.

7. Тахрымэ текбири /эхлэл текбир/ Намаазд зогсоход Аллаахү акбаар гэж эхлэх . Энэхүү эхлэх текбирийг Ифтитах текбир гэнэ. Өөр үг хэлснээр текбир хийсэн тооцогдохгүй.

Б/ Намаазын доторх фарз /Рүкн/

Намаазд зогсонгуут биелүүлэх таван фарз байна. Эдгээр фарз бүрийг рүкн гэнэ.

Намаазын доторх фарз гэвэл:

1. Кыйам Намаазыг эхлэхэд үйлдэхдээ босч зогсох гэсэн үг. Босч зогсож үл чадах өвчтөн сууж үйлднэ. Сууж үл чадах хүн хэвтээд толгой дохиж үйлдэнэ. Сандалд сууж намааз үйлдвээс шашинд үл нийцнэ.

2. Кырает унших гэх утгатай. Намаазд Кураан керимийн сүре аятүүдийг унших

3. Рүкү Кыраетийн дараа гараа өвдөгтөө тавиад тонгойх гэсэн үг. Рүкүд хамгийн багадаа гурван удаа Субхане раббыел-азым гэнэ. Өндийж байхдаа Семиаллахү лимен хамидех гэнэ. Өндийгөөд Раббена лекел-хамд гэнэ.

4. Сежде: Рүкүгийн дараа газар өвдөглөн мөргөх гэсэн үг. Сежде нь дараалан хоёр удаа гар, магнай, хамраа газар тавьж мөргөх юм. Сежде бүрт багадаа гурван удаа Субхане раббыел-ала гэнэ.

5. Каде-и ахире Сүүлийн рекатд (Эттэхыаййатү)г унших хүртэл суух юм. Үүнийг сүүлийн суулт хэмээн нэрлэх нь ч бий.

Намаазын агуу их үйл хэрэг хамгийн чухал ибадет болох нь ийм олон болзол нөхцөлтэй байгаагаас нь харвал ойлгомжтой байна. Түүнээс гадна важиб, сүннет, мустахаб, мекрүх, мүфсидүүдийг үүн дээр нэмвэл боолын Эзэн Тэнгэрийнхээ өмнө хэрхэх хэрэгтэй нь ойлгогдно. Боол нар угтаа хүчгүй хөөрхийлөлтэй бүтээгдэгчид болох ба амьсгаа авах бүртээ өөрийг нь бүтээсэн Аллаахаар дутагдан гачигдна. Намааз нь боолыг сул дорой гэдгийг мэдрүүлэх ибадет болно.

Бидний номонд эл мэдлэгийг дэс дараалан өгүүлэх болно.

• НАМААЗЫН БОЛЗЛУУД •

1. АБДЕСТ БУСНИСНЫГ ЦЭВЭРЛЭХ / тахарет/

Энэ хэсэгт абдэст, гүсл, тееммүмийн талаар өгүүлнэ.

АБДЕСТ АВАХ

Абдест авах нь намаазын фарз юм. Кураан-и кэримыг гартаа барих, Кабег тойрон мөргөх, тилавэт сежде хийх, оршуулгын буюу женазе намааз үйлдэхийн тулд абдест авах хэрэгтэй. Үргэлж абдесттэй байх, орохдоо абдесттэй орох, абдесттэй юм идэх уух их буян юм.

Абдесттэй байхдаа нас барагчдад шехидийн буян оногдоно. Бидний Пайгамбаар элч саллаллахү алейхи ве селлем айлдахдаа

“Абдесттэй байхдаа нас нөгчигч бээр үхлийн зовлонг үл мэднэ. Яагаад гэвэл, абдест итгэл сүсэгтэй байхын шинж юм. Намаазын түлхүүр бие махбодыг нүглээс цэвэрлэнэ”.

“Мусылмаан хүн абдсет авахад нүгэл нь чих, нүд, гар, хөлөөс нь ангижирна. Суухдаа өршөөгдөөд сууна”.

“Хүний үйл үйлдлийн хамгийн буянлаг нь намааз юм. Абдест хийгчид зөвхөн мүмин нар болно. Мүмин хүн өдөр ч абдест авч

шөнө унтахдаа ч абдесттэй унтах ёстой. Ийн хийвэл Аллаахын

ивээлд багтна. Абдесттэй байхдаа идэж уугчийн гэдсэнд байх хоол ус Аллаахыг дурсна. Гэдсэнд байхдаа ч түүний төлөөнөө Аллаахаас өршөөл эрнэ”хэмээв.

Абдестийн фарз, сүннет, эдебүүд цээрлэсэн хийгээд бусниах зүйлс ч байдаг. Абдестгүй гэдгээ мэдсээр байж намааз үйлдэгч кафир болно. Намааз үйлдэхэд абдест нь бусних хүн тэр даруй мөрөндөө мэндчилж намаазаа дуусгана. Цаг хугацаа өнгөрөхөөс өмнө абдест авч намаазыг эхнээс нь дахин үйлднэ.

Абдестийн фарзууд

Абдестийн фарз Ханефи мезхебийнхээр дөрвөн зүйл байна.

1. Нүүрээ нэг удаа угаах
2. Хоёр гараа тохойг оруулаад нэг удаа угаах
3. Толгойн дөрөвний нэг хэсгийг илж норгох өөрөөр хэлбэл нойтон гараа толгойдоо илбэх
4. Хоёр хөлөө хоёр талын шагайн хамт нэг удаа угаах

Шафий мезхебт зорин хүсэхүй ба цэгцлэхүй ч фарз юм. Нүүрээ угаахдаа нийет хийх хэрэгтэй, ус нүүрэнд хүрэхээс өмнө нийэт хийвэл абдест нь жинхэнэ болохгүй. Нүүр эрүүний сахлыг угаах ёстой. Малики мэзхебт делк бас мивалат буюу эрхтнээ нэг нь нөгөөгийн ардаас угсран угаах фарз юм.Шийчүүд хөлөө угаахгүй нүцгэн хөлөө илж арчдаг.

Абдест хэрхэн авах вэ?

1. Абдестийг эхлэхэд доорх дуа уншина:Бисмиллахил-азим. Велхамдү лиллахи ала динил-Ислам. Ве ала тевфик-ыл –иман. Эл-хамдү лилахил-лези жеалелмае тахурен ве сеалел-исламе нурен “Агуу их Аллахын нэрээр эхлэнэм . /Бидэнд/ Ислаам шашныг хайрлан имааныг соёрхсон Аллаахыг талархан магтан дуулаг Усыг цэвэрлэгч ислаамыг гэгээтүүлэгч Аллаахыг талархан магтан дуулаг.”

Дараа нь гараа бугуй хүртэл гурван удаа угаана.

2. Баруун гараар ам руу гурван удаа ус авахдаа доорх дуа уншина.

Аллаахюммес-кыны мин хавди небиййике кесен ла эзменбадехү эбеден.

“Аяа Аллах минь Түүнээс уусны дараа дахиж хэзээ ч цангахуйг

үл мэдрэх Неби усан санг боол наддаа нэг аяга уулгагтун”

3. Баруун гараараа хамартаа гурван удаа ус авч зүүн гараараа нусаа нийнэ.

Аллахүме эрихни райихател женнети верзүкни мин неимиха. Ве ла түрихни райихатен-нар“Аяа Аллах минь Надад Диваажингийн үнэрийг үнэртүүл. Намайг Диваажингийн буянаар тэжээ. Тамын үнэрээр бус”

4. Алгандаа ус авун нүүрээ гурван удаа угаахааа

Аллахюме бейиид вежхи бинурике йевме тебйаддү вүжүхү эвлийаке ве ла түсеввид вежхи би зүнуби йевме тесведдү вүжүхү адайке“Аяа Аллах минь Гэрэл гэгээгээрээ Ариун номч нарын гэрэлтүүлсэн шиг миний нүүрийг ч гэсэн гэрэлтүүл. Дайснуудын чинь нүүр хар байх өдөр намайг нүглээс минь болж нүүрийг минь бүү харлуул “ гэх дуаг уншина.

5. Зүүн гараараа баруун гараа тохой хүртэл гурван удаа угаахдаа Аллаахюмме атини китави бийемини ве хасибни нисабен йесирен (Аяа Аллах минь Номыг минь баруун талаас минь өг намайг хялбараар байцаа) дуаг уншина.

6. Зүүн гараа тохойтой нь гурван удаа угаахад

Алахүмме ла тутини китаби би шимали ве ла мин верай захри ве ла түхасибни хисабен шедиден (Аяа Аллах минь зүүн ба ард талаас номыг минь бүү өг. Намайг хүнд тооцоогоор бүү байцаа) дуаг уншина.

7. Хоёр гарыг угаасны дараа гараа дахин угааж нойтон байхдаа толгойгоо илж норгохдоо

Аллахюмме харрим шари ве бешери ален Нар. Ве эзилени тахте зыллы аршике йевме ла зилле иллаа зыллү аршике”Аяа Аллах минь Бие махбод үсийг минь тамд бүү хаягтүн. Сүүдэргүй өдөр намайг Арш-алагийн сүүдэрт халхлагтүн” дуаг уншина

8. Дараа нь баруун зүүн гарын долоовор хуруугаар хоёр чихний ухархайд ус өгөхөд эрхий хуруугаар чихний ар хэсгийг илж арчина.Аллахюмежални минеллезине йестемиунел-кавле фе йеттвиуне ахсенеху “Аяа Аллаах минь Намайг үг сонсож хамгийн сайхныг баригч болгож хайрла” дуаг уншина

9. Гарын алганы гадна талаар хүзүүг илж арчихад

Аллахүме атык ракабети минен-Нар (Аяа Аллаах минь биеийг минь тамын галаас аварч хайрла) дуаг уншина.

10. Хүзүүгээ илж арчсаны дараа зүүн гарын чигчий хуруугаараа баруун хөлийн чигчий хуруунаас эхлээд хөлийн хурууны завсруудыг цэвэрлэж өсгийтэй цуг баруун хөлийг гурван удаа угаахадаа. Аллахүме себбитт кадемеййе алес- сыраты йевме тезиллю фихил-экдамү дуаг уншина.(Аяа Аллах минь Хөл минь хальтрах үед сиратын гүүрэн дээр хөлийг нь тогтоож хайрла)

11. Зүүн хөлөө гурван удаа угаахад хөлийн хурууны завсрыг чигчий хуруугаар энэ удаа эрхий хуруунаас эхлэн чигчий хуруу хүртэл хөлийн хурууны завсрыг цэвэрлэн шагайтай нь хамт угаахдаа: Аллахүме ла татрүд кадемеййе алес-сирати йевме татрүдү күл-лү акдами адайке. Аллахүмеж-ал сайи мешкүрэенн ве зенби магфүрен ве амели макбүлен ве тижарети лен тебүре(Аяа Аллах минь Чиний дайснууд сират гүүрэн дээр хөл нь хальтрах өдөр миний хөлийг бүү хальтраа. Аяа Аллах минь. Үйл ажлыг минь талархан соёрх. Нүглийг минь өршөөн соёрх. Үйлдлийг минь хүлээн соёрх. Наймаа арилжааг минь ариун болгож хайрла) дуаг уншина

Бидний Пайгамбаар саллаллаху алейхи ве селлем айлдахдаа"Хэн нэгэн абдест авсныхаа дараа тэнгэр лүү харж энэ дуаг уншвал Сүбханекеллахүмме ве бихамдике, Эсхедү эн ла илахе илла энте вахдеке ла шерике леке естагфирүке ве этүбү илейке ешхедү эн лха илахе иллаллах ве эшхедү энне Мүхамммеден авдүке ве Ресүлүке. /Аяа Аллах минь Чамайг талархлаар чинь тесбих төгс болгоно би. Чамаас өөр тахил тавиг байхгүй цор ганц болохыг, хамтрагчгүй болохыг, Мүхаммед алейхисселамын чиний кел ба Элч нь болохыг гэрчлэнэ би" Аллаах тэр хүний нүглийг өршөөх ба зөвшөөрсөн гарын үсгээр нотлож Арш-и ала /Тэнгэрийн хүч үзэгдэх газар/гийн доор хамгаална. Шүүгдэх өдөр энэ дуаг унших хүн ирж тэр буяны төлбөрийг авна"хэмээжээ.

Нэг хадис-и шерифт "хэн нэгэн абдест авсныхаа дараа "инна энзелнахү" сүрег нэг удаа уншвал Эрхэм Эзэн Тэнгэр тэр хүнийг сыддык /зөв итгэлт бишрэлт/ гэж тооцно. Хоёр удаа уншвал шехид гэж тооцно. Гурван удаа уншвал Пайгамбаруудтай уулзуулна" хэмээн айлдав.

Бас нэг хадис-и шерифт (хэн нэгэн абдест авсныхаа дараа

миний тухайд арван удаа салатү селам хэлвэл Эрхэм Аллаах тэр хүний уйтгарыг гаргаж баярлан дуаг нь хүлээн авна) хэмээжээ. Абдест авахдаа мэдэхгүй хүмүүс абдест авахдаа унших хэрэгтэй Их буян болно. Абдестийн төгсгөл рүү эсхүл абдестийг дуусгасны дараа "Аллахюммежални минет-теввабин, вежални минел-мүтетаххирин, вежални, мин ибадик-эс- салихин, вежални минеллезине ла хавфүн алейхим ве лахүм йахзенун" дуаг унших нь маш их буян юм. Абдест дуаг үл мэдэх хүн эрхтэн бүрээ угаахдаа Келиме-и шехадет унших нь их буянд хүрэх учиртай.

Ухаантай бол намааз үйлд Яагаад гэвэл аз жаргалын титэм юм.
Чи намаазыг ийнхүү мэд, мүслүман хүний гайхамшиг юм.

Абдестийн сүннет

Абдестийн сүннет арван найм юм:

1. Абдестийг эхлэхэд Бесмеле унших.
2. Гараа бугуйн хамт гурван удаа угаах.
3. Амаа усаар гурван удаа зхйлах . Үүнийг Мазмаза гэнэ.
4. Хамартаа гурван удаа ус авч нийх .Үүнийг Истиншак гэнэ.
5. Хөмсөг хууз живрээ сахлын доорх үл үзэгдэх арьсыг нүүрээ угаахдаа норгох.
6. Нүүрээ угаахдаа хоёр хөмсөгнний доод талыг норгох.
7. Сахлын сөрвийсөн хэсгийг гараараа илж арчина.
8. Сахлаа баруун гарын нойтон хуруугаар самнах мэт үйлдэх.
9. Шүдээ ямар нэг юмаар ухах цэвэрлэх. Шүд цэвэрлэгч /Мисвак/ хэрэглэх нь чухал сүннет юм/
10. Толгойн бүх талыг нэг удаа нойтон гараараа илж норгох.
11. Хоёр чихээ нэг удаа нойтон гараараа илж норгох.
12. . Хүзүүг гурван хурууга нийлүүлээд нэг удаа месх хийх.
13. Гар ба хөлийн хурууны хоорондох салааг салаавчлан угаах.
14. Угаах газрыг гурван удаа угаах.
15. Нүүрээ угаахдаа зүрх сэтгэлээрээ ниййет хийх.
16. Тертиб өөрөөр хэлбэл дэс дараалан угаах.
17. Хонхор газрыг угаахдаа нойтон хуруугаараа норгох.
18. Мүвалат Эрхтэн бүрээ дараалан цувруулан хурдан угаах.

Абдестийн зүй ёс /эдеб/

Абдестийн эдеб хорин найм байна:

Эдеб нь хийвэл буян болж хийхгүй бол нүгэл үл болох зүйл гэсэн үг. Гэтэл сүннетийг хийвэл буян болох ба хийхгүй байх нь тензихэн мекрүх юм. Эдебийг мендүб мустехаб /зарлиглаагүй боловч хийх буянт үйл/ ч гэнэ. Абдестийн эдеб доорх болно.

1. Абдестийг намазын цаг болохоос өмнө авах /Шалтагтай хүн намаазын цаг орсноос хойно авах болно/
2. Угаалгын өрөөнд цэвэрлэж байх үедээ кыблег баруун эсвэл зүүн талдаа авах Авдестийг бусниахад кыбле рүү урд ба хойд талаараа хандах нь бүхлээрээ мекрүх юм.
3. Бохир заваан зүйл холилдоогүй бол усаар цэвэрлэх.
4. Цэвэрлэсний дараа алчуураар хуурайлах .
5. Цэвэрлэсний дараа ичимхий газраа шууд хучих.
6. Бусдаас тусламж хүсэхгүйгээр абдестээ өөрөө авах.
7. Кыблегийн эсрэг талд абдест авах.
8. Эрхтэн бүрийг угаахдаа келиме-и шехадет унших.
9. Абдестын дуаг унших.
10. Амандаа баруууун гараараа ус авах.
11. Хамртаа баруун гараараа ус авах.
12. Хамраа зүүн гараараа нийх.
13. Амаа угахдаа шүдээ Мисвак буюу шүд цэвэрлэгчээр цэвэрлэх. Шүд цэвэрлэгч үгүй бол сойз хэрэглэж болно.
14. Амаа угаахдаа мацагтай биш бол амаа зайлахгүй байх. Хоолойгоо хөнгөхөн зайлах нь абдест ч гэсэн гүслд ч гэсэн сүннет юм. Мацагтай байхад мекрүх юм.
15. Хамраа угаахдаа усыг хамрынхаа уг хүртэл татах.
16. Чихээ нойтон гараараа илж арчихад нэг хурууг чихний ухархайд хүргэх.
17. Хөлний хурууг шинжлэхэд зүүн гарын чигчий хуруугаар шинжих.
18. Гараа угаахдаа бөгжийг хөдөлгөх Бариу бөгжийг заавал хөдөлгөх шаардлагатай ба фарз юм.
19. Ус элбэг байлаа ч хамаагүй хямгадан угаах.
20. Усыг тос түрхэх мэт маш бага хэрэглэхгүй байх /гурван удаа ч гэсэн угаасан газрас хамгийн багадаа хоёр дусал ус дусах

хэрэгтэй/

21. Нэг саваас абдест авбал тэрхүү савыг усаар дүргэж орхих.

22. Абдест угаал дуусангуут эсхүл дундуур Аллахюммеж- ални минеттеввабин... дуаг унших.

23. Абдест угаалгын дараа Сүбха өөрөөр хэлбэл хоёр рекат намаз үйлдэх.

24. Абдесттэй байхдаа абдест авах өөрөөр хэлбэл намааз үйлдсэний дараа шинэ намааз үйлдэхээр дахин нэг удаа абдест авах.

25. Нүүрээ угаахад нүдний цөцгийн нуухыг цэвэрлэх.

26. Нүүр гар хөлөө угаахдаа фарз болох газраас арай их хэсгийг угаах /Гараа угаахад алгандаа ус дүүргээд тохой руу урсгах хэрэгтэй/

27. Абдест авахад хэрэглэх уснаас хувцас, үс толгойдоо хүргэхгүй байх.

28. Өөрийн мезхебд мекрүх үл болох нэг зүйл өөр мезхебд фарз бол үүнийг хийх нь мустехаб юм.

Абдест авахад цээрлэх зүйлс

Абдестийг авахад хийх хорио цээртэй зүйл арван хоёр байна. Эдгээрийг хийх нь хараам эсвэл мекрүх юм.

1. Угаалгын өрөө болоод хөдөө газар абдест бусниах үед кыблег урд хойноо зүг байрлахгүй байх хэрэгтэй.
2. Цэвэрлэхийн тулд хэн нэгний дэргэд ичимхий газраа гаргах хараам юм.
3. Баруун гараараа ичимхий газраа цэвэрлэхгүй байх хэрэгтэй.
4. Ус байхгүй нөхцөлд хүнсний бүтээгдэхүүн, бордоогоор, яс, мал амьтны хоол нүүрс бусдын хөрөнгө, сагс, ваарны хэлтэрхийгээр хулс, навч, бөс даавуу, цаасаар цэвэрлэх нь мекрүх юм.
5. Абдест авсан цөөрөм буюу усан сандаа нулимж нусаа нийж болохгүй.
6. Абдест угаалын эрхтнийг хил хязгаараас нь хэт их эсхүл багаар угааж болохгүй ба гурваас бага эсхүл илүү олон угаах хэрэггүй.
7. Абдест угаалын эд эрхтнийг цэвэрлэгээнд хатаасан бөсөөр эсвэл цаасаар хатаах хэрэгтэй.

8. Нүүрээ угаахдаа усыг нүүрэнд ус цацаж угааж болохгүй .Духны дээд талаас доошоо цутгах хэрэгтэй.

9. Усыг үлээж үл болно.

10. Ам нүдээ тас зууж аних хэрэггүй. Уруулын ил хэсэг болоод нүдний зовхи нороогүй багахан хэсэг үлдвэл абдест үл хүлээн зөвшөөрөгднө.

11. Баруун гараараа нусаа нийж болохгүй.

12. Толгой, чих эсхүл шилэн хүзүүний аль нэгийг тухай бүрт нь гараа тус тусад нь норгож нэгээс илүү олон удаа месх хийж үл болно. Тухай бүрд норголгүйгээр давтаж болно.

Мисвак ба шүд цэвэрлэгч хэрэглэх

Абдест авахад шүд цэвэрлэгч хэрэглэх нь сүннет-и мүеккеде юм. Хадис-и шерифт айлдруун: Мисвак хэрэглэж намааз үйлдэх нь шүд цэвэрлэгчгүй намазаас дал дахин үнэ хүндтэй юм.

Сираж-үл-веххаж номонд мисвак буюу шүд цэвэрлэгч хэрэглэхийн арван таван ач тус байдгийг зааж байна

1. Үхэх мөчид келиме-и шехадетийг хэлэх шалтгаан болно
2. Шүдний буйлыг бэхжүүлнэ.
3. Цэр залхагийг арилгана.
4. Амны хөндийн өвчинг арилгана.
5. Амны өвчинг арилгана.
6. Амны эхүүн үнэрийг арилгана.
7. Аллаах түүнд талархна.
8. Тархины судсуудыг хүчжүүлнэ.
9. Чөтгөрийг давчдуулна.
10. Нүдний хараа сайжирна.
11. Буян ба сайн үйл ихснэ.
12. Сүннетээр үйл үйлднэ.
13. Ам нь цэвэршнэ.
14. Фасых-үл-лисан болно. Өөрөөр хэлбэл сайн сайхан яригч болно.
15. Шүд цэвэрлэгч хэрэглэгдсэн хоёр рекат намаазын буян нь шүд цэвэрлэгчгүй үйлдсэн далан рекат намаазын буянаас илүү их юм.

Мисвак буюу шүд цэвэрлэгч нь Араб нутагт ургах Эрак

модны мөчир болно. Цэвэрхэн үзүүрээс нь хоёр сантиметр хүртэл хальсласан хэсэг нь хэдэн цаг усанд байлгана. Дараа нь нүдэхэд сойз мэт хэрэглэнэ. Эрак мод байхгүй бол тослог модны мөчрөөр хийнэ. Эмэгтэйчүүд шүд цэвэрлэгчийн оронд шүд цэвэрлэгч хэрэглэх сүннетийг хүсэн зорьж бохь хэрэглэх хэрэгтэй.

Абдест авахад анхаарах зүйлс

Зайлшгүй шаардлага аргагүй байдалд ороогүй нөхцөлд доорх арван зүйлийг дагах хэрэгтэй

1. Хоёр гар нь бэртэж гэмтсэн хүн цэвэрлэгээ хийхгүй. Гараа шороонд нүүрээ хананд хүргэж тееммүм хийнэ. Нүүрэнд нь шарх байвал намазыг абдестгүй үйлдэх ба намазаа үл орхино.

2. Өвчтэй хүнд эхнэр татвар эм үр хүүхэд ах дүү нар нь абдест авахуулна

3. Чулуу болоод төсөөтэй зүйлээр цэвэрлэх нь усыг орлоно.

4. Галзуу эсхүл ухаа алдсан хүн хорин дөрвөн цагийн хугацаанд сэргэж эрүүлжихгүй бол бие нь сайжрангуут намаазаа каза хийхгүй. Архи, хар тамхи, эмээр оюун ухаан нь сарнисан хүн намааз бүрийг каза хийнэ. Хэвтэхдээ толгойгоороо дохиж үл чадахаар хүнд өвчтөн хорин дөрвөн цагаас илүү урт үргэлжлэх хүнээс оюун ухаан хэвийн байлаа ч намазаа өнгөрөөж болно.

5. Угаалгын газар орохын тулд зориулсан өмд өмсөх, толгой боож орох нь мүстехаб бөлгөө

6. Угаалгын газар ороход гартаа Аллаахын нэр ба Кураан-и керим бичээстэй ямар нэг зүйл байх хэрэггүй. Ямар нэг юманд ороосон эсхүл халаасанд байх нь зүгээр.

7. Угаалгын газар зүүн хөлөөрөө орж баруун хөлөөрөө гарах хэрэгтэй.

8. Угаалгын газар ичимхий газраа бөхийж байгаад задгайлах ба тэнд ярихгүй байх хэрэгтэй

9. Ичимхий газар ба бохир заваан зүйл рүү харахгүй байх, угаалгын газар нулимахгүй бах хэрэгтэй

10. Ямар ч усанд жамийн ханан, оршуулгын газар, замд, бие засаж болохгүй

Абдестийг бусниах зүйлс

Долоон зүйл абдестийг бусниана. Эдгээр нь:

1. Хүнээс ялгарах өтгөн шингэн:

а/ Их бага абдест бусниах, унгах.

б/Ихтикан өөрөөр хэлбэл клизмын багажийн үзүүр хүний хойд сүв рүү хийж гаргахад эргэн тойрон норсон байвал бусниана. Хуучин бол абдестийг шинэчлэх нь сайн юм.

в/Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн шээс алдахгүйн тулд урдаа тавьсан хөвөн бөглөөсийн гадна үлдсэн хэсэг нь норвол буснина.

2. Амнаас гарах бохир заваан зүйлс:

а/ Бөөлжис ам дүүрвэл.

б/ Нулимахад цус нулимснаас их бол.

в/ Ходоод элэгнээс гарах шингэн цус.

3. Арьснаас ялгарах.

а/Цус шарх шар ус салангидаар гарвал.

б/Цэцэг өвчин, алимад хатигнаас гарах цус, шар ус гүсл абдестэнд угаах хэрэгтэй газар тархвал жишээ нь хамраас гарах цус ясыг нэвтэрвэл, чих чихний ухархайгаас гарвал.

в/Хатиг ба шархны цус, шар усыг хөвөнгөөр шингээвэл.

г/Мисвак ба шүдний чигжүрийн цус аманд орвол.

д/ Чих гэдэс хөхөнд өвчин зовиурлан шингэн ялгарвал. е/

Шавьж их цус сорвол абдест буснина.

4. Унтах

Хажуугаараа хэвтэж унтаад сэрэхдээ тохой болоод ямарваа нэг зүйлд тулж босвол абдест буснина.

5. Ухаан алдах, галзуурах, саа өвчин тусах, алхахад ганхахаар согтох нь абдестийг бусниана.

6. Рүкү ба сеждетэй намаазд чангаар инээх нь намааз болоод абдестийг бусниана. Харин хүүхдийн абдест намааз бусниахгүй. Намаазд инээмсэглэх нь намаазыг ч абдестийг ч бусниахгүй. Хажуу дахь хүмүүс сонсвол тас тас хөхрөх гэнэ. Өөрөө ч сонсохгүй бол инээмсэглэл гэнэ.

7. Мүбашерет-и фахише. Өөрөөр хэлбэл нүцгэнээр ичимхий газраа үрэх нь эрэгтэй ба эмэгтэйн абдестийг бусниана.

Абдест авснаа мэдээд дараа нь буснисан хэмээн сэжиглэвэл абдест бусниагүйд тооцно. Абдест буснисныг мэдээд дараа нь абдест авах үедээ эргэлзвэл абдест авах хэрэгтэй болно.

Абдестийг үл бусниах зүйлс

Эдгээр нь абдестийг бусниахгүй:

1. Ам, чих, арьсан дахь шархаас гарах өт хорхой.
2. Бага хэмжээний бөөлжих.
3. Цусаар бөөлжихөд гарах шингэн цус бөөлжиснөөс бага бол.
4. Шүлсэн дэх цус түүнээс бага бол.
5. Толгойгоос гарах хатсан цус их байлаа ч гэсэн.
6. Ходоод болоод элэгнээс гарах хатуу цус ам дүүрэхгүй бол.
7. Чихэнд дусаасан цус чих буюу хамраас гарвал.
8. Хамарт орсон зүйл хэдэн өдрийн дараа буцаж гарвал.
9. Нэг зүйлийг хазахад тэр зүйл дээр цус үзэгдвэл.
10. Өвдөлгүйгээр ямар нэг шалтгаанаар уйлах юм уу сонгино, утаа, хийгийн нөлөөгөөр нүдний нулимс асгарвал.
11. Эмэгтэй хүн хүүхдээ хөхүүлбэл.
12. Их ч гэлээ хөлөрвөл.
13. Ялаа шумуул, бөөс, самбарын өт гэх мэт шавьж их хатгалаа ч гэсэн.
14. Бага хэмжээтэй үл тархах цус ба ам үл дүүрэх бөөлжисөөр бөөлжих.
15. Унтахдаа тулж байсан зүйлийг авахад унахгүй бол.
16. Намаазд унтах.
17. Нохой сууж толгойгоо өвдгөн дээрээ тавьж зүүрмэглэвэл.
18. Хөлөө нэг тийш нь жийж газарт сууж зүүрмэглэвэл.
9. Нүцгэн амьтны дээр зүүрмэглэвэл амьтан босвол эсвэл тэгш газар явж байвал.
20. Намаазд инээмсэглэх.
21. Намаазын үед инээхийг зөвхөн өөрөө сонсвол Дахк гэнэ. Дахк намаазыг бусниана.
22. Үс хууз сахал авах хумс хэрчих.
23. Шархны гэр унавал абдест буснихгүй.

Абдестийн хөнгөлөлт Дан гутал ба шархны боолт дээр гараараа илж арчих

Мэсх гэдэг нь илж арчих гэсэн үг. Хоёр төрлийн месх байна.

1. ДАН ГУТАЛТАЙ ҮЕД ИЛЖ АРЧИХ: Мест гэдэг нь хөлний угаах нь фарз болох газрыг хучсан, ус үл нэвтрэх гутал гэсэн үг. Месх их болж хуруу дан гутлын хоншоор хүрэхгүй бол илж арчихуй хоосон зайтай бол зөвшөөрөхгүй. Мест нь нэг цаг замд алхангуут хөлнөөс мултран тайлагдахгүй байх хэлбэрээр бат бэх хөлд тохиромжтой байх хэрэгтэй. Хөлний улаар хөл дээрээ эсвэл зөвхөн ул нь арьсаар бүрхсэн оймсон дээр илж арчих нь шашны зүй юм. Хатуу болоод алхахад доош үл унах илж арчих нь шашинд тохирох юм.

Дан гутал абдестгүй байдал хүний хөлөнд норохоос хамгаалдаг. Хөлийг угаасны дараа дан гутлыг өмссөний дараа абдест авах нь шашинд зүй юм.

Месх буюу илж арчихуй нь дан гуталтай үед хийгднэ. Местийн доор өөрөөр хэлбэл уланд нь месхийг үл хийнэ.

Сүннетээр месх хийхийн тулд баруун гарын нойтон таван хуруу баруун хөлийн гутал дээр зүүн гарын хуруунууд ч зүүн хөлийн гутал дээр үзүүрээс төгсгөл хүртэл наалдуулан хөлийн хуруун дээр ирэх үзүүрээс гутлын түрий хүртэл татна. Гараар илж норгоно, местэд үл хүрнэ. Месх гурван хуруу өргөнтэй бас урт байх нь фарз юм.

Месхийг гарын гадна талаар хийх нь шашинд тохирох буюу жайз боловч дотор талаар хийх нь сүннет юм.

Нойтон өвсөн дээр алхаж бороонд местүүдийн дээд хэсэг норвол месх орлоно.

Месттэй үеийн месхийн хугацаа суурин суух хүний хувьд хорин дөрвөн цаг, аянчин хүний хувьд гурван өдөр гурван шөнө өөрөөр хэлбэл далан хоёр цаг юм. Энэ хугацаа местийг өмссөн цагт бус мест өмссөний дараа абдест нь буснисан цагт эхэлнэ. Дан гуталтай хүн абдест буснисаас хойш хорин дөрвөн цаг өнгөрөөгүй байхад аян замд гарвал энэхүү местэд гурван өдөр гурван шөнө месх хийж болно. Зочин байхдаа суурин суугч бол хорин дөрвөн цаг өнгөрсөн бол местээ гаргаж хөлөө угаагаад абдест авна.

Хөлний гурван хуруу багтах хэмжээнд урагдсан местээр месх хийх шашинд тохирохгүй. Урагдсан нь үүнээс бага бол месх шашинд тохирох юм. Нэг мест буюу дан гутал хэд хэдэн газар бага хэмжээгээр урагдсан бол эд нар бөөгнөвөл гурван хуруу хэртэй болбол энэ үед месх хийх нь шашинд тохирохгүй. Нэг дан гуталд хоёр хуруу бусад дан гутал хоёр эсвэл нэг хуруу үзэгдэх чинээний уранхай бол үүнд месх хийж болно.

2. ШАРХ БООЛТТОЙ ҮЕД ИЛЖ АРЧИХ: Шарх, хатиг, арьс Задарч зүсэгдсэн бол эсвэл дотор нь хийсэн гавар түрхэц хөвөн оосор хийн даавуу фластер ороох холбоо гэх мэт зүйл задрах хийгээд ил гаргахад шарх сэдэрвэл эсвэл боолттой бол угаахын оронд дээр нь нойтон гараараа илж арчина.

Ийм шалтгаантай хүн хүссэн цагтаа абдест авна. Авсан абдестээрээ хүссэн үедээ фарз ба нафиле үйлдэх ба Күраан-и керим уншина. Намаазын цаг дуусвал абдест нь буснина. Намаазын цаг бүрт эхэлсний дараа шинэ абдест авч энэхүү цаг дуустал бүхий л ибадетийг хийнэ.

Өртэй болохын тулд абдестийг бусниах зүйл үргэлжлэх ёстой. Өөрөөр хэлбэл, амжаад намаазын цагийн дотор абдест авч зөвхөн фарзыг үйлдэх хугацаанд абдесттэй байж чадаагүй хүн шалтагтай буюу өзр болно. Өзртэй хүний өзр нь дараах намаазын цаг бүрт нэг удаа бага зэрэг ялгарвал өзр нь үргэлжилж байгаа хэмээн тооцогдно.

ГҮСЛ
/Биеийн абдест/

Намааз зөв болохын тулд абдест хийгээд гүсл зөв байх хэрэгтэй. Бохирдсон /Жүнүб/ эм ,эр аль аль нь, сарын тэмдэг төрөлтийн дараах үед байх эмс намаазын цагийн төгсгөлд тэрхүү намаазыг үйлдэх хүртэл цаг хугацаа үлдэхэд гүсл абдест авах нь фарз юм. Бохирдол нь хурьцаж, үрийн шингэн ялгарснаар үүснэ.

Манай Пайгамбаар Элч саллалахү алейхи ве селлем айлдруун:" Гүсл абдест авахаар босох хэн нэгэнд биенд нь байх үснийх нь тоогоор ширхэгчлэн буян нэмэгднэ. Тийм хэмжээний нүгэл өршөөгднө. Диваажин дахь зэрэглэл нь дээшилнэ. Гүслынх нь

төлөө түүнд өгөгдөх буян энэ ертөнцөд оршигч бүх зүйлээс илүү буянлаг байх болно. Аллаах сахиусан тэнгэр нарт энэхүү боол хар шөнө залхайралгүй босч миний тушаалыг бодож бохироо угааж гүсл хийж байна. Энэхүү боолын нүглийг өршөөж хүлцсэнийг та нар гэрчлэгтүн" хэмээн айлджээ.

Өөр нэг хадис-и шерифт "Хиртэх юм бол хурдхан гүсл абдест авагтун. Учир нь кирамен катибын сахисан тэнгэр нар жүнүб байдлаар хэсүүчлэх хүнд гомдно" хэмээн айлдсан байна. Имаам-и Газали рахметуллахи алейх өгүүлрүүн "Хэн нэгэн зүүдэндээ надад хэлэхдээ нэг хэсэг хугацаанд бохир биетэй байв. Одоо надад гал цамц өмсгөв. Одоог хүртэл гал дунд байна. Нэгэн хадис-и шерифт "Зураг, нохой, бохирдсон хэн нэгэн байх гэрт энэрэл нигүүлсэл сахиус тэнгэр нар орохгүй" хэмээн айлджээ .

Намааз үйлдэж эс үйлдэх хүн бүхэн нэгэн намаазын цагийг бохирдсоноор өнгөрөөвөл маш их зовлон үзэх болно. Усаар угаах боломжтой бус бол тееммүм хийх хэрэгтэй. Бохирдсон хүн эдгээрийг хийж үл болно:

1 Ямар ч намаазыг үл хийнэ

2 Кураан-и керим ба аятүүдэд гар хүрч үл болно.

3 Кабег тойрч мөргөж болохгүй

4 Жами ба месжидэд орж болохгүй

Гүслын Фарзууд

Ханефи мезхебд гүслын фарз гурав байдаг:

1. Амаа угаах. Амны дотор зүүний үзүүрийн хэртэй нороогүй хэсэг үлдвэл шүдний дээд хэсэг ба шүдний онгорхой норохгүй бол гүсл болохгүй.

2. Хамраа угаах. Хамар дахь нусны дор, аман дахь зажлаагүй талхны доор ус нэвтрэхгүй бол гүсл болохгүй. Ханефи мезхебд ам хамраа угаах абдест авах үед ч гүсл нь фарз юм. Шафи мезхебд гүсл угаахдаа ниййет хийх нь бас фарз юм.

3. Биеийнхээ бүх хэсгийг угаах. Хүйсний хонхор, сахал, хөмсөг ба хуузны доод хэсэг дэхь арьс, толгойн үсийг угаах нь фарз юм. Хумс, уруул, нүдний зовхи болон биеийн аль нэгэн хэсэгт ус үл нэвтрэх зүйлс байвал, хумсанд хумсны будаг байвал гүсл абдест авсанд тооцогдохгүй.

Гүслын сүннетүүд

1. Эхлээд гараа угаах.
2. Бэлэг эрхтэн ба хойт сүвэгчийг угаах.
3. Бүх биеэ хир буртгаас цэвэрлэн салгах.
4. Гүслаас өмнө абдест авах, нүүрээ угаахдаа гүслийг зорин хүсэх. Шафийй мезхэбд ниййет хийх нь фарз юм.
5. Бүх биеэ гурван удаа зүлгэж угаах.
6. Бүх биеэ угаасны дараа хоёр хөлөө унгаах.

Гүсл абдестийг хэрхэн авах вэ?

Сүннетийн замаар гүсл абдестийг доорх байдлаар авна:

1. Эхлээд цэвэр ч байлаа гэсэн хоёр гар, ичимхий газрууд, биеийнхээ бохир заваан хир буртагтай хэсгийг угаах хэрэгтэй.

2. Дараа нь бүтэн абдест авах ёстой. Нүүрээ угаахдаа гүслд нийет хийх хэрэгтэй. Хөлнийх нь доор ус үл хуримтлагдвал хөлөө хамгийн сүүлд угаах хэрэгтэй.

3. Дараа нь бүтэн биедээ гурван удаа ус цутган угаах ёстой. Эхлээд гурван удаа толгой руу, дараа нь баруун мөр, дараа нь зүүн мөрөнд цутгаж, цутгах бүртээ тэрхүү тал бүхэлдээ норох хэрэгтэй. Эхний ус цутгахад биеэ зүлгэх хэрэгтэй.

Гүслд нэг эрхтэн рүү асгасан усыг өөр бусад эрхтэн лүү цутгавал тэр хэсэг ч цэвэрлэгдэнэ. Учир нь гүслд бүх бие нэг эрхтэнд тооцогдоно. Абдест авахдаа нэг эрхтэнд цутгасан усаар өөр нэг эрхтэн норвол угаагдсанд тооцогдохгүй. Гүсл бүрэн болвол дахин абдест авах нь мекрүх юм. Гэхдээ гүсл хийхдээ абдест буснивал дахин нэг удаа авах хэрэгтэй болно.

ТАЙЛБАР: Шүд бөглөөс ба бүрхээстэй үед:

Ханефи мезхебд шүдний завсар ба шүдний онгорхой норохгүй бол гүсл бүрэн гүйцэд болохгүй. Иймээс шүдийг бөглөж бүрхвэл гүсл абдест жинхэнэ болохгүй. Хүн бохирдлоосоо салахгүй. Алт мөнгө ба бохир үл болох бусад зүйлээр хийсэн бөглөөс бүрхүүлийн дотуур ус нэвтрэхгүй бол Ханефи мезхебийн эрдэмтэн мэргэдийн олонхийн үзэхээр гүсл абдест шашинд тохирохгүй.

Тахтави “Меракыл-ферлахр” тайлбарын ерэн зургадугаар хуудсанд үүнээс гадна үүний орчуулга болох “Нимет-и Ислам” номонд ийнхүү бичиж байна.: Нэг Ханефи хүн өөрийн мезхебийн дагуу хийж чадаагүй үйлийг хийхийн тулд Шафий мезхебийн дууриах нь хангалтгүй юм. Бахр-үр–райк ба Нехр-үл-фаык зэрэг номноо ийн бичигджээ. Гэхдээ энэхүү үйлийг хийхэд тэрхүү мезхебийн болзлыг биелүүлэх хэрэгтэй. Хараж татвар зовлон бэрхшээлгүй шарт болзлуудыг гүйцэтгэлгүйгээр дууриавал тэр хүнийг мүлеффик гэх ба амар хялбарыг цуглуулагч гэнэ. Ийм хүн шашинд тохирохгүй.

Өөрийн мезхеб дэхь нэг фарзыг үл хийгч хэн нэгэн хүн энэхүү фарзыг хийхйн тулд бусад мезхебийг дууриах хэрэгтэй. Гэхдээ энэ ажлыг хийхдээ дагаж дууриасан мезхебийн шартуудыг ч биелүүлэх хэрэгтэй. Шүдээ бүрхүүлж бөглөөс хийлгүүлсэн Ханефи мезхебд хамаарах хүн Малики эсвэл Шафий мезхебүүдийг дууриахын тулд гүсл абдест намаазд хүсэн зорихдоо Имам-и Малике ба Имам-и Шафийг дагахдаа санах нь хангалттай. Өөрөөр хэлбэл гүсл абдест авч эхлэхдээ / Малике ба Шафий мезхебийг даган зохицохоор зорин хүслээ би гэх үгийг зүрх сэтгэлдээ болгоох хүний гүсл абдест жинхэнэ болно. Амандаа бүрхүүл бөглөөстэй Ханефи мезхебийн хүн ийн зорин хүсэхэд гүсл өөрөөр хэлбэл бүтэн биеийн абдест нь үнэн мөн болно. Бохирдолтоос чөлөөлөгдөж цэвэршнэ. Малики ба Шафий мезхебийг даган дууриавал абдест ба намааз нь үнэн мөн болно. Шүдний бүрхээс ба бөглөөстэй биш хүмүүст ч имам болж болно.

Шафий мезхебийг дууриагчийн имаамын ард Фатиха сүрег унших нь өөрийн болоод бусдаар дамжуулаад северейнд өөрөөр хэлбэл хоёр абдест бусниах хоёр эрхтэнд гарын алгаараа хүрвэл сүйлж гэрлэх нь харам болох, арван найман ??? эмээс өөр эмийн арьсанд арьс нь хүрвэл абдест авч абдестийг зорин хүсч бага бохироос зайлсхийх хэрэгтэй. Кураан-и керимийг гартаа барих үед Шафий мезхебийнхээр абдесттэй байх хэрэгтэй. Ханефи мезхебд хамаарах нэг аялагч Шафий мезхебийнхийг даган давтаж үд ба орой болоод шөнийн намаазыг урдьчлуулж хойшлуулж хамт цугаар үйлдэхийн тулд Шафий мезхебийнхээр абдесттэй байх хэрэгтэй.

Эмэгтэйчүүдийн сарын тэмдэгтэй ба төрсний дараах байдал

Арван нэгэн төрлийн гүслийн абдест байдаг. Тав нь фарз юм. Эдгээрээс хоёр нь эмэгтэйн сарын тэмдэг ба төрсний дараах үеэс салангуут гүсл абдест авах хэрэгтэй.

Ибни Абидин Менхел-юл-вардин нэрт зохиолдоо Мусылмаан эрэгтэй бүрийн эмэгтэй хүн бүрийн шашны амьдралын дүрмийн сурах нь фарз болохыг исламын хууль эрхийн мэргэд үг санал нэгтэйгээр заасан. Мусылмаан эмэгтэй хүн бүр сарын тэмдэг ба төрсний дараах үеийн талаар мэдэх нь фарз юм. Мусылман эрэгтэй хүн бүр гэрлэх цагтаа сарын тэмдэг ба төрсний дараах үеийн мэдлэгийг сурч мэдэх хэрэгтэй. Гэрлэнгүүтээ эхнэртээ ч гэсэн заах хэрэгтэй.

Сарын тэмдэг нь найман нас дүүргэж есөн нас хүрсэн эрүүл охин болоод сарын тэмдэг нь сүүлийн минутаас арван таван өдөр өнгөрсөн эмэгтэйд үзэгдэн багадаа гурван өдөр үргэлжлэх цусыг хэлнэ. Төрсний дараах үе гэдэг нь цус гарах гэсэн үг. Эмэгтэй хүнд төрсний дараа үзэгдэх цус юм. Энэ цусны хамгийн бага хугацаа байхгүй. Цус зогсвол тэр даруй гүсл абдест авах хэрэгтэй. Хамгийн урт хугацаа нь дөчин өдөр юм. Дөчин өдөр гүйцэнгүүт цус нь тасалдахгүй ч гэсэн гүсл хийж намазаа эхлэнэ. Дөчин өдрийн дараа ирэх цус өөрөөр хэлбэл шалтаг болно. Эмэгтэйчүүдийн сарын тэмдэгтэй өдрөө тогтоон цээжлэх хэрэгтэй.

Нифас, амаржсны дараах цус хамгийн бага хугацаа гэж тодорхой хугацаа байхгүй. Цус тогтонгуут хурдхан гусул авах хэрэгтэй.ахмгын урт хугацаа нь 40 хоног юм.энэ 40 хоног дуусангуут цус тогтоогүй байлаа ч гуслаа аваад намаазаа эхлэх нь зүй.40хоногийн дараа үзэгдэх цус нь истихаза буюу шалтаг цус мэт.эмэгтэйчүүд нифас эхэлсэн өдрөө цээжлэх хэрэгтэй.

Истихаза /шалтаг цус/ гурван өдөр өөрөөр хэлбэл далан хоёр цагаас таван минүт ч болов бага болох шинээр эхлэгч нарт арван өдрөөс удаан үргэлжлэх хуучных бол сарын тэмдгээс их байж арван өдрийг хэтрэх жирэмсэн тавин таван насыг давсан /аисе/ эмэгтэйчүүд есөөс бага насны охидод үзэгдэх цусыг хэлнэ. Энэ нь цусны өвчний шинж тэмдэг юм. Урт хугацаанд ялгарах нь аюултай бөгөөд эмчид хандах хэрэгтэй.

Истихаза шалтгаантай эмэгтэй байн байн хамраас нь цус гоожих хүн энэ нөхцөлд намаз үйлдэж мацаг барьж болно.

Сарын тэмдэг хийгээд төрсний дараах байдалтай байхдаа эмэгтэй хүн намааз үйлдэж, мацаг барьж болохгүй. Тилавет ба шүкир сежде хийж болохгүй. Кураан-и керимд гар хүрч болохгүй. Жами ба месжид рүү орж болохгүй. Кабег тойрч мөргөж болохгүй. Ватйд оршиж болохгүй. Цэвэрлэгдвэл мацагаа каза хийж намаазаа каза хийж болохгүй. Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем "сарын тэмдэг эхэлсэн хийгээд дууссаныг эр нөхрөөсөө нуух эмэгтэй хараагдна" хэмээжээ. Сарын тэмдэг хийгээд төрсний дараах байдал төгсвөл тэр даруй гүсл хийж биеэ угаах фарз гэх нь Аллахын захирамж мөн.

ТЕЕММҮМ

Тееммүм нь шороогоор цэвэрлэх гэсэн үг. Абдест авах эсвэл гусл үйлдэхийн тулд хэрэгтэй ус байхгүй ус байлаа ч хэрэглэгдэх боломжгүй нөхцөл байдалд цэвэр шороо элс шохой чулуу гэх мэт шороон төрлийн цэвэр зүйлээр Ханефид цаг хугацаа эхлэхээс өмнө ч тееммүмийг үйлднэ. Бусад гурван мэзхебийн хувьд цаг хугацаа эхлэхээс өмнө үйлдэх нь шашинд үл тохирно.

Тееммүм абдест ба гүслийн хөнгөвчлөл болно. Манай шашинд шороогоор тееммүм хийх нь усаар цэвэрлэхтэй адил их хэмжээний хир буртгийг шороогоор цэвэрлэж болохыг ил тодоор үзүүлж байна.

Тееммүмийг шаардах үндсэн нөхцөл байдал нь доорх байдалтай юм.

1. Абдест ба гүслд хэрэглэх цэвэр ус олдохгүй бол.
2. Хотод үргэлж ус эрж хайх нь фарз үүрэг юм.
3. Ус хэрэглэхэд саад болох өвчин эмгэг, ус хэрэгдэхэд хүйтэнд нас нөгчих эсхүл өвдөх аюул байх.
4. Усны дэргэд дайсан эсхүл махчин араатан, хортой амьтдын аюулаас айх.
5. Шорон гянданд байж ус хэрэглэж чадахгүй байх.
6. Үхлийн заналд өртөх.
7. Замд зорчих үед хажууд нь уух уснаас илүүчлэх ус байхгүй байх.
8. Худгаас ус гаргах боломж байхгүй байх.

Тееммүмийн фарз

Тееммүмд гурван фарз байна:

1 Бохирдлоо цэвэрлэх эсвэл абдестгүй байдлаа арилган цэвэрлэхийн тулд зорин хүсэх.

Абдестгүй хүн шавьдаа үзүүүлэх гэж тееммүм хийвэл үүгээр намааз үйлдэж болохгүй..

2 Хоёр гарынхаа алгыг цэвэр шороонд хүргэж нүүрээ бүхэлд нь гараараа илж арчих.

3 Гарын алгаараа цэвэр шороонд хүрч эхлээд баруун дараа нь зүүн гараа илж арчих явдал юм.

Тееммүмийн фарз хоёр гэж хэлэгчид байдаг. Хоёрдох ба гуравдах фарзыг нэг фарз хэмээн хэлж байна. Хоёр хэлбэр аль аль нь зөв юм.

Тееммүмийн сүннет

1. Бесмелегээр эхлэх.
2. Шороонд гараа хүргэх.
3. Гарын алгаа шороонд үрэх.
4. Гарын алганд шороо байгаа бол тэр шороог дуустал хоёр гарыг таван хуруугаар нэгийг нөгөөтэй нь хавсран үрэх .
5. Гарыг шороонд хүргэхдээ хуруугаа дэлгэх.
6. Эхлээд нүүрээ дараа нь баруун гар дараа нь зүүн гараараа илж арчих.
7. Абдест авч буй мэт хурдан хийх.
8. Гарын шуу нүүрэнд месх буюу гараа хүргээгүй газар үлдэхгүй байх.
9. Тееммүмээс өмнө хүссэн газартаа ус эрэх.
10. Гараа шороог цохин хүчтэй оруулах.
11. Гарын шууг дээр өгүүлсэн байдлаар гараараа илж арчих.
12. Хурууны салааг месх хийх үед бөгжөө хөдөлгөх.

Тееммүмд эдгээрийг анхаарах хэрэгтэй

1. Абдестгүй хүн шавьдаа үзүүлэхийн тулд тееммүм хийвэл тэрхүү тееммүмээр намааз хийгдэхгүй.

2. Тееммүмээр намааз үйлдэхийн тулд зөвхөн тееммүмийг зорин хүсэх хангалтгүй Намаазыг зорин хүсэх хэрэгтэй.

3. Нэг газрын шорооноос хэд хэдэн хүн тееммүм хийж болно. Учир нь тэйэммүм хийгдэх шороо гэх мэт нь хэрэглэсэнд тооцогдохгүй. Тееммүмийн дараа гар нүүрээс унах тоосыг хэрэглэгдсэн гэж үзнэ.

4. Шафий ба Ханбелид тееммүмийг зөвхөн шороогоор хийнэ Бусад мезхебүүдэд шорооны төрлийн ямар ч цэвэр зүйлээр дээр нь эдгээрийн тоос байхгүй байлаа ч гэсэн тееммүм хийнэ Шатаж үнс болсон эсхүл халуунд хайлах зүйлс шорооны зүйлд хамаатахгүй. Ийнхүү мод өвс нимгэн мод, төмөр, будаа, тосон будагтай хана, зэс, алт, шилээр тееммүмийг хийхгүй. Элс болно. Сувд, шүр болохгүй. Шохой ба гөлтгөнөөр угаасан гантиг цемент шаазан шанага сав шавар болно. Харин шавар байх үед ус чийг талаас илүүгүй бол тееммүм хийдэг.

5. Нэг тееммүмээр төрөл бүрийн намааз хийх нь шашинд тохирох юм. Жуулчин хоёр километрээс бага зайд ус байхыг шинж тэмдэг эсхүл ухаантай насанд хүрсэн шударга мусылмаан мэдээлвэл ихэд мэдэрч бодох үед бүх тал руу хоёр зуун метр явж эсхүл хэн нэгнийг илгээж эрэх фарзтай байна. Сайн мэдрэхгүй бол усыг хайх хэрэггүй. Хэн нэгнээс ус асуулгүйгээр тееммүм хийж намаазанд зогсвол дараа нь хажууд нь байх шударга хүнээс ус байгаа гэх мэдээг авбал абдест авч намазаа шилжүүлнэ.

6.Хоёр километрээс хол зайд ус байхад тееммүмээр намаз хийх нь шашинд тохирох юм

7. Эд юмсынх нь дунд ус байгааг мартсан хүн хот хөдөөд биш бол тееммүмээр намааз хийж болно

8.Усаа дууссан гэж бодсон хүн намаазын дараа усаа харвал тееммүмээр хийсэн намаазаа ахиж үйлднэ. Жуулчин хажууд байгаа хүнээс ус хүсэх нь важиб юм. Ус өгөхгүй бол тееммүмээр хийнэ. Найз нь усыг зах арилжааны үнээр зарвал мөнгө их жуулчин худалдаж авах нь хэрэгтэй устай хүн усаа хэт мэхлэн дамлан зарвал тееммүмээр мөргөл үйлдэхийг шашин зөвшөөрөх болно. Зах арилжааны үнээр авах мөнгө үгүй бол тееммүм хийнэ

9. Цөл газар замд уухын тулд бэлдсэн ус байгаа бол тееммүм хийж болно

10. Ус бага бол бохирдсон хүн сарын тэмдэгтэй эмэгтэйгээс

абдестгүй өөд болоочоос өмнө угаах хэрэгтэй. Усны эзэн бусдаасаа түрүүлэн угаана. Өөр өөр эзэнтэй усыг нийлүүлсэн үед эхлээд өөд болоочийг угаана

Бохирдсон /Жүнүб/ хүн тееммүм хийсний дараа абдест нь буснивал бохирдсон болохгүй. Бага ус байвал зөвхөн абдест авна

11. Бохирдсон хүн биеийн гадаргын талаас илүү нь шарх, яр, цэцэг улаан гэх өвчтэй бол тееммүм хийнэ. Арьсны ихэнх хэсэг бүрэн бүтэн бол шархтай хэсгийг норголгүйгээр угаах боломжтой бол гүсл хийнэ. Шархтай хэсгийг норголгүйгээр угааж болохгүй бол мөн л тееммүм хийнэ.

Тееммүмийг хэрхэн хийх вэ?

1. Эхлээд бохирдсон ба абдестгүй байдлаас цэвэрлэгдэхийн тулд зорин хүснэ. Тееммүмээр намааз хийхийн тулд зөвхөн тееммүмд зорин хүсэх хангалттай бус. Ибадет болох өөр зүйлийг жишээ нь оршуулгын буюу женазе намаз, сежде-и тылавет хийх эсхүл абдест гүслийн төлөө тееммүм хийхээр зорин хүсэх хэрэгтэй.

Тееммүмийг зорин хүсэхэд абдест ба гүслыг ялгах шаардлагагүй. Абдестийг зорин хүссэнээр бохирдол ч цэвэршинэ. Бохирдлыг цэвэрлэхээр зорин хүссэн тееммүмээр намааз үйлдэж болно. Абдестийн төлөөнөө хоёрдогч тееммүм шаардлагагүй.

2. Хоёр гараа тохойноос дээш шавсан байдлаар хоёр гарын алгыг шороо чулуу болон шохойгоор шавсан хананд хүргэж багадаа гурван хуруу хүрэх байдлаар хоёр алгааараа нүүрээ месх хийх өөрөөр хэлбэл илэх. Гар нүүрэнд зүүний үзүүрийн чинээ газар хүрэхгүй бол тееммүм хийсэнд тооцогдохгүй.

Нүүрээ бүрэн месх хийхийн тулд гарын алга дэлгээстэй дөрвөн хуруу нэг нь нөгөөдөө нийлсэн хоёр гарын хоёр дунд хурууны үзүүр нь нэг нь нөгөөдөө хүрсэн байж гарын алгыг үсэнд хүргэн эрүү рүү удаан доошлуулна. Хуруунууд хөндлөн байдлаар магнай нүдний зовхи хамрын хоёр хажуу уруулын дээр эрүү нүүрний хэсгийг сайтар илэх хэрэгтэй. Энэ үед гарын алгаар хацрыг илнэ.

3. Хоёр алгаа дахин шороонд хүргэж нэг нь нөгөөтэй нь хавсраад тоосыг шороонд гөвсний дараа эхлээд зүүн гарын дөрвөн хурууны дотор талаар баруун гарын доод хэсгийг хурууны үзүүрээс тохой тийш илж гарын дотоод хэсгийг зүүн алгаар тохойгоос алга хүртэл

Илэх, дараа нь зүүн эрхий хурууны дотор талаар баруун эрхий хурууны гадна талыг илнэ. Бөгжөө тайлах хэрэгтэй. Дараа нь дахин ийнхүү баруун гараар зүүн гарыг илнэ. Гарын алгыг шороонд хүргэх ёстой. Шороо тоос гарт үлдэх шаардлагагүй.Абдест ба гүслийн тееммүм ижил юм.

Тееммүмийг бусниах зүйлс

Тееммүмийг шаардах шалтаг нөхцөл байдал алга болох хийгээд ус олдож абдест гүслийг бусниах үед тееммүмыг ч бусниана.

Абдест, гүсүл, тееммүмийн ач тус

Ибадетийн зорилгоор хийх хоёр цэвэрлэгээд бие махбод эрүүл байхад хэрэгтэй их олон ашигтай зүйлс бий. Бие махбод хийгээд сэтгэл зүй эрүүл ахуйн талаас ч олон ач тус байдаг. Судалж тогтоосон тоолж барамгүй олон ашиг тусаас заримыг нь доор жагсаан үзүүлж болно.

1. Өдөр тутмын амьдралд бидний гар хүрээгүй газар, бидэнд халдаагүй нян гэж байдаггүй билээ. Ийнхүү абдест авахдаа гар нүүр хөлөө угаах нь арьс өнгөний өвчин үрэвслээс хамгийн сайнаар хамгаалах арга юм. Зарим нэгэн нян, шимэгч хорхой, бактери биенд арьсаар дамжин ордог.
2. Амьсгалын тогтолцооны шүүлтүүр болдог хамрыг угааснаар тоос болоод нянгийн бөөгнөрөл хуний биед нэвтрэхээс сэргийлнэ.
3. Нүүр угаах нь арьсыг хүчжүүлэн бэхжүүлэх ба тархи толгойн өвчин ядаргааг хөнгөлж өгнө. Судас мэдрэлийг хөдөлгөөнд оруулна. Үргэлжид абдест авагчид хөгширч өтөллөө ч гэлээ нүүр царайных нь сайхан толио арилдаггүй нь ийм шалтгаантай юм.
4. Бохирдлын шалтгаан болох нөхцөл байдалд их чармайлт хүч зарцуулах ба зүрх цудасны эргэлтийн хурд ихэсч амьсгаа нэмэгддэг. Бие махбод хэт ажилласнаас болж ядарч залхах зохирол сулрах нь мэдэгдэх ба ерөнхийдөө сэтгэхүйн үйл ажиллагаа нэлээдгүй удааширна. Гүсл хийснээр бие махбодь урьдын эрч хүчээ олж авна. Бие махбодийг тодорхой зай завсартайгаар үргэлж угаах нь хамгаалах эмчилгээний талаас маш чухал юм.

5. Бидний бие махбодийн ердийн нөхцөлд зогсонги цахилгааны тэнцвэр байдаг. Бие махбодийн эрүүл мэнд энэхүү цахилгааны тэнцвэртэй шууд холбоотой. Энэхүү тэнцвэр сэтгэлзүйн төвөгтэй байдал цаг агаарын нөхцөл, хувцас хунар, амьдрах болоод ажлын газар энэ хооронд гуслыг шаардах нөхцөл байдлаар буснина. Энэхүү цахилгааны ачаа тээш уурлах үед хэвийнхээс дөрөв дахин гусл шаардагдах нөхцөл байдалд арван хоёр дахин ихэсдэг. Өдгөө цагт "Хэт ягаан" туяагаар гаднах арьсны тусгай зургийг авсан ба энэхүү гэрэл зурагт бэлгийн хаьцаанд орсны дараа биеийн бүх гадаргуу хэт тогтонги цахилгаан давхарганд бүрхэгддэгийг тогтоосон билээ. Энэхүү давхарга арьсны хүчилтөрөгчийн солилцоонд саад болохын сацуу арьсны өнгө гундаж амархан хорчийж үрчийх шалтгаан болно. Энэ байдлаас чөлөөлөгдөхийн тулд бие махбоийн зүүний сүвэгч хэмжээний газар үлдэхгүй байх байдлаар бүхэлд нь угаах хэрэгтэй. Ийнхүү усны бөөмс дусал нь сөрөг цахилгааны хүчдлийг зайлуулж биеийг хөрсжүүлж дахин хэвийн байдалд нь буцаан оруулна. Ийнхүү гусл нь анагаах ухааны талаас үзэхэд ч заавал хийх хэрэгтэй цэвэрлэгээ юм.

6. Абдест ба гусл абдест цусны эргэлтийн тогтолцоонд ч эерэг нөлөөг үзүүлнэ. Судасны хатуурал нарийслаас сэргийлнэ. Абдестд тохирох нөхөн сэргээл гэж байдаг. Лимфийн тогтолцоо хамгийн чухал төвийн нэг болох хамрын ар хэсэг бүйлсэн булчирхайнуудыг угааж сэргээнэ. Түүнчлэн хүзүү ба хажууг угаах нь лимфийн тогтолцоонд нөлөө үзүүлнэ. Абдест ба гүслээр хялбарших лимфийн эргэлтийн нөлөөгөөр лимфозит гэгдэх идэвхтэй эсүүд бие махбодийг хор хөнөөлтэй элементүүдээс хамгаалах ба биеийн эсрэгүүцлийг нэмнэ.

7. Ус байхгүй үед шороогоор хийгдэх тееммүм ч их хэмжээгээр бие махбод дахь тогтсон сөрөг энергийг үгүй хийнэ.

2. БОХИР БУРТГИЙГ ЦЭВЭРЛЭХ

Бие махбодь хувцас хунар ба намааз хийх газар бохир буртаг, хир буртаггүй байх ёстой. Толгойн алчуур, титэм, дан гутал ба модон углааш ч хувцаст багтна. Хүзүүг ороосон орооолтын гажсан хэсэг намааз хийгчтэй хамт байх тул хувцас гэж тооцогдох ба хэрвээ цэвэр бус бол намааз зөвшөөрөгдөхгүй. Дэвсгэрийн хөл

хүргэн толгой тавьдаг газар цэвэр бусад газар нь бохир байвал намааз зөвшөөрөгдөнө. Яагаад гэвэл дэвсгэр нь ороолт шиг бие махбодтой хамт байдаггүй. Гэхдээ таглаатай шилэн дотор шээс тээгчийн намааз шашинд тохирохгүй.

Яагаад гэвэл шил нь шээс ялгарах газар биш юм. Үүнээс халаасандаа таглаатай үнэртэн спирт үнэртэнтэй шил битүү хайрцаганд цустай алчуур, бохирдсон алчуур байхад намааз хийх шашинд тохирохгүй болно. Хоёр хөл хүрэх сежде хийдэг газар цэвэр болох хэрэгтэй. Бохир зүйлийг бүтээсэн даавуу шил нейлон дээр намаз хийхийг хүлээн зөвшөөрдөг. Сеждед хүний банзал хуурай бохирд хүрэхэд хор хөнөөл үгүй.

Арьс хувцас намаз хийгдэх газар дирхем хэмжээний эсвэл энэ хэмжээнээс их хүнд бохир буртаг байхгүй бол намааз хүлээн зөвшөөрөгдөх ба дирхем /4,8 грамм/ хэмжээ байвал тахримэн мекрүх фарз болно. Угаах нь важиб болно. Дирхемээс их бол угаах фарз юм. Бага нь сүннет юм. Дарсны дуслыг ч угаах фарз. Имамэйнэ /имам-и Эбү Юсүф ба имам-и Мүхаммед/ гийнхээр мөн бусад гурван мезхебд хүнд бохирыг бүгдийг нь юм уу өчүүхэн хэсгийг ч болов угаах нь фарз. Бохирын хэмжээ халдсан цагийнх бус намаазд зогсох үеийн хэмжээ юм.

Дирхем кала хэмжээ хатуу бохир зүйлст нэг мискал өөрөөр хэлбэл дөрвөн грамм наян дециграмм хүнд жин юм. Шингэн бохир гарын алга дэлгээстэй байх үеийн усны түвшний өргөнтэй адил талбай байна. Нэг мискалаас бага байх хатуу бохир хувцас нь алганы дотроос илүү өргөн талбайд тархвал намаз саад болдоггүй.

Бохир хоёр төрөл байдаг

1 Хүнд бохир буртаг Хүнээс ялгарах абдест эсхүл гүслын шалтгаан болсон бүхий л зүйлс мах нь үл идэх амьтан /сарьсан багваахайнаас бусад/ ба тэдгээрийн зулзаганы өвчигдсөн арьс, мах, ялгадас, шээс, хүн ба амьтны бүхий л амьтны цус, дарс, сэг ,гахайн мах гэрийн шувуу болон амьтны ялгадас ба ачлагын амьтны, хонь ямааны бохир буртаг муухай өөрөөр хэлбэл хүнд бохир юм.

2. Хөнгөн бохир буртаг Эрхтэн ба хувцасны нэг хэсэг хөнгөн бохирдвол нэг хэсэг ба эрхтний дөрөвний нэг хүртэлх бохир намаазд хөнөөлгүй. Махыг нь идэж болох дөрвөн хөлтэй амьтны

шээс махыг нь үл идэх шувууны ялгадас хөнгөн бохир юм. Тагтаа, болжмор гэх мэт махыг нь идэх шувууны ялгадас нь цэвэр юм. Дарсыг нэрснээр гаргаж авсан архи спирт нь хүнд бохир болох ба уух нь дарс мэт хараам юм. Намааз үйлдэхдээ цус, спирт согтоох эдийг хувцас хунар арьснаас угааж арилгах хэрэгтэй.

Бохир зүйлийг цэвэр ус болгоноор абдест ба гусл авсан усаар, цуу сарнайн ус мэт шингэнээр цэвэрлэнэ. Абдест гүслд хэрэглэгдэх усыг ашиглагдсан ус гэнэ. Энэхүү ус цэвэр юм. Гэхдээ абдестийг буснисан байдлыг цэвэрлэгч бус. Үүгээр бохирийг цэвэрлэнэ. Гэхдээ абдест авч гусл хийхгүй.

Истинжа буюу цэвэрлэгээ

Хүний урд хойноос гарсан өтгөн шингэн хийгээд эл хэсгийг цэвэрлэхийг истинжа гэнэ. Өөрөөр хэлбэл угаалгын өрөөнд абдест буснисны дараа эрэгтэй ба эмэгтэй чулуу ба усаар урд ба хойдохыг нь цэвэрлээд өтгөн шингэн үлдээхгүй байх нь сүннет юм. Гэхдээ бусдын дэргэд ичимхий газруудыг нээлгүйгээр усаар истинжа хийхгүй бол өтгөн ялгадас их болохгүй ч гэлээ ус ба истинжагаас татгалзана. Ичимхий газрыг задгайлж болохгүй. Намазыг ийнхүү хийнэ. Нээвэл нүгэлтэн болно. Хараам үйлдсэн болно. Аглаг зэлүүд газар болвол усаар цэвэрлэгээ хийх ба намаазыг дамжуулна. Яагаад гэвэл нэг тушаалыг хийх нэг хараамыг үйлдэх шалтгаан болж буй бол хараамыг хийхгүйн тулд тэр тушаалыг хойшлуулна эсвэл орхино.

Яс, хоол хүнс, бордоо, туйпуу, саг, шилний хэсэг, нүүрс, амьтны хоол, бусдын эд хөрөнгөөөр, үнэтэй өөрөөр хэлбэл мөнгө болох зүйлс жишээ нь торго, жамигээс хаягдсан зүйлсээр, земзем /Кабе дэхь ариун сүү/ ус, навч, цаасаар цэвэрлэх нь тахримэн мекрүх юм. Хоосон цаасыг ч хүндлэх хэрэгтэй. Үнэ хүндтэй бус нэр алдар, шашинд тустай бус бичээстэй цаас ба сониноор цэвэрлэвээс шашинд тохирох юм. Гэхдээ Ислаамын үг үсгээр бичигдсэн ямар ч цаасаар цэвэрлэгээ хийхгүй. Биеийн урд хойд талаараа кыблэ рүү хандаад зогсоогоор шалтагггүй нүцгэнээр абдест бусниах нь мекрүх юм. Шээс хуримтлагдах газар гусл хийхийг шашинд зөвшөөрөхгүй. Гэхдээ шээс урсан өнгөрөөд хуримтлагдахгүй бол шашинд тохирох болно. Цэвэрлэгээнд хэрэглэгдэх ус бохир болно. Хувцас руу үсрэхгүй байх ёстой. Үүний

тулд цэвэрлэгээг хийхэд ичимхий газруудыг нээх аглаг зэлүүд газарт хийх хэрэгтэй юм. Усны цоргоны дэргэд гараа дотоожийнхоо дотор хийж шээсний газраа алган дахь усаараа түрхэж угаах нь цэвэрлэгээ болохгүй. Шээсний дусал холилдож алганы ус бохир зүйл болох ба дуссан хувцас бохирдно. Энэ ус дуссан газрын нийлбэр алганы доторхоос илүү болбол намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй.

Истибра

Эрэгтэйчүүд алхаж, ханиаж эсвэл зүүн талд хэвтэж истибра хийх нь өөрөөр хэлбэл шээсний замд дусал үлдээх нь важиб юм. Шээсний дусал үлдээгүй гэж бодолгүйгээр абдест авч хэрэггүй. Нэг дусал нэвчвэл абдест зогсож хувцас хиртнэ. Дотуур хувцсанд гарын алганыхаас бага нэвчвэл абдест авч хийсэн намааз мекрүх болно. Их нэвчвэл намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй. Шээсээ зогсоож чадахгүй истибрагаар зовж энэлж буй хүмүүс арвайн хэмжээтэй ургамал хөвөн оосрыг шээсний сүвэндээ хийх хэрэгтэй. Нэвчих шээсийг хөвөн өөртөө шингээнэ. Гэхдээ хөвөнгийн үзүүр гадна талдаа үлдэхгүй байх ёстой.

3. СЕТР-И АВРЕТ Ичимхий газрыг нуух

Аврет Махалли ба эмэгтэйчүүдийн нөмрөх хучих ёсон

Хэн нэгний нээж бусдад үзүүлэх, бусдын харах нь харам болох газрыг Аврет махалли гэнэ. Эрэгтэйчүүдийн аврэт махалли хүйснээс өвдөгийн доод тал хүртэл юм. Өвдөг нь аврет юм. Эдгээрийг нээлттэй байхад нь хийгдэн намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй. Намааз үйлдэхэд биеийн бусад хэсгийг /гар толгойг/ хучих оймс өмсөх эрэгтэйчүүдэд сүннет юм. Эдгээрийг нээлттэй хийх нь мекрүх .

Эмэгтэйчүүдийн гарын алга, нүүрээс бусад бүх газрыг гарын гадна тал үс хөл нь дөрвөн мезхэвт аврет юм. Үүний тулд эмэгтэйчүүдийг Аврет гэнэ. Эдгээрийг хучих нь фарз юм. Аврет эрхтнүүдийн аль нэгнээс дөрөвний нэг нь нэг рүкн нээлттэй үлдвэл намааз буснин сарнина. Бага хэсэг нээгдвэл намаз үл буснина. Намааз нь мекрүх болно. Нимгэн, биеийн эрхтний хэлбэр өнгө

харагдах

даавуу болохгүй гэсэн үг.

Эмэгтэйчүүд намаазаас бусад цагт ганцаараа байхдаа өвдөг ба хүйсний хооронд хэсгээ хучих нь фарз бөгөөд нуруу гэдсээ хучих нь важиб, бусад газрыг хучих нь зүй ёс юм.

Расулуллаах саллаллахү алейхи ве селлем айлдруун: “Харь эмийг тачаадан харагчийн нүдийг галаар дүүргэн тамд аваачна. Харь эмтэй гар баригчийн гарыг нь хүзүүтэй нь холбож тамд шиднэ. Харь эмтэй хэрэггүйгээр тачаадан яригч хэлсэн үг бүрийн төлөөнөө мянган жил тамд үлднэ».

Өөр нэг хадис-и шерифт “Хөрш эм болоод найз нөхрийнхөө эм рүү тачаан шунаж харах харь эмийг харахаас арав дахин илүү нүгэл . Нөхөртэй эм рүү харах нь ганц бие охид руу харахаас мянга дахин олон нүгэл. Буруу хурьцахуйн нүгэл ийм билээ” хэмээжээ.

Расулуллаах саллалахү алейхи ве селлем айлдахдаа: Аяа Али Гуя хасаа бүү нээгтүн. Үхсэн амьд хэний ч гуя хас руу бүү харагтун!

Бас нэгэн хадис-и шерифт “Ичимхиий газраа бүү нээгтүн Яагаад гэвэл хажуунаас тань хэзээ ч үл салах сахиусан тэнгэрүүд байдаг. Тэднээс ичигтүн. Тэднийг хүндлэгтүн. Эдгээр нь Хафаза сахиусан тэнгэрүүд юм” хэмээжээ.

Мөн хадис-ир шерифүүдэд айлдахдаа: Ичимхий газраа хучигтун. Эхнэр болоод татвар эмээсээ бусдад бүү үзүүл. Гагцаар байхдаа ч гэсэн Аллаахаас ичигтүн. Өөрийгөө эмэгтэйчүүдтэй адилтгах эрэгтэйчүүдийг, эрэгтэйчүүдтэй адилтгах эмэгтэйчүүдийг Аллах хараан зүхэг!

Нэг охины гоо үзэсгэлэнг харсан хүн нүдээ түүнээс тэр даруй салгавал Аллаах нэгэн шинэ ибадетийн буян хишгийг хийх бөгөөд энэхүү ибадетийн амтыг тэр дороо мэдэрнэ.

Ичимхий газраа задгайлах, бусдын ичимхий газрыг харагчдыг Аллаах зүхэн харааг/

Өөрийгөө нэг овог лугаа адилтгагч тэдний нэг болно. Үүнээс үзвэл ёс сургахуун үйл ажил хувцас хунараа бусадтай ижилсгэгч тэднийх болно. Мода ба кафирүүдийн заншилд зохицогчид хараамыг уран сайхны урлаг хэмээн нэрлэгчид, хараамыг үйлдэгчдийг жүжигчин дэвшилт хэмээгч нар энэхүү хадис-и шерифээс сургамж авч аюужин сэрэмжлэх хэрэгтэй.

Эр эрийн, эм эмийн ичимхий газрыг харах нь хараам юм. Үүнээс үзвэл, эрчүүд эмэгтэйчүүд рүү, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн ичимхий газар луу харах нь хараам . Эрэгтэйн эрэгтэй ба эмэгтэйн аль алины хувьд ичимхий газар нь өвдөг ба хүйсний хоорондох хэсэг юм. Эмэгтэй хүний хувьд ичимхий газар ч ийм юм . Эмэгтэй хүний харь эрэгтэйн хувьд ичимхий газар нь гар биеэс гадна бүх бие нь юм. Харь эмийн ичимхий газар луу тачаан шунахгүйгээр ч гэлээ харах нь хараам юм. Хөнжилдөө нүцгэн хэвтэх өвчтөн толгой нь хөнжил дотор байхдаа далд намааз үйлдвэл нүцгэн үйлдэж болно. Толгойгоо хөнжлөөс гаргаж үйлдвэл хөнжлөөр бүтээж үйлдсэнд тооцогдох ба шашинд зөвшөөрөгджээ.

Нэг эр сүй тавьж өөрийн болгох нь үүрд хараам болох арван найман махрем гэгдэх эмэгтэйн толгой, нүүр, зүүлт, гар, өвдөгнөөс доош шилбийг тачаадахгүй гэж итгэж буй бол харж болно. Уг эр хөх, суга, ташаа, өвдөг, нурууг нь харж болохгүй.

Нэгэн эмийн хувьд авга ах, авга эгч нагац эгч ба нагац ахын хүүхэд ч харь эр мэт. Хүргэн ба хүр дүү хүр ах ч харь эр болно. Эд нартай ярих, тоглоом хошигнох, нэгэн газар цуг байх нь харам юм. Нэгэн эр махрем болох арван найман эмтэй үхэх хүртлээ гэрлэж үл болно. Эд нартай ярьж болно. Хамтаар нь аль нэг газар байж болно. Эмэгтэй ч гэсэн арван найман эрэгтэйтэй гэрлэж үл болно. Энэхүү арван найман эр ба эм нь ийм юм:

Ураг удмын ах дүүс бологчид:

	ЭРЭГТЭЙЧҮҮД		ЭМЭГТЭЙЧҮҮД
1.	Эцэг	1.	Ээж
2.	Эцэг ба эхийн эцэг	2.	Ээжийн ба аавын ээжүүд
3	Хөвгүүн хийгээд хөвгүүн ба охины хөвгүүд	3.	Охин ба хүүгийн охины охид
4.	Эрэгтэй дүү	4.	Охин дүү
5.	Эрэгтэй дүүгийн хөвгүүд	5.	Охин дүүгийн охид
6.	Эмэгтэй дүүгийн хөвгүүд	6.	Эрэгтэй дүүгийн охид
7.	Авга ах ба нагац ах	7.	Авга эгч ба нагац эгч

Сүүний ах дүүс бологчид:

	ЭРЭГТЭЙЧҮҮД	ЭМЭГТЭЙЧҮҮД
8.	Сүүн эцэг	8. Сүүн ээж
9.	Сүүн эцэг ба эхийн эцэг нар	9. Сүүн ээж аавын ээжүүд
10	Сүүн хөвгүүн,сүүн хөвгүүн ба охины хүүхүүд	10. Сүүн охин сүүн хүү
11.	Сүүн эрэгтэй дүү	11. Сүүн эмэгтэй дүү
12	Сүүн эмэгтэй дүүгийн хөвгүүд	12. Сүүн эмэгтэй дүүгийн охид
13.	Сүүн эрэгтэй дүүгийн хөвүүд	13. Сүүн эрэгтэй дүүгийн охид
14.	Сүүн авга ах нагац ах	14. Сүүн авга эгч нагац эгч

Сыхрийет /гэрлэлтээр/ ах дүүс бологчид:

	ЭРЭГТЭЙЧҮҮД	ЭМЭГТЭЙЧҮҮД
15	Хадам эцэг	15 Хадам ээж
16	Дагавар хүү	16 Дагавар охин
17	Хойд эцэг	17 Хойд эх
18	Хүргэн	18 Бэр

4. ИСТИКБАЛ-И КЫБЛЕ
/Кыбле рүү хандах/

Намаазыг Кыбле тийш хандаж үйлдэх гэсэн үг. Мекке-и Мүкеерреме хотод байх Кабегийн байшнгийн чиглэлийг Кыбле гэнэ. Анх эхлээд Куддус байв. Хижретээс арван долоон сарын дараа Шабан сарын дундуур Мягмар гарагт Кабе рүү хандах тухайд зарлигласан билээ.

Кыбле нь Кабегийн байшин бус талбай нь юм. Өөрөөр хэлбэл газраас Тэнгэрийн хүч орших газар /Арш/ хүртэл тэр хоосон зай нь кыбле юм. Үүний улмаас тэнгис далай ба худгийн ёроолд өндөр уулд нисэх онгоцонд энэ чиг тийш намааз үйлднэ. Нүдний мэдрэлийн солбилцох чиглэлийн хоорондох орон зай Кабед тохирвол намааз үнэн мөн болно. Гэхдээ:

1. Өвчний шалтгаан.

2. Эд хөрөнгө хулгайлагдах аюул.

3. Махчин амьтны заналхийлэл.

4. Дайсантай таарах аюул осол.

5. Унаа малаасаа буугаад бусдын тусламжгүйгээр мордож үл чадах бол хоёр намазыг /үд болоод ороиг , үдэш болоод шөнийг малики ба шафии мезхебийг даган дуурияж/ хамтатгаж үйлдэж чадахгүй бол, намаазаа чадал нь хүрэх газар луу хандаж үйлднэ. Усан онгоц, галт тэрэг, нисэх онгоцонд кыбле рүү хандах нь зайлшгүй болзол юм.

5. НАМААЗЫН ЦАГ ХУГАЦАА

Расүл-и экрем Саллаллахү алейхи ве селлем нэг хадис-и шерифт айлдахдаа: “Жэбрайл алехисселам Кабе хаалганы хажууд хоёр өдөр надад имаам болов. Бид хоёр үүр цайхад өглөөний намаазыг, нар уул толгодоос холдоход үдийн намаазыг, бүх юмны сүүдэр өөрийн хэмжээтэй болоход оройн намаазыг, нар жаргахад нарны дээд хэсэг үзэгдэхгүй болоход үдшийн намаазыг, гэгээ бүрий болоход шөнийн намаазыг үйлдэв. Хоёр дахь өдөр өглөөний намазыг агаар тэнгэр гэрэлтэхүйд, үдийнхийг бүх зүйлийн сүүдэр өөрийн хэмжээний хоёр дахин их болохуйд, оройг үүний дараа шууд залган оройнхийг нь мацаг бусних үед, шөнийнхийг шөнийн гуравны нэг хугацаа өнгөрөхөд үйлдэв. Дараа нь Аяа Мүхамммед Чиний ба өнгөрсөн үеийн Пайгамбаруудын намааз цаг энэ билээ. Сүсэглэн дагагчид чинь таван удаагийн намаазыг тус бүрд нь энэхүү хоёр цаг хугацааны хооронд үйлдэг гэж хэлсэн” гэв. Өдөр болгон үйлдэхээр зарлигдсан намаазын тоо хэмжээ нь тав болох нь үүнээс ойлгомжтой байна.

Өглөөний Намаазын цаг: Үүр цайснаас өөрөөр хэлбэл дорно зүгт тэнгэр цайрч эхлэхээс нар мандтал бөлгөө.

Үдийн намазын цаг: Сүүдэр богиносч уртсан эхлэх цагаас эхлэн сүүдэр нэг буюу хоёр дахин уртсах хүртэл үргэлжилнэ. Эхнийх нь хоёр имаамд өөрөөр хэлбэл Имам –и Ебү Юсүф ба Имам-и Мүхаммедийнхээр, хоёрдох нь Имма-и азам Эбү Ханифе “рахметүллахи алейхим”ийнхээр юм

Оройн намазын цаг : Үдийн цаг дуусангуут эхэлнэ. Энэ нь:

1. Имам-и Эбү Юсүф Имам-и Мүхаммедийнхээр бол сүүдэр, өөрийг нь үүсгэх биеийн хиртэй уртсахад эхлээд нар шингэх хүртэл

үргэлжилнэ.

2. Имам-и азам Эбү Ханифегийнхээр сүүдэр өөрийг нь үүсгэсэн биетээс хоёр дахин их болж эхлэхээс нар шингэтэл хүртэл үргэлжилнэ. Гэхдээ нар шарласан хойно өөрөөр хэлбэл тэнгэрийн заадас шугамд жадны хэмжээгээр ойртвол намааз бүрийг үйлдэх нь хараам юм. Өөрөөр хэлбэл оройн намаазыг энэ хэрээр хойшлуулах нь хараам юм. Гэхдээ оройн намаазаа үйлдээгүй бол нар жаргах хүртэл үйлдэх хэрэгтэй.

Үдшийн намаазын цаг: Нар шингэсний дараа эхлээд үдшийн гэгээ харлатал өөрөөр хэлбэл улайрал дуустал үргэлжилнэ.

Шөнийн намаазын цаг: Үдшийн намазын хугацаа өнгөрснөөс эхлээд үүр цайрах хүртэл үргэлжилнэ. Имам-и азам Эбюү Ханифе рахметуллахи алейхийнхээр бол шөнийн намаазын цаг нь тэнгэрийн цагаан алга болохтой цуг эхлэнэ. Тэгээд ч оройн намаазын цагт иймэрхүүгээр өнгөрсөн билээ. Өөрөөр хэлбэл хоёр имаамын үзэхээр шөнийн намаазын цаг болсны дараа хамгийн багадаа хагас цаг дахин хүлээж шөнийн намазыг үйлдвэл бүхий л имамын дагуу үйлдсэн болно. Шөнийн намаазыг шалтаггүйгээр шашны хууль ёсны дагуу шөнийн дундаас хойш орхих нь мекрүх юм.

Намаазыг цагаас нь өмнө хойно үйлдэх нь харам юм. Түркийе сонины бэлтгэсэн ханын хуанлид намааз ба имсак буюу мацаг эхлэх цаг зөв заасан байна.

Намаазыг үйлдэх нь тахримен мекрүх өөрөөр хэлбэл харам болох цаг хугацаа гурав байдаг. Энэхүү гурван цагт эхэлсэн фарз жинхэнэ болохгүй. Нар мандах, жаргах, өдрийн дунд байх гэсэн гурван цагт урьдаас бэлтгэсэн оршуулгын намаз, сежде-и тылавет, сежде-и сехв ч зөвшөөрөгдөөгүй. Нар жаргахад зөвхөн тэр өдрийн оройн намаазыг үйлднэ.

Зөвхөн нафиле үйлдэх нь мекрүх болох хоёр цаг байдаг. Өглөөний намаазын фарзыг үйлдсэний дараа үдшийн намаазын фарзаас өмнө нафиле үйлдэх нь мекрүх юм.

Тайлбар Туйлд намаз ба мацаг:

Улс орон бүрийн намаазын цаг тэр улс нутгийн экватороос хол байх ба улирлаас хамаарч өөрчлөгднө. 67 градусаар өнгөрөх хойд туйлын дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст байрших хүйтэн

газруудад нарны хэлбэгий их болох үед гэгээ алга болоогүй байхад үүр цайж эхэлнэ. Үүний тулд Балтийн тэнгисийн хойд үзүүрт зун шөнө бололгүйгээр шөнийн ба өглөөний намаазын цаг эхэлдэггүй. Ханефи мезхебт цаг нь намаазын зайлшгүй болзолт биш шалтгаан юм. Шалтгаан байхгүй бол намааз фарз болохгүй. Тиймээс ийм нутаг оронд агч мусылмаан нарт энэхүү хоёр намааз фарз биш. Бөмбөрцгийн өмнөд хагаст бүх газар тэнгис далай байх тул ийм улс орон үгүй юм.

Шабаны гуч дахь шөнө нэг хотод хавирган сар үзэгдэхэд бүх дэлхийд мацаг барьж эхлэх хэрэгтэй. Өдөр үзэгдэх хавирган сар ирэх шөнийн хавирган сар юм. /Туйл болоод Сар луу явах мусылмааны аялал биш бол энэ сард өдөр нь мацаг барих хэрэгтэй. Хорин дөрвөн цагаас илүү урт өдөр хоногт мацагт цагаар эхэлж цагаар буснина. Өдөр нь ийм урт биш хотын мусылман нарны цагтай зохицно. Хэрвээ мацаг барихгүй бол өдөр нь урт бус хотод ирэнгүүт каза хийнэ.

АЗААН БА ИКАМЕТ

Азаан хүн бүхэнд зарлан мэдэгдэх гэсэн үг. Таван удаагийн намааз ба каза намаз болоод Жүма намазд итгэгчийн өмнө эрэгтэйчүүд азан унших нь сүннет-и мүеккеде юм. Эмэгтэйчүүдийн азаан ба икамет унших нь мекрүх юм. Азааныг бусдад намаазын цагийг мэдэгдэхийн тулд өндөр дээр газраас уншина. Азааныг уншихад хоёр гараа өргөж нэг нэг хуруугаа хоёр чихнй хонхорхойд байршуулах нь мустехаб юм.

Икамет унших нь азаанаас илүү сайн юм Азаан ба икаметийг кыбла рүү хандаж уншина Уншихдаа ярихгүй бас хүний мэндэнд хариулахгүй.

Азаан ба икаметийг ямар нөхцөлд унших вэ?

1. Тал газар ногооны цэцэрлэг ганцаар болон хүй бөлөгтэй каза хийхэд эрэгтэйчүүдийн азаан ба икаметийг чанга дуугаар унших нь сүннет юм. Азааныг сонссон хүмүүс, жинничүүд чулуу хүртэл шүүгдэх өдөр гэрч болно. Хэд хэдэн каза намаазыг нэг дор хийгчид эхлээд азаан ба икамет уншина. Дараагийн казаг үйлдэхэд бүгдэд

нь зөвхөн икамет уншина. Дараахь казад азаан уншихгүй ч байж болно.

2. Гэртээ гагцаар эсхүл хүй бүлэгтэй вакт намаазыг үйлдэн азаан ба икамет үл уншина. Яагаад гэвэл, жамид унших нь азаан ба икамет гэрт ч уншсанд тооцогдно. Гэхдээ унших нь зүй явдал юм. Хороо хорины жамид хүй бүлгийг тодорхой хүмүүс байх жамид вакт намазыг хүй бүлгээрээ үйлдсэний дараа гагцаар үлдсэн хүн азаан ба икамет уншихгүй. Замд байх эсвэл имам ба мүеззинийг байхгүй байх мөн хүй бүлэг нь тодорхой хүмүүс байхгүй байх жамид янз бүрийн цагт ирэгчид нэг вакт намазын тулд төрөл бүрийн хүй бүлэг хийнэ. Хүй бүлэг бүрт эзан ба икамет уншина. Ийм жамид гагцаар үйлдэгч азаан ба икаметийг өөрөө сонсох хэмжээнд дуутайгаар уншина.

3. Зочид өөр хоорондоо хүй бүлгээр ч, гагцаар үйлдэхдээ ч гэсэн азаан ба икамет уншина. Гагцаар үйлдэгчийн хажууд найз нөхөд нь байвал азааныг орхиж болно. Аян замд гарах хүн нэг гэрт гагцаар үйлдэхдээ ч азаан ба икамет уншина. Яагаад гэвэл жамид унших намаазыг түүний намаазд хамаарахгүй. Аян замд гарагч зарим хүн гэртээ азаан уншвал дараа нь намааз үйлдэгчид уншихгүй.

Ухаантай хүүхэд мөн сохор хүн, бутач хүүхэд хийгээд азаан мэдэх авч үсэг үл мэдэх харанхуй хөдөөний хүн унших нь сэжиглэлтгүйгээр шашин номд тохирно. Жүнүб хүн азаан икамет унших нь абдестгүй азаан унших эмэгтэй нүгэлтний, согтуу хүний азаан унших, суугаад азаан унших нь хатуу мекрүх юм. Эдгээрийн азааныг дахин уншина. Азаан үнэн зөв болохын тулд мүеззин хүн мусылмаан, оюун ухаан бүрэн байх хэрэгтэй. Өсгөгчөөр унших нь үнэн зөв болохгүй.

Худлаа итгэн сүслэгчийн азаан үнэн зөв болохгүй байдаг нь ибадетд түүний үг хүлээн зөвшөөрөгдөөгүйгээс болж байгаа юм. Хоёр нүүртэн ба өсгөгчийн эзанаар цаг хугацаа ирсэн гэж итгэхгүй. Үүний эзан эсвэл өгсөн тэмдэгтээр мацаг нь буснихгүй.

Азааныг өргөмжилж хүндлэл үзүүлэгчид түүний үсэг үгийг нь өөрчилж бусниалгүй аялан дуулалгүй минарет цамхагт гарч сүннетд тохируулан уншигч нар дээд зэрэг зиндаанд хүрэх болно. Гэхдээ азааныг сүннетд тааруулж уншихгүй бол жишээ нь зарим үгийг өөрчилж орчуулж зарим газар дуулан аялж унших юм уу азааны дуу өсгөгчөөр түгэж байгаа бол /Яагаад гэвэл

өсгөгчөөс гарах дуу, имаам юм уу мүеззиний дуу биш юм. Энэ дуу цахилгаан ба соронзон болж хувирна. Энэхүү цахилгаан ба соронзонгоос гарах дуу сонсогдоно/ сонсож буй хүн ямар ч хэсгийг нь дахин давтахгүй.

Тайлбар Азаныг өсгөгчөөр уншиж болох уу?

Минарет цамхаг нь өлгөх өсгөгч мүеззиний хувьд залхууран алхайрах хэрэглүүр болох ба азааныг харанхуй өрөөнд сууж сүннетд үл зохицож унших шалтгаан болно. Зуун зууны туршид тэнгэр огторгуй руу зүглэн уртсах оюун санаана чимэг минарет цамхаг ч гэсэн энэхүү муу ёстон нараас шалтгаалан өсгөгчийн шон болсон юм. Ислаамын мэргэн багш нар шинжлэх ухааны олж нээсэн болгоныг сайшаан хүлээж авсан ба жишээ нь хэвлэлийн үүсгэлийг дэмжиж хөхүүлэн ач тустай ном судар хэвлэгдэж эрдэм ухаан түгэхийг хүссэн. Радио болоод өсгөгчөөр газар бүр ач нөлөөтэй нэвтрүүлэг хийх нь ислаамын шашныг таашаан ашиглах нь нээлт болох нь эргэлзээгүй билээ. Гэхдээ мусылмаан нарыг азааны уянгат дуу авианаас салгаж ибадетийг өсгөгчийн хэт чанга дуугаар үйлдэх нь хор хохиролтой юм. Өсгөгчийг жамид байрлуулах нь хэрэгцээгүй зарлага юм. Имаан сүсэгтний зүрх сэтгэлд тэнгэрийн үр нөлөө үзүүлэх номын ёст мүминчүүдийн дуу хоолойн оронд христийн сүмийн хонх шиг гонгинох энэхүү зэмсэг байхгүй байхад минарет цамхагт унших азаан болоод жами дахь текбирийн дуу харь хүмүүст хүртэл Эзэн Тэнэгэрийн хайрт умбах онгодыг бий болгож байв /вежде/ Хороо хорин бүрт унших азааныг сонсоод жами сүмийг дүүргэх хүй бүлэг Асхаб-и кирамын цагт байдаг шигээ намаазаа даруухнаар даган баясаж байв. Азааны мусылмаанчуудын сэтгэлийг хөдөлгөн догдлуулах тэнгэрлиг үр нөлөө нь өсгөгчийн төмөрлөг дуугаар устаж байна.

Расүллүллах саллаллахү алейхи ве селлем нэг хадис-и шерифт айлдахдаа Хэн нэгэн азаны дууг сонсонгуутаа мүеззинтэй хамт намуухнаар уншвал үсэг бүрт нь мянган буян ногдох ба мянган нүгэл нь устна» хэмээв.

Азааныг сонсох хүн Кураан-и керим уншиж байга бол сонссоноо удаанаар хэлэх нь сүннет юм. Хаййе алаг сонсонгуут

эдгээрийг хэлэлгүйгээр ла хавле вела күввете илла биллах гэнэ. Азааны дараа салеват уншина. Дараа нь азааны дууг уншина. Хоёрдох удаа Эшхэдү эннэ Мухамэдэн Расүлуллаах гэж хэлэнгүүтээ хоёр эрхий хурууныхаа хумсыг үнссэний дараа хоёр нүдээ арчих нь мустехаб юм. Икаметд ингэж хийхгүй.

Азааныг унших нь

Аллахү экбер	4 удаа
Эшхедү эн ла илахе иллаллах	2 удаа
Эшдү енне Мухамеден Ресүлуллах	2 удаа
Хаййэ алес салах	2 удаа
Хаййе алел-фелах	2 удаа
Аллаахү экбер	2 удаа
Ла илахе ил лаллах	1 удаа

Зөвхөн өглөөний азаанд хаийе алел-фелах ийн дараа хоёр удаа Эс-салатү хайрун минэн-нэвм”-ийг уншина.

Икаметд “Хаййэ алел-фелах”-ийн дараа хоёр удаа Кад камэ тис-салатү гэнэ.

Азаанын Дуа уншлага

Рэсүлуллах саллАллахү алэйхи вэ селлем айлдаруун:

Эзан уншихдаа энэ Дуа уншлагыг уншигтун:

“Вэ энэ эшхедү эн ла илахе иллалахү вахдэху ла шерикелэх ве эшхедү энээ Мухаммеден абдүхү вэ рэрэсулүх вэ радитү биллахи раббээн вэ бидл-ислами динэн вэ би Мухамедин саллаллахү алэйхи вэ селлееэмеэ расулэн небиййа”

Өөр нэг хадис-и шэрифдээ зарлигдаруун: “Аяа сүсэгтэн олон минь Эзан дуусангуут эл Дуа уншлагыг уншигтун:

“Аллахүммэ раббе хазихид-даветит–таммэти вэс-салати-каймэти ати Мухаммеденил-весилете вед-л-фадителете вед-дересетер-рефилате вебасхү мэкамэн махмудэнил-лэзи веадтехү иннеке ла тухлифүл-миад”

Азааны үгсийн утга

Аллахү экбер : Аллаах агуу их юм. Түүнд аливаа зүйл хэрэггүй. Боол нарынхаа ибадет үл дутагдахаас илүү том юм. Ибадетүүд Түүнд ямар ч ашиггүй билээ. Энэхүү чухал утгыг оюун сэтгэхүйд сайтар суулгахын тулд энэ үгийг дөрвөн удаа хэлнэ.

Эшхедү эн ла илахе иллаллах: Агуу их болохоор хэний ч ибадетээр дутахгүй боловч Түүнээс өөр хэний ч эрх үгүй гэдгийг гэрчлэн итгэнэ би. Юу ч Түүнтэй адил бус юм.

Эшхедү энне Мухамеден Ресүлуллах : Би Мүхаммед алейхи ве ала алихиссалатү весселамийг Түүний илгээсэн Пайгамбаар Элч гэдэгт Түүний хүссэн ибадетүүдийн замыг заагч гэдгийг Аллаахд зөвхөн Түүний заан бошголсон ибадетүүд зохино гэж гэрчлэн итгэнэм.

Хаййе алес салах, хаййе алел-фелах: Мусылманчууүд бүрэн аварал буян /фелах/ аз жаргал аврагдалд шалтгаан болох намаазд дуудах хоёр үг болно.

Аллаахү акбаар: Түүнд тохирох ибадетийг хэн ч хийж үл чадна. Хэн нэгний ибадетийг Түүнд тохирсон байхаас маш агуу маш хол юм.

Ла илахе иллаллах: Ибадетд өмнө нь дорд үзэгдэх эрх эзэмшигч нь зөвхөн Тэр билээ. Түүнд тохирох ибадетийг хэн ч хийж чадахгүй ч гэлээ Түүнээс өөр хэнд ибадет зориулагдах эрхгүй юм

Намазын агуу их нэр төр нь Түүнийг хүн бүрт өгүүлэхйн тулд шилэгдсэн эдгээр үгийн агуу ихээс ойлгогдох ёстой юм.

НИЙЙЕТ /ЗОРИН ХҮСЭХ/

Ифтихак текбир хэлэгдэхэд ниййет хийгдэнэ. Намазд зорин хүснэ гэдэг нь нэр цаг кыблег имаамдаа тааруулахыг сэтгэл зүрхэндээ болгооно гэсэн үг. Ифтихак текбирийн дараа хийгдэх ниййет үнэн болохгүй ба тэрхүү намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй. Фарз ба важибыг зорин хүсэхэд аль нь фарз аль нь важиб болохыг нь мэдэх хэрэгтэй. Рекатын тоогоор зорин хүсэх шаардлагагүй. Сүннетийг үйлдэхэд Намаазыг зорин хүсэх хэрэгтэй. Оршуулгын намаазд Аллахын тулд намаазд өөд болоочийн тулд дуа руу хэмээн зорин хүснэ.

Имаамын эрэгтэйчүүдэд имам болохоор зорин хүсэх нь зайлшгүй болзол биш. Имам бэлэн байгаа хүй бүлэгт имаам боллоо гэж нийет хийхгүй бол хүй бүлэгтэй цуг хийх буян хишиг ногдохгүй. Имаам болохоор ниййет хийвэл энэхүү буян ногдоно. Имаам эмэгтэйчүүдэд имаам болохоор зорин хүсэх хэрэгтэй. Ибадэтыг үйлдхэд зөвхөн амаараа зорин хүсэх нь хүрэлцээтэй бус чин зүрхнээсээ нийет эс хийвэл намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй.

ТАХРИМЕ ТЕКБИРИ

Намааз эхлэхэд Аллаахү акбаар гэж хэлж эхлэх нь фарз юм. Өөр үгээр илэрхийлж болохгүй. Зарим мэргэд эрдэмтэд Тахриме текбирийг намаазын дотор багтдаг хэмээсэн байдаг. Эдний бодлоос үүдвэл намаазын болзол ба рүкн аль аль нь зургаа болж байна.

• НАМААЗЫН РҮКНҮҮД •

Намаазын доторх фарзыг рүкн хэмээнэ. Нийт тав байна.

1. Кыйам

Намазын таван рүкнээс эхнийх нь кыйам юм. Кыйам нь босоо зогсох гэсэн үг юм. Босоо зогсож үл чадах өвчтөн сууж үйлднэ. Сууж үл чадах өвчтэй хүн нуруугаараа хэвтэж толгойгоороо үйлднэ. Нүүр нь тэнгэр лүү бус кыбле рүү хандахын тулд толгойн доор нь дэр тавина. Хөлөө Кыбле рүү хандуулан тэнийлгэхгүй. Босоо байхдаа хоёр хөлний хооронд дөрвөн хурууны хэртэй зайтай байх хэрэгтэй. Босож зогсож үл чадах өвчтөн зогсохоор толгой нь эргэн толгой шүд нүд болоод бусад газар нь ихэд өвдсөн, шээс унгас алдсан шарх нь цус урсах зогсох үед дайснаас айх эд таваар хулгайд алдах заналд учирсан, зогсоогоор намааз үйлдэхэд мацаг болоод уншилга нь бусних, ичимхий газар нь задгай үзэгдэх хүмүүс сууж үйлднэ. Рүкүгийн тулд бага зэрэг бөхийнө. Сэждегийн тулд толгойгоо газар тавна. Толгойгоо газар тавьж үл чадах хүн рүкүгийн тулд бага сеждегийн тулд илүү их бөхийнө. Сеждегийн тулд бөхийх нь рүкү тулд тонгойсноос илүү их болохгүй бол намааз хүчин төгөлдөр бус

юм. Газарт чулуу ба самбар тавьж үүний дээр сежде хийвэл намаз

хүлээн зөвшөөрөгдлөө ч гэсэн нүгэлд хамаарна. Өөрөөр хэлбэл хатуу мекрүх болно.

2. Кырагат

Сүннетүүд ба витрын рекат бүрт түүнчлэн ганцаар үйлдэхэд фарзын хоёр рекатанд зогсоогоор Күраан-и керимээс нэг аят унших нь фарз юм. Богино байсан ч хамаагүй сүре унших илүү буянтай.

Кырает болгож энд Фатиха унших сүннетүүдийн ба витр намаазын рекат бүрт фарзуудын хоёр рекатд Фатихагаас өөр сүре эсвэл гурван аят унших важив юм. Фарзуудад Фатиха ба замм-и сүрег анхны хоёр рекатд унших уажиб эсхүл сүннет юм. Фатихаг сүрегийн түрүүнд унших ч гэсэн важиб юм. Энэхүү таван важибаас нэг нь мартагдвал сежде-и сехв хийх хэрэгтэй.

Кыраетд Куран-и керимийн орчуулгыг унших шашинд тохирохгүй.

Имаам Жүма болоод баярын намаазаас гадна намааз бүрт нэгдүгээр рекатд хоёрдугаар рекатд уншихын хоёр дахин урт унших сүннет юм. Ганцаараа байхад рекат бүрд нэг ижил хэмжээгээр уншиж болно. Имаам ижил намаазын нэг ижил рекатд нэг ижил аятыг уншихыг занших нь мекрүх . Нэгдүгээр рекатд уншсаныгаа хоёрдугаар рекатд унших нь ч тензихэн мекрүх юм. Эсрэгээр нь унших /керих/ юм. Хоёрдугаархид нь нэгдүгээр рекатд уншсанаас дараачийн сүрег алгасан дараачийнхийг нь унших мекрүх юм. Кураан-и керимийг хуудасны дараагаар нь унших нь үргэлж важиб юм.

3. Рүкү

Кыйамд кыраетийн дараа текбир уншиж рүкүд бөхийнө. Рүкүд эрэгтэйчүүд гарын салаагаа дэлгэж өвдөгнийхөө дээр тавьна нуруу болон толгойгоо нуруутай тэгш байлгана.

Рүкүд багадаа гурван удаа (Сүбхане раббийел азым) гэнэ. Гурван удаа уншилгүйгээр имаам толгойгоо өргөвөл уг хүн ч тэр даруйдаа өргөнө. Рүкүд гар хөл босоо байна.Эмэгтэйчүүд гарын салаагаа дэлгэхгүй. Нуруу хөл гараа босоо байлгахгүй.

Рүкүд босоход Семиалахү лимен Хамидех гэх нь Имаам болон ганцаар үйлдэгчид сүннет юм. Хүй бүлэг үүнийг хэлэхгүй. Үүний дараа тэр даруйдаа Раббена лекел хамд гэх ба босоо байдлаасаа

Аллаахү акбаар гэж сежде рүү тонгойн эхлээд баруун, дараа нь зүүн

Өвдөг, дараа нь баруун, дараа нь зүүн гар, дараа нь хамар ба магнайгаа газар тавина.

4. Сежде

Сеждед гарын хуруу нэг нь нөгөөтэйгээ нийлсэн кыбле рүү харж чихний хавьд толгой хоёр гарын алгын хооронд байх хэрэгтэй. Магнайг цэвэр газар өөрөөр хэлбэл чулуу шороо самбар ширдэг дээр талбих фарз болох ба хамрыг ч цугт нь талбих важиб гэгдэв. Шалтаггүйгээр зөвхөн хамрыг тавих нь шашинд тохирохгүй. Зөвхөн магнайг тавих мекрүх юм.

Хоёр хөлийг эсвэл багадаа хоёр хөлний нэг нэг хурууг газар тавих нь фарз эсвэл важиб юм. Өөрөөр хэлбэл, хоёр хөлийг газар тавихгүй бол намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй эсхүл мекрүх.

Сеждед хөлийн хурууг нугалаад үзүрийг нь кыбле рүү чиглүүлэх нь сүннет мөн.

Эрэгтэйчүүд гар ба гуя ташаа гэдсэндээ наахгүй. Гар ба өвдгөө газар тавих нь сүннет юм. Өсгийг кыйамд нэг нь нөгөөгөөс нь дөрвөн хуруу хэртэй хол рүкүд кавме ба сеждед нийлүүлэн барих сүннет юм. Сежде рүү явахад өмдний хэсгийг дээш татах мекрүх бөгөөд эдгээрийг дээш татаж мушгих нугалаж намаазд зогсох мекрүх юм. Гар хөл хормой банзалыг шууж нугалсан богиноор намааз үйлдэх мекрүх юм. Залхууран алхайрч эсхүл толгой боолттой үйлдэхийн чухлыг үл бодон толгой задгай намаз үйлдэх мекрүх юм. Намазыг үл чухалчлах нь кафир болно. Хиртэй хувцастай, ажлын хувцастай намааз үйлдэх нь мекрүх юм.

5. Каде-и ахире

Сүүлчийн рекатд “Эттехыййатү”-г унших хүртэл суух нь фарз юм. Суухдаа гарын хуруугаар дохиж зангахгүй. Эрэгтэйчүүд зүүн хөлөө хурууны үзүүр баруун тийш эргэсэн байдлаар газар тавина. Энэ гаран дээр сууна. Баруун хөлөө цэх байлгана. Харин хуруунууд нь газар хүрнэ. Хурууны үзүүр кыблегийн эсрэг талд бага зэрэг нугаларах хэрэгтэй. Ийн суух нь сүннет юм.

Эмэгтэйчүүд бөгсөө газар тавьж сууна. Ташаа нь нэг нь нөгөөдөө ойр байна Баруун хөлөө баруун талаас гадагш гаргана. Зүүн хөлөө хурууны үзүүр баруун тийш эргэсэн байдлаар доор нь үлдэнэ.

• НАМААЗЫГ ХЭРХЭН ҮЙЛДЭХ ВЭ? •

Эрэгтэй хүний ганцаар хийх намааз

Жишээ нь /өглөөний намаазын сүннет/ ийнхүү үйлдэгднэ.

1. Эхлээд кыбле тийш харж зогсно. Хөл нэг нь нөгөөгөөсөө дөрөв хуруу хүртэл зайтай зэрэгцүүлэн барина. Гарын таван хуруу чихний зөөлөнд хүрч гарын алга кыбле рүү зүглүүлэн тэнийлгэнэ. Зорин хүслээ. Аллахын зөвшөөрснөөр энэ өдрийн өглөөний намаазын сүннетийг хийхээр кыбле рүү хандлаа гэж бодсоны дараа Аллахү экбэр гэж хэлээд хүйснийхээ дор баруун гарыг зүн гарын дээр холбоно.

2. Нүдээ сежде хийгдэх газраас салгалгүйгээр а/ Сүбханеке/ уншина б/ Еюзю Бесмелегийн дараа Фатиха уншина с/ Фатихагийн дараа бесмеле уншилгүйгээр нэг замм-и сүре /жишээ нь Елем терекейфе/ уншина.

3. Замм-и сүрегийн дараа Аллахү екбер хэмээгээд рүкүд мэхийнэ. Гараараа өвдгийн хаалтыг битүүлээд бэлхүүсээ цэх байлгах ба нүдээ хөлнөөсөө үл салган гурван удаа

Субхане Раббыйел-азым гэнэ. Тав буюу долоон удаа ч хэлж болно.

4. Семиаллахү лименхамидех гээд өндийн босоход өмд татагдахгүй, нүд сеждегийн газраас салахгүй. Гүйцэд цэх зогсонгуутаа Раббена лекел хамд гэнэ. /Ийнхү цэх зогсохыг кавме гэнэ./

5. Удаан босоо зогсолгүйгээр Аллахү екбер хэмээн сежде рүү тонгойно. Сежде рүү шилжих дарааалал нь а/ Баруун өвдөг дараа нь зүүн өвдөг, баруун гар, дараа нь зүүн гар, хамар ба магнай газарт тавина. б/ Хөлийн хуруу кыбле чигт нугална в/ Толгойг хоёр гартаа хавчуулна г/ Гарын алгыг газарт наана. Тохой газарт наахгүй. д/ Энэ байдалд байхдаа хамгийн багадаа гурван удаа Субхане Раббиел-ала гэнэ.

Дараа нь :

6. Аллахү екбер гээд зүүн хөл газар тэнийж баруун хөлийн хуруунууд кыбле тийш нуглан ташааны дээр сууна. Хоёр гарын алга өвдөг дээр талбиад хурууг зөнгөөр нь орхино.

7. Ташаан дээр удаан байлгүйгээр Аллахү екбер гэж дахин

сеждед хүрнэ. /Хоёр сеждегийн хооронд суухыг желсе гэнэ/

8. Сеждед дахиад багадаа гурван удаа Субхане Раббийел-ала гэсний дараа Аллахү екбэр гээд босч зогсно. Босч зогсохдоо гараараа газар тулахгүй. Сеждегээс босоод эхлээд дух, дараа нь хамар, дараа нь зүүн гар, баруун гар, дараа зүүн өвдөг, баруун өвдөг газраас босох хэрэгтэй.

9. Зогсож байхдаа бесмелегийн дараа Фатиха ба үүний дараа замм-и сүре уншиж Аллахү-екбэр гээд рүкүд тонгойно.

10. Хоёрдугаар рекатд нэгдүгээр рекатд заасан байдлаар гүйцэтгэнэ. Харин хоёрдугаар сеждегийн дараа Аллахү екбер гэж хэлэнгүүтээ босолгүйгээр өвдөг нуглан сууна мөн.

а/ (Эттехыййатю) (Аллахүме салли) (Аллахүмме барик) ба (Раббена атина) Дуаг уншсаны дараа эхлээд баруун хөл тийш эргэж (есселамү алейкүм ве рахметуллах) дараа нь зүүн мөр тийшээ эргэж (Есселамү алейкүм ве рахметүллах) гэж мэндчилнэ.

б/ Мэндчилсний дараа (Аллахүмме ентесселам ве минкесселам тебаректе йа зел-желали вел-икрам) гэнэ. Огт ярилгүйгээр өглөөний намаазын фарзыг үйлдэхээр босно. Яагаад гэвэл сүннет ба фарзын хооронд ярих нь намаазыг бусниахгүй ч гэлээ буяныг нь багасгана.

Намаазын дараа аль нэг нь бүрэн гүйцэд байж гурван удаа өршөөл залбирал уншина. Дараа нь (Айет –үл-күрси) ба гучин гурван тэсбих, гучин гурван тахмид мөн гучин гурван текбир ба нэг техлил өөрөөр хэлбэл (Ла илахе иллаллах вахдедү ла шерикелех лехүл мүлкү ве лехүл хамдү ве хюве ала күлли шейин кадир) / уншигдана. /Эдгээрийг дуугүй унших хэрэгтэй. Их дуугаар унших бидат буюу буруу юм/ Дараа нь дуа хийнэ. Дуад эрэгтэйчүүд гараа хүйсний хавь хүртэл өргөнө. Гарыг тохойноос нугалахгүй. Алга нээгдэнэ, гарын алгаа тэнгэр огторгуй лүү эргүүлнэ. Яагаад гэвэл намаазын Кыбле Кабе байгаа шиг Дуаны кыбле нь тэнгэр огторгуй юм. Дуаны дараа тухай бүрд нь Бэсмеле уншиж арван нэгэн Ихлас хоёр Кул-еүүзу мөн 67 (Эстагфирүллах)гэх нь мустехаб юм. (Сүбханераббике) айет-и керимег уншиж гараа нүүрнээ илбэнэ.

Дөрвөн рекат сүнетийн фарзын хоёрдугаар рекатын дараа техыййат уншиж босно. Сүннетийн гурав дөрөвдүгээр рекатд Фатихагийн дараа замм сүре уншихгүй. Оройн фарз нь ийм бөлгөө. Өөрөөр хэлбэл гурав дахь рекатд замм сүрэ уншихгүй. Витрын гуравдугаар рекатд Фатихагийн дараа замм сүре уншина. Дараа

нь текбир авчирч гарыг чих тийш өргөнө. Дараа нь Кунут Дуаг уншина. Гайр-и мүеккед болох оройн ба шөнийн намаазын өмнөх сүннетүүд ч гэсэн бусад дөрвөн рекаттай сүннет мэт юм. Гэхдээ хоёр дахь рекатын дараа суухад этехйыййатын дараа Аллахүме салли ве барикүүд ч уншигдна.

Эмэгтэй хүний ганцаар хийх намаз

Жишээ нь Өглөөний намаазын сүннетийг ийнхүү хийнэ.

1. Биеийн хэлбэр галбир үл мэдэгдэх байдлаар толгойноосоо хөлний хуруу хүртэл хучин нөмрөг ба урт хувцас өмснө. Зөвхөн гар болоод нүүр ил үлднэ. Намаазд унших сүре болоод дуа нь дээрх эрэгтэй хүний ганцаар байхдаа хийх намаазынхтай адил юм.а/ Гараа эрэгтэйчүүд шиг чихэндээ авчрахгүй гараа мөрний орчимд авачиж зорин хүснэ. Текбир авч, гараа цээжнийхээ дээгүүр холбоод намаазаа эхэлнэ.б/ Рүкүд бүрэн цэх зогсохгүй.в/ Сеждед тохой газар дэлгэнэ. г/Тешеххүде ташаан дээр сууна. Өөрөөр хэлбэл баруун болон зүүн хөл баруун талд байж зүүн ташаан дээр сууна.

Намаазд эмэгтэйчүүдийн хувьд сайн хучлагатай байхын хамгийн хялбар хэлбэр нь гараа ч хучих өргөн толгойны алчуур хөлөө хучих өргөн урт банзал юм.

• НАМАЗЫН ВАЖИБУУД •

Намаазын важиб нь доорхи нар юм .

1. Фатиха сүрег унших.
2. Фатихагийн дараа нэг сүре эсвэл багадаа гурван богино аят унших.
3. Фатихаг сүрегээс түрүүнд нь унших.
4. Фатихаг мөн Фатихагаас хойш унших сүрег фарзуудын нэгдүгээр хоёрдугаар рекатд важиб ба сүннетүүдийн рекат бүрд унших.
5. Сеждег нэг нь нөгөөгийн хойноос хийх.
6. Гурав ба дөрвөн рекаттай намаазын хоёрдугаар рекатд намазд суух хэмжээгээр суух. Сүүлчийн суулт нь фарз юм.
7. Хоёрдугаар рекатд суух хэмжээнээс илүү суухгүй байх.

8. Сеждед хамраа магнайтайгаа хамт газар хүргэх.

9. Сүүлийн рекатд суухдаа Эттехыйатү Дуаг унших.

10. Намаазд биеийн хөдөлгөөний зүй ёсыг /тадил-и эркан/ зохицон дагах.

11. Намазын төгсгөлд Эселамү алейкүм ве рахметүллах гэх.

12. Витр намаазын гурав дахь рекатын эцэст күнүт дуа унших.

13. Баярын намаазд текбир унших.

14. Имам өглөө, жума. Баярын намаз, теравих, витр намаазд орой ба шөнийн намаазын анхны хоёр рекатд чанга дуугаар унших.

Имаамын ба ганцаар үйлдэгчийн үд ба оройнх фарзууда үдшийн гуравдахь ба шөнийн гуравдахь ба дөрөв дэх рекатуудад зөөлөн дуугаар унших нь важиб юм. Имаам чанга дуугаар унших ёстой газар гагцаар үйлдэгч өндөр нам дуугаар унших нь шашинд тохирно.

Курбаан баярын босго өдөр өглөөний намаазаас дөрөв дэх өдрийн оройн намааз хүртэл хорин гурван фарз намаазын араас шууд (Текбир-и тешрик) унших нь важиб юм.

• СЕХВ /ЭНДҮҮРЭН МАРТАХ/ СЕЖДЕ•

Намааз үйлдэгч намаазд фарз болох зүйлсийг мэдээд эсвэл мартаад орхивол намааз буснина. Хэрвээ нэг уажибийг мартаад орхивол намааз буснихгүй. Гэхдээ сехв сежде хийх хэгтэй болно. Сежде-и сехвийг мэдсээр байж үл хийгч эсвэл намаазын важибуудаас нэгийг нь мэдээд орхисон хүний тэрхүү намаазыг шинээр хийх нь важиб юм. Үл хийвэл нүгэл болно. Сүннетийг орхиход сежде сехв хэрэггүй. Сежде-и сехв нэг фарз хойшлуулах эсвэл нэг уажибийг орхих буюу хойшлуулахад хийгднэ.

Намаазд хэд хэдэн удаа сежде-ти сехв чухал шаардлагатай болбол нэг удаа хийх хангалттай. Имаамын эндүүрэх нь өөрт нь зохицогчдын сежде-и сехв хийхийг шаардна. Имаамд зохицогч эндүүрвэл өөрөө имаамаас ангид сежде-и сехв хийхгүй.

Сежде-и сехв хийхийн тулд техыййат уншиж нэг талдаа селам өгсний дараа хоёр сежде хийж суух ба (Техыйат) (Салли ве барык) (Раббена) Дуа уншиж намааз төгсгөнө. Нэг юм уу хоёр тал руу мэндчилсний дараа эсхүл нэг ч мэндчилгээгүйгээр ч сежде-и сехв хийгдэж болно.

Сежде-и сехвийг шаардах онцлог:

Суух хэрэгтэй атал босох, босох ёстой атал суух, чангаар унших шаардлагатай атал дотроо унших. дотроо унших атал их чангаар унших. Дуа унших байтал Кураан-и керимээс унших. Кураан-и керимээс уншихын оронд Дуа унших. Жишээ нь, Фатиха сүрегийн оронд Еттехыйатү Дуаг унших. Еттехыйатү унших атал фатиха унших гэх мэт. Энд Фатиха хаягдаж байна. Намаазыг дуусгалгүйгээр мэндчлэх. Фарз намазудын нэгдүгээр болоод хоёрдугаар рекатд замм-и сүрег уншилгүйгээр гурав болоод дөрөвдүгээр рекатыг унших . Анхны хоёрдугаар рекатд Фатихагаас хойш замм-и сүре уншихгүй байх. Баярын намазын текбирийг нь орхих. Витр намазд күнүт Дуаг орхих.

• ТИЛАВЕТ СЕЖДЕ •

/Судар уншин газарт мэхийх/

Кураан-и керимд арван дөрвөн газар сежде аят байдаг. Эднээс нэгийг нь уншиж сонссон хүний утгыг нь ойлгохгүй ч гэсэн нэг сежде хийх нь уажиб юм. Сежде айетүүдийг бичигч үелэгч сежде хийхгүй.

Уул, цөл бусад газраас ойж буцаж ирсэн дууг сонсогчдын мөн шувуунаас сонсогчдын сежде хийх нь уажиб болохгүй. Хүний дуу байх хэрэгтэй. Радио болоод өсгөгчөөр сонссон дууны хүний дуу биш, хафизын дуутай төстэй амьгүй зэмсгийн дуу болохыг урьд бид өгүүлсэн билээ. Ийм учраас радио болон тоглуулагчаас унших сежде айетүүдийг сонсогчийн тилавет сежде хийх нь уажиб болохгүй.

Тилавет сежде хийхийн тулд абдесттэйгээр кыблегийн эсрэг босоо зогсож гарыг чихэнд хүргэлгүйгээр Аллахү екбер хэмээн сеждед бөхийнө. Гурван удаа Сүбхане раббийел ала гэнэ. Дараа нь Аллахү екбер гэж сеждегээс босонгуутаа сежде-и тилавет бүрэн дуусна. Эхлээд нийет хийх хэрэгтэй. Нийетгүй бол хүлээн зөвшөөрөгдөхгүй.

Намазд уншингуут тэр даруй тусгайлан рүкү эсвэл нэг сежде хийж босч зогсоно. Уншихаа үргэлжлүүлнэ. Сежде айетийг уншсаны дараа хоёр гурван аятийн дараа намаазын рүкүнд мэхийвэл

тилавет сеждед нийет хийвэл намазын рүкү эсвэл сежденүүд тилавет сеждег орлоно. Хүй бүлэгтэй цуг хийгч нь имаам сежде аятийг уншмагц имаамын уншсаныг сонсоогүй ч гэсэн имаамтай цуг түүнчлэн нэг рүкү хоёр сежде хийнэ. Хүй бүлгийн рүкүг зорин хүсэх хэрэгтэй. Намаазын гадна сүүлд ч орхиж болно.

• ШҮКИР СЕЖДЕ •

/Талархлын мэхийлт/

Тилавет сежде мэт юм. Өөрт нь хишиг буян ирэх эсвэл нэг зовлонгоос чөлөөлөгдсөн хэн нэгний Аллаахын тулд сежде-и шүкр хийх мустехаб юм. Сеждед эхлээд Элхамдүлиллах гэнэ. Дараа нь сежде тесбихийг уншина. Намазын дараа сежде хийх мекрүх юм.

Намаазд биеийн хөдөлгөөнөө үл сахин мөрдөгч нь бүх бүтээгдэгч нарт хор хөнөөлтэй. Учир нь тэр хүний нүглийн шалтгаанаар бороо үл орно, газарт тариа үл ургана. Цаг бусаар бороо орж ач тусын оронд хохирол гарз авчрах болно хэмээн айлджээ.

• НАМАЗЫН СҮННЕТҮҮД •

1. Намазын эхэнд гараа чих рүүгээ дөхүүлэх.
2. Гарын алгаа кыбле рүү чиглүүлэх.
3. Текбир авсны дараа гараа холбох.
4. Баруун гараа зүн гарын дээр тавих.
5. Эрэгтэй хүн гараа хүйсний доор тавих, эмэгтэй нь цээжиндээ талбих.
6. Ифтитах текбирийн дараа Субханеке унших.
7. Имам ба ганцаар үйлдэгч Эузу унших.
8. Бесмеле унших.
9. Рүкүд гурван удаа Субхане раббийел-азым гэх.
10. Сеждед гурван удаа Субхане раббийел-ала гэх.
11. Сүүлчийн суултанд Салеват дуаг унших.
12. Мэндлэхдээ хоёр мөр руугаа харах.
13. Имам Жума намааз ба баярын намаазаас гадна намааз бүрт нэгдүгээр рекатд хоёрдугаар рекатд уншихаас хоёр дахин урт унших.
14. Рүкүгээс босоход имаам ба гагцаар үйлдэгч Семиаллахү лимен хамидх гэх.

15. Рүкүгээс босоход Раббена лекел -хамд гэх.

16. Сеждед бүлийн хуруугаа нугалж тахийлган үзүүрийг нь кыбле рүү хандуулах.

17. Рүкү болон сеждед буухад сеждегээс босоход Аллаахү акбаар гэх.

18. Гар болон өвдгийг газар тавих.

19. Хөлийн хоёр өсгий нэг нэгээсээ дөрвөн хуруу зайд рүкүд зогсохдоо ба кавме ба сеждед нийлүүлж үйлдэх.

20. Фатихагийн дараа амин гэх рүкүгийн өмнө текбир унших, рүкүд гар хуруу задгайлан өвдгийн дээр холбох сеждегийн тулд текбир авах, суухдаа зүүн гараа газар буулгаж баруун хөлөө босгож суух хоёр сеждегийн хооронд суух.

Үдшийн намаазд богино сүре уншина.

• НАМААЗЫН МУСТАХАБУУД •

1. Намазыг үйлдэхдээ мөргөх газар луу харах.

2. Рүкүд байхдаа хөлний үзүүр /өлмий/ лүүгээ харах.

3. Сеждед хамрын үзүүрээ харах.

4. Техыййатд суухад өвдөгний дээд тал руу харах.

5. Фатихагийн дараа унших аятын тоо хэмжээ өглөө болон үдийн намаазд урт, үдшийн намаазд богино байх.

6. Имаамд зохицох /уярах/ хүн текбирийг нууцаар унших.

7. Рүкүд хуруунуудаа нээж өвдгөн дээрээ тавих.

8. Толгойгоо нуруутай нь хамт рүкүд цэх барих.

9. Сеждед хүрэхэд эхлээд баруун, дараа нь зүүн өвдгөө газар тавих.

10. Сеждег хоёр хөлний хооронд хийх.

11. Сеждед хамрынхаа дараа духаа тавих.

12. Намааз унших яцад эвшээвэл гарын гадраараа амаа хаах.

13. Эрэгтэйчүүд сеждед тохойгоо өргөж дээш нь барих Эмэгтэйчүүд гараа газар тавина.

14. Эрэгтэйчүүд сеждед гар хөлөө гэдэснээсээ саланги байлгана.

15. Рүкү ба сеждед гурав гурван удаа тесбих унших хүртэл зогсох.

16. Сеждегээс толгойгоо авсаны дараа гараа газраас авах.

17. Гараа авсны дараа өвдгөө авах.

18. Техыйатд гараа гуя ташаан дээрээ талбиж хуруугаа кыблегийн эсрэг цэх барих, нуглахгүй байх, алинийг нь ч хөдөлгөхгүй байх.

19. Баруун зүүн тийш мэндлэхдээ толгойгоо мөрлүүгээ эргүүлэх.

20. Мэндлэхдээ мөр рүү харах.

• НАМААЗЫН МЕКРҮХ •

1. Хувцсаа өмсөлгүйгээр мөрөндөө өлгөж үйлдэх.

2. Сеждэд суухдаа банзал, хормой, өмдөө татах.

3. Цамц, банзал, ханцуй нь шамласан байдалтайгаар намаз үйлдэх.

4. Хэрэгцээгүй өөрөөр хэлбэл, ач тусгүй үйл хөдлөл хийх.

5. Ажлын хувцастай мөн ахас дээдсийн дэргэд очиж үл болох хувцастай намааз үйлдэх.

6. Амандаа уншилганд саад болох зүйл байлгах. Саад болбол намааз буснина.

7. Толгой нүцгэн намаз үйлдэх.

8. Бага их абдестэнд шаваралдан чихцэлдэх, салхилаж байхад намаазд зогсох.

9. Намаазд байхдаа сеждегийн газрын чулуу, шороог гараараа цэвэрлэх.

10. Намаазд зогсож байхдаа хуруугаа тачигнуулан дуугаргах.

11. Намаазд гараа шанаандаа тулах.

12. Толгойгоо эргэн тойронд эргүүлэн харах, нүдээ эргэн тойрон гүйлгэн харах, Цээжин биеэ эргүүлбэл намааз буснина.

13. Тешеххүдүүдэд нохой мэт суух.

14. Сеждед эрэгтэйчүүд гараа газар тархаах.

15. Хүний нүүр лүү эгц харж намааз үйлдэх.

16. Намаазд байхдаа хүний мэндийг авах.

17. Намааз болон намаазын гадна эвшээх.

18. Намазын үед нүдээ аних.

19. Имаам михраб буюу намааз хийлгэх газар дотор зогсох.

20. Имаам ганцаар хүй бүлгээс хагас метр өндөрт зогсох нь тензихэн мекрүх юм.

21. Имаам ганцаар хүй бөлгөөс хагас метрийн өндөрт байх нь тензихэн мекрүх юм.

22. Урд эгнээнд хоосон газар байхад хойд эгнэээнд зогсох,

эгнээнд байр байхгүй нөхцөлд эгнээгүйгээр ганцаар зогсох.

23. Хүн, амьтны зурагтай хувцас өмсөж үйлдэх.

24. Хүн амьтны зураг намаз үйлдэгчийн толгойд өмнө баруун зүүн хэсэгт хананд зураастай эсвэл даавуу цаасанд хийгдэн өлгөөсгэй тавигдсан бол мекрүх юм. Хэрээсийн зураг ч гэсэн хүн амьтны зурагтай адил.

25. Бадарсан галын хажууд намаз үйлдэх.

26. Намазд аятүүд тесбих уншлагыг гараараа тоолох.

27. Толгойгоос хөлөө хүртэл хормогч энгэрэвч өмсч үйлдэх.

28. Нүцгэн толгойдоо салдэ өмсөж толгойн орой задгайгаар үйлдэх.

29. Ам хамраа хучиж үйлдэх.

30. Шалтаггүйгээр хоолойноосоо цэр нус гаргах.

31. Гараа нэг хоёр удаа хөдөлгөх.

32. Намаазын сүннетүүдээс аль нэгийг нь орхих.

33. Шаардлагагүй үед хүүхдээ тэвэрч намааз үйлдэж эхлэх.

34. Зүрх сэтгэлийг эзэмдэн хайр эмээхүйн сүсгийг зайлуулах зүйлс, жишээ нь чимэг гангараа бүжиг хөгжим хүсч мөрөөдөх, хоол хүнсийн дэргэд намааз үйлдэх.

35. Фарз үйлдэхэд шалтаггүйгээр хана багана түших.

36. Рүкүд тонгойх, босохдоо гараа чихэнд аваачих.

37. Кыраетийг рүкүд мэхийхдээ үйлдэх.

38. Сежде болоод рүкүд имаамаас өмнө толгойгоо тавих, өндийлгөх.

39. Бохир байж болох газар намаз үйлдэх.

40. Шарилын зүг харж намаз үйлдэх.

41. Тешеххүдүүдэд сүннетэд зохицон суух.

42. Хоёрдугаар рекатд нэгдүгээрээс гурван аят уртаар унших.

Намазын гадна мекрүх болох зүйлс

1. Угаалгын газар бүх газарт абдестийг бусниахад мөн цэвэрлэгээ хийхэд кыбле рүү өмнө ба ар талаараа хандах.

2. Нар ба сарны эсрэг абдест бусниах.

3. Бага хүүхдийг кыблегийн эсрэг талд тэвэрч абдест бусниах нь тэвэрч буй том хүнд мекрүх юм. Үүний тулд томчуулд хараам болох зүйлийг багачуулаар хийлгэх нь хийлгүүлэгч том хүнд хараам юм.

4. Кыблегийн эсрэг өзргүйгээр хоёр хөл ба өрөөсөн хөлөө сунгах.

5. Кураан ба шашны ном судрын эсрэг хөлөө сунгах. Дээд газарт байрлаж байгаа бол мекрүх болно.

• НАМАЗЫГ БУСНИАХ ЗҮЙЛС •

1. Шалтаггүйгээр ханиах эсвэл хоолойгоо засах.

2. Намааз хийгч хэн нэгэн бусад нь найтаахад.

3. Намаазыг ганцаар үйлдэгч хүн нөгөө талд хүй бөлгийн дотор имаам уншиж байхад эндүүрснийг сонсоод түүнийг зөвтгөвөл намаз буснина. Хэрвээ имаам ч энэ хүний сануулганд зохицон уншвал имамын намааз буснина.

4. Намаазын дунд /ла илахе иллаллах/ гэвэл хэрэв зорилго нь хариулт бол намаз буснина.

5. Ичимхий газраа задгайлах.

6. Өвчин болон бусад зовлон зүдгүүрээс болж уйлах /Диваажин ба Тамыг ярьж түүнээс болж уйлбал үл буснина/.

7. Гар болон хэлээрээ бусдын мэндийг хүлээн авах.

8. Казад үлдсэн намазын тоо хэмжээ таваас хэтрээгүй бол намааз хийж байхад үүнийг санавал.

9. Намаазын явц дунд түүнийг харсан хэн нэгэн намааз үйлдэхгүй байна хэмээн бодох хэмжээнд намааз үйлдвэл.

10. Намаазын явц дунд юм идэж уух.

11. Намаазын явц дунд үг хэлэх.

12. Имаамаас бусад хүний алдааг заах.

13. Намаазын явц дунд инээх.

14. Намаазын явц дунд гиншиж ёхлох, ёолох.

Намааз бүрийг бусниахыг мүбах болгох зүйлс

1. Могойг алахын тулд бусниах.

2. Зугатах амьтныг барихын тулд бусниах.

3. Мал сүргийг чоноос аврахын тулд бусниах.

4. Буцалгаж буй зүйл дэвэрсэн бол.

5. Цаг хугацаа ба хүй бүлгийг алдахаас айхгүй нөхцөлд бусад мезхебүүдэд намаазыг бусниах зүйлсээс холдохын тулд жишээ нь дирхемээс багахан бохир зүйлийг цэвэрлэхийн тулд мөн харь эмд

хүрснээ санавал абдест авахын тулд намаазыг бусниах нь шашинд тохирох юм.

6. Абдест авах, унгахын тулд ч намаазыг бусниаж болно.

Намааз бүрийг бусниахын тулд фарз болох зүйлс

1. Туслаач хэмээн бархирах, хэн нэгнийг аврахын төлөө, нүхэнд унах сохор хүн, шатаж түлэгдэх, усанд живэх хэн нэгнийг аврах, галыг унтраахын тулд уншиж буй намазаа зогсооно.

2. Ээж аав ,өвөө эмээ нь дуудвал фарз намазыг бусниах нь зайлшгүй бус шашинд тохирох ч байсан шаардлагагүй бол бусниахгүй байх хэрэгтэй. Нафиле /сүннетүүд багтаад/ бол буснина. Маш чухал бол фарзыг ч бусниана.

• ХҮЙ БҮЛЭГ БА НАМААЗЫГ ОЛОНХИЙН ХАМТААР ҮЙЛДЭХ •

Намаазд хамгийн багадаа хоёр хүнээс нэг нь имаам болсноор хүй бүлэг болно. Таван удаагийн намаазын фарзуудыг хүй бүлэгтэй намааз үйлдэх нь эрэгтэйчүүдэд сүннет юм. Жума болон баярын намааз хийхэд хүй бүлэг нь фарз юм. Хүй бүлэгтэй цуг хийх намаазд илүү их буян хурдаг хэмээн хадис-и шерифт мэдэгдэж байна. Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем айлдахдаа (Хүй бүлэгтэй цуг хийх намаазд ганцаар үйлдэх намаазаас хорин долоо дахин илүү буян хайрлана. Мөн айлдруун: Сайн абдест авч месжидээс нэгэнд нь хүй бүлэгтэй хамтаар намааз хийхээр явагчид Аллаах алхам бүрт нь буян оноох ба алхам болгондоо үйл үйлдлийн дэвтрээсээ нэг нүглийг арчих ба Диваажинд түүнийг нэг зэрэглэл дээшлүүлнэ) Хүй бүлэгтэй үйлдэх намааз мусылмаан нарын нэгдэл нягтралыг хангана. Хайр энрэлийг нэмнэ. Зовлон зүдгүүртэй хүмүүс өвчтэй хүмүүс энэ дашрамд амар хялбараар гарч ирнэ. Хүй бүлэг нэг зүрх нэг бие махбодь мэт болдгийн хамгийн чухал жишээ юм.

Өвчтэй саатай, өрөөсөн хөл нь тайранхай, алхаж үл чадах өндөр настангууд, сохор хүн хүй бүлэгт орох нь шарт болзол биш юм.

Хүй бүлэгтэй хамт үйлдсэн намаазд өөрийгөө дагуулах хүнийг

Имаам гэнэ. Имаамын ёс ба үүнтэй зохицоод хүй бүлэг болохын шарт болзлууд байдаг.

• ИМААМ ЁСНЫ БОЛЗЛУУД •

Имаам болохын тулд зургаан болзол хэрэгтэй юм. Эдгээр болзлуудас нэг нь л байхгүй байгаа имаамын ард хийгдэх намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй.

1. Мусылман болох Эбү Бекр-и Сыддык ба Өмер-үл Фарукийн радийаллахү анхүма" халифе болоход үл итгэх мираж өргөмжлөл ба булшны зовлонд үл итгэгч имаам болж болохгүй.

2. Идэр насанд хүрсэн байх.

3. Ухаан нь эрүүл саруул байх. Согтуу, зөнөг хүн имаам болж болохгүй.

4. Имаам нь эрэгтэй байх. Эм хүн имаам болж болохгүй.

5. Ядахдаа Фатиха-и шерифе ба нэг аятийг зөв уншиж чадах.

6. Шалтаггүй байх.

Имаам нь Куран-и керимийг унших дүрмээр унших хэрэгтэй. Кыраетийг сайхан гэх нь унших дүрмээр уншина гэсэн үг юм. Намаазын шартуудад чухалчлахгүй имаамын хойно намаазыг үл үйлдэнэ. (Шашин номд зохицогч ба нүгэл үйлдэгчийн хойно намааз үйлдэгтүн та бүхэн) гэх хадис-и шерифийг жами имаамд бус Баасан гарагийн намаазыг үйлдүүлж буй зарлиг тушаамж амбан захирагч нарт зориулсан билээ.

Имаамын ёсонд хамгийн тохирох хүн сүннетийг /өөрөөр хэлбэл шашны мэдлэгээ/ хамгийн сайн мэдэх хүн юм. Энд тэнцэх хүмүүс байвал Кураан-и керимйг хамгийн сайн унших имаам юм. Энэ ч тэнцэх хүмүүс байвал шашинд илүү их нийцэх хүн имаам болно. Дахиад л тэнцвэр бий болбол нас ахисан хүнийг илүүд үзнэ.

Боол, баян, хэрэгтэн, нүгэлтэн, хоёр нүүртэн, сохор ба буруу хурьцлаар төрсөн хүүхдийг имаам болгох нь мекрүх юм. Имаам хүй бүлгийг залхаан ядраах байдлаар намаазыг уртасгаж болохгүй.

Эмэгтэйчүүд ганцаар намааз үйлдэж хүй бүлэгтэй намаз үйлдэх нь мекрүх юм.

Ганц хүнтэй үйлдэх имам түүнийг баруун талдаа зогсооно. Хоёр хүнтэй имам болох бол урд нь гарна. Эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүд ба хүүхдэд тохируулахыг шашин зөвшөөрөхгүй.

Имаамын ард эрэгтэйчүүд эгнээ болно, дараа нь хүүхдүүд, түүний ард нь эмэгтэйчүүд эгнээ үүсгэнэ.

Имаам эмэгтэйчүүдэд ч имаамын ёсонд зорин хүссэн бол адил намаазд байгч эмэгтэй нэг эрэгтэйтэй нэг эгнээнд намаазд зогсвол эрэгтэйн намааз буснина. Хэрвээ имаам энэхүү эмэгтэйтэй хамт имаамын ёсыг зорин хүссэн бол хажуудаа зогсох эрэгтэйд хохирол болохгүй.

Гэхдээ эмэгтэйн намаазыг шашин сайшаахгүй. Босоогоор намааз үйлдэгч, суугаа үйлдэгчид зохицох нь шашинд тохирох юм. Суурин байх аялагч имаамд зохицож болно. Имаамд зохицож намааз үйлдсэний дараа имаам абдестгүй болохыг мэдэх хүн намаазаа ахиж үйлднэ. Регайб Берат ба Кадр намаазыг хүй бүлэгтэй хамт үйлдэх нь мекрүх юм.

Хүй бүлэг хүслээ ч гэсэн имаам фарз мөргүүлэхдээ кырает ба тесбихүүдийг сүннетээс илүү унших нь тахримен мехрүх юм.

Имаамд рүкүд амжиж чадаагүй хүн тэрхүү рекатыг имаамтай цуг үйлдсэнд тооцогдохгүй. Имаам рүкүд байхад ирэх хүн нийет хийнэ. Зогсоогоор текбир уншиж намаазд оролцно. Тэр даруйдаа рүкүд мэхийж имаамд зохицно. Рүкүд тонгойлгүйгээр имаам рүкүгээс босвол рүкүд амжаагүйд тооцогдно.

Имаамаас урьд рүкүд мэхийх, сежде рүү шилжих, эсхүл түрүүлж босох нь тахримен мекрүх юм. Фарз намаазуудыг үйлдмэгц эгнээг бусниах нь мустехаб юм.

Нэг мүмин таван удаагийн намаазыг өдөр болгон хүй бүлэгтэй хамт үйлдвэл бүх Пайгамбаар алейхимүсселам нар үйлдсэн мэт буянг олно.

Хүй бүлэгтэй үйлдсэн намаазын энэ хэмжээний эрдэм буян имаамын намааз хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлд бий болно.

Хэн нэгэн хүй бүлгийг шалтаггүйгээр орхиж явбал тэр хүн Диваажингийн анхилуун үнэрийг мэдэрч үл чадна. Хүй бүлгийг шалтгаангүй орхигчид дөрвөн номд хараагдана гэж ангилагдсан билээ.

Таван удаагийн намаазыг хүй бүлэгтэй хамт үйлдэхээр чармайх хэрэгтэй. Шүүгдэх өдөр гэгээн Аллаах долоон давхар газрыг долоон давхар тэнгэрийг хуурай газар ус далай бүхий л бүтээгдэгчдийг жинлүүрийн нэг талд тавьбал болзлыг ажиглан хүй бүлэгтэй үйлдсэн нэг удаагийн намаазын буянг нөгөө талд талбивал хүй бүлэгтэй үйлдсэн намаазын буян илүү хүнд байх болно.

Имамд зохицохуй зөв болохын тулд арван болзол байдаг

1. Намаазд зогсоход текбирийг хэлэхийн өмнө имаамд зохицохоор зорин хүснэ гэсэн үг. (Бэлэн буй имаамд зохицов би) гээд зүрх сэтгэлдээ тунгаах хэрэгтэй
2. Имаам эмэгтэйчүүдийг имаам болохоор зорин хүсэх хэрэггүй. Гэхдээ зорин хүсвэл өөрөө хүй бүлгийн буянаас ч хүртнэ.
3. Хүй бүлгийн өсгий имаамын өсгийгөөс хойно байх хэрэгтэй.
4. Имаам ба хүй бүлэг адил фарз намаазыг үйлдэх хэрэгтэй
5. Имаам ба хүй бүлгийн хооронд эмэгтэйчүүдийн эгнээ байхгүй байх нь хэрэгтэй
6. Имаам ба хүй бүлгийн хооронд завь өнгөрөх хэмжээний гол унаа тэрэг өнгөрөх хирийн зам байхгүй байх хэрэгтэй.
7. Имаам эсвэл хүй бүлгийг хэн нэгнийг үзэх эсхүл хоолойг нь сонсоход тохиромжтой цонхгүй хананы хооронд байх хэрэггүй.
8. Имаам амьтанд хүй бүлгийн газар эсвэл үүний эсрэг байх хэрэгтэй.
9. Имаам ба хүй бүлэг өөр хоорондоо үл нийлсэн байх хэрэгтэй.
10. Бусад мезхеб дэхь имаамыг дагах хүй бүлгийн намааз үнэн зөв болохын тулд хоёр өгүүлэл байдаг: нэгдэх үгээр бол хүй бүлэг өөрийн мезхебээс хамааран намааз нь үнэн зөв болох имаамд бусад мезхебд байгчид ч зохицож болно. Энэхүү үгээс үзэх юм бол бүрээс ба шүдний бөглөөстэй имаамд зохицохыг шашин сайшаана. Хүй бүлэг нэг хүн бол имаамын баруун талын эгнээнд зогсоно. Зүүн талд зогсох нь мекрүх юм. Ард нь зогсох ч мекрүх юм. Хөлнийх нь өсгий имамынхаас урд биш бол намаз үнэн зөв болно. Хоёр ба түүнээс илүү хүн байвал имаамын ард талд зогсно.

Имаамтай цуг ганцаар үйлдэж байгаа мэтээр үйлднэ. Гэхдээ зогсоо байхад имаамын дотроос уншлаа ч гэсэн чанга дуугаар уншлаа ч хүй бүлэг ямар нэг зүйл уншихгүй. /Шафий мезхебт имаамтай цуг хүй бүлэг ч гэсэн намуухнаар Фатиха уншина./ Гэхдээ эхний рекатд (Субханеке) уншина. Имаам чанга дуугаар Фатихаг дуусгамагц хүй бүлэг удаанаар амин гэнэ. Үүнийг чанга дуугаар хэлэхгүй байх хэрэгтэй. Рүкүгээс босоход имаам (Семиаллахү лимен хамидех) гэж хэлэнгүүт хүй бүлэг зөвхөн (Раббена лекел хамд) гэнэ. Дараа нь бөхийхөд (Аллаахү акбаар) хэмээгээд имаамтай цуг хүй бүлэг ч гэсэн сеждед мөргөнө. Рүкүд сеждед

мөн суухад

гагцаар үйлдэх мэт хүй бүлэг ч уншина. Мацаг сард Витр намааз Рамазааныг хүй бүлэгтэй цуг үйлднэ. Бусад цагт ганцаар үйлднэ.

Месбүкийн намааз

Имаамд зохицогчид дөрвөн янз байдаг Эдгээр нь (Мүдрик) (Мүктеди) (Месбүк) (Лахик) юм.

Мүдрик ифтитиак текбирийг имаамтай цуг авагчийг хэлнэ

Мүктеди ифтитак текбирт үл амжигчийг хэлнэ

Месбүк эхний рекатд имаамд үл амжигчийг хэлнэ.

Лахик ифтитах текбирийг имаамтай хамт уншиж дараа нь өөрт нь абдестийг бусниах нөхцөл байдал бий болсноор абдест авч дахин имаамыг дагагчийг хэлнэ. Энэ хүн урьд байсан шигээр кыраетгүйгээр рүкү ба сежде тесбихүүдийг хэлж намааз үйлднэ. Тэр хүн хэрэв энэ ертөнцийн үг яриаг хэлээгүй бол имаамын дараа байгаа мэт. Гэхдээ жамигээс гарсны дараа ойр нэг газар абдестээ авах хэрэгтэй. Яагаад гэвэл, их хол явбал намааз нь буснина хэмээжээ.

Месбүк өөрөөр хэлбэл имаамд анхны рекатд амжиж чалаагүй хүн имаам хоёр талд мэндчилсэний дараа босч зогсоод амжиж чадаагүй рекатүүдийг гүйцээнэ.

Кыраетүүд эхний, дараа нь хоёр дахь, дараа нь гурав дахь рекат үйлдэж байгаа мэт уншина. Суухыг дөрөв дэх, гуравдахь, хоёр дахь рекат дараалан өөрөөр хэлбэл сүүлээс нь эхлүүлж хийнэ. Жишэ нь шөнийн намаазын сүүлийн рекатд амжсан хүн имаам мэндчилсний дараа босч нэг дэх, хоёр дахь рекатд Фатиха ба сүрег уншина. Нэг дэх рекатд сууна. Хоёр дахьд нь суухгүй.

Таван зүйлийг имаам хийхгүй бол хүй бүлэг ч хийхгүй:

1. Имаам кунут дуа уншихгүй бол хүй бүлэг ч уншихгүй.
2. Имаам баярын намааз дахь текбирийг үл хийвээс хүй бүлэг ч хийхгүй.
3. Имаам дөрвөн рекаттай намаазын хоёр дахь рекатд суухгүй бол хүй бүлэг ч суухгүй.
4. Имаам сежде аятыг уншиж сежде хийхгүй бол хүй бүлэг ч хийхгүй.

5 Имаам сежде-и сехв хийхгүй бол хүй бүлэг ч хийхгүй.

Дөрвөн зүйлийг имаам хийвэл хүй бүлэг хийхгүй:

1. Имаам хоёроос олон удаа сежде хийвэл хүй бүлэг хийхгүй.
2. Имаам баярын текбирийг нэг рекатд гурваас олон удаа хийвэл хүй бүлэг хийхгүй.
3. Имаам оршуулгын намаазд дөрвөөс олон текбир хийвэл хүй бүлэг хийхгүй.
4. Имаам тав дахь рекатд босвол хүй бүлэг босохгүй имамыг хүлээж хамтдаа мэндчилнэ.

Арван зүйлийг имаам хийхгүй бол хүй бүлэг хийнэ:

1. Ифтитах текбирд гараа өргөх
2. Субханеке унших
3. Рүкүд мэхийхэдээ текбир хэлэх
4. Рүкүд тесбих унших
5. Сеждед мөргөхдөө текбир хэлэх
6. Сеждед тесбих унших
7. Сэмиаллахү гэхгүй бол раббена лекел хамд гэх
8. Эттехыйатыг дуустал нь унших
9. Намаазын төгсгөлд мэндчлэх
10. Курбаан баярт хорин гурван фарзын дараа мэндчилэнгүүт текбир уншина. Энэ хорин гурван текбирийг тешрик текбир гэнэ.

• ОРШИЛ ТЕКБИРИЙН ДЭЭД ЧАНАР •

Хэн нэгэн оршил /ифтитах/ текбирээ имаамтай цуг уншвал намрын өдрүүдэд салхинд модны навч хэрхэн унадагтай адилаар тэр хүний нүгэл унаж арилна.

Нэг өдөр Расүллүллах саллаллахү алехи ве селлем намааз үйлдэх цагт нэг хүн өглөөний намаазд ифтитах текбир хийж амжсангүй Нэг боолыг аварчээ. Тэгээд дараа нь ирээд Расүллүллах саллаллахү алехи ве селлемээс асуув. Аяа Реасүлүллах би өнөөдөр оршил текбирийг хийж амжсангүй. Нэг боолыг аварлаа. Оршил текбирийн буянд хүрч чадсан болов уу? хэмээн асуув. Расүллүллах саллаллахү алехи ве селлем Эбу Бекр-и Сыддык радыйалахү анхаас (Энэхүү ифтитах текбирийн талаар чи юу хэлэхсэн билээ?) хэмээн асуув. Эбу

Бекр-и Сыддык радыйаллахү анх айлдруун Аяа Ресүллүллах Дөчин тэмээ эзэмшлээ ч дөчүүлээ алт эрдэнэс ачиж байлаа ч эрдэнэсийг нь ядууст өглөг болгон өгвөл мөн л имаам лугаа хамт авах оршил текбирийн буянд хүрч чадахгүй хэмээв.

Түүний дараа Расүллүллах саллаллахү алехи ве селлем (Аяа Омар Энэхүү ифтитах текбирийн талаар чи юу хэлэхсэн билээ?) хэмээхэд. Гэгээн Омар радыйаллахү анх Аяа Расүллүллах Мекке Мединегийн хооронд дүүрэн тэмээ байлаа ч эд бүгд ачаа эрдэнэсийг нь би ядууст өглөг болгон тараалаа ч имаамтай цуг үйлдэх оршил текбирийн буянд хүрч чадахгүй хэмээв.

Түүний дараа Расуллүллах саллаллахү алехи ве селлем (Аяа Осман Энэхүү оршил текбирийн талаар чи юу хэлэхсэн билээ?) хэмээхэд. Гэгээн Осман зин –нурейн радыйаллаху анх Аяа Расүллүллах Миний бие шөнө хоёр рекат намааз үйлдэхэд тухай бүрт нь Агуу их алдар цуут Кураан судрыг дуустал нь уншлаа ч гэлээ имаамтай цуг үйлдэх оршил текбирийн буянд хүрч чадахгүй хэмээв. Расүллүллах саллаллахү алехи ве селлем (Аяа Али Энэхүү ифтитах текбирийн талаар чи юу хэлэхсэн билээ?) хэмээхэд. Гэгээн Али керремаллахү вежнхех Аяа Расүллүллах Дорноос өрнө хүртэл куффар тэрслүү нар дүүрэн байлаа ч Эзэн Тэнгэр минь надад хүч чадал хайрлаад бүгдтэй нь дайтлаа ч имаамтай цуг үйлдэх оршил текбирийн буянд хүрч чадахгүй би хэмээжээ.

Түүний дараа Гэгээн Расүллүллах саллаллахү алехи ве селлем (Аяа итгэн сүсэглэгчид ба асхаб минь! Долоон давхар газар долоон давхар тэнгэр огторгуй цаас байлаа ч хүрхрээ дүүрэн бэх байлаа ч бүх модод үзэг боллоо ч бүх сахиусан тэнгэр нар бичээч боллоо ч шүүгдэх өдөр хүртэл бичлээ ч гэлээ имаамтай цуг үйлдэх оршил текбирийн буянг бичиж үл чадна) хэмээжээ.

Үлгэр : Сарайд барьсан месжид

Имаам-и аазам Эбү Ханифегийн шавь имаам-и Эбү Юүсүф рахметуллахи алейх, Харун Решид цагтаа кады буюу шүүгч байв. Нэг өдөр Харүн Решидийн хажууд байхдаа нэг хүн нөгөө хүнийг шүүхэд өгчээ. Харүн Решидийн түшмэл нь би түүний гэрч нь гэв. Имаам-и Эбү Юүсүф түшмэлийн гэрчлэхийг хүлээн зөвшөөрсөнгүй. Халифе яагаад түшмэлийн гэрчлэлийг хүлээн

зөвшөхгүй байгаа юм бэ чи? хэмээн асуув. Имаам та нэг өдөр түүнд ажил хэрэг зарлигласан билээ. Тэр ч танд би таны боол билээ хэмээсэн. Хэрвээ зөв хэлсэн бол боолын гэрчлэл зөвшөөрөгдөхгүй. Худлаа хэлсэн бол худалчийн гэрчлэлийг ч сонсож болохгүй хэмээн өгүүлэв. Халифе би гэрчлэвэл хүлээн зөвшөөрөх үү чи? хэмээн асуув. Үгүй зөвшөөрөхгүй гэв. Яагаад? гэв. Чи намаазаа хүй бүлэгтэй хамт үйлдэхгүй байна хэмээв. Би мусылмаан нарын үйл хэргээр хөөцөлдөж байна гэв. Имаам Бүтээгчийг дагах газар бүтээгдэгчийг дагаж болохгүй хэмээв. Халифе чи зөв хэлж байна гээд ордондоо месжид барихыг тушаасан ба Мүеззин ба имаам томилж түүнээс хойш намаазыг үргэлж хүй бөлөгтэй хамт үйлдэв.

• ЖУМА НАМААЗ •

Аллах Жума буюу Баасан гарагийг мусылманчуудад хайрласан юм. Жума өдөр үдийн цагт Жума намаазыг хийх нь Аллаахын зарлиг юм.

Аллаах Жума сүрегийн сүүлийн аят-и керимед өгүүлснийг утгачлавал (Эй имаан хийж бахдан баясах боол нар минь Жума өдөр үд орчим азаан уншигдах цагт хүтбе сонсох жума намаазыг хийхээр жами руу гүйгтүн! Худалдаа арилжаагаа зогсоогтун! Жума намааз ба хүтбе та бүхэнд бусад ажлаас тань илүү ач тустай юм. Баасан гарагийн намаазыг үйлдсэний дараа жамигээс гарч энэ дэлхийн үйл ажлаа хийхийн тулд тарагтун. Та бүхэн Аллаахаас хүнс тэжээлийг хүлээж ажиллагтун. Аллаахыг ихэд санах дурсах хэрэгтэй тэгснээрээ ч аврагдах хэрэгтэй!)

Намаазын дараа хүссэн нь ажил руугаа явж ажиллаж, хүссэн нь жамид үлдээд намааз үйлдэж Кураан-и керимийг уншина. Баасан гарагийн намаазын цаг эхлэхэд худалдаа хийх нь нүгэл болно.

Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем янз бүрийн хадис-и шерифүүдэд айлдахдаа (Нэг мусылмаан хүн Баасан гарагт гүсл абдест авч Баасан гарагийн намаазд явбал нэг долоо хоногийн нүгэл өршөөгдөх ба алхам бүрт чинь буян хурна)

(Баасан гарагийн намаазыг үл үйлдэгчдийн зүрх сэтгэлийг Аллаах тамгална.Боол гэдгээ үл ухагч /Гафил/ болцгооно).

“Хамгийн дээд үнэт өдөр бол Баасан гараг бөлгөө. Баасан гараг баярын өдрүүд хийгээд Ашүре өдрөөс ч илүү хүндтэй

билээ. Баасан гараг нь энэ ертөнц ба Диваажинд алинд ч мусылмаанчуудын баяр юм”.

(Хэн нэгэн саад хориг байхгүй байхад Гурван удаа Баасан гарагийн намаазыг үл үйлдвэл Аллаах зүрх сэтгэлийг нь тамгална. Өөрөөр хэлбэл сайн буян хийж чадахгүй болно).

(Баасан гарагийн намазын дараах нэг мөчид мүминий тэр агшинд хийсэн дуа эргэж буцахгүй).

(Баасан гарагийн намаазын дараа долоон удаа Ихлас ба Мүаввитейн уншигчийг Аллаах нэг долоо хоног осол гамшиг муу үйлээс хамгаална)

Бямба гараг жүүд нарт Ням гараг назарей болоод христиан нарт хайрлагдсан лугаа адил Баасан гараг мусылмаан нарт соёрхогдсон. Энэ өдөр Мусылман нарт сайн буян элбэг дэлбэг сайн сайхан буй болдог).

Баасан гарагт үйлдсэн ибадетд бусад өдөр хийсэн мөргөлөөс багадаа хоёр дахин илүү буян оногдно. Баасан гарагт үйлдсэн нүгэл ч гэсэн хоёр дахин үржинэ. Баасан гарагт сүнснүүд цуглан хурж нэг нь нөгөөтэйгээ танилцна. Булш бунханг айлчилна. Энэ өдөр булш бунхны зовлон зогсно. Зарим мэргэдийнхээр бол мүминий зовлон дахиж эхлэхгүй дуусна. Кафир Баасан гараг ба Рамазан сард үл ззовох авч энэлэн нь шүүгдэх өдөр хүртэл үргэлжилнэ. Энэ өдөр эсвэл шөнө нь нас нөгчсөн мүминчүүд булшны зовлон үл амсна. Там Баасан гарагт их халуун болохгүй. Адаам алейхисселамыг Баасан гарагт бүтээсэн. Баасан гарагт Тамд илгээсэн. Диваажинд очигч нар Аллаахыг Баасан гарагт харах болно.

Жүма намаазын фарз

Жүма өдөр арван зургаан рекат намааз үйлднэ. Үүнээс хоёр рекатыг нь үйлдэх фарз юм. Өглөөний намаазаас илүү хүчтэй намааз юм. Жүма намааз фарз болохын тулд хоёр төрөл зайлшгүй болзол байдаг.

1. Эда болзол.
2. Вүжүб болзол.

Эда зайлшгүй болзлоос нэг нь дутуу болвол намааз хүлээн зөвшөөрөгдөхгүй. Вүжүб болзлууд байхгүй бол хүлээн зөвшөөрөгднө.

Еда өөрөөр хэлбэл

Жүма намааз нь үнэн болохын тулд долоон шарт байна.

1. Намаазыг хотод хийх / хот гэдэг нь : Хүй бүлэг хамгийн томоохон жамид үл багтах газар гэсэн үг.
2. Төрийн тэргүүн ба амбан захирагчийн зөвшөөрлөөр хийх ба эс бөгөөс тэдний томилсон илтгэгч /хатиб/ өөртөө бусдыг орлуулж болно.
3. Үдийн намаазыг цаг хугацаанд нь үйлдэх .
4. Цаг хугацаа дотроо хутбе унших /Номч мэргэд Жума хутбег унших намаазд зогсоход Аллаахү акбаар гэх мэт хэмээв.

Өөрөөр хэлбэл хоёр хутбег ч гэсэн зөвхөн араб хэлээр унших хэрэгтэй. Хүндэт хатиб илтгэгч дотроос нь эүзүг уншиж дараа нь дээд дуугаар хамд ба сена мөн келиме-и шехадет салат-ү селам уншина. Дараа нь буян зовлонгийн шалтган болох зүйлсийг сануулж аят-и кериме уншина. Сууж босно. Хоёр дахь хутбег уншиж шашны сургаалын оронд мүминчүүдийн төлөө дуа хийнэ. Дөрвөн халифегийн алдрыг хэлэх нь мустехаб юм. Хүтбетэй энэ ертөнцийн үгийг холих хутгах харам юм. Хүтбег нүтк ба яриа хэлбэрт оруулж хэрэггүй. Хүтбег богино унших сүннет юм. Урт удаанаар унших нь мекрүх билээ./

5. Хүтбег намаазаас өмнө унших.
6. Баасан гарагийн намаазыг хүй бүлэгтэй цуг үйлдэх.
7. Жамийн хаалгыг хүн бүрт нээлттэй байлгах.

Жума намаазын шарт болзол ес байна

1. Хот ба тосгонд суугсдад фарз, аянчдад фарз биш.
2. Бие бүтэн эрүүл байх, өвчтэй болон өвчтөнг орхиуж үл болох асрагч хамгаалагчид фарз биш юм.
3. Эрх чөлөөтэй байх.
4. Эрэгтэй байх.
5. Ухаан санаа эрүүл, идэр насанд хүрсэн байх.
6. Сохор биш байх. Замд хүргэгчид байлаа ч сохор хүнд фарз биш юм.
7. Алхаж явж чадах ёстой. Зөөх хэрэгсэл байлаа ч саа өвчтэй ба хөлгүй хүмүүст фарз биш юм.

8. Шорон гянданд биш байх, дайсан, засаг төр, түрэмгийлэгчээс үл айх

9. Хэт их бороо цас шуурга, шавартай, хүйтэн биш байх

Жума намаазыг хэрхэн хийх вэ?

Баасан гарагт үдийн азаан уншингуут арван зургаан рекат Баасан гарагийн намаз үйлднэ. Эдгээр нь дэс дараагаараа доорх байдалтай байна:

1. Эхлээд, жума намазыг дөрвөн рекат Анхны сүннетийг үйлднэ. Энэхүү сүннет үдийн намаазын анхны сүннет мэт үйлдэгднэ. Үүнийг "Нийет хийлээ. Аллахын зөршөөрснөөр Баасан гарагийн намаазын анхны сүннетийг үйлдэхийн тулд кыбле рүү хандлаа би" хэмээн зорин хүснэ.

2. Дараа нь жами дотор хоёрдох азаан ба хүтбе уншина.

3. Хүтбег уншсаны дараа икамет уншиж хүй бүлэгтэй Баасан гарагийн намазын хоёр рекат фарз үйлднэ.

4. Жума намаазын фарз үйлдсэний дараа дөрвөн рекат сүүлчийн сүннет үйлднэ. Үүнийг үйлдэх нь үдийн намаазын анхны сүннетийнхтэй адил юм.

5. Үүний дараа "Надад фарз болох үйлдэж чадаагүй сүүлчийн үдийн намаазын фарзыг үйлдэхээр" зорин хүсч (Ахир зухур) намааз үйлднэ. Дөрвөн рекат энэхүү намаазыг үйлдэх нь үдийн намазыг үйлдэхтэй адил юм.

6. Дараа нь хоёр рекат тухайн хугацааны сүннет үйлднэ. Үйлдэх нь өглөөний намаазын сүннетийг үйлдэхтэй адил.

7. Үүний адил Айет-ел-күрси ба тесбихүүд уншиж дуа хийнэ.

Жума өдрийн сүннет ба зүй ёсууд

1. Жумаг пүрэв гарагаас угтах

2. Баасан гарагт гусул абдест авах

3. Толгойны үс сахлаа хусах Хуузны нэг баримаас илүүг хумсаа авах Цэвэр хувцас өмсөх

4. Баасан гарагийн намаазд аль болох эрт явах

5. Урьд эгнээнд гарахын тулд хүй бүлгийн мөрөөс хэтрэхгүй байх

6. Жамид намаз үйлдэгчийн урдуур үл гарах.

7. Хүндэт илтгэгч индэрт гарсны дараа юу ч үл хэдэх яригч руу дохиж зангаж ч гэсэн хариу үл өгөх, азааныг дахин давтахгүй байх.

8. Баасан гарагийн намазын дараа Фатиха, Кафирун, Ихлас, Фелак ба Нас сүрег долоон удаа унших.

9. Оройн намаазын цаг хүртэл жамид үлдэж ибадет хийх.

10. Эхл-и сүннет мэргэдийн ном судраас өгүүлэх, мэргэд багш нарын хичээл айлдалд орлцох байлцах.

11. Баасан гарагг бүхэлд нь ибадетээр өнгөрөөх.

12. Баасан гараг салеват-и шерифег үйлдэх.

13. Кураан-и керим унших Кехф сүрег унших.

14. Садака буюу өглөг өгөх.

15. Ээж аавыхаа булшийг нь эргэн тойрох.

16. Гэрийн хоолоо элбэг дэлбэг амттан хийх, бэлдэх.

17. Их хэмжээгээр намааз үйлдэх. Казад үлдсэн намазтай хүмүүс каза намаз үйлдэх хэрэгтэй.

• БАЯРЫН НАМААЗУУД •

Шеввал сарын анхны өдөр фытр /өглөг/буюу Рамазан баярын Зилхижжегийн аравдах өдөр бол Курбаан баярын анхны өдөр юм. Энэ хоёр өдөрт нар гарч /болгоомжлох хугацаа өнгөрсний дараа/ хоёр рекат баярын намааз үйлдэх нь эрэгтэйчүүдэд важиб буюу зайлшгүй юм.

Баярын намаазын шартууд Баасан гарагийн намаазын шарт болзолтой адилхан. Гэхдээ энд хутбе сүннет бөгөөд намаазын дараа уншина.

Рамазаан баярт намаазын урд амттан /хасарваань жимс эсхүл чихэр/ идэх, гусыл хийх, мисвак хэрэглэх, хамгийн өнгөтэй сайн хувцсаа өмсөх, фитра өглөгийг намазын өмнө өгөх, жами очих замдаа текбир унших нь мустехаб юм.

Курбаан /Өргөлийн/ баярын намаазаас өмнө юм идэхгүй байх, намаазын дараа эхлээд курбааны мах идэх, намааз руу явахдаа чанга дуугаар шалтагтай хүнтэй хүн удаанаар текбир унших нь мустехаб юм.

Баярын намааз хоёр рекат юм. Хүй бүлэгтэй хамтаар хийх бөгөөд дан ганцаар үйлдэхгүй.

Баярын намаазыг хэрхэн үйлдэх вэ?

1. Эхлээд “Зорин хүслээ би, зайлшгүй хийх ёстой баярын намаазыг үйлдэхээр бэлэн байгаа имаамыг дагав би” гэж зорин хүсээд намааз эхлэнэ. Дараа нь Сүбханеке уншина.

2. Сүбханекегийн дараа гараа гурван удаа текбир уншиж чихэнд хүргэж анхны болоод хоёрдоход нь гараа хоёр талд сул орхино. Гурав дахьд нь хүйсний доор гараа холбон барина. Имаам эхлээд Фатиха дараа нь нэг сүрэ уншиж хамтдаа рүкүд мэхийнэ.

3. Хоёр дахь рекатд имаам эхлээд Фатиха ба нэг сүре уншина. Дараа нь хоёр гар гурван удаа текбир авчирч дээш өргөнө. Гуравдахь рекатд ч хажуудаа сул орхино. Дөрөвдэх текбирт гарыг чих тийш аваачилгүйгээр рүкүд тонгойно. Товчоор: (Хоёр орхи нэг холбо Гурав орхи нэг бөхий) гэж тогтон цээжлэнэ.

Тешрик текбирүүд /Нэгдэн нягтрах залбирал

Курбаан баярын урд өдөр өглөөний намаазаас дөрөв дэх өдөр оройн намааз хүртэл хажи нар ба хаж руу яваагүй эрэгтэй эмэгтэй хүн бүхний хүй бүлэгийн хамтаар ч бай ганцаар ч бай үйлдсэн фарз намаазын дараа мэндчилэнгүүт нэг удаа Тешрик текбирийг унших нь важиб юм.

Оршуулгын намаазын дараа уншиж болохгүй. Жамигээс гарсны дараа эсвэл ярьсны дараа унших хэрэггүй.

Имаам текбирийг мартсан бол хүй бүлэг орхиж явахгүй. Эрэгтэйчүүд чанга дуугаар уншиж болно. Эмэгтэйчүүд удаанаар хэлнэ.

• ТЕШРИК ТЕКБИР •

“АЛЛААХУ АКБААР, АЛЛААХУ АКБААР. ЛА ИЛАХЕ ИЛЛАЛЛААХ ВАЛЛААХУ АКБААР. АЛЛААХУ АКБААР ВЕ ЛИЛЛАХИЛХАМИД”

• ҮХЭЛД БЭЛДЭХ •

Үхлийг санах нь хамгийн том сургамж юм. Имаантай хүн бүр үхлийг байнга санаж байх нь сүннет юм. Үхлийг олонтаа санах

нь захирамж тушаалыг дагаж нүглээс зайлсхийх шалтгаан

болно. Хараам үйлдэх зориг зүрх багасна. Бидний хайрт Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем айлдаруун: (Амтыг устгагч цэнгээн наргианыг төгсгөгч үхлийг үргэлж санагтун!) Шашны мэргэлийн зарим нь өдөр бүр нэг удаа санах нь заншил болгосон байв. Агуу их евлиа мэргэн Мүхаммед Бехаеддин-и Бүхари күддисет сиррүх өдөр болгон хорин удаа өөрийгөө үхсэн, авсанд орсон хэмээн боддог байв. Алсын зорилго гэдэг нь урт удаан амьдрахыг хэтийдэн хүсэхийг хэлнэ. Ибадет хийх, шашинд зүтгэхийн тулд урт удаан амьдрахыг хүсэх нь алсын зорилго бус юм. Алсын зорилготон ибадетийг хугацаанд нь хийж чаддаггүй билээ. Наманчлахаа болино. Зүрх сэтгэл нь хатуужина. Үхлийг огтоос үл дурсна. Шашны сургаал ба зөвлөгөнөөс сургамж авахгүй.

Урт зорилготон ямагт энэ ертөнцийн эд таваар эрх тушаалд хүрэхийн тулд амьдралаа зарцуулна. Нөгөө ертөнцийг умартна. Зөвхөн таашаал цэнгэл амар тайвнаа бодно.

Хадис-и шерифт айлдахдаа: Үхэхээсээ өмнө үхэгтүн. Тооцоонд орохоосоо өмнө өөрсдийгөө тооцогтун.

Үхлийн дараа болох зүйлсийг та нарын мэдэж байгаа шигээр амьтад мэддэг байсан бол идэх тарган амьтан олж чадахгүй байсан.

Өдөр шөнөгүй үхлийг санагч хүн шүүгдэх өдөр шехидүүдийн хажууд байх болно.

Алсын бодлын шалтгаан энэ ертөнцийн таашаалд шунан дурлах, үхлийг мартах, эрүүл энх залуу зандан насандаа хууртах явдал юм.

Алсын бодлын эмгэгэээс ангижрахын тулд энэхүү шалтгааныг үгүй хийх хэрэгтэй. Үхэл цаг мөч бүрт ирж болохыг бодох хэрэгтэй. Алсын санааг эзэмшигч болохын хор хөнөөл үхлийг санахын ач тусыг сурах хэрэгтэй. Хадис-и шерифт айлдахдаа:

Үхлийг олонтаа санагтун. Түүнийг санах бодох нь хүнийг нүгэл үйлдэхээс хамгаалж нөгөө ертөнцөд хор хөнөөлтэй зүйлээс зайлсхийх шалтгаан болно.

Үхэл гэж юу вэ?

Үхэл нь үгүй болох гэсэн үг биш юм. Үхэл нь хүний сүнс, бие хоерын холбоос төгсөх явдал юм. Сүнс биеэс сална гэсэн үг. Үхэл

нь хүн нэг байлдлаас нөгөө нөхцөл байдал руу шилжинэ гэсэн үг. Нэг гэрээс нөгөө гэр лүү нүүсэн мэт. Гэгээн Омар бин Абдүлазиз өгүүлрүүн: Та нар зөвхөн мөнхийн ёс төгсгөлгүйн тулд бүтээгдсэн. Харин нэг гэрээс нөгөө гэр лүү нүүдэллэнэ. Үхэл нь мюминд бэлэг хишиг юм. Нүгэлтэн нарт гамшиг юм. Хүн үхлийг хүсэхгүй. Гэтэл үхэл арга залиас илүү буянтай билээ. Хүн амьдрах дуртай байдаг. Гэтэл үхэл түүнд ач буянтай бөлгөө. Номын ёст мюмин хүн үхсэнээрээ энэ ертөнцийн зовлон тарчлан ядаргаа зүдэргээнээс ангижрана. Дарангуй хэрцгий нарын үхлээр улс орон мюмин нар тайван амгаланд хүрдэг. Нэг хэрцгий дарангуй үхэхэд дуулах эртний нэг бейт буюу хоёр мөрт дараах байдалтай болно.

Өөрөө ч амгалан байсангүй, ертөнцөд ч энх жаргаланг өгсөнгүй Ертөнцөөс нуран одов, булшинд агч тэсэн үлдэг

Мүмин сүснийхээ бие махбодиос ангижирсан нь хоригдол шорон гяндангаас чөлөөлөгдсөнтэй адил. Мүмин үхсэний дараа энэ ертөнц рүү эргэн ирэхийг хүсдэггүй. Зөвхөн шехидүүд л энэ дэлхийд дахин ирж дахиад шехид болохыг хүсдэг. Үхэл мусылмаан хүн бүрийн бэлэг юм. Нэг хүний шашныг зөвхөн оршуулга л хамгаална. Оршуулгын амьдрал нь нэг бол Диваажингийн цэцэрлэгт орших эсвэл Тамын нүхэнд байх мэт.

Үхэл бол үнэн юм

Үхлээс чөлөөлөгдөх боломжтой юу? Мэдээжээр үгүй. Хэн ч нэг мөч болтугай амьдрах өөрт нь боломжгүй. Амьдрах хугацаа нь дууссан хүн үхнэ. Энэ хугацаа нь нүд нээгээд аних хүртэл өнгөрсөн мөч болно. Кураан-и керимд нэг аят-и керимээс утгачлавал, (Эсэллэрийг ирсэн үед түүнийг нэг цаг урагш хойш болгохгүй) хэмээн айлджээ.

Аллаах хэн нэгний үхлийг хаана таална тэр хүн эд хөрөнгө, үр хүүхдээ орхиж тэнд нас нөгчнө.

Аллаах бидний өдөрт хэдий хэр амьсгаа авч өгдгийг мэднэ. Түүний мэдэхгүй зүйл гэж үгүй. Имаан хийж амьдрал минь ибадетээр өнгөрсөн бол төгсгөл нь аз жаргал болно.

Аллаах Азрайл алейхисселамд айлдруун (Нөхдийнхөө амийг

хялбар ав, дайснуудынхаа амийг хүндээр ав!) хэмээжээ. Имаантай хүмүүст энэ нь ямар их гайхамшигт мэдээ билээ. Имангүйчүүдийн хувьд ямархуу хүнд гамшиг билээ.

• ОРШУУЛГЫН НАМААЗ •

Нэг мүмин нас нөгчсний мэдээг авагч эрэгтэйчүүдэд, эрэгтэйчүүд үгүй бол эмэгтэйчүүдэд оршуулгын намааз фарз-й кыфайе юм. Оршуулгын намааз Аллаахын тулд намаазд үхсэн хэн нэгний хувьд Дуа юм. Чухалд үл бодогчийн имаан нь зайлна.

Оршуулгын намаазын шарт болзлууд

1. Өөд болооч мусылмаан байх ёстой.
2. Угаасан байх ёстой. Угаалгүйгээр хөдөөлүүлээчийн дээр.

нь шороо асгаагүй бол гаргаж угаагаад дараа нь намааз үйлднэ. Оршуулга болоод имаам байх газар цэвэр болох хэрэгтэй.

3. Шарил ба биеийн хагасаар толгой ба толгойгүй хагасаас илүү бие нь имаамын өмнө байх хэрэгтэй.
4. Шарилыг газарт эсвэл газарт ойрхон гараар барьж чулуун дээр тавих хэрэгтэй. Шарилын түрүү хэсэг имаамын баруун талд, хөл хэсэг нь имаамын зүүн талд байх юм. Эсрэгээр тавих нь нүгэл юм.
5. Шарил имаамын өмнө бэлэн байх хэрэгтэй.
6. Шарил ба имаамын ичимхий газар хучиатай байх хэрэгтэй.

Оршуулгын намаазын фарзууд

1. Дөрвөн удаа текбир унших.
2. Босоо байдалтай үйлдэх.

Оршуулгын намаазын сүннетүүд

1. Субханеке унших.
2. Салеват унших.
3. Өөртөө ба өөд болоочд, бүх мусылмаан нарт өршөөл ба нигүүлслийн төлөө мэдэгдэх дуагаас мэдэхээ унших.

Оршуулгын намаазыг жами дотор үл үйлднэ.

Амьдаараа төрөөд эндэж өөд болсон хүүхдэд нэр өгч угааж цагаан өмсгөл өмсгөөд намаазыг үйлднэ.

Оршуулгыг зөөх үед авсны даөрвөн талаас барих ба Эхлээд шарилын тэргүүн тал баруун мөрөнд хөл тал нь баруун мөрөнд дараа нь толгой тал зүүн мөрөнд дараа хөл тал зүүн мөрд хийгдэх байдлаар тухай бүрт нь арав арван алхам зөөнө. Бунханд хүрэх үед оршуулга мөрнөөс газар буулгаагүй байхад сууж болохгүй. Оршуулах үед үл оролцогчид сууна.

Оршуулгын намаазыг хэрхэн үйлдэх вэ?

Оршуулгын намаазын дөрвөн текбирээс нэг бүр нь нэг рекат мэт байна. Дөрвөн текбирээс зөвхөн эхнийхэд нь гар чихэнд хүрнэ. Дараах гурван текбирд гарыг чих рүү аваачихгүй.

1. Анхны текбир уншиж хоёр гар холбонгуут Сүбханеке уншина. Уншиж байхдаа вежелле сенаүке ч гэнэ. Фатиха уншихгүй.

2. Хоёр дугаар текбирийн дараа тешеххүдде суух үед унших салеватууд өөрөөр хэлбэл Аллахүмме салли ба Барик Дуаг уншина.

3. Гурав дугаар текбирийн дараа оршуулгын дүа уншина. Оршуулгын дүаны оронд Раббена ати-на эсхүл зөвхөн Аллахүммагфирлех гэх эсвэл дуа ниййет буюу зорин хүсэхүйгээр Фатиха сүрег уншиж ч болно.

4. Дөрөв дүгээр текбирийн дараа тэр даруйдаа баруун тийш дараа нь зүүн тийш мэндчилнэ. Мэндчлэхэд оршуулга ба хүй бөлөгт хүсэн зорино.

Имаам зөвхөн дөрвөн текбир ба хоёр мөрд мэндчилгээг чанга дуугаар хэлэх ба бусдыг нь амандаа уншина.

Оршуулгын намаазыг үйлдсэний дараа авсны хажууд дуа унших шашинд үл тохирно. Мекрүх болно.

• ТЕРАВИХ НАМААЗ •

Теравих намааз эр эмийн хувьд сүннет юм. Рамазаан-и шерифийн шөнө бүр үйлдэнэ. Хүй бүлэгтэй хамт үйлдэх нь сүннет-и кифайе юм. Хугацаа нь шөнийн намаазын дараа витрийн урд юм. Витрийн дараа ч үйлдэж болно. Жишээ нь Теравих намаазын нэг

хэсэгт нь амжиж имаамтай витр намаазыг үйлдэх хэн нэгэн теравих намаазаас амжиж үйлдээгүй рекатуудаа витрийн дараа үйлднэ.

Үйлдээгүй теравих намааз каза үл болно. Каза болбол нафиле болно. Теравих болохгүй. Теравих намааз хорин рекат юм.

Теравихийг хэрхэн үйлдэх вэ?

Витр намаазыг зөвхөн Рамазаан сард хүй бүлэгтэй үйлднэ. Теравих намаазыг хоёр хоёр рекат байдлаар арван селамаар дөрвөн рекат бүрийн төгсгөлд хүлээж тесбих хийж үйлдэх нь мустехаб юм. Каза өртэй хүн чөлөөт цагтаа таван удаагийн сүннетүүд ба теравихийн оронд ч гэсэн каза үйлдэж нэг юуны түрүүнд казаг дуусгаж дараа нь энэхүү намаазуудыг үйлдэж эхлэх хэрэгтэй.

Теравих намаз жамид хүй бүлэг лүгээ үйлдэхэд бусад нь гэртээ гагцаар үйлдэж болно. Нүгэл үл болно. Гэхдээ жами дахь хүй бүлгийн буянаас хоцроно. Гэртээ нэг эсвэл хэдэн хүнтэй хамт үйлдвэл гагцаар үйлдэхээс хорин долоо дахин илүү буян хураана. Ифтитах текбир бүрт зорин хүсэх нь илүү сайн болно. Шөнийн намаазыг хүй бүлэгтэй хамт үл үйлдэгч нар теравихийг хүй бүлэгтэй үйлдэж болохгүй. Шөнийн намаазыг хүй бүлэгтэй үйл үйлдлэгч хүн фарзыг ганцаар үйлдэж дараа нь теравихийг хүй Шөнийн намаазыг хамт үйлдэж болно.

Тавдугаар бүлэг



• АЯН ЗАМЫН НАМААЗ •

Ханефи мезхебт байх хүн арван таван өдрөөс бага хугацаагаар байхыг зорин хүсч зуун дөрвөн киломэтр ба илүү хол газар явбал аянчин болно.

Аялагч эсвэл жуулчин болно гэдэг нь зорчигч болно гэсэн үг. Жуулчин дөрвөн рекат фарз намаазыг хоёр рекат хийнэ. Суурин байгч имаам таарвал мөн л дөрвөн рекат хийнэ. Жуулчин имаам болбол хоёрдох рекатын сүүлд мэндчилнэ. Дараа нь түүнд тохирох хүй бүлгийн намаазыг бүрэн бүтэн болгохын тулд хоёр хоёроор дахин үйлднэ.

Аялагч хүн дан гуталтайгаар гурван өдөр гурван шөнө мэсх хийж болно. Мацагаа зогсоож болно. Зорчигч тав тухтай бол мацагаа зогсоохгүй байх нь илүү дээр. Курбаан гаргах важиб буюу зайлшгүй болохгүй. Жүма намааз ч гэсэн аялагчийн хувьд фарз буюу гарцаагүй биш юм.

Намаазын үеийн төгсгөлд аян замд гарсан хүн энэ намаазыг хийгээгүй бол хоёр рэкат хийнэ. (Нимет-и исламд) “нафилэ буюу нэмэлт намаазуудыг босоо зогсож хийх хүч хүрэлцэх атал сууж үйлдэх нь бүхий л цаг мөч бүх газар оронд шашинд тохирох юм. Сууж үйлдэхэд рюкюд биеэ тонгойно. Сеждед толгойгоо газар хүртэл мэхийнэ. Гэхдээ шалтаггүй байхад нафилег сууж үйлдэгчдэд босч зогсон үйлдэгчдийн хагас хэмжээнд буян ногдно. Таван удаагийн намаазын сүннетүүд ба теравих намаз ч гэсэн нафиле намааз юм. Аян замд өөрөөр хэлбэл хот хөдөөгөөс гадна нафиле намаазыг мал амьтан дээр үйлдэх нь сайз юм. Кыбле рүү эргэх рүкү ба сежде хийх хэрэггүй. Толгой дохиж үйлднэ.Өөрөр хэлбэл рүкүд биеэ бага зэрэг тонгойно. Сеждегийн тулд үүнээс илүү их мэхийнэ. Мал амьтан дээр ихээхэн бохир буртаг байх нь

намаазд саад үл болно. Газарт нафиле үйлдэхэд ядрагчид таяг, хүн, хананд тулж үйлдэх нь шашинд тохирох юм. Өөрөөр алхахдаа намааз үйлдэх жинхэнэ бус юм.

Фарз ба важиб намаазууд зайлшгүй шаардлагатай бус бол мал амьтан дээр үйлдэх шашинд тохирохгүй. Зөвхөн шалтгаар үйлдэж болно. Зайлшгүй шаардлагатай шалтгууд эд таваар, амь нас мал амьтан нь аюул заналд өртөх, мал амьтнаас холдоход мал унаа болоод мал байх юм уу хажуу хавьд байх эд хогшил хулгайлагдах, махчин амьтан, дайсан газарт шавар шалбааг бороо орох, өвчтөн морь малнаасаа буух мордоход өвчин илаарших нь удаашрах эсвэл аюул осолд өртөх, буусны дараа морь унаандаа туслуулагүйгээр мордож чадахгүй байх. Боломжтой бол морь малаа кыбле рүү эргүүлж зогсоон үйлднэ. Боломжгүй бол хөдлөх зүгт үйлднэ. Морь унаан дээрх махмил гэгдэх авдар үхэг мэт зүйлийн дотор үйлдэх ийм болно. Амьтныг зогсоож махмилийн доор багана хийвэл Серир өөрөөр хэлбэл ширээ буйдан мэт болж газарт үйлдэнэ гэсэн үг. Кыбле тийш босоогоор үйлдэх хэрэгтэй. Бууж чадах хүн фарзыг махмилд үйлдэж болохгүй.

Онгоц, завинд намааз үйлдэх гэгээн Жафер Таййар Хабешистан /Этиопи/руу явахад Расулүллах саллаллаахү алехи ве селлем түүнд заан сургасан шигээр ийм болно: Хөдөлж буй завь онгоцонд шалтаггүйгээр фарз ба важиб үйлднэ. Завь онгоцонд хүй бөлөг лүгээ хамт үйлдэж болно. Хөдөлж байх завь онгоцонд ч битүү дохиолон үйлдэх нь шашинд үл тохирох ба рүкү ба сежде хийнэ. Кыбле рүү чиглэх нь ч хэрэгтэй. Намаазыг эхлэхэд кыбле рүү хандан зогсно. Завь онгоц эргэхтэйн хамтаар өөрөө кыбле рүү хандна. Завь онгоцонд бохир буртагаас цэвэрлэх ч хэрэгтэй. Имам-и аазам Эбү Ханифегийн үзэхээр явах завь онгоцонд фарзууд ч шалтаггүй байхад газар сууж үйлдэх нь шашинд тохирох болно.

Тэнгис далайн дунд зогссон завь онгоц их ганхан хөдөлж байвал явж байгаа завь онгоц мэт бөлгөө. Эрэг дээр зогсох завь онгоцонд фарзыг сууж үйлдэж болохгүй. Эрэг рүү гарах боломжтой бол босч зогсоод үйлдэх нь үнэн зөв боломжгүйгээр газар шороо луу гарч үйлдэх хэрэгтэй. Эд хөрөнгө, амь нас эсхүл завь онгоцны хөдлөх аюул байвал завь онгоцонд зогсоогоор үйлдэх нь шашинд тохирох юм.

Ибни Абдин хэлэхдээ : /Хоёр дугуйтай байвя амьтан алд

холболгүйгээр газар цэх зогсож үл чадах тэрэг унаанд зогсоход ч явахад ч намааз үйлдэх, амьтан унаан дээр үйлдэх лүгээ адил. Дөрвөн дугуйтай тэрэг машин зогсож байхдаа ширээ мэт. Хөдлөхдөө мал амьтны тухайд дээр бичигдсэн шалтгууд ба дотор нь фарз үйлдэж болох ба тэрэг унааг зогсоож кыблегийн эсрэг талд үйлднэ. Зогсоохгүй бол явж одсон онгоцынх мэт үлднэ. /Хөдөлгөөний явцад кыбле рүү эргэж үл чадагч Шафий мезхебийг дуурияж хоёр намазыг хамтатгана. Үүнд ч боломж байхгүй бол кыбле тийш эргэх нь үл тооцогдно. Сандал буйданд суугаад битүү дохиолон намааз үйлдэх хэнд ч жайз буюу шашинд тохироогүй бөлгөө. Автобус, онгоцонд намааз үйлдэх нь тэрэг унаанд үйлдэх лүгээ адил.

Фарз ба важибүүдийг аялалд шаардлагагүй бол амьтан дээр үйлдэхгүй байх хэрэгтэй. Унаа уналгыг зогсоож кыбле тийш хандан зогсоогоор үйлдэх хэрэгтэй. Үүний тул унаа уналганд суулгүйгээр хэрэгтэй арга хэмжээг урьдаас хэрэгжүүлэх хэрэгтэй.

Зочин усан онгоц ба галт тэргэнд зайлшгүй намаазд кыблегийн тийш зогсох сежде газрын хажууд луужин тавих хэрэгтэй. Усан онгоц ба галт тэрэг эргэхэд өөрөө кыбле тийш эргэх хэрэгтэй. Цээжээ кыблегээс холдуулбал намааз нь буснина. Автобус, галт тэрэг, долгионт тэнгист кыбле тийш үл эргэгчдийн фарз намазууд шашинд тохирохгүй тул эдгээр нь замд байх явцад Шафий мезхебийг даган дуурияж үдийн икинди орой ба йас намаазыг хамтатгаж болно. Өөрөөр хэлбэл, аян замд байхад энэ хоёр намаазыг нэг нь нөгөөгийн хойноос үйлднэ. Яагаад гэвэл, Шафий мезхебд 80 километрээс хол үргэлжлэх аялалд икиндиг үдийн намаазын цагт йатсийг оройн намаазын үед авчирч үйлдэх эсхүл үдийнхийг икинди цагт орйнхыг йатси намазын цагт техбир уншиж хоёр намазыг нэг дор үйлдэх нь шашинд тохирох юм. Үүний тул Ханефи мезхебд хамаарах хүн замд кыбле тийш эргэж чадахгүй бол замд гарсны дараа өдөр нэг газар зогссон цагт үдийн цагт үдийнхийг үйлдэнгүүт шууд оройн намазыг ч үйлдэх хэрэгтэй. Шөнө зогсох цагт Шөнийн намазыг Шөнийн намазыг намазын цагт оройнхыг дараа нь нэг дор үйлдэх энэхүү дөрвөн намаазыг зорин хүсэхдээ (Шафий мезхебийг давтан дуурияж Дуа хийж байна) гэж зорин хүсч өөрөөр хэлбэл зүрх сэтгэлдээ болгоох хэрэгтэй. Замд гарахаас өмнө эсвэл аялал дууссаны дараа хоёр өөр цагийн намаазыг хамт үйлдэж болохгүй.

• ӨВЧТЭЙ ҮЕИЙН НАМААЗ •

Абдестийг бусниах зүйл биеэс гарах үргэлжлэх бол шалтаг Өзр гэнэ. Шээс дотоод үргэлжлэх, хий унгас алдах, хамраас цус гоожих, шархаас цус шар ус гарах, өвчин хавдсанаас болж нулимс урсах нэг намаазын цагийн дотор үргэлжид байх бол энэ хүн сарын тэмдгийн цус нь гарах эм шалтагтайд тооцогдоно. Бөглөж юм уу эмээр эсвэл намаазыг сууж нэг бол толгой дохиж эдгээрийг зогсоох хэрэгтэй. Шээс алдах эрэгтэй шээсний замдаа арвайн хэмжээний ургамлын хөвөн хийнэ. Хөвөн бөглөөс бага хэмжээний шээсийг шингээж гадагш дусахад саад болно. Ийнхүү абдест үл буснина. Хөнгөрөхөд хөвөн бөглөөс аяндаа гадагшилна. Шээс их алдаж буй бол илүүдэл нь хөвөн бөглөөсд шингэж гадагшлах ба абдест буснина.

Гусл абдест авангуут өвдсөнөөс эсхүл өвчин хүндэрснээс үргэлжлэн удахаас айгч хүн тееммүм хийнэ. Энэ айдас өөрийн туршлагаар эсхүл мусылмаан эмчийн хэлснээр мэдэгднэ. Муу үйл нүгэл үйлдсэнээрээ алдаршаагүй хэн нэгэн эмчийн үг ч хүлээн зөвшөөрөгднө. Хүйтэн болж хоргодох газар усыг халаах хоовон, хотод халуун усны газрын мөнгө олохгүй байх нь өвчний шалтгаан болж болно. Ханефид нэг тееммүмээр хүссэн хэмжээнд хүртэл намааз үйлдэж болно. Шафий маликид фарз намааз болгонд шинээр тееммүм хийнэ.

Абдест эрхтний хагас нь шархтай хүн тееммүм хийнэ. Шарх хагасаас бага бол бүрэн бүтэн газрыг нь угааж шархыг нь месх хийнэ. Гуслд бүх бие нэг эрхтэн хэмээн тооцогдох тул бүх биеийн хагас нь шархтай бол тееммүм хийнэ. Шархтай газар хагасаас бага бол бүрэн бүтэн газар угааж шархыг месх хийнэ. Шарханд месх муу нөлөөлвөл боолтоор месх хийнэ. Үүнд ч гэсэн хохирол үзүүлбэл месхийг орхино. Абдестд болоод гүслд хүний толгой тархинд месх хохирол үзүүлбэл толгойг месх үл хийнэ. Гар нь хатангишснаас /экзема/ ус хэрэглэж үл чадагч тееммүм хийнэ. Нүүр царай гараа газарт / шохой шороо чулуутай хананд/ шүргэнэ. Гар хөл нь огтлоостой хүний нүүр нь ч шархтай бол намаазыг абдестгүй үйлднэ. Абдест авхуулах хүн олоогүй хүн тееммүм хийнэ. Хүүхэд боол хөлсөлж буй хүнд тусламж хэрэгтэй. Бусдаас ч тусламж хүснэ. Гэхдээ тэдэнд тусламж шаардлагатай биш. Эхнэр

ба нөхөр ч бие биенээ абдест авахуулах албатай бус билээ.

Цус авахуулж хануур хорхой тавиулсан мөн шарх хатигтай яс нь хугарсан гэмтсэний улмаас боолт/хөвөн хийн даавуу дээр фластр / мерхем/ тавьсан хийгээд тэр хэсгээ халуун усаар угааж месх хийх боломж хүч хүрэхгүй бол абдест болон гүслд эдгээрийн хагасаас нь илүү дээр нэг хэсэг илж арчина. Боолтыг тайлах нь хохиролтой бол доорх бүрэн бүтэн газрыг угаахгүй. Боолтын хооронд үзэгдэх бүрэн бүтэн арьсны хэсгүүдийг илж арчина, месх хийнэ. Боолтыг абдесттэйгээр боох ороох хэрэггүй. Гараараа илж арчсаны дараа боолтыг өөрчлөвөл дээр нь дахиад боовол шинэ боолт дээгүүр месх шаардлагатай бус бөлгөө.

Босоо зогсож үл чадах эсвэл босоо зогсвол өвчин нь уртсана гэдгийг ихээр бодох өвчтөн намаазаа суугаад үйлдэж рюкюд биеэ бага зэрэг мэхийнэ. Дараа нь цэх босч дараа нь хоёр удаа сежде хийнэ.

Амархан байгаа мэт сууна. Өвдөг сөхрөх тойруулан ихтиба нууцлал хийх өөрөөр хэлбэл бөгсөөрөө сууж гараа өвдөгний эргэн тойронд цагариглах нь шашинд тохирох юм. Толгой, өвдөг, нүдний өвчин өвчинд тооцогдоно. Дайсандаа харагдахаас айх нь ч шалтаг юм. Босоогоор байхад мацаг абдест нь буснигч ч суугаад үйлднэ. Нэг зүйлд тулгуурлан зогсож чадах нь түшиж үйлднэ. Босоо зогсож удаан байж үл чадагч оршил текбирийг үйлдэж өвдөнгүүт сууж үргэлжлүүлнэ.

Газарт сежде хийхээс чадахгүй хүн босоо зогсоогоороо уншиж рюкю ба сеждегийн тулд сууж битүү дохиолно. Суугаад рүкүгийн тулд багахан сеждегийн тулд илүү ихээр мэхийнэ. Бие нь тонгойгоогүй хүн толгойгоо бөхийлгөнө. Нэг зүйл дээр сежде хийх хэрэггүй. Нэг зүйл дээр сежде хийвэл сеждегийн тулд рүкүгээс илүү их бөхийсөн бол намааз нь жинхэнээсээ болсон хэдий ч мекрүх юм. Түшиж суух боломжтой байхад хэвтэж толгой дохих нь шашинд үл тохирно. Манай Пеайгамбаар саллаллахү алехи ве селлем нэг өвчтөн дээр эргэн очив. Энэ өвчтөн гараа дэрээрээ өргөж дээр нь сежде хийхйг хараад дэрийг авав. Өвчтөн нэг хэрчсэн мод аваад дээр нь сежде хийхийг үзээд хэрчсэн модыг ч авав. (Чадал чинь хүрвэл газарт сежде хий. Газарт бөхийж чадахгүй бол дээр нь нэг зүйл гаргаж үүн дээрээ сежде бүү хий. Има хийж үйлд сеждед рүкүгээс илүү их тонгой) хэмээв. Бахр-үр-райкд өгүүлсэн шигээр Ал-и Имран сүрегийн зуун ерэн нэгдэх айет-и керимед утгачлавал

(Намаазыг чадал нь хүрэгч босоо зогсож үйлднэ Чадалгүй нь сууж үйлднэ. Үүнээс ч илүү чадал дорой нь хэвтэж үйлдэнэ) хэмээн айлдаж байна. Имран бин Хүсайн өвдөнгүүт Расулаллаах Саллаллахү алейхи ве селлем түүнд , (Босоогоороо үйлд. Чадал чинь хүрэхгүй бол сууж үйлд. Үүнд ч гэсэн хүч хүрэхгүй бол хажуугаараа эсвэл дээшээ харж хэвтээд үйлд) хэмээн айлджээ . Үүнээс үзэхэд босч, зогсож чадахгүй өвчтөн сууж үйлднэ. Сууж үл чадагч хэвтэж үйлднэ. Сандал буйданд үйлдэхийг зөвшөөрөөгүй юм. Өвчтөн автобус, нисэх онгоцонд явагчийн буйдан сандалд үйлдэх нь ислаамын шашинд үл тохирно. Хүй бөлөг рүү явахад босоогоор үйлдэж үл чадагч гэртээ босоогоороо үйлднэ.

Хорин зүйлээс нэг нь байх нь хүй бөлөг рүү явахгүй байхын шалтаг болно. Бороо, хүчтэй халуун хүйтэн, амь нас эд хөрөнгөнд нь довтлох дайснаас айх гэлмэх, найз нөхөд нь явж замд гагцаар үлдэхээс айх, тэнгэр ихэд харанхуй байх, ядуу өртэй хүн баривчлагдаж шорон гянданд орохоос айх, сохор байх, явж чадахааргүй саа тахир татуу байх, нэг хөл нь тайрагдсан байх, өвчтэй тахир татуу байх, шавар балчиг, алхаж чадахүй байх, алхаж үл чадах намстай ховор тохиох фыкх хуулийн хичээлийг алдах, дуртай хоолоо өнгөрөөх айдас хүйдэс, аяллын замд гарсан байх, оронд нь орхих хэн ч байхгүй өвчтөний сахиур, шөнийн хүчтэй салхи, угаалгын газар явахын тулд чихэлдэх, өвчин нь ихдэхээс сунжрахаас айх, өвчтөн ба өвчтөн нь асаргаагүй үлдэх сахиур, их өтөлснөөс алхах нь хүнд төвөгтэй байх зэрэг нь Баасан гарагийн намаазд очихгүй байх шалтаг юм. Хүй бүлэг рүү алхаад явах ирэх тэрэг унаанд сууж очихоос илүү эрхэм юм. Жамид сандал буйданд сууж толгой дохин үйлдэх шашинд тохирохгүй юм. Ислаамын шашин заагаагүй байдлаар ибадет хийх нь Бидат буюу буруу ёсон болно. Бидат үйлдэх нь их нүгэл болохыг хууль эрхийн номноо бичжээ.

Нэг зүйлд тулгуурлан сууж үл чадах өвчтөн дээш харж хэвтэн, дээш харж хэвтэж чадахгүй бол баруун хажуугаараа хэвтэж толгойгоороо дохино. Кыбле рүү эргэж үл чадагч амархан байх зүг рүү үйлднэ. Дээш харан хэвтэгчийн толгой доор нэг зүйл тавьж нүүрийг нь кыбле тийш харуулна. Өвдгийг боох нь сайн. Толгой дохиж үл чадагчийн намаазыг каза нөхвөрт үлдээх нь шашинд тохирох юм. Намаазын хооронд өвчтөн хүч нь хүрэх байдлаар

үргэлжлүүлнэ. Газарт сууж үйлдэгч өвчтөн намаазд бие сайдвал босч зогсоод үргэлжлүүлнэ. Оюун ухаанаа мэдэхгүй хүн намааз үйлдэхгүй. Таван удаагийн цаг хугацаа өнгөрөлгүйгээр илааршвал таван удаагийн намаазыг казаба нөхөж хийнэ. Зургаан намааз өнгөрвөл огт каза хийхгүй.

Битүү дохиолоод ч үл үйлдэх намаазыг хурдан каза хийх нь фарз юм. Каза хийлгүйгээр үхвэл үйлдээгүй намазыг искатд орхисон эд хөрөнгөнөөс фидйе/нөхвөр төлбөр/ өгөхийг гэрээслэх нь важиб юм. Гэрээслэхгүй бол асрамжлагч нь тэр бүү хэл харь хүн өөрийн эд хөрөнгөнөөс искат хийх нь шашинд тохирох болно хэмээжээ.

• КАЗА НАМААЗУУД •

Намааз нь биеэр үйлдэх ибадет болох тул өөр хүн оронд нь үйлдэж үл болно. Хүн бүүр өөрөө үйлдэх хэрэгтэй. Намаазыг цаг хугацаанд нь үйлдэхийг Эда гэнэ. Аливаад нэг цагт дахин үйлдэхийг Йаде гэнэ. Жишээ нь мекрүх болж үйлдэх намаазыг хугацаа өнгөрөөгүй байхад үүнд боломж гарахгүй бол үргэлж йаде нь важиб юм. Фарз ба важиб болох намаазыг хугацаа нь өнгөрсний хойно үйлдэхийг Каза хийх гэнэ.

Нэг өдрийн таван удаагийн гарцаагүй болоод витрийг үйлдэхэд каза болгохоор эмхлэх нь фарз юм. Таваас илүү казагүй хүнийг Тертибтэн гэнэ. Баасан гарагийн гарцаагүйг тэр өдрийн үдийн намаазын үед үйлдэх хэрэгтэй. Өглөөний намаазд сэрж үл чадагч хүтбе (шашны яриа) уншихад ч гэлээ санавал үүнийгээ тэр даруй каза болгох хэрэгтэй. Нэг намаазыг үйлдээгүй нөхцөлд дараагийн таван намаазыг үйлдэх жайз болохгүй. Хадис-и шерифт (Нэг намазыг унтаж өнгөөрөөж мартагч хүн дараагийн намаазыг хүй бүлэгтэй үйлдэхэд санавал, имаамаар намаазыг дуусгаж дараа нь урьдах намаазыг каза хийгтүн. Үүнээс хойш имаамын хамтаар үйлдсэнийгээ дахин үйлд) хэмээн айлджээ.

Фарзыг каза хийх фарз юм. Важибийг каза хийх нь важиб юм. Сүннетийг каза хийхийг захирамжлаагүй. Ханефи мезхебийн мэргэн багш нар үг дуу нэгтэйгээр заахдаа /Сүннет намаазыг зөвхөн цаг хугацаанд нь үйлдэхийг зарлигласан юм. Хугацаанд нь үйл үйлдэх сүннет намааз хүнд өр шир болон үлдэхгүй. Иймийн тул хугацаанаас нь хойш каза хийхийг захирамжлаагүй юм. Өглөөний сүннетийг

важибт ойрхон тул тэр өдөр үдээс өмнө фарзаар каза хийнэ. Өглөөний сүннетийн хувьд үдээс хойш харин бусад сүннетийг хэзээ ч каза хийхгүй. Каза болбол сүннетийн буян гарч ирэхгүй. Нафиле үйлдэх болно.

(Ибни Абидинд) (Тергиб-юс-салят) 165-2 дахь хуудсанд өгүүлэхдээ /Сүннетийг сууж үйлдэх нь шашинд тохирох бөгөөд огтоос үл үйлдэх нь нүгэл юм. Фарзыг шалтгаар сууж үйлдэх нь шашинд тохирох юм гэжээ.

Фарз намаазыг мэдээд шалтаггүйгээр орхих нь их нүгэл болно. Хугацаанд нь үл үйлдэх ийм намаазуудыг каза хийх /нөхвөрт үлдээх/ шаардлагатай. Фарз ба важиб болох намаазыг мэдсээр байж казад орхихын тулд хоёр шалтаг байна. Нэг нь дайсны хажууд байх, хоёрдох нь аян замд байх өөрөөр хэлбэл гурван өдөр аян замд явах зориг хүсэлтгүй ч гэлээ замд байх хэн нэгний хулгайчаас, махчин амьтнаас, үер шуурганаас айх явдал юм. Энэ нь сууж эсвэл ямар нэгэн тал руу эргэж эсвэл амьтан дээр толгой дохиж хийж чадаагүй үед казад үлдээж болно. Энэ хоёр шалтгаанаар фарзуудыг казад орхих унтах махртах шалтгаанаар алдах нь нүгэл болохгүй. Эшбах тайлбарт /живэх гэж байгаа хүн түүнтэй адил нөхцөлд орсон хүнийг аврахын тулд намаазыг хойно үйлдэх нь үнэн мөн юм хэмээж байна. Гэхдээ шалтаг дуусангуут тэр даруй каза үйлдэх нь гарцаагүй болно. Хараам болох гурван хугацаагаас гадна чөлөөт цагтаа үйлдэх болзол шартаар үр хүүхдийнхээ хүнс тэжээлийг олох хүртэл хойшлуулахыг зөвшөөрсөн байна. Илүү их хойшлуулбал нүгэлд орж эхэлнэ. Тэгээд ч Бидний Хайрт Пайгамбаар саллалллахү алехи ве селлем айлдахдаа Хендекийн байлдаанаас болоод үйлдэж чадаагүй дөрвөн намаазыг тэр даруйдаа тэр шөнө Эсхаб-и кирам радыйалахю анхюм шархтай маш их ядарсан байсан боловч хүй бөлөг лүгээ хамт үйлдэв. Бидний Хайрт Пайгамбаар саллалллахү алехи ве селлем айлдахдаа (Хоёр фарз намаазыг хамт авчрах их нүгэл юм). Өөрөөр хэлбэл, нэг намаазыг цагт нь үл үйлдэж хугацаанаас нь хойно үйлдэх нь хамгийн их нүгэл юм. Нэг хадис-и шерифт айлдахдаа (Нэг намазын цаг өнгөрсний дараа үйлдэх хэн нэгийг Аллаах наян хүкбе Тамд унгаана). Нэг хүкбе наян хойд ертөнцийн жил бөгөөд хойд ертөнцийн нэг өдөр энэ ертөнцийн мянган жилтэй адил юм.

Нэг намаазын хугацаа хугацаанаас нь хойно үйлдсэний шийтгэл энэ болох бол огтоос үл үйлдэхийн шийтгэлийг бодох хэрэгтэй.

Бидний Хайрт Пайгамбаар саллаллахү алехи ве селлем айлдахдаа (Намааз шашны тулгуур багана юм. Намааз үйлдэгч шашнаа зөвтгөх болно. Намаазыг үл үйлдэгч шашнаа сүйтгэх болно). Нэг хадис-и шерифт айлдахдаа “Шүүгдэх өдөр имааны дараа анхны асуулт нь намаазын тухай байх болно” гэв. Аллаах айлдахдаа (Ая боол минь Намаазынхаа хариултыг өгч чадвал чөлөөлөлт чинийх болно. Бусад тооцоог хөнгөлж өгнө) гэв. Анкебүт сүре дөчин тавдугаар аятд утгачилбал, (Өө сэвгүй үйлдэх нэг намааз хүнийг бохир муухай үйл үйлдэхээс хамгаална) хэмээн айлджээ. Бидний Хайрт Пайгамбаар саллалллахү алехи ве селлем (Хүний Аллаахдаа хамгийн ойр байх цаг нь намааз үйлдэх цаг юм).

Нэг мусылмаан хүн ямар нэг намаазыг хугацаанд нь үйлдэхгүй байх нь хоёр төрөл байна. 1 Шалтагаар үйлдэхгүй байх 2 Намазыг үүрэг гэж мэдэх чухалд тооцох атлаа залхууран орхих.

Фарз намаазыг шалтаггүйгээр хугацаа нь өнгөрсөн хойно үйлдэх өөрөөр хэлбэл казад орхих хараам их нүгэл юм. Энэ нүггэл каза хийнгүүт зөвхөн намаз үл үйлдэх нүгэл өршөөгднө. Хэн нэгэн намаазыг каза хийхгүй бол зөвхөн наманчлалаар өршөөгдөхгүй. Каза үйлдсэний дараа наманчлавал өршөөгдөхөд найдна. Наманчлахад үйлдээгүй намазыг каза хийх хэрэгтэй. Каза хийх чадал байсаар байтал каза нөхвөр хийхгүй бол мөн их нүгэл үйлдсэнд тооцогдно. Энэ их нүгэл намааз бүрийг үйлдэх хүртэл /6 минут/ хоосон цаг өнгөрөнгүүт урьдах нэг зовлонгийн хугацааны хэртэй нэмэгднэ. Яагаад гэвэл намаазыг чөлөөт цагт тэр даруй каза хийх нь гарцаагүй юм. Каза үйлдэхээр чухалд үл тооцох хүн эцэс төгсгөлгүй шатах болно. -(Үмдет үл ислам) (Жами-үл фетава) д хэлэхдээ, /Дайсантайгаа тулгарахад нэг фарз намаазыг үйлдэх боломжтой байхад орхих долоон зуун их нүгэл үйлдэх мэт нүгэл юм / Казаг хойшлуулахын нүгэл нь хугацаанд нь үл үйлдэх нүглээс илүү их юм. Нэг намаазын анхны казаг үйлдэхээр зорин хүсч нэг казаг үйлдвэл энэхүү нүгэл бүгдээрээ өршөөгднө.

Тайлбар Сүннетийн оронд каза намазыг хийж болох уу?

Гэгээн Абдулкадир-и Гейлани фүтүүх-үл гайб номондоо ийн өгүүлрүүн: Мүмин хүн хамгийн түрүүнд фарз хийх хэрэгтэй.

Түүний дараа нафилег хийнэ. Фарзын өр байхад сүннет үйлдэх нь тэнэглэл юм. Фарзын өртэй хүний сүннет хүлээн зөвшөөрөгдөхгүй. Али ибни Эби Талиб радиаллахү анх өгүүлэхдээ Расулаллаах саллаллахү алейхи ве селлем айлдруун: (Фарз өртэй хүн казагаа үйлдэлгүйгээр нафиле үйлдвэл дэмий хоосон зовсонд тооцогдно. Энэ хүн казагаа төлөхгүй бол Аллаах түүний нафиле намазуудыг нь хүүлэж авахгүй). Абдулкадир-и Гейланы бичсэн энэхүү хадис-и шерифийн тайлбаруудаас Ханефи мезхебийн мэргэдийн нэг гэгээн Абдүлхак-ы Дехлеви айлдаруун: Энэ мэдээ фарзын өртэй хүмүүсийн сүннет ба нафиле хүчингүй болохыг зааж байна. Сүннет нь фарзуудыг нөхдөг . Үүний утга нь фарзыг үйлдэж байхад үүний төгс боловсрохуйн шалтгаан болсон нэг зүйлийг алдвал сүннетүүд үйлдэгдсэн фарз төгс болохын шалтгаан болно. Фарзын өртэй хүний хүчин төгөлдөр бус сүннетүүд ч ашиггүй юм. Кудус кады /шүүгч/ Мүхаммед Садык Эрхэм абугай Файте намаазыг каза хийх талаар өгүүлэхдээ ийнхүү ярьж байна. Их мэргэн гэгээн ибни Нүжеймээс асуухдаа Хэн нэгний казад үлдсэн намаазыг ч болов өглөө, үд, орой, үдэш, шөнийн намаазуудын сүннетүүдийг энэхүү намазуудын каза нөхвөрт зорин хүсээд үйлдвэл энэ хүнийг сүннетээ орхисонд тооцох уу? Хариулсан нь: /Сүннетийг орхисон болохгүй. Яагаад гэвэл таван удаагийн намаазын сүннетүүдийг үйлдэх зорилго нь тэр цаг хугацааны дотор фарзаас өөр нэг намааз дахин үйлдэнэ гэсэн үг. Чөтгөр огтоос намааз үйлдүүлэхгүй байхыг хүсдэг. Фарзаас өөр нэг намаазыг дахин үйлдэж чөтгөрийг эсэргүүцэж түүнийг дийлнэ гэсэн үг. Сүннетийн оронд каза үйлдсэнээр сүннет ч хийгдэн. Каза өртэй болоочид намаазын цаг бүрт тэрхүү фарзаас өөр намааз үйлдэж сүннетийг биелүүлэхийн тулд каза үйлдэх хэрэгтэй. Яагаад гэвэл, олон хүн каза үйлдэлгүйгээр сүннетүүдийг үйлдэж байна. Эдгээр нь Диваажин луу явна. Гэтэл сүннетийн оронд каза үйлдэгчид Тамаас чөлөөлөгднө хэмээн айлдав.

Каза намаазыг хэрхэн үйлдэх вэ?

Каза намаазыг юуны түрүүнд үйлдэж түүнчлэн наманчлан их шийтгэлээс чөлөөлөгдөх хэрэгтэй. Үүний тул сүннетүүдийг ч гэсэн каза зорилгоор үйлдэх хэрэгтэй. Залхууран намаз үл

үйлдэгчид олон жилийн турш каза өртэй хүмүүс намаазыг эхлэх үед сүннетийг үйлдэхдээ тэрхүү цагийн анхны нөхвөрт үйлдсэн намаазаа каза хийгээгүйг зорин хүсч үйлдэх хэрэгтэй. Эдгээрийн сүннетүүдийг каза намаазын төлөө нийет хийж үйлдэх нь дөрвөн мезхебд ч гэсэн хэрэгтэй. Ханефи мезхебт намаазыг шалтаггүйгээр казад үлдээх нь хамгийн их нүгэл юм. Энэ маш их нүгэл намаазыг үйлдэх хүртэл хоосон цаг өнгөрөхөд нэг дахин нэмэгдэж байна. Яагаад гэвэл намаазыг чөлөөт цагтаа тэр даруй каза хийх нь зүй юм. Тооцоо хүндлэлд огт үл тохирох энэ аймшигт нүгэл зовлонгоос аврагдахын тулд үдийн намаазын анхны дөрвөн рекатыг үйлдэхэд анхны казад үлдсэн үдийн фарзыг ниййет хийж каза үйлдэх хэрэгтэй. Үдийн сүүлчийн сүннетийг үйлдэхэд анх казад үлдсэн өглөөний гарцаагүйг зорин хүсч каза үйлдэх хэрэгтэй. Оройн сүннетийг үйлдэхдээ гурван рекат оройн фарзыг зорин хүсч каза намаз үйлдэх хэрэгтэй. Ийнхүү өдөр бүр нэг өдрийн каза намаз төлөгднө.Теравих намаазыг үйлдэхдээ ч гэсэн каза зорин хүсч казаг үйлдэх хэрэгтэй. Хэдэн жилийн каза намаз байгаа бол үүнд төдий жил үргэлжлүүлэх хэрэгтэй. Каза дуусангуут дахиад сүннетүүдийг үйлдэж эхлэх хэрэгтэй. Хугацаа байгаа бол түүнчлэн боломж бүрт каза намааз үйлдэж тэрхэн даруйдаа каза төлөөсөө дуусгах хэрэгтэй. Үйлдээгүй каза намазын нүгэл өдөр өнгөрөх тутам нэг дахин нэмэгднэ.

Зургадугаар бүлэг

• НАМАЗ ЭС ҮЙЛДЭГЧИД •

Хазрет-и Эбү Бекр-и Сыддык радыйаллахү анх айлдруун: таван удаагийн намазын цаг болоход сахиусан тэнгэрүүд өгүүлрүүн: аяа Адаамын үр сад босогтун, хүмүүсийг шатаахын тулд бэлтгэгдсэн галыг намааз хийж унтраа гэнэ. Нэг хадис-и шерифт (Мүмин ба кафирийг ялгах ялгаа нь намааз юм) хэмээжээ. өөрөөр хэлбэл мүмин намааз үйлдн,э кафир намааз үйлдэхгүй. Мунафикчүүд заримдаа үйлдэж заримдаа үйлддэггүй. Мунафикчүүд Тамд ихэд зовлон шийтгэл амсна. Мүфессирчүүдийн шах Абдүллах ибни Аббас радыйаллахү анхүма хэлэхдээ Расүлуллахаас саллаллахү алейхи ве селлемаас ийн сонссон билээ:"Намааз үл үйлдэгчид шүүгдэх өдөр Аллаахыг ууртай байхыг харах болно" гэжээ.

Хадис имаанчууд үг хэл нэгтэйгээр мэдээлэхдээ Нэг намаазыг цаг тухайд нь хүсэн зорьж үл хийгчид өөрөөр хэлбэл намаазын цаг болж байхад намааз үйлдээгүйдээ сэтгэл үл энэлэгчид кафир болно гэв. Эсвэл үхэхдээ имаангүй явна. Харин намаазыг огт санаандаа оруулахгүй, намаазыг үүрэг гэж үл тооцогчид хэрхэх вэ? Эхл-и сүннетийн номч мэргэд үг нэгдэж ибадет имааны хэсэг биш гэжээ. Гэхдээ намаазд санал онол нийлсэнгүй. Фыкх имаануудаас Имам-и ибни Ханбел, Исхак ибни Рахевейх, Абдүллах ибни Мүбарек, Ибрахим Нехай Наким бин Утейбе, Эййуб Сахтийани, Давуд Тай, Эбу Бекр ибни Шейбе, Зүбейр бин Харб ба олон тооны томоохон эрдэмтэн мэргэд нэг намаазыг зорин хүсч өөрөөр хэлбэл мэдсээр байтал үл хийгчид кафир болно гэлцжээ. Тийм бол аяа шашны ахан дүүс минь нэг намаазыг бүү алдагтун! Сул бүү үйлдэгтүн! Үнэн сэтэглээсээ үйлд! Аллаах шүүгдэх өдөр эдгээр номч багш нарын дүгнэлтийн дагуу шийтгэл өгвөл хэрхэх вэ?

Ханбели мезхебт нэг намазыг шалтаггүй үл хтйгчид муртед мэт цаазлуулах шийтгэл авна. Угаахгүй цагаан өмсгөл өмсүүлэхгүйгээр намаз хийгдэхгүй. Мусылмаанчуудын ихсийн газар хөдөөлүүлэхгүй оршуулга тодорхой болгохгүй. Ууланд нүхэнд хийдэг.

Намааз үл хийгч хүн Шафии мезхебт мүртед болохгүй ч гэсэн шийтгэл нь цаазлуулах явдал юм. Намааз үл хийгчдэд Малики мезхебийн заалт дээрх лүгээ адил юм.

Намааз үл хийгч Ханеби мезхебд намаазыг эхлэх хүртэл шоронд хоригдох ба цус урстан жанчуулна. Таван зүйлийнг үл хийгчид таван зүйлийг алдна.

1. Эд хөрөнгөнийхөө өглөг зекатыг үл өгөгчид эд барааныхаа үр буяныг үзэхгүй.

2. Ушираа өгөөгүй хүний тариалан болоод орлогонд нь элбэг баялаг үлдэхгүй

3. Садака өглөг үл өгөгчийн эрүүл энх үлдэхгүй

4. Дуа залбирал үл хийгч хүссэндээ үл хүрнэ.

5. Намаазын цаг ирэх үед хийхийг үл хүсэгчид эцсийн амьсгалдаа Келиме-и шехадет авчирч чадахгүй.

Нэг хадис-и шерифт өгүүлэхдээ: (Намазыг шалтаггүй үл хийгч хүнд Аллаах арван таван бэрхшээл өгнө. Зургаа нь энэ дэлхийд, гурав нь үхэх цагт, гурав нь булшинд, гурав нь булшаас хөдлөх үед өгөгднө).

Дэлхийд байх зургаан зовлон:

1. Намаазыг үл хийгчийн амьдрал нь элбэг бийлэгжүү болохгүй

2. Нүүр царайнд нь Аллаахын хайрладаг хүний гоо сайхан халуун дулаан төрх үлдэхгүй

3. Ямар ч сайн үйлд нь буян ирэхгүй

4. Дуа залбирал нь хүлээн соёрхохгүй

5. Түүнийг хэн ч хайрлахгүй

6. Үүнд Мусылманчуудын сайн дуа залбирлын ашиг тус болохгүй

Нас нөгчихдөө амсах зовлон:

1. Муу муухайгаар амь өгнө.

2. Өлсөж үхнэ

3. Их ус уулаа ч цанган зовж үхнэ

Булшинд амсан эдлэх зовлон зүдгүүр:

1. Булш түүнийг шахан хавчина, яс нь нэг нь нөгөөдөө нэвтэрнэ.

2. Авс галаар дүүрнэ, өдөр шөнөгүй түүнийг шатаана

3. Аллаах авс руу нь том могой илгээнэ. Энэ ертөнцийн могойтой адилгүй ба өдөр болгон намаазын цагт түүнийг хатгана нэг мөч ч амсхийлгүй.

Шүүгдэх өдөр үүрэх зовлон:

1. Тамд очсон зовлонгийн тэнгэр нэр хажуунаас нь үл сална

2. Аллаахын хилэгнэлийг харах болно.

3. Тооцоо нь их хатуу болж Тамд хаягдна.

• НАМААЗ ҮЙЛДЭГЧИЙН АЧ БУЯН •

Намааз үйлдэхийн сайн буян, намааз хийгчдэд өгөх буянг мэдэгдэх хадис-и шериф олон байдаг. Абдүлхак бин Сейфүдддин (Эшиат- үл-лемеат) номонд намаазын чухлыг өгүүлсэн хадис-и шерифүүдэд айлдахдаа:

1. Эбү Хүрейрэ радыйаллахү анх хэлэхдээ, Ресуллүллах саллаллахү алейхи ве селлем зарлиг буулгахдаа: (Таван удаагийн намааз ба Жүма намаазыг дараагийн Жума өдөр хүртэл, Рамазаны мацагийг дараа жилийн Рамазан хүртэл хийх нүглийн баталгаа юм. Их нүгэл үйлдэхээс зугтаагчдын бага нүглийн өршөөгдөх шалтгаан болно).Заримдаа үйлдсэн бага нүглээс боол эрхгүйг нь үгүй хийнэ. Бага нүглүүдийг өршөөж дууссан их нүглийн тулд зовлон нь нимгэрэх шалтгаан болно. Их нүглийн өршөөгдөхийн тулд наманчлах хэрэгтэй. Их нүгэл үгүй бол зэрэг дэв дээшлэх шалтгаан болно. Энэхүү хадис-и шериф Мүслимд бичээстэй байдаг. Таван удаагийн намааз алдаа эндүүтэй бол Жума намаазууд түүнийг өршөөх шалтгаан болно. Жума намаазууд алдаатай бол Рамазан мацаг өршөөх шалтгаан болно.

2. Мөн л Эбү Хүрейрэ радыйаллахү анх хэлэхдээ Ресулуллах саллаллахү алейхи ве селлем айлдахдаа: (хаалганы өмнө ус урсах эл усандаа өдөр бүр таван удаа угаавал биед нь хир үлдэх үү?) Асхаб-и кырам хариу болгон үгүй огтоос хир буртаг үлдэхгүй Ресүллах минь гэв. (Намааз хийгчдийн бага нүглийг Аллаах үгүй хийнэ) хэмээжээ. Энэ хадис-и шериф Бухари ба Мүслимд бичээстэй буй.

3. Абдуллах ибни Месуд радыаллахү анх хэлэхдээ нэг хүн харь эмийг үнсжээ. Өөрөөр хэлбэл ансарын нэг нь хасарваань жимс зарж байв. Нэг эм хасарваань жимс авахаар ирэв. Эмийн төлөөх хуял тачаал хөдлөжээ. Гэрт жимсний илүү сайн нь буй. Нааш ир түүнээс өгөе гэжээ. Гэртээ ирэнгүүтээ эмэгтэйг тэвэрч үнсэв. Эмэгтэй Юу хийнэ вэ Аллаахаас ай гэв. Тэр алдаа хийснээ ойлгож машид гэмшив. Ресулуллахд ирж хийсэн нүглээ хэлэв. Ресулуллах саллаллахү алейхи ве селлем үүнд хариулсангүй. Аллаахаас вахий мэдээ хүлээв. Дараа нь энэ хүн намааз үйлдэв. Аллаах Нуд сүрегийн зуун арван тавдугаар аятыг илгээв. Энэ айет-и керимед утгачлавал, (Өдрийн хоёр талд мөн нар шингэнгүүт намааз үйлд. Сайн үйл муу үйлийг мэдээжээр үгүй хийнэ) хэмээн зарлиглав. Өдрийн хоёр тал гэдэг нь үдээс өмнө үдээс хойно гэсэн үг. Өөрөөр хэлбэл өглөө, үд, оройн намаз болно. Өдөртэй ойрхон шөнийн намааз ч гэсэн үдшийн болоод шөнийн намааз билээ. Энэ аяти керимед өдөр бүрийн таван удаагийн намааз нь нүгэл өршөөгдөх шалтгаан болдгийг өгүүлж байна.

Энэ хүн Ахад хэрэгтэй болох их нүгэл үйлдлээ. Аллаахын яа Ресүлүлаах энэ баярт мэдээ зөвхөн миний тулд уу? Эсхүл бүх үммэтийн тулд уу? гэв. (Бүх үмметэд) хэмээн айлдав. Энэхүү хадис-и шериф хоёр Сахихд /хадист/ бичээстэй буй.

4. Энэс бин Малик радыаллахү анх айлдахдаа хэн нэгэн Ресүлүлах саллааллахү алейхи ве селлемд ирээд Хад гэгч шийтгэл өгөгдөх нүгэл үйлдэв. Намайг хад шийтгэл оноо хэмээв. Ресүллүллах ямар нүгэл үйлдсэнийг нь энэ хүнээс асуусангүй Намаазын цаг болов. Хамт үйлдэв. Ресүллүллах саллаллахү алейхи ве селлем намаазаа дуусгангуут энэ хүн босоод Аяа Ресүлүлаах саллаллахү алейхи ве селлемд: - Би Хад гэгч шийтгэл оногдох нүгэл хийв. Аллахү теалягийн номноо зарлигласан шийтгэлийг надад оноо хэмээв. Чи бидэнтэй цуг намааз үйлдээгүй гэж үү хэмээн айлдав. (Тиймээ үйлдсэн!) гэв. (Битгий гунирх, Аллаах нүглийг чинь өршөөв) гэв. Энэ хадис-и шериф хоёр үндсэн номд бичээстэй. Энэ хүн хад шийтгэл хэрэгтэй болох их нүгэл үйлдсэнээ санасан юм. Намааз үйлдэнгүүт өршөөгдсөн нь үүнийг бага нүгэл болохыг харуулж байна. Эсвэл хад гэсэн нь бага нүглийн төлөөс болох Тазирын шийтгэл байв. Хоёрдох асуултанд Хад шийтгэл хий хэмээгээгүй нь ийм болохыг харуулж байна.

5. Абдүллах ибни Месүд радыйаллахү анх хэлэхдээ: Аллаахын хамгийн их ямар амелд дуртай болохыг Ресүлүлах саллаллахү теаля алейхи ве селлемээс асуув би. (Цаг хугацаанд нь үйлдэх намааз) хэмээн айлдав. Зарим хадис-и шерифүүдэд ч гэсэн. (Аллаах юуны өмнө хугацаандаа үйлдсэн намаазд ихэд дуртай) хэмээн зарлиг болсон байдаг. Үүний дараа юуг хамгийн ихээр дуртай вэ хэмээээн өгүүлэв би. (Ээж аавдаа сайн үйл хий) хэмээн зарлиг болов. Үүний хойно алиныг илүү дуртай вэ хэмээн асуулаа би. (Аллахын зам мөрд жихад хий) хэмээн айлдав. Энэ хадис-и шериф ч гэсэн хоёр Сахих /жинхэнэ/ номонд бичээстэй. Ондоо нэг хадис-и шерифт (Ажил үйлийн хамгийн сайн нь хооллох явдал) хэмээжээ. Өөр нэгэнд (Мэндийг дэлгэрүүлэх явдал) Өөр нэгт (Шөнө хүн болгон унтаж байхад намаз үйлдэх явдал юм) хэмээн өгүүлжээээ. Бас нэг хадис-и шерифт (Хамгийн дээд хүндэт үйлс бол гар хэлээрээ хэнийг үл гомдоохуй юм) Нэг хадис-и шерифт (Хамгийн дээд үйл бол жихад юм) гэж айлдсан бол нэг хадис-и шерифт (Хамгийн дээд үйл нь хажж-и межбүр юм) хэмээв. (Аллаахыг санж явах явдал бөгөөд Үргэлж байхуй нь үйл үйлдэл юм) хадис-и шерифүүд ч байдаг. Асуулт асуугч нарын нөхцөл байдалд тохируулан янз бүртйн хариулт өгөгдсөн бөлгөө. Эсвэл, цаг үедээ зохицох хариу өгөгдсөн. Жишээ нь: ислам шашны эхэн үед үйл үйлдлийн хамгийн хүндтэй бөгөөд үнэ цэнэтэй нь жихад байлаа. /Манай цаг үед үйл хийдлийн хамгийн үнэ хүндтэй нь ном хэвлэлээр кафир нар мезхебгүй хүмүүст хариу өгч Эхл-и сүннет итгэл бишрэлийг түгээх явдал мөн. Ийнхүү жихад хийгчдэд мөнгө эд хөрөнгө бие махбодоороо туслагчид эдгээрийн олж авсан буянд хамтрагч болно. Ает-и кериме болоод хадис-и шерифүүд намаз зекят, садакагаас илүү үнэ хүндтэй нь болохыг үзүүлж байна. Гэхдээ үхлийн байдалтай хүнд ямар нэгэн зүйл өгч үхлээс нь аврах нь намааз үйлдэхээс илүү үнэ цэнэтэй бөлгөө.

6. Жабир бин Абдуллах мэдээлэхдээ Ресүллүллах саллаллахү алехи ве селлем айлдаруун: (Хүн ба күфрийн хоорондын зааг намаазыг орхих явдал юм). Яагаад гэвэл намааз хүнийг күфрт аваачихаас хамгаалах хөшиг юм. Энэхүү хөшиг хоорондоос алга болох үед боол кафир тэрслүү рүү гулсан орно. Энэхүү хадис-и шериф намаазыг орхих нь маш муу болохыг үзүүлж байна. Асхаб-и кирмаас маш олон хүн намаазыг шалтаггүйгээр орхигч кафир болно хэмээв. Шафии ба Малики мезхебд кафир болохгүй ч гэлээ

алуулах нь важиб юм. Ханефи мезхебд намазыг үйлдэх хүртэл шоронд хоригдож зодуулна.

7. Үбаде бин Самит радыйаллахү анх өгүүлэхдээ Ресүллах саллаллахү алехи ве селлеим айлдаруун: (Аллаах таван удаагийн намааз үйлдэхийг зарлиглан тушаав. Хэн нэгэн сайхан абдест авч намаазыг хугацаанд нь үйлдвэл рүкүнүүд хүндлэлээ бүрэн гүйцэтгэвэл Аллаах түүнийг өршөөнө хэмээн амлажээ. Эдгээрийг үл хийгч хувьд амлаагүй бөлгөө). Үүнийг хүсвэл өршөөнө хүсвэл зовлон болгоно. Энэхүү хадис-и шерифийг Имам –и Ахмед Эбу Давид ба несай өгүүлсэн бөлгөө. Үүнээс үзвэл, намаазын шартуудад рүкү ба сеждег анхаарах хэрэгтэй. Аллаах үгээсээ буцахгүй. Үнэн зөв намааз үйлдэгчдийг заавал өршөөнө.

8. Эбу Емамае-и Бахили радыйаллаху анх өгүүлэхдээ Ресүллүллах саллаллахү алейхи ве селлем айлдруун: (Таван удаагийн намаазыг үйлдэгтүн. Нэг сардаа мацаг баригтун. Эд хөрөнгийнхөө зекятыг өгөгтүн. Дээр чинь байх ноёдод даган захирагдагтун. Раббынхаа Диваажинд очигтүн) үүнээс үзэхэд өдөр бүр таван удаа намааз үйлдэж Рамазан сард мацаг барьж эд хөрөнгөнийхөө зекятыг өгөгч Аллаахын энэ ертөнцийн халифе нь болох эзэн ноёдын исламын суртахуунд тохирох зарлиг тушаалыг даган мөрдөх мусылмаан хүн Диваажинд очих болно. Энэхүү хадис-и шерифийг имам-и Ахмед болон Тирмизи өгүүлсэн байдаг.

9. Асхаб-и кирамын алдартны нэг болох Бүрейде-и Эстеми радыйаллахү анх өгүүлэхдээ Ресүллах саллаллахү алейхи ве селлем айлдаруун:(Та нарын хоорондын амлалт нь намааз юм. Намаазыг орхин огоорогч кафир болно) Дээрхээс харахад намааз үйлдэгчийн мусылмаан болох нь ойлгомжтой байна. Намаазыг чухалд үзэн намаазыг анхны үүрэг хэмээн хүлээж аваагүйгээс үл мөргөн залбирагч кафир болно. Энэхүү хадис-и шерифийг имам-и Ахмед ба тирмүзи Несай ба Ибни Маже өгүүлсэн билээ.

10. Эбү Зер-и Гыфари радыйаллахү анха өгүүлэхдээ намрын өдрийн нэгэнд Ресүллах саллаллахү алехи ве селлем лүгээ хамт гадаа гарав. Навч унаж байв. Нэг модноос хоёр навч тасалж аваад энэхүү модны бүх навч унав. (Аяа Эбү Зер нэг мусылмаан Аллаахын зөвшөөрөхийн тулд намааз үйлдэнгүүт энэхүү модны навч унах лугаа адил нүгэл нь унан ховхорно) хэмээн айлдсан. Энэ хадис-и шерифийг Имам-и Ахмед мэдээлэв.

11. Зейд бин Халид Жүхеми мэдээлэхдээ Ресүллүллах саллаллахү алейхи ве селем өгүүлэхдээ: (Нэг мусылмаан үнэн зөвөөр хүндлэн хоёр рекат намааз үйлдвэл өнгөрсөн нүгэл өршөөгднө) хэмээв. Өөрөөр хэлбэл бага нүгэл бүгдээрээ өршөөгднө. Энэхүү хадис-и шерифийг Имам-и Ахмед рахиме-хүллахү теаля өгүүлэв.

12 Абдүллах бин Амр ибни Ас радыйаллахү теаля анхүма мэдээлэхдээ ресүллах саллаллахү алехи ве селлем айлдруун, (Хэн нэгэн намаазыг эда хийвэл нэг намаз шүүгдэх өдөр гэрэл бурхан болох ба Тамаас аврагдах шалтгаан болно. Намаазыг хамгаалахгүй бол гэрэл ба бурхан болохгүй, аврагдахгүй. Карүн ба Фиравүн Хаман Үбей бин Халефтэй хамт оршино). Дээрхээс харвал, хэн нэгэн намаазыг фарз, важиб, сүннет, эдебт зохицуулж үйлдвэл энэхүү намааз шүүгдэх өдөр гэрэл дунд оршихын шалтгаан болно. Ийнхүү намааз эс үйлдсээр байвал шүүгдэх өдөр дээр дурдсан кафир нартай хамт байх болно. Өөрөөр хэлбэл, Тамд хүчтэй зовлон туулна. Үбей бин Халеф Мекке кафир нарын хамгийн хатуу хэрцгий нь байв. Үхүд дайнд Ресүллүллах саллаллахү алейхи ве селлем ариун гараараа түүнийг там руу илгээсэн бөлгөө. Энэхүү хадис-и шериф имам-и ахмед ба Бейхеки ба Дарими өгүүлсэн бөлгөө.

13 Агуу их Табиин нэг Абдүллах бин Шакик рахиметүллахү теаля хэлэхдээ /Асхаб-и кырам радыйаллаху анхүм ибадетүүдийн дундаас зөвхөн намаазыг орхигчдын кафр болохыг хэлжээ. /Үүнийг Тирмизи өгүүлсэн. Абдүллах бин Шахик Өмерээс Али Осман болоод Айше радыйаллахү анхүмэийг хадис-и шериф өгүүлэн хүүрнэжээ. Нижретийн зуун наймдугаар онд наснаас нөгчив.

14 Эбү Дерда радыйаллахү анх хэлэхдээ, Миний ихэд хайрлаж явдаг нэгэн надад хэлэхдээ,“хэсэг хэсгээр таслуулж галд шатаагдлаа ч гэсэн Аллаахд юуг ч адилдтган бод! Фарз намаазуудыг бүү орхи! Фарз намаазуудыг мэдсээр байж орхигч мусылмаан шашнаас гарна. Архи дарс бүү уугтүн, дарс бүхий л муу нүглийн түлхүүр мөн” Үүнээс үзвэл, фарз намаазыг үл хайхран орхигч кафир болно. Залхууран алхайран орхигч кафир болохгүй ч гэлээ их нүгэл болно. Ислаам шашны заасан таван шалтгаас нэгийг нь алдах нь нүгэл биш юм. Дарс ба согтоох ундаа бүгд оюун ухааныг авч одно. Оюун ухаангүй хүн бүхий л өөдгүй мууг үйлдэж болно.

15. Али радыйаллаҳу анх мэдүүлэхдээ Ресүлуллах саллаллахү алейхи ве селлем айлдахдаа: (Аяа Али Гурван зүйлийг үйлдэхийг бүү хойшлуулагтун. Цаг нь болоход намаазыг тэр даруй үйлд. Оршуулгад бэлтгэгдвэл намазаа даруй үтэр үйлд. Нэг охины күфрийг олонгуут тэр дороо гэрлүүл хэмээв). Энэхүү хадис-и шерифийг Тирмизи рахиме-хүллахү теаля" өгүүлэв. Оршуулгын намаазыг хоцроохгүйн тулд мекрүх болох гурван цагт ч үйлдэх хэрэгтэй.

Энэ бүхнээс үзвэл охиныг кюүвфүнд өөрөөр хэлбэл тохирч тэнцэх хүнд нь өгөх хэрэгтэй, күфв гэдэг нь баян байх их цалин пүнлүүтэй байна гэсэн үг биш. Күфв болно гэдэг нь эрэгтэй хүн номын ёст мусылмаан байх, Эхл-и сүннет итикадд байх, намааз үйлдэх, архи уухгүй байх, өөрөөр хэлбэл ислаамын шашин суртахуунд тохирах нафака /амьдрах мөнгө/ олж чадах хэмжээнд ажил төрөлтэй байна гэсэн үг юм. Эрэгтэй хүний зөвхөн баян, байр оронтой болохыг хүсэгчид охиноо гай гамшигт аваачиж Тамд унагаах болно. Охин ч гэсэн намааз үйлдэх толгой гар нь задгай гадагшаа гарахгүй махрем бус ах дүүтэйгээ хүртэл ганцаар үлдэхгүй байх хэрэгтэй.

16. Абдүллах ибни Омар радыйаллахү анхүма мэдүүлэхдээ Ресүллах саллаллахү алейхи ве селлем өгүүлрүүн (Намаазаа цаг нь болоход тэр даруй үйлдэгчдийн Аллах баярлан талархана. Цаг хугацааных нь төгсгөлд үйлдэгчдийг ч өршөөн хэлтрүүлнэ). Энэхүү хадис-и шерифийг Тирмизи рахиме-хүллахү теаля өгүүлэв. Шафии ба Ханбелид намааз бүрийг цагаас нь өмнө үйлдэх нь үнэ хүндтэй юм. /Гэхдээ үдийн намазыг имамейний үгээс үзвэл, оройн намазын хугацаа эхлээхээс оройн ба шөнийн Имам-и аазамынхаар цаг нь эхлэнгүүт үйлдэх нь сайн бөгөд болгоомжилно. Нүглээс болгоомжилж дадсан хүмүүс үйл ажил бүртээ болгоомжилно./

17. Үмми-и Ферве радыйаллахү анха мэдүүлэхдээ Ресүллүллах саллаллахү алехи ве селлемд ямар үйл хэрэг үнэ хүндтэй болохыг нь асуув. (Үйл үйлдлийн үнэ хүндтэй нь цагаасаа өмнө үйлдсэн намаз юм) хэмээв. Энэхүү хадис-и шерифийг имам-и Ахмед Тирмүзи ба Эбү Давүд рахиме-хүмүллахү теаля мэдүүлэв. Намааз ибадетийн хамгийн орой дээд нь юм. Цаг хугацаа нь эхлэв үү үгүй юу үйлдвэл илүү гайхамшигтай болно.

18. Айше радыйаллахү анха хэлэхдээ Ресүллүллах салллахү теяла алейхи ве селлемийн намаазаа дараачийн цагт үйлдэхийг хоёр

удаа харсан хэмээв.

19. Үммү Хабибе радыйаллахү анха Ресүллүллах салллахү алейхи ве селлем айлдаруун, (нэг мусылман боол өдөр бүр фарз намазаас гадна арван хоёр рекат тетаввү болгон намааз үйлдвэл Аллаах түүнд Диваажинд нэг ордон бий болгоно). Энэхүү хадис-и шериф Муслимд бичээстэй буй. Үүнээс үзвэл, өдөр бүр таван удаагийн фарзаар үйлдэх сүннет намаазуудыг Ресүллүллах салллахү алейхи ве селлем тетаввү өөрөөр хэлбэл нафиле намаз хэмээж байнам.

20. Их Таби /Даган соёрхогч/ Абдүллах бин Шакик рахимехүллахү теаля айлдахдаа, Ресүллүллах салллахү алейхи ве селлемийн тетаввү намаазыг өөрөөр хэлбэл нафиле намаазыг гэгээн Айше радыйаллахү анхаас асуув /Үдийн фарзаас урьд дөрөв дараа нь үдшийн ба шөнийн фарзын дараа хоёр, өглөөний намазын фарзаас өмнө хоёр рекат үйлддэг байсан хэмээн өгүүлсэн. Энэ мэдээг Мүслим ба Эбү Давуд рахиме-рахимахүллахү теаля мэдүүлсэн болно.

21. Айше радыйаллахү анха өгүүлрүүн Ресүллүллах саллаллахү алейхи ве селлемын нафиле ибадетүүдээс хамгийн их үргэлжлүүлсэн нь өглөөний намаазын сүннет нь байв. Энэ мэдээ Бүхари д Мүслимд бичээстэй билээ. Айше радыйаллахү анха таван удаагийн намаазд үйлдэх сүннетийн намаазыг нафиле намааз гэнэ.

Исламын их мэргэн тэрслүү мезхэб нарын эсрэг Эхл-и сүннетийн хамгийн хүчтэй хамгаалагч Аллаахын сонгосон шашныг түгээн дэлгэрүүлж, шашны бус зүйлийг нураагч дайчин тэмцэгч /мүжахид/ Имам-и Раббани мүжеддид-и элф и сани Ахмед бин Абдул-эхад Фарүки Серхенди рахметүллахи алейх ислам шашинд хосгүй нандин Мектүбат номын анхны боть хорин есдүгээр бүлэгт айлдахдаа:

Аллахын зөвшөөрсөн үйл хэрэг нь фарз ба нафиле юм. Фарзуудын сацуу нафилегийн ямар үнэ цэнэ үгүй юм. Нэг фарзыг хугацаанд нь үйлдэх мянган жил тасралтгүйгээр нафиле ибадет хийхээс илүү үнэ хүндтэй юм. Бүх төрлийн нафиле жишээ нь намаз, зекят, мацаг, өмре хаж, зикр, фикр бүгд ийм билээ. Тэр бүү хэл нэг фарзыг хийхэд үүний сүннетүүдээс нэг сүннет эдебүүдээс нэг эдеб хийх нь ч гэсэн бусад нафилег хийхээс хэд дахин илүү үнэ цэнэтэй юм. Эмир-үл-мүмин Өмер-үл-Фарүк радыаллахү анх

нэг өдөр өглөөний намазыг хийлгэхдээ хүй бөлгийн дундаас нэг хүнийг олж хараагүй ба шалтгааныг нь асуухад тэрбээр шөнө болгон нафиле намаз үйлдэж байна. Магадгүй унтаад хүй бүлэгт ирж чадаагүй байх гэцгээв. Тэгэхэд тэрбээр /Бүхий л шөнө унтаад хүй бүлэгтэйгээ өглөөний намаазыг үйлдсэн бол илүү сайн байх байлаа/ гэж айлдав. Үүнээс үзвэл, нэг фарзыг хийхэд эдеб буюу зүй ёсоос нэгийг нь хийх нэг мекрүхаас зайлсхийх санаа бодлын хяналтаас хэд дахин илүү үнэ цэнэтэй юм. Тиймээ эдгээр нь тэрхүү эдебүүдийг хийсэн хийгээд мекрүхүүдээс зайлсхийсэнтэй хамт хийгдвэл мэдээжээр маш ач тустай болно. Гэтэл тэдгээргүй болонгуут юунд ч үр ачаа өгөхгүй. Үүнтэй адилаар нэг зоос зекят өгөх нь мянга мянган зоос садака өглөг өгөхөөс илүү дээр юм. Тэр нэг зоосыг өгөхдөө нэг эдебийг нь ажиглах жишээ нь ойр ах дүүдээ өгөх ч тэрхүү нафиле садакагаас хэд дахин илүү дээр юм. /шөнийн намаазыг үйлдэхийг хүсэгчдийн каза намаазыг үйлдэх нь хэрэгтэй болох нь үүнээс ойлгомжтой байнам. Аллаахын зарлиг тушаалыг фарз, хорио цээрийг нь хараам, Би Диний Пайгамбаарын тушаал зарлигийг Сүннет, хориг цээрлэлийг Мекрүх, эдгээрийг нийтэд нь (Ахкам-и исламиййе) гэнэ. Сайхан ёс суртахуунтай хүмүүст сайн үйл хийх нь фарз юм. Ахкам-и исламиййегийн нэг зааврыг үл таалагч (Кафир) (Мүртед) болно. Бүгдэд нь итгэгчийг Мусылмаан гэнэ. Алхайран залхуураад Ахкам-и исламиййед үл зохицох муылмааныг Фасик буюу нүгэлт хоёр нүүртэн хэмээнэ. Нэг фарз нэг хараамд үл зохицох нүгэлт хоёр нүүртэн Тамд явна. Фасикийн хийсэн бүх зүйл сүннетүүд нь хүлээн зөвшөөрөгдөхгүй буян үл оногдоно. Нэг лира зекят үл өгөгчийн сая сая доллар төлж хийсэн буяны үйл хишгийн аль нь ч зөвшөөрөгдөхгүй. Барьсан жами сургууль, эмнэлэг, буяны нийгэмлэгүүдийн хийсэн тусламжинд буян үл оногдно. Шөнийн намаазыг үл хийгчийн теравих намааз ч үл хүлээн зөвшөөрөгднө. Фарз болоод важибуудаас гадна хийх ибадетийг Нафиле гэнэ. Сүннетүүд нь нафиле ибадет юм. Энэхүү тодорхойлолтоор каза намаазыг үйлдэгч сүннетийг ч үйлдсэн болно. Нэг фарзыг үйлдэх нэг хараамаас зайлсхийхийн буян нь сая сая нафиле буянаас илүү их юм. Нэг фарзыг үл хийгч нэг хараам хийгч Тамд шатна. Нафиле ибадетүүд түүнийг Тамаас аврахгүй. Ибадетэд хийгдэх өөрчлөлтийг /Бидат/ гэнэ. Ибадет үйлдэхэд хожмын заншлаар /бидат/ үйлдэх нь хараам бөгөөд ибадет

бусних шалтгаан болно. /245 дугаар хуудсыг үзнэ үү/ Хадис-и шерифт (Хожмын заншлаар Бидат үйлдэгчийн ямар ч ибадет үл зөвшөөрөгдөнө) гэж айлджээ. Фасикын жишээ нь эхнэр, охин нь алчуур хэрэглэдэггүй хүний бидаттай хүний жишээ нь ибадетд өсгөгч хэрэглэгч хүний хойд талд намааз үйлдэхгүй байх хэрэгтэй сургаал болоод шашны талаарх хиймэл үг сургаалыг сонсохгүй байх хэрэгтэй, номыг нь уншихгүй байх хэрэгтэй. Нөхөр дайсан аль ч болов инээмсэглэсэн царай, амттай үг хэл үзүүлэх хэрэгтэй хэнтэй ч марган тэмцэхгүй байх хэрэгтэй. Хадис-и шерифт (Тэнэг хүнд хариу хэлж хэрэггүй) хэмээн айлдав. Ибадетүүд зүрх сэтгэлийн цэвэр ариун байдлыг нэмнэ. Нүгэл зүрх сэтгэлийг харлуулж номын ашиг авч үл чадах болно. Мусылмаан хүн бүрийн имаанын болзлууд фарз ба хараамуудыг сурах хэрэгтэй. Мэдэхгүй байх нь шалтаг биш юм. Өөрөөр хэлбэл мэдэх хэрнээ итгэхгүй байх мэт/ (Мектүбат) иран хэл дээрх ном юм. Орчуулга нь энд гүйцэв. Гэгээн Имам-и Раббани 1034 /Манай эриний 1624/ онд Энэтхэгт Шерхенд хотод наснаас нөгчив.

• НАМААЗЫН ҮНЭН ЧАНАР •

Ислаамын их эрдэмтэн Абвүллах-и дехлеви рахметүллахи алейх (Мекатиб-и шерифе) номын захиандаа айлдахдаа: Намаазыг хүй бүлэгтэй цуг үйлдэх мөн Түманынетээр үйлдэх, рүкүгийн дараа бөөгнөх (кавме) хоёр сеждегийн хооронд суух (желсе)-ыг бидэнд Аллаахын Пайгамбаар өгүүлсэн билээ. Кавме ба суухыг фарз болохыг өгүүлэх эрдэмтэд байдаг. Ханефи мезхебийн мүфти нараас Кадыхан энэ хоёрын важиб болохыг энэ хоёроос нэгийг нь мартангуут Сежде-и сехв хийх важиб буюу зайлшгүй болохыг мэдсээр байж үл хийгчийн намаазыг дахин үйлдэхийг заажээ. Мүеккед сүннет болохыг өгүүлэгчид важибт ойр сүннет гэсэн байна. Сүннетийг хөнгөлөн үзэж чухалд үл тооцох нь күфр бөлгөө. Намаазын кыйамд рүкү кавме желсе сеждед мөн суусан цагт өөр өөр шинж чанар нөхцөл байдлууд гарч ирнэ. Бүхий л ибадетүүд намаазын дотор хурна. Кураан-и керимийг унших, тесбих /сүбханаллах гэж хэлэх /өөрөөр хэлбэл сүбханаллаах гэх/ Ресүллүллахд салеват хэлэх, нүгэлд өршөөл эрэх хэрэгцээгээ зөвхөн Аллаахаас хүсч Түүнд дуга хийх нь намаазын дотор

хураагдан цугларсан бөлгөө. Мод, өвс намаазд зогсох мэт босоо байна. Амьтад рүкү байдлаар амьгүй зүйлс ч гэлээ намаазд Каде /намаазын суулт/-д суух мэт газар таран байрласан байнам. Намааз үйлдэгч эл ибадетийг бүгдийг нь хийж байна. Намааз үйлдэх өргөмжлөл гайхамшигт /мираж/ шөнө фарз болсон. Тэр шөнө гайхамшиг үйлдэхээр хувь ногдсон Аллаахын хайрт Пайгамбаарт зохицохын дагахыг бодон намааз үйлдэх нэгэн мусылман хүн Тэр Дээд Пайгамбаар мэт Аллаахт ойртсон сууринд өргөмжлөгднө. Аллаах ба Түүний Элчийн эсрэг найрсаг ёсорхуу байж тайван амгалан намааз үйлдэгчид энэхүү зэрэглэлд өргөмжлөгдсөнөө ойлгоно. Аллаах ба Түүний хайрт Элч энэхүү сүсэгтэн олонд өршөөн нигүүлсэн их буян оршсон бөгөөд намааз үйлдэхийг фарз болгосон байна. Үүний тулд Бидний Эзэн Тэнгэрт талархан баярлаг. Түүний хайрт элч салеват ба техыййат болон дуга үйлдсэн. Намаз үйлдэхдээ гарч ирэх баясгалантай амгалан тайван гайхагдахаар зүйл бөлгөө. Бидний багш Мазхер-и Жан-и Жанан айлдахдаа Намаз үйлдэхэд Аллаахыг үзэх харах боломжгүй ч гэсэн үзэх мэт болно. Энэ нөхцөл байдал гарч ирэхийг тасаввүфын /мистикчид/ дээд мэргэд үг дуу нэгтэй мэдүүлсэн байдаг. Ислаамын шашны эхэн үед намаазыг Күдүсийн эсрэг үйлддэг байв. Бейт-үл-мүкаддесийн эсрэг үйлдэхийг орхиж Ибрахим алейхиссаламын кыбла рүү хандахыг тушаах цагт Медине дэх жүүд нар уурлан бухимджээ. /Бейт-үл–мүкаддесийн эсрэг үйлдсэн намааз хэрхэн вэ?/ гэцгээв. Бекара сүре 143 айет-и кериме ирж (Аллаах та нарын имааныг соёрхон таалахгүй) хэмээн утгачлан айлдав. Намааз хариугүй үлдэхгүй хэмээн мэдүүлсэн бөлгөө. Намааз имаан үгээр өгүүлэгдсэн. Үүнээс үзэхэд намаазыг сүннетэд тохируулан үйлдэхгүй байх нь имааныг алдна гэсэн үг болно. Бидний эрхэм элч (Миниий нүдний гэрэл гэгээ амт нь намаазд байдаг) хэмээв. Энэхүү хадис-и шариф Аллаах намаазд гарч ирээд гэрч болдог. Ингэхлээр нүдэнд минь амгалан тайван бий болдог гэсэн үг билээ. Нэг хадис-и шарифт (Аяа Билал радыйаллаху анх Намайг тайвшруул) хэмээн зарлиг болсон ба энэ нь Аяа Билал Эзэн уншиж намаазын икаметийг хэлж намайг амраа гэсэн үг болно. Намаазаас өөр зүйлд тайвшралаа хайх хүн зөвшөөрөгдөхгүй юм. Намаазыг гээн алдагч бусад шашны үйлийг ч илүү ихээр хаяж орхино.

• НАМААЗ ДАХЬ ДЭЭД ЧАНАР •

Имиам-и Раббани рахметүллахи алех Мектүбат номын нэгдүгээр боть хоёр зуун жаран нэгдүгээр бүлэгт айлдахдаа:

Намааз нь Ислаамын таван шартаас хоёрдох нь гэдгийг зайлшгүй мэдэх ёстой. Бүхий л гибадетүүдийг өөртөө агуулсан байдаг. Ислаамын тавны нэг хэсэг нь ч гэлээ энэхүү хураах цогцлох чанараасаа болоод дан ганцаараа мусылмааны ёсон хэмэээх болсон бөлгөө. Хүнийг Аллаахын буянд аваачих явдал хийдлийн анхдагч нь болсон бөлгөө. Ертөнцийн Эзэн ба Элчүүдийн хамгийн оройн дээд бологчийн өргөмжлөлийн шөнө Дивааажинд оногдох хишиг буян дэлхийд буусны дараа энэ дэлхийн нөхцөл байдалд зохирон өөрт нь гагцхүү намаазд үр нөлөө хайрласан билээ. Иймээс Намааз мүмин нарын өргөмжлөл гайхамшиг /мираж/ юм хэмээн зарлиг болсон билээ. Нэг хадис-и шарифт Хүний Аллаах-д хамгийн ойр байх үе нь намаазын үе юм хэмээн зарлигласан байна. түүний замд яг ул мөрөөр нь замнагч дээдэст, үзэхүйн төрөөс ирэх энэ ертөнцийн их хувь хишиг зөвхөн намаазд оршдог. Тиймээ энэ ертөнцөд Аллаахыг үзэх боломжгүй бөгөөд энэ дэлхий үүнд тохиромжгүй юм. Гэхдээ түүнийг дагасан дээдэст намааз үйлдэхэд зарим зүйл үзэхүй / рует/ заяагдна. Намааз үйлдэхийг зарлигдаагүй байсан бол зорилго чиглэлийн гоо царайны хөшгийг хэн татна гэж? Хайрлан дурлагч хайртанаа хэрхэн олох байсан гэж? Намааз гомдон гунихарсан сүнс санаанд амт оруулагч юм. Намааз өвчтөнг амирлуулагч юм. Сүнсний тэжээл бол намаз юм. Зүрх сэтгэлийн анагаал эм нь намаз юм. Аяа Билал намайг тайвшруул гэж эзэн уншихыг зарлигдах хадис-и шариф үүнийг зааснаараа Намааз миний зүрхний баясал хөөр нүдний цөцгий юм гэх хадис-и шариф энэхүү хүслийг үзүүлж байна. Таашаал тэнгэрийн хайрт умбан мансуурах онгод /вежд/ мэдлэг, ухаан, албан тушаал, гэрэл, зүрх сэтгэл дэхь өнгө будаг, хэмжээ, ойлгогдох эс ойлгогдох, харагдах шинж тэмдэгтэй тэмдэггүй оршихуйн аль нь намаазын гадна үүсэн бий болбол мөн намаазын үнэн чанараас ямар нэг зүйл ухагдахгүй бол энэхүү эл буй нар бүгд сүүдэр тусгал хэлбэрээс үүссэн байнам. Магадгүй хоосон бодол /вехм/ мөрөөдлөөс өөр юу ч биш. Намаазын үнэн чанарыг үл ухагч насанд хүрсэн хүн намаазд зогсонгуут энэ ертөнцөөс тасарч нөгөө ертөнцийн амьдралд

орох ба нөгөө ертөнцөд

байх хишиг буянтай золгох ба өөр хооронд нь тусгал мөрөөдөл хутгалдалгүйгээр уугуул шинжээс нь таашаал хувь хүртнэ. Яагаад гэвэл энэ ертөнцийн бүхий л төгс төгөлдөр хувь хишиг сүүдэр ба үзэгдлээс тогтно. Сүүдэр ба үзэгдэл холилдолгүйгээр шууд уугуул мөнөөс үүсэн гарч ирэхүй нөгөө ертөнцөд л хамаатай. Энэ ертөнцөд уугуул мөнөөс хүртэхийн тулд өргөмжлөл миграж хэрэгтэй. Энэхүү өргөмжлөл нь мүмин хүний намааз болно. Энэхүү хувь хишиг зөвхөн энээ сүсэгтэн олонд л хамаатай. Пайгамбаараа даган баяссаны ачаар үүн лүгээ золгоно. Учир нь Эдний Пайгамбаар саллаллаху алехи уа саллам Өргөмжлөлийн шөнө энэ ертөнцөөс ангижирч нөгөө ертөнц рүү ажирсан. Диваажин руу орж рүетийн аз жаргал хувь хишигээр соёрхогдсон. Аяа Эзэн Тэнгэр минь. Чи Агуу их Пайгамбаар “саллаллаху алейхи уа селлем”ийг бидний зүгээс Түүний агуу ихэд зохирсон сайн үйл буяныг соёрх. Бүхий л Пайгамбаар “ала небиййана уе алехимуссалевату веттеслимат” нарын буян хишгийг өгөгтүн. Тэд нар чамайг таньж таалалд чинь хүрэхээр зүтгэж чиний дуртай замыг заасан бөлгөө.

Тасаввүфийн замд оршигч олон хүн өөрсдөд нь намаазын үнэн чанарыг мэдээгүй, намаазын төгс төгөлдөр шинжийг таниагүй учраас зовлонгийнхоо илаарлыг өөр зүйлээс хайсан ба зорилгодоо хүрэхийн тулд ондоо зүйлд өөрсдийгөө зориулсан билээ. Тэр бүү хэл эдний зарим нь намаазыг энэ замаас ангид зорилго үйлстэй нь холбоогүй гэж бодсон. Мацагыг намаазаас илүүд үзсэн. Намаазын үнэн мөнийг үл ухсан олон хүн зовлонгоос гэтэлгэх сүнс санаагаа амирлуулахыг гуурсан бишгүүр /сима/ дуу аялгуу өөрөөр хэлбэл хөгжим онгод /вежд/ мансуурахад эрж хайж байв. Зорилго нь хайрлагдсан хөгжмийн хөшиг халхавчийн цаана байгаа гэж бодсон. Иймээс бүжиг хатираанд өөрсдийгөө зориулсан атал Аллаах эрүүлжих үр нөлөөг бүтээгээгүй гэх хадис-и шарифийг сонссон байв. Тиймээ усанд живэх гэж байгаа анхлан сэлэгч гартаа тааралдсан өвс бүрээс зуурна. Аливаа нэгэнд дурлах нь дурласан хүнийг дүлий сохор болгодог. Эдгээрт хэрэв намаазын төгс төгөлдөр шинжээс өчүүхэн ч байтугай амталж мэдсэн бол гуурсан бишгүүр хийгээд ая дуу аманд ч үл багтаж онгодлохуй санаанд нь орохооргүй байсан бөлгөө.

Аяа дүү минь Намааз ба хөгжмийн хооронд хэдий хэр хол зай байна намаазд гарч ирэх болох ялж төгс нөгчихүй ба хөгжмөөс гарч

ирэх нөлөө ч гэсэн нэг нь нөгөөгөөсөө тэр хэрээр хол юм. Оюун ухаантай хүн энэ хэрийн бэлгэ бошгоос олон зүйл ойлгоно.

Ибадетүүдээс таашаал авах намааз үйлдэх нь төвөггүй санагдах нь Аллаахын хамгийн том хишиг буяны нэг бөлгөө. Ялангуяа намаазын амтыг мэдрэх хувь, төгс төгөлдрийг үл мэдэгчдэд оногдохгүй. Ялангуяа фарз намаазын амтыг зөвхөн тэд л мэдэрнэ. Яагаад гэвэл төгс төгөлдөрд ойртогч нарт нафиле намаазын амтыг мэдүүлнэ. Эцэст нь зөвхөн намаазын амт л мэдэгднэ. Нафиле намаазууд амт шимтгүй болж фарзуудын үйлдэх нь их ашиг орлого гэж тооцогдоно.

/Нафиле намаз фарз ба важибээс гаднах намааз гэсэн үг. Таван удаагийн намаазын сүннетүүд бусад важиб үл болох намаазууд бүгдээрээ нафиле юм. Меккед болох үл болох бүх сүннетүүд нафиле буюу сул юм/.

Бүхий л намаазаас ялгаран гарч ирэх амт шимээс хүсэл ташаалд хувь үгүй юм. Хүн энэхүү амтыг мэдрэхэд хүсэл ташаал нь уйлагнан хашгирна. Аяа Эзэн Тэнгэр минь Энэ ямар том цол хэргэм буй. Бид мэт сүнс санаа нь өвчтэй хүмүүсийн энэхүү үгийг сонсох нь их хувь хишиг, жинхэнэ аз жаргал мөн.

Энэ дэлхийд намаазын цол зэрэг нөгөө ертөнцөд Аллаах үзэхийн өргөмжлөл мэт гэдгийг сайтар мэдэгтүн та бүхэн. Энэ дэлхийд хүний Аллаахтай хамгийн ойр байх цаг хугацаа нь намааз үйлдэх цаг юм. Нөгөө ертөнцөд хамгийн ойр болдог нь ч хишиг хувь, өөрөөр хэлбэл Аллаахыг харах цаг мөч болно. Энэ дэлхий дэх бүхий л гибадетүүд хүнийг хүн болгож чадах нөхцөл байдалд авчрахын төлөө билээ. Ибадетийн уг зорилго бол намааз үйлдэх явдал юм. Мөнхийн аз жаргал төгсгөлгүй буян хишигтэй золгохуйг зөвхөн намааз үйлдсэнээр олж авна.

Намааз бүхий л ибадетүүд болон мацагаас ч илүү үнэ хүндтэй бөлгөө. Намааз нь гомдсон сэтгэлийг таашаалаар дүүргэнэ. Намааз нүглийг үгүй хийнэ. Хүмүүсийг муу муухайгаас хамгаална. Хадис-и шерифт Намааз миний зүрхний баяр баяслын эх сурвалж билээ. хэмээн өгүүлжээ. Намааз гоморхогч сүнс санаанд амт шим оруулна . Намааз сүнс санааны хүнс билээ. Намааз зүрх сэтгэлийн эмчилгээ болно. Намааз зарим мөчид ойлгон мэдрэгчийн хэл. Муса алейхисселамд хэлсэн хүн мод мэт болох нь бий.

Гэгээн Имам-и Раббани Мектүбат номын 1 боть 266 дахь бүлэгт өгүүлрүүн

Итгэл сүсэг болоод бишрэн шүтэхүйг цэгцэлсний дараа фыкх ахкамыг /өөрөөр хэлбэл манай шашны зарлиглан хорьсон зүйлийг мэдээжээр сурах хэрэгтэй. Фарз, важиб, халаал ба хараамуудыг, сүннет ба мекрүхүүдийг болон эргэлзээтэй зүйлийг шаардлагатай хүртэл нь сурах энэхүү мэдлэгээрээ үйлдэл хийх хэрэгтэй. Фыкх номуудыг сурах мусылмаан бүрт хэрэгтэй. Тэднийг мэдэхгүйгээр мусылман болохгүй/ Аллаахын тушаалыг хийх, Түүний таалах мэтээр амьдрахаар зүтгэх хэрэгтэй. Түүний хамгийн их таалдаг тушаан захирамжилсан зүйл нь өдөр бүр таван удаа намааз үйлдэх явдал. Намааз шашны тулгур багана юм. Намаазын чухал болох хэрхэн үйлдэхийг өгүүлнэ. Ихэд анхааран сонсогтун та бүхэн. Эхлээд сүннет /өөрөөр хэлбэл хууль эрхийн номуудад бичигдсэн бүрэн зохицон абдест авах хэрэгтэй. Абдест авахдаа биеийн угаавал зохих хэсгийг гурван удаа тухай бүртээ тал бүрийг бүрнээр нь угаахад их анхаарах хэрэгтэй. Ийнхүү сүннетэд тохирсон абдест авах болно. Толгойд месих хийхдээ толгойны бүх талыг хамтруулан зүлгэх хэрэгтэй. Чих шилэн хүзүүг сайтар илж арчих хэрэгтэй. Хөлийн хурууг халаал болгоход /өөрөөр хэлбэл хөлийн хурууны завсрыг цэвэрлэхэд/зүүн гарын жижиг хурууг хөлний хурууны доод хэсгээс хооронд нь хийнэ гэж заасан бөлгөө. Үүнийг чухалчилж мустехаб хэмээн өнгөрөхгүй байх хэрэгтэй. Мустехабыг хөнгөлөн үзэх хэрэггүй. Эдгээр нь Аллаахын дуртай таалдаг зүйл юм. Хэрвээ бүх ертөнцийг өгснөөр дуртай ажлаа хийж болохыг мэдвэл энэ дэлхийг өгч тэр ажлыг хийж чадвал ихэд ашиг тус олох ба хэд хэдэн сагс хэсгийг өгч үнэ цэнэтэй нэг алмаазыг олж авах мэт болно. Эсхүл хэд хэдэн чулууны хэлтэрхий өгч нас нөгчсөн нэг хайрт хүний сүнсийг эгүүлэн авчирч амьдруулах мэт юм.

Намааз мүмин нарын өргөмжлөл юм. Өөрөөр хэлбэл өргөмжлөлийн шөнө Манай Пайгамбаар саллаллаху алейхи ве селлемд илэрсэн хишиг буяныг энэ ертөнцөд Түүний сүслэн дагагч нарт зөвхөн намааз л амтлуулан мэдрүүлнэ. Эрчүүд фарз намаазыг хүй бүлэгэй хамт үйлдэхэд ихэд анхаарах хэрэгтэй. Тэр бүү хэл нэгдэх такбирийг имаамтай хамт авах хэрэгтэй. /Эмэгтэйчүүдийн

хүй бүлэг болоод намааз үйлдэхийн тулд хафиз сонсох эсхүл мевлид /Мухаммедын төрсөн тухай яруу найраг/ сонсохын тулд жамид эрчүүдийн хооронд хутгалдах, ялангуяа буян хураахын тулд Баасан гарагийн намааз руу ирэх нь нүгэл бөлгөө.

Намаазыг цагт нь үйлдэх нь /цагтаа үйлдэж буйгаа мэдэх/ шарт юм. /Ганцаар байхдаа намааз бүрийг эхлээд цаг хугацаанд нь үйлдэх хэрэгтэй. Оройн болоод шөнийн намаазыг Имаам-и агзамын хэлснээр бол хамаарч үйлдэх хэрэгтэй. Намааз хэдий хугцаанаас нь оройтож үйлдэнэ төдий чинээ буян нь хорогдно. Мустехаб болох цагт хүй бүлэгтэй хамт үйлдэхийн тулд месжид рүү явахын тулд юм. Намаазыг үйлдэлгүйгээр цаг нь гарвал хүн алсан мэт их нүгэл болно. Каза хийснээр энэхүү нүгэл өршөөгдөхгүй. Зөвхөн өр зээл төлөгднө. Энэ нүглийг өршөөн хэлтрүүлэхийн тулд төгс наминчлал /тевбе-и насүх/ хийх эсвэл хажж-и мебрүр хийх хэрэгтэй. (Ибн-и Абидин)

Намаазд Кураан-и керимийг сүннет болох хэмжээгээр унших хэрэгтэй. Рүкү ба сеждед хөдөлгөөнгүй зогсох магадгүй хэрэгтэй. Учир нь фарз эсвэл уажиб юм. Рүкүгээс босонгуут биеийн яс хэвийн байрандаа орохоор цэх шулуун зогсох хэрэгтэй. Үүний дараа нэг хэсэг энэ байдлаар зогсох нь фарз эсвэл уажиб эсвэл сүннет гэсэн байна. Хоёр сеждегийн хооронд суух ч ийм юм. Үүнийг магадгүй ихэд анхаарах хэрэгтэй. Рүкү ба сеждед тесбих унших нь хамгийн багадаа гурван удаа байна. Ихэнх нь долоо эсхүл арван нэг байна. Имаамын хувьд хүй бүлгийн байдлаас хамаарна. Хүч чадалтай хүн зовлон зүдгүүргүй цагт ганцаар үйлдэхэд тесбихүүдийг хамгийн бага хэмжээгээр унших нь ямар ичгүүртэй байдал вэ? Ядахдаа гурван удаа хэлэх хэрэгтэй. Сеждед хэвтэхэд газарт илүү ойр байх эрхтэнг түрүүлж тавих ёстой. Тэгвэл, эхлээд хоёр өвдөг дараа нь хоёр гар дараа нь хамар магнайг талвина. Хоёр өвдөг гарын баруун талынхыг нь эхэлж тавина. Сеждегээс босоход дээр байх эрхтэн эхлээд өргөгднө. Тиймээс эхлээд магнайг өргөх хэрэгтэй. Босоо зогсож байхдаа сеждегийн оронд рүкүд байхад хөл сеждед хамрын үзүүр суухад хоёр гар эсвэл өвөр лүү харна. Энэхүү бидний хэлсэн газар луу харж нүд эргэн тойрон руу хальтрахгүй бол намааз хүй бүлэгтэй үйлдэгдэж болно. Өөрөөр хэлбэл, зүрхээрээ энэ дэлхийгээс чөлөөлөгдөж болно. Хүндлэл гарч ирнэ. Тиймээс ч Пайгамбаар саллалллаху алейхи уе

селлем ийнхүү айлдсан билээ. Гарын хурууг рүкүд сарвайлгах сеждед нийлүүлэх нь сүннет юм. Эдгээрийг анхаарах хэрэгтэй. Хуруу нь саланги эсвэл нийлээстэй байлгах нь шалтгаангүй юм уу хий хоосон зүйл биш. Ислаам шашны эзэн /өөрөөр хэлбэл Бидний Пайгамбаар саллалллаху алейхи уе селлем/ ач тусыг нь болгоож ийн хийсэн билээ. Бидний хувьд ислаамын ёсны эзэнд нь зохицох, тэнцэх их ач тус үгүй бөлгөө. Алейхиссалеуату уесселам. Энэ хэлсэн бүхэн хууль эрхийн номуудад заасан зүйлийг хийх урамшуулал дэмжээс зоригжуулан бадраахуй юм. Аллаах бидэнд болоод та бүхэнд ислам шашны үзүүлсэн номын ёсын үйлсийг хийх хувь ногддог. Пайгамбаруудын угсаа эзэн хамгийн сайн хамгийн орой дээд хүндэллийн тулд “алейхи уе алейхим уе ала али күллин минессалеуати ефдалуха уе минеттеслимати екмелуха” энэ дугаг минь зөвшөөрөн соёрх, Амин.

Имам-и Раббани рахметүллахи алейх Мектүбат номын мөн хоёрдугаар боть жаран есдүгээр бүлэгт айлдаруун:

Аллаах талархаг. Түүний сонгосон таалсан боол нарт тайван амгалан байг. Таны захиа ирлээ. Найз нөхөд чинь зөв замаас ангижраагүй нь ойлгомжтой болж ихэд баярлуулав. Аллаах зөв үйл зөв замдаа буйг тань нэмэг. Найз нөхөдтэйгээ хамт өгсөн үүргийг хийсээр байна бид нар. Таван удаагийн намаазыг тавь жаран хүний хүй бүлэгтэй хамт үйлдэж байна. Бид гэж хэлнэ, та нар Иймийн тулд Аллахтай хамт байх нь бие махбод эрхтэн нь ч ахкам-и шерийег хийхээр чимэглэх юутай том буян хишиг вэ. Энэ цагт хүмүүсийн дийлэнх нь намаазыг үйлдэхдээ аядуу хандаж байна. Түманинет / өөрөөр хэлбэл эрхтэн хөдлөхгүй байх/ ба зөв мөргөх уг үндсийг / тадыл эркан/ /нэг өдөр сүбханаллах гэж хэлэх хүртэл хөдөлгөөнгүй зогсох/ чухалд үл тооцож байна. Иймийн тулд миний хайрт та бүхэнд энэ цэгийг өгүүлэх зайлшгүй байлаа. Сайтар сонсогтун, Бидний Пайгамбаар саллаллаху алехи уе селлем. Хамгийн том хулгайч бол өөрийнхөө намаазыг хулгайлагч юм хэмээв. Аяа Ресүллах Хэн нэгэн өөрийнхөө намаазыг хэрхэн хулуун хумслана гэж хэмээн асууцгаав. Энэ удаа айлдахдаа Рүкү ба сеждед бэлхүүсээ газар байрлуулж бага зэрэг үл зогсох хүний намаазыг Аллаах хүлээж авахгүй хэмээв. Бидний Пайгамбаар саллаллаху алехи

уе селлем хэн нэгнийг намааз үйлдэх үед рүкү ба сеждег бүрэн гүйцэд хийж буй эсэхийг үзээд Чи намаазаа ийнхүү үйлддэг тул Мүхаммед алейхиссилату уесламын шашнаас өөр шашинд хамаатайгаар үхэхээс аюулгүй байна уу хэмээв. Мөн айлдахдаа Та нараас хэн нэгэн намаазыг үйлдэхдээ рүкүгийн дараа бүрнээр нь үйлдэж цэх цэгцээр зогсохгүй бол босоогоор эрхтэн бүрийг газартаа байхгүй бол намааз нь бүрэн гүйцэд болохгүй. Энэ удаа айлдахдаа, Хоёр сеждегийн хооронд цэх суухгүй бол намаз тань бүрэн гүйцэд болохгүй хэмээв. Нэг өдөр бидний Пайгамбаар саллаллаху алехи уе селлем нэг хүн намаз үйлдэж байхад намаазын хууль дүрэм ба уг үндэст зохицоогүйг рүкүгээс босоход өндийж зогсож босоогүйг хоёр сеждегийн хооронд суухгүй байгааг хараад айлдахдаа, Хэрвээ намаазаа ийнхүү үйлдэж үхвэл шүүгдэх өдөр чамайг миний сүслэн дагагчдынх гэж хэлэхгүй. Өөр нэг газар айлдахдаа Ийм байдлаар үхвэл Чи Мүхаммед алейхисселамын шашинд хамаатайгаар үхэхгүй болно хэмээв. Эбү Хурейре радыйаллаху анх айлдахдаа, Жаран жил бүхий л намаазаа үйлдэж нэг ч намааз нь үл хүлээн зөвшөөрөгдөх хүн рүкү ба сеждегээ бүрэн гүйцэд хийгээгүй хүн юм хэмээв. Зейд ибни Вехб рахметүллах алейх нэг хүн намааз үйлдэхдээ рүкү сеждегээ бүрэн гүйцэд хийхгүй байгааг харав. Хажуудаа дуудаад хэдий хэр хугацаанд ийнхүү намааз үйлдэж байна хэмээн асуухад дөчин жил гэхэд чи дөчин жил намааз үйлдээгүй юм байна. Үхвэл Мүхаммед Ресуллаллах саллаллаху алейхи уе селлемийн сүннет өөрөр хэлбэл шашинд нь үхэхгүй чи хэмээв.

Таберани рахметаллахи Эвсатдаа өгүүлэхдээ, нэг мүсүлман намазаа сайхан үйлдэж рүкү ба сежденүүдээ бүрэн гүйцэд үйлдвэл намааз баярлан хөхиж гэрэл гэгээтэй болно. Сахиусан тэнгэрүүд нар тэрхүү намаазыг тэнгэрт хүргэн соёрхоно. Тэрхүү намазыг үйлдэгчид сайн дуга хийж чи намайг алдаа дутагдалтай болохоос авран хамгаалдгийн адил Аллаах ч гэсэн чамайг хамгаалаг гэнэ. Намаазыг сайхан үйлдэхгүй бол харлана. Сахиусан тэнгэрүүд тэр намаазаас жигшинэ. Тэнгэр огторгуйд хүргэж өгөхгүй. Тэрхүү намааз үйлдэгчид муу Дүга хийнэ. Чи намайг алдаж муу муухай байдалд оруулсан шигээр Аллаах ч гэсэн чамайг алдаг хэмээв. Тэгэхээр намаазаа бүрэн гүйцэд үйлдэхээр зүтгэх хэрэгтэй. Тадил-и эрканыг хийж рүкү сежде Кавмег / өөрөөр хэлбэл, рүкүгээс босч

зогсохыг / мөн Желсег / өөрөөр хэлбэл, хоёр сеждегийн хооронд суухыг/ сайтар үйлдэх хэрэгтэй. Бусдын алдаа дутууг харангуутаа хэлэх хэрэгтэй. Шашны ахан дүүсэд намазыг бүрэн гүйцэл үйлдэхээр туслах хэрэгтэй. Түманинет /өөрөөр хэлбэл эрхтэн хөдлөхгүй байх/ ба тадыл эрканы /нэг өдөр сүбханаллах гэж хэлэх хүртэл хөдөлгөөнгүй зогсох/ хийх шалгтаан болох хэрэгтэй. Ихэнх мусылман үүнийг хийх баяр баясгалангаас хагацаж байна. Энэхүү буян алга болсон байна. Энэ үйл үйлдлийг дахин гаргаж ирэх нь маш чухал юм. Бидний Пайгамбаар саллаллаху алехи уе селлем айлдахдаа Миний мартагдсан сүннетийг илрүүлэн сэргээгчид зуун шехидийн буян оногдоно хэмээв.

Хүй бүлэгтэй хамтаар намазыг үйлдэхэд эгнээг шулуун эмхтэй хийхэд ч анхаарах хэрэгтэй. Эгнээний хойно урд зогсох ёсгүй. Хүн бүр нэг эгнээнд зогсохыг хичээх хэрэгтэй. Бидний Пайгамбаар саллаллаху алехи уе селлем эхлээд эгнээг цэгцлээд дараа нь намаазд зогсдог байв. Эгнээг цэгцлэх нь намаазыг үйлдэхийн нэг хэсэг хэмээн айлддаг байв. Аяа Эзэн Тэнгэр минь бидэнд эцэс төгсгөлгүй намаазын цаг хугацаа хайрлан соёрх Бид бүгдийг зөв замаас бүү салга

Нэг мусымаан хүн Энэ дэлхийд гэгээн хойд насанд сайд болохыг хүсвэл өөрт нь доорх гурван ааш аяг байг:

Бүтээгдэгч нараас юуг ч үл хүлээх Мусылман нар /ба зимми / исламын нутагт гэрээгээр суух кафир/ кафир нарыг үхсэн ч гэсэн/ гүтгэхгүй байх. Бусдын эрх хамаарах зүйлийг авахгүй байх.

• НАМААЗЫН ЭСРАР БУЮУ НУУЦЛАГУУД •

Имам-и Раббани күддисе сиррүх Мектүбат номынхоо нэгдүгэр боть гурван зуун дөрөвдүгээр бүлэгт айлдахдаа:

Аллаах талархаж Бидний Пайгамбаар саллаллаху алехи уе селлемд салауат уншсаны дараа мөнхийн аз жаргалтай золгохоор дүга хийнэ би. Аллаах олон тооны аят-и керимэд Аллаахын хүсэн таалах үйл үйлдлийг хүсэх мүминүүдийн Диваажинд орохыг өгүүлж байна. Энэхүү Аллаахын хүсэн таалах үйл үйлдлүүд юу вэ бүхий л сайн үйл үү? эсвэл зарим нь уу? Хэрэв сайн үйл бүгдээр бол эдгээрийг хэн ч хийж үл чадна. Зарим нь бол ямар сайн үйлс хүсч байна вэ? Эцэстээ Аллаах лүтф хийж ийнхүү өгүүлсэн ба

Аллахын хүсэн таалах үйл үйлдэлд Ислаамын таван рүкү тулгуур юм. Исламмын энэхүү таван үндсийг хэн нэгэн эрхээрээ өө сэвгүй хийвэл Тамаас аврагдах гэдэгт ихэд найддаг. Яагаад гэвэл энэ нь угтаа номын ёст үйлс бөгөөд хүнийг нүгэл, өөдгүй муухай зүйл хийхээс хамгаалан сэргийлнэ. Эцэстээ Куран-и керимд Анкебүт/ Аалз/ сүре нь дөчин тав дахь аятд утгачилвал, Өө сэвгүй хийсэн нэг намааз хүнийг муухай бохир зүйлийг үйлдэхээс хамгаална хэмээн зарлигдаж байна. Нэг хүнд Ислаамын таван шарт болзлыг биелүүлэх хувь оногдвол буян хишгийг талархсан болно. Яагаад гэвэл өөрөө Ниса /Эмс/ сүре зуун дөчин зургаа дахь аятэд утгачилвал Имаан хийж талархвал зовлонд унагахгүй хэмээн зарлиглаж байна. Тэгвэл Ислаамын таван болзлыг биелүүлэхийн тулд амин зүрхнээсээ зүтгэх хэрэгтэй.

Энэхүү таван болзлоос хамгийн чухал нь намааз бөгөөд шашны тулгуур багана бөлгөө. Намаазын зүй ёсоос нэгийг нь ч болов алдалгүйгээр үйлдэхээр чармайх хэрэгтэй. Намаазыг бүрэн гүйцэд үйлдэж чадсан бол Ислаамын үндсэн язгуур томоохон суурь тавигдсан болно. Тамаас аврах бат бэх оосроос зуурч авах болно. Аллаах бид бүгдэд зөв намааз үйлдэх хувь оноог Намаазд зогсохдоо Аллааху акбаар гэх нь Аллаах ямар ч бүтээгдэгчийн гибадет хэрэгцээгүй болохыг бүх талаас юугаар ч үл дутагдахыг хүмүүсийн намааз түүнд ашиггүй болохыг зааж байна. Намаазын доторх текбирүүд нь Аллаахын эсрэг зохих ибадет хийхээр тохирох хүч чадал бидэнд байхгүйг үзүүлнэ. Рүкү дэхь тесбихүүдэд ч гэсэн энэ утга байх тул рүкүгийн дараа текбирийг тушаан захирамжлаагүй бөлгөө. Гэтэл сежде тесбихүүдийн дараа гэж тушаасан. Яагаад гэвэл сежде нь даруу дорой байдлын хамгийн туйл адгийн явдал ба өчүүхэн дорой байхын хамтийн дээд зэрэг тул үүнийг хийнгүүт зүй ёсоороо бүрэн гүйцэт ибадет хийсэнд тооцогдно. Энэхүү үзэл бодлоос сэргийлэхийн тулд сеждед хэвтэж босоход текбир унших нь сүннет болохын зэрэгцээ сежде тесбихүүдийг хэлэхийг зарлиг болгосон билээ. Намааз мүминий өргөмжлөл болох тул намаазын төгсгөлд бидний Пайгамбаар саллаллаху алехи уе селлем өргөмжлөлийн шөнө хэлж таалан болгоосон үгсийг өөрөөр хэлбэл Эттехиййатүг уншихыг тушаасан болно. Тэгвэл намааз үйлдэгч хэн нэгэн намааз-өргөмжлөлийг үйлдэх байдлаар Аллаахад төгс ойр байхуйг

намазаас эрж хайх хэрэгтэй.

Бидний Пейгамбер саллаллаху алейхи уесселам айлдахдаа Хүний Эзэн Тэнгэртээ хамгийн ойр байх цаг мөч нь намааз үйлдэх цаг юм хэмээв. Намааз үйлдэх хэн нэгэн Эзэн Тэнгэртэйгээ ярьж Түүнд залбиран гуйж Түүний агуу ихийг Түүнээс бусад нь юу ч биш болохыг харах явдал мөн. Иймийн тулд намаазд айдас гэлмэх гарч ирэх тул тайтгаран амгалан болохын тулд намаазын төгсгөлд хоёр удаа мэндчлэхийг тушаасан байна.

Бидний Пайгамбаар саллаллаху алейхи уе селлем нэг хадис-и шерифт Фарз намаазын дараа 33 тесбих, 33 тахмид, 33 текбир, нэг техлил хийхийг зарлиглан тушаасан байна. Үүний шалтгаан нь намаазын алдаа дутуу тесбихээр халхлагдана. Түүнд бүрэн тохирох ибадет хийгдээгүйг өгүүлнэ. Тахмидийн хувьд намааз хийх хувь тохиосон нь Түүний тусламж болохыг ойлгоод энэхүү том буян хишигт баярлан талархна. Текбирийг хийж Түүнээс өөр ибадетэд тохирох хэн ч үгүй болохыг өгүүлнэ.

Намаазыг шарт болзол зүй ёстойгоо тохируулан үйлдвэл алдаа дутагдал ч гэсэн хучигдан халхлагдан намаазыг хайрлан соёрхохдоо ч талархан ибадет хийх өөр хэний ч эрх үгүйг зүрх сэтгэлээсээ цэвэр тунгалгаар келиме-и тевхидийн гэрчлэлд өгүүлэхэд энэхүү намааз хүлээн зөвшөөрөгдөх болно. Энэ хүн намааз үйлдэгч аврагдагчийн нэгэн болно. Аяа Эзэн Тэнгэр минь! Пйгамбаар нарын хамгийн оройн дээд хүндлэлийн “алейхи уе ала алихимүссалеуатү уеттеслимат” төлөө биднийг намааз үйлдэгч мөн аврагдагч аз жаргалтай боолын нэг болгон соёрх Амин!

Гэгээн Имам-и Мүхаммед Масүм Мектүбатынхаа хоёрдугаар боть арван нэгдүгээр захиандаа айлдахдаа:

Аллаах хүмүүсийг эзэнгүй хий орхиогүй. Хүссэн бүхнээ хийхийг зөвшөөрөөгүй. Тачаан гэгээрэхийн хүсэл ба мэдээжээр амьтанлаг таашаал хэтрэн гажиж захирагдахыг ийнхүү гай гамшигт туугдахыг хүсээгүй. Тайван амгалан амьдарч эцэс төгсгөлгүй аз жаргалд золгохын тулд хүсэл таашаалаа хэрэглэх замыг нь заасан ба энэ болоод нөгөө ертөнцийн аз жаргалын шалтгаан болох ач тустай зүйлсийг хийхийг тушаасан Хор хөнөөлтэй зүйлийг хийхийг хорьсон бөлгөө. Энэхүү тушаал хоригийг Ахкам-и исламиййе гэсэн. Энэ дэлхийд тайван амгалан

амьдарч аз жаргалтай золгохыг хүссэн хүн ислаамын шашинд зохицох нь зайлшгүй үүрэг билээ. Тачаан эгээрэх ба уугуул чанарын ислаамын ёсонд үл тохирох хүсэл тачаалаа орхих хэрэгтэй. Ислаамын ёсонд үл таарвал эзэн ба бүтээгчийн уур хилэн барьж авах болно. Ислаамын ёсонд зохирох боол мусылмаан байлаа ч кафир ч бай энэ дэлхийд аз жаргалтай тайван амгалан болно. Эзэн нь түүнд туслана. Энэ дэлхий тариалангийн талбай юм. Талбайд тариа тарилгүйгээр үр ургацыг нь идэж таашаан жаргах хүн ургацаа алдах төдийгүй энэ дэлхийн амьдралыг түр зуурын таашаал цэнгэл шунал хүслээ хэтрүүлэн гуйвуулан хийж өнгөрөөгч ч гэсэн мөнхийн хишиг хувиас хүртэх хязгааргүй таашаалыг алдна. Энэ нөхцөл байдал оюун ухаантай хүний хүлцэн зөвшөөрөх зүйл бус бөлгөө. Төгсгөлгүй амт шимтийг алдаж гээхийн шалтгаан болох зуурдын хор урхагтайгаар хийхийг илүүд үзэхгүй. /Аллаах энэ дэлхийн таашаалаас зуурдын амт шимтээс хүсэл хуялд амт шимттэй санагдах зүйлээс нэгийг нь ч хориглон цээрлээгүй бөлгөө. Эдгээрийг ислаамын шашинд зохицох хор хохиролгүйгээр хэрэглэхийг зөвшөөрсөн/ Ислаамын ёсыг шууд дагахад юуны өмнө /Эхл-и сүннет/ ийн мэргэдийн Асхаб-и кырамаас сурч Куран-и керим ба хадис-и шерифүүдээс ойлгож өгүүлсэн Акайд зохицон имаан хийх, дараа нь хараам хорио болсон зүйлийг мэдэж сурч эдгээрээс зайлсхийж сэргийлэхээр зарлигласан зүйлийг сурч хийх хэрэгтэй. Эдгээрийг үйлдэхийг /Ибадет/ хийх гэнэ. Хараамаас сэргийлэн зайлсхийхийг /Таква/ гэнэ.

Ниййет хийж ахкам-и ислаамийед зохицохыг ибадет үйлдэх гэнэ. Аллаах зарлиг тушаал ба хорио цээрийг Ахкам-и ислаамиййе мөн Ахкам-и илахиййе гэнэ. Тушаасныг фарз, хорьсоныг нь хараам гэнэ. Хамгийн дээд үнэт ибадет ислаам шашны үндэс нь өдөр бүр таван удаа намааз үйлдэх явдал юм. Намааз үйлдэж босоогоор кыблегийн эсрэг Фатиха унших, кыблегийн эсрэг мэхийх, кыблегийн эсрэг толгойгоо газар талбих гэсэн үг. Эдгээрийг кыблегийн эсрэг талд хийхгүй бол намааз үйлдсэнд тооцогдохгүй /Намаазыг үйлдэгч мусылмаан юм. Намаазыг үл үйлдэгч нэг бол мусылмаан, нэг бол кафир юм. Намаазыг үйлдэхээр гарч ирэх курб-и илахи /өөрөөр хэлбэл, Аллаахыг хайрлах/ өөр ибадетүүдийг хийхэд ховор хувь хишиг болно.

Өдөр бүр

таван удаагийн намаазыг хүй бүлэг лүгээ хамт /өөрөөр хэлбэл, энэ ертөнцийн ажил хэргийг бодолгүйгээр /хүй бүлэгтэй үйл хөдөлгөөнөө засахтай цуг анхааралтай абдест аваад мүстехаб болох цаг үед үйлдэх хэрэгтэй. Намаазыг үйлдэхэд Аллаах ба боолын хоорондох хөшиг нээгднэ. Таван удаагийн намаазыг үйлдэгч өдөр бүр таван удаа биеэ угааж цэвэрлэх хүн мэт нүглээс цэвэрлэгднэ. Өдөр бүр таван удаагийн намаазыг зөв зүйтэй үйлдэгчид зуун шехидийн буян ногдоно.

Арилжааны эд зүйлс хөдөө бэлчигч амьтдын /тариалангийн талбайгаас модноос гарган авсан ургац цаасан лира авлагын/ зекятуудыг тушаал зарлиг болсон газарт дуртайяа өгөх хэрэгтэй. Зекет өгсөн эд хөрөнгө хорогдохгүй. Зекетыг нь өгөөгүй эд хөрөнгө Тамд гал болно. Аллаах их нигүүлсэн хэрэгцээнээс илүү эд хөрөнгө өглөг өгөх боломжийн хэмжээтэй байвал нэг жилийн дараа зекетийг нь өгөх ёстойг зарлигласан Амь нас ба эд хөрөнгийг өгөгч нь тэр юм. Эд хөрөнгөө бүгдийг амь насаа өгөх ёстойг тушаасан бол түүнд хайртай хүмүүс шууд өгөх байв.

Рамазан-и Шериф сард Аллаах тушаан зарлигласан тул дуртайгаар мацаг барих хэрэгтэй. Энэхүү өлсөж цангахуйг аз жаргал гэж бодох хэрэгтэй.

Ислаамын барилга тав байна. Нэг дэх нь /Эшхедү эн-ла-илахе-иллаллах ве эшхеджу енне Мүхамеден абдүхү уе Ресүлүхү /гэх үүний утгыг мэдэж итгэх. Үүнийг Келиме-и шехадет гэнэ. Үлдсэн дөрөв нь намааз, зекет, мацаг ба хаж юм. Энэхүү таван үндэсээс нэг нь гэмтвэл ислаам шашин ч гэмтнэ. Итгэл бишрэлийг цэгцлэн эмхэлж ислаамын шашинд зохицсоны дараа Софиййе-и алиййегийн /Дээд ид шидийн/ замаар урагшлах хэрэгтэй. Аллаахын цэцэн мэдлэг энэ замд гарч ирэх ба шунал тачаалын хүслээс аврагдах тавилан оногдов. Эзнээ үл таних хүн хэрхэн амьдарч чадаж хэрхэн тайван амгалан байх вэ? Энэ замд цэцэн мэргэн болохын тулд /фена бил-марүф/ хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Аллаахаас өөр бүгдийг мартах хэрэгтэй. Өөрийгөө байгаа гэж бодох хүн цэцэн мэдлэгт хүрэхгүй. Фена ба Бека хүн чанар ба зүрх сэтгэлд гарч ирэх зүйл юм. Хэлж өгүүлснээр ойлгогдохгүй. Цэцэн мэдлэгт үл хүрэгч үүнийг байнга хайх хэрэгтэй. Доромж үзэгдэхээр зарлиг болгоогдсон түр зуурын зүйлийг засах гэж оролдож хэрэггүй.

• НАМААЗЫН ДАРАА ДУА •

Элхамдүлиаллахи Раббилалемин. Эссалатү уесселамү ала Ресүлина Мүхаммедин уе Алихи уе Сахбини эжмаин. Аяа Эзэн Тэнгэр минь үйлдсэн намаазыг минь хүлээж соёрх. Сүүлийн төгсгөлийг минь хайрлан соёрх, сүүлчийн амьсгаандаа келиме-и шевхид хэлэхийг минь оноон соёрх, үхэгсдийг минь өршөөж хүлцэн соёрх, алахуммагфир верхам ве энте хайруррахимин. Тевефценни мүслимен ве элхыкни биссалихин. Алахүммагфир-ли ве ли-валидеййе ве ли-үстазийе ве лилмүминине вел мүминат йевме йекумүл хисаб. Аяа Эзэн Тэнэгэр минь Намайг чөтгөрийн нүгэл ба дайсны нүглээс тачаал хүсэлд автах нүглээс хамгаалан соёрх. Гэр оронд минь сайн сайхан хоол хүнс буян соёрх. Ислаам шашны сүсэгтэн олонд амар мэнд буян соёрх. Ислаамын дайсан нарыг энэлээн сүйтгэж соёрх. Кафир нартай дайтаж буй мусылмаан нарт тэнггэр эзний авралаар туслан соёрх. Аллахүмме иннеке афуввун керимүн түхиббүл афве фату анни. Аяа Рабби Өвчтөнд минь илаар зовогчдод арга чарга соёрх. Аллахуме инни эселүке ссыххате вел-афийете вел-эманете ве хүсне лхүлки веррыдае билкадери бирахметике йа эрхамеррахимин. Ээж аав, үр хүүхэд, ах дүү, найз нөхөд бүхий л шашны ах дүү нарт минь буянт амьдрал, нас, ёс суртахуун, саруул ухаан, эрүүл энх, амирлангуй шашны зам мөр зүг чиг, буян хайрлан соёрх. Йа Рабби Амин. Велхамдү-лиллахи раббилалемин. Аллахүмме салли ала..., Аллахүмме барик ала..., Аллахүмме Раббена атина... Велхамдү лиллахи Раббилалемин. Эстагфирүллах, эстагфирүллах эстагфирүллах, эстагфирүллахел азим элкерим эллези ла-илахе илла хүв эл-хаййел-каййүме ве этүбү илейх.

Тайлбар :/Дуа хүлээн зөвшөөрөгдөх шар-болзол/

1. Мусылмаан байх
2. Эхл-и сүннетийг итгэн бишрэх. Үүний тулд дөрвөн мезхебээс нэгийг нь дагах дууриах хэрэгтэй
3. Фарзыг хийх, Казад үлдсэн намаазуудыг шөнө ч мөн сүннетүүдийн оронд каза хийж юуны өмнө төлөх хэрэгтэй.

Фарз намааз нь казад үлдсэн хүний сүннет ба нафиле намаазууд

Дуа нь хүлээн зөвшөөрөгдөхгүй. Өөрөөр хэлбэл, жинхэнэ ч гэсэн

буян ногдохгүй. Чөтгөр мусылмаан нарыг хуурахын тулд фарзыг чухал бус хэмээн харуулж сүннет ба нафилег хийхэд хүргэнэ. Намаазыг цаг хугацаа нь болсныг мэдээд юуны өмнө цаг хугацаанд нь үйлдэх хэрэгтэй.

4. Хараамаас зайлсхийх, Халаалыг идэгчийн Дуа хүлээн зөвшөөрөгднө.

5. Эвлийа-и кирамаас нэгийг нь весилэ хийж Дуа хийх хэрэгтэй. Энэтхэгийн мэргэдийн нэг Мүхамммед бин Ахмед Захид Тергиб-ус-салат номын тавин дөрөв дэхь хэсэгт перс хэлээр өгүүлэхдээ: /хадис-и шерифт /Дуа хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хоёр зүйл хэрэгтэй. Нэг дэх нь Дуаг ихласаар хийх хэрэгтэй. Хоёрт идэж өмсөх нь халаал байх хэрэгтэй. Мүмины өрөөнд өчүүхэн ч атугай хараам цээр байвал энэ өрөөнд уншсан Дуа огтоос хүлээн зөвшөөрөгдөхгүй. хэмээжээ. Ихлас Аллаахаас өөр юуг ч үл бодож зөвхөн Аллаахаас хүсэх гэсэн үг. Үүний тулд Эхл-и сүннет эрдэмтэн мэргэдийн өгүүлсэн шигээр имаан хийх ислаамын хууль ёсонд зохицох ялангуяа дээр нь боолын эрх байхгүй байх таван удаагийн намаазыг үйлдэх хэрэгтэй.

• ТЕЖДИД-И ИМААН ДУА •

/итгэл үнэмшлийг шинэчлэх/

Аяа Рабби Хин-и бюлүүгээсээ энэ мөчийг хүртэл ислаамын дайснуудад буруу номынхонд хууртаж хийсэн буруу цэгцүй итгэл бишрэл мөн буруу номын, нүгэл болох хэлж сонсож харсан үйлдсэндээ гэмшсэн би, дахин ийм буруу андуу итгэж хийхгүй гэдгээ чармайн шийдэн зорьлоо би. Пайгамбаруудын эхнийх болох Адаам алехисселам ба даараач нь бидний хайрт Пайгамбаар Мүхаммед алейхис селам юм. Энэ хоёр Пайгамбаарт, энэ хоёрын хооронд ирж буцсан бүхий л Пайгамбаруудын үг өгүүлбэрт итгэн сүслэв би. Бүгдээрээ үнэн итгэлт бөлгөө. Өгүүлсэн айлдсан нь зөв юм. Аментү биллах ве би-ма жае мн индиллах, ала мүрадиллах, ве аментү би-Ресүлиллах ве би-ма мин инди Ресүлиллах ала мүрад-и Ресүлиллах, аментү биллахи ве Мелаикетихи ве күтүбихи ве Рүсүлихи велйевмил-ахири ве билкадери хайрихи ве шеррихи миналлахи теаля вел-басү бадел мевти хаккүн эшхедү эн ла илахе иллаллах ве ешхедү энне Мүхаммден абдюхү ве ресүлүх.

• НАМААЗЫН ЦЭЦЭН МЭРГЭН •

Намаз ба бидний эрүүл мэнд

Мусылмаан намаазыг Аллаахын зарлиг тул үйлдэх ба Манай Раббин зарлиг тушаамжинд олон тооны цэцэн мэдлэг ач тус байдаг. Хорио цээрэнд нь гэсэн олон тооны хор хөнөөл байгаа нь гарцаагүй билээ. Энэхүү ач тус нэг хэсгийг өнөөдөр анагаахын мэргэжилтнүүд тогтоосон байна. Ислаам шашны эрүүл мэндэд өгөх ач холбогдлыг ямар ч шашин суртал өгөөгүй юм. Бидний шашин хамгийн оройн дээд ибхдет болох намаазыг насан зүг болтлоо үйлдэхийг зарлиглан тушаасан байна. Намаазыг үйлдэгч эрүүл мэндийн ач тусдаа ч мэдээжээр олно. Намаазын эрүүл мэндийн талаас хангах зарим нэгэн ач тус гэвэл: доорх болно.

1. Намаазд хийх үйл хөдлөл удаан болохоор хүний зүрхийг ядраахгүй ба өдрийн янз бүрийн цагт байх тул хүнийг үргэлж хүчтэй байлгана.

2. Өдөртөө толгойгоо наян удаа газар талбих хүний тархинд хэмнэлээр цус илүү хангагдна. Иймээс тархины эс эд сайтар тэжээгдэх тул ой тогтоомж болоод зан аашын муудах нь намааз үйлдэгч нарт цөөн тохиолдно. Энэ хүмүүс илүү эрүүл эсэн амьдрал туулна. Өнөөдөр анагаах ухаанд “деманс сэнил” гэх зөнөглөх өвчинд өртөхгүй.

3. Намааз үйлдэгчдийн нүд эмх цэгцтэйгээр хөдөлдөг болохоор илүү хүчтэй цусны эргэлт бий болгоно. Энэ шалтгаанаар нүдний дотоод даралт нэмэгдэхгүй, нүдний урд хэсгийн шингэн үргэлж өөрчлөгднө. Нүдийг аргах эсхүл нүд усжих өвчнөөс хамгаална.

4. Намааз үйлдэх үеийн изометрийн үйлдлүүд гэдэсний хоол хүнс сайн холилдож цөс сайн урсаж улмаар цөсний уутанд хур хуримталал бий болохгүй байх, цөс төмөржих байх энзимүүдийн хялбар суллагдахад тус дөхөм болох ба өтгөн хаагдахуй ч алга болоход ч үүрэг их юм. Бөөр ба шээсний зам мөр сайтар цалгихаас авахуулаад бөөрөнд чулуужихаас сэргийлэх, шээс түгжрэхээс ангижрахад тус дөхөм болно.

Таван удаа үйлдэх намаазын хэмнэлийн хөдөлгөөнүүд өдөр тутмын амьдралд ажиллуулж үл чадах булчин үе мөчийг ажиллуулж артроз шохойжих гэх мэт үе мөчний өвчин булчин шөрмөс татахаас урьдчилж сэргийлнэ.

5. Бие махбодын эрүүл мэндэд цэвэр цэмцгэр байдал зайлшгүй хэрэгтэй. Абдест ба гүсл материаллаг болоод оюун ухааны цэвэрлэгээ бөлгөө. Ийнхүү намааз нь цэвэрлэгээ чухамхүү өөрөө юм. Яагаад гэвэл бие махбод ба сүнс санааны цэвэрлэгээгүйгээр намааз болохгүй. Абдест ба гүсл биеийн цэвэр байдлыг хангана. Ибадетийн үүргийг биелүүлэх хүн санаа сэтгэлийн хувьд амарч цэвэржсэн байх болно.

6. Хамгаалах эмчилгээнд үзүүлэх хугацаанд хийх бие махбодын хөдөлгөөн ихэд чухал юм. Намаазын цаг нь цусны эргэлтийг шинэчлэх, сэлбэх, амьсгалыг амьдруулахад хамгийн зохимжтой цаг болно.

7. Нойрыг эмхлэн цэгцлэх чухал зүйл нь намааз юм. Тэр ч бүү хэл бие махбодод байх зогсонги цахилгаанжилт сеждег хийснээр газарт сарнина. Ийнхүү бие махбод дахин эрүүл цовоо болно.

Намаазын энэхүү ач тусыг хүртэхийн тулд намаазыг цаг хугацаанд нь үйлдэхийн хамтаар их идэхгүй байх, идсэн хоол хүнс цэвэр халаал байхад анхаарах хэрэгтэй бөлгөө.

Хэнд ч үлдэцтэй биш дэлхийн өмч мөнгө тарих нь.

Долдугаар бүлэг

• НАМААЗЫН ИСКАТ •

Өөд болоочийн Искат ба Дэвр

(Нур-үл изахд) (Тахтави) (Халэби) ба (Дүрр-үл-мухтар) зэрэг тайлбарт намаазын казагийн дараа (Мүлтэкад) (Дүррү-үл мүнтэкад) (Викайэд) (Дүрэрд) (Жэвхэрэд) бусад дээд үнэт номуудад мацагийн дараа гэрээслэгч өөд болооч искат ба дэвр хийх хэрэгтэй болох тухай бичээстэй байна. Жишээ нь Тахтави тайлбарт /хашийэ/ / Бариагүй мацагийн фидйэ/цагаатгал мөнгө/ өгч искат хийх мадаггүй аят буюу гэрч байдаг. Намааз мацагаас илүү чухал болох тул шашны ямар нэг шалтгаар хийж чадаагүй ба каза хийхийг хүссэн мөртөө үхлийн өвчинд баригдсан хэн нэгний каза хийж чадаагүй намаазын дотор мацагт хийхтэй адил искат хийх тухайд бүх эрдэмтэд санал нэгтэй байдаг. Намаазын искат байхгүй гэх хүн шашин үл мэдэгч / жахил/ болно. Яагаад гэвэл мэзхэбүүдийн нэгдмэл санааны эсрэг болж байна. Хадис- и шерифт /Хэн нэгэн хүн өөр хэн нэгний оронд мацаг барьж болохгүй, намаз хийж болохгүй, гэхдээ түүний мацаг намаазын тулд ядуу хүнийг хооллоно хэмээн зарлиглав. Эхл-и сүннэт эрдэмтдийн илүү шинжийг ойлгохгүй мэзхэб имаамуудыг ч өөрсөд шигээ мөрөөдлөөр ярьж байна хэмээн бодох зарим хүн /Ислаам шашинд искат ба дэвр байхгүй. Искат нь христиан шашны нүгэл арилгахтай адил гэх мэт үг хэл сонсогдно. Ийм мэт үг өөрсдийг нь аюултай нөхцөл байдалд оруулж байна. Учир нь Манай Пйгамбаар элч саллаллахү алэйхи вэ селлем сүсэгтэн олон минь гажуу зүйлд нэгдэж болохгүй гэж айлдав. Энэхүү хадис-и шэриф мюжтэхидчүүд/ дээд имаан шашны эх бичвэрийг тайлбарлагч нар/-ийн санал нэгтэйгээр хэлсэн үгийг мэдээжээр зөв болохыг зааж байна. Эдгээрт үл итгэх энэ хадис-и ү-шерифт итгээгүй хэрэг болно. Ибни Абидин витр

намаазыг

өгүүлэхдээ /шашинд зайлшгүй болох өөрөөр хэлбэл ислаамыг үл мэдэгчид /жахил/ мэдэх эрдэмтдийн санал нэгдсэн /ижма/ мэдлэгт үл итгэх хүн кафир болно/ хэмээн айлдаж байна. Исма нь эрдэмтэд үг санал нэгдэх гэсэн үг. Искатыг нүгэл арилгахтай яаж адилтгаж болох вэ. Христийн санваартан нар нүгэл арилгана хэмээн хүмүүсийг мөлжиж дээрэмдэж байна. Гэтэл Ислаам шашинд санваартан нар искат хийхгүй. Искатыг зөвхөн нас нөгчигчийн эцэг эх хийж болох ба мөнгийг санваартан нарт бус ядууст өгнө.

Өнөөдөр бараг бүх газар искат деврийн үйл ажиллагаа ислаам шашны дагуу хийгдэхгүй байна. Ислаам шашинд искат байхгүй гэгчид ингэж хэлэхгүйгээр өнөөдрийн искат девр ислаам шашинд тохирохгүй байна гэсэн бол маш сайн болохсон. Бид ч тэднийг дэмжих байлаа. Ингэж хэлснээрээ аюумшигт аюулд автахаас аврагдаж Ислаам шашинд зүтгэсэнд тооцогдох байв. Искат ба деврийг манай шашны дагуу хэрхэн хийх талаар доор өгүүлнэ. Ибни Абидин каза намаазын дараа айлдруун:

Файтэ намаазтай /өөрөөр хэлбэл, өзрөөр алдаж казад үлдсэн намаазтай /хүн эдгээрийг толгой дохиод ч болов чадал нь хүрч байхад үйлдээгүй бол үхэхдээ кеффарат буюу цагаатгалын искат хийхээр гэрээслэх нь важиб юм. Казад хүч нь хүрээгүй бол гэрээслэх хэрэггүй. Рамазан-и шерифт мацаг идэх зочин ба өвчтөн каза хийх цаг ололгүйгээр үхвэл гэрээслэл хийх шаардлагатай бус. Аллахү теаля эдгээрийн шалтагийг хүлээн зөвшөөрнө. Өвчтөний кефаратийн искат нь үхсэний дараа асрамжлагч нь хийнэ. Үхэхээс өмнө хийхгүй. Амьд хүн өөртөө искат хийх нь шашинд үл тохирно. Жилал-үл күлүбд хэлэхдээ, /Аллах болон боолын эрхтэй хүн хоёр гэрчийн хажууд гэрээслэл хэлэх эсхүл бичсэн зүйлийг эл хоёр хүнд унших нь важиб юм. Эрхгүй хүний гэрээслэл мустахаб юм./

Цагаатгал искатын төлөө гэрээслэх өөд болоочийн асрамжлагч өөрөөр хэлбэл өв хөрөнгөө зөв зарцуулахаар гэрээслүүлсэн өвлөгч хүн өв хөрөнгийн гуравны нэгээс нэг удаагийн намааз бүрийн төлөө мөн витр намаазын төлөө каза нөхвөр хийгдэх хэрэгтэй нэг өдрийн мацагт нэг фитрагийн хэмжээний өөрөөр хэлбэл хагас сая/таван зуун хорин тохой эсхүл мянга долоон зуун тавин грамм /буудайг ядууст / эсхүл ядуусын төлөөлөгчдөд/ фиде /цагаатгал мөнгө/ өгнө.

Цагаатгал искатаар гэрээслээгүй бол асрамжлагч цагаатгал искат хийх нь Ханефид шаардлагатай биш. Шафий мезхебд гэрээслээгүй ч

гэсэн асрамжлагч искат хийх хэрэгтэй. Боолын эрхийг гэрээслэлгүй ч гэсэн өөд болоочийн орхисон эд хөрөнгөнөөс вели буюу асрамжлагч төлөх нь Ханефи мезхебд ч шаардлагатай байдаг. Тэр бүү хэл авлагатай хүмүүс өв хөрөнгөнөөс нь шүүхийн шийдвэргүйгээр авч болно. Казад үлдэх мацагийн фиде нь өөрөөр хэлбэл, эд бараагаар төлөхийг гэрээслэсэн бол үүнийг биелүүлэх важиб юм. Яагаад гэвэл ислаамын шашин тушаан зарлиглаж байна. Гэрээслээгүй бол намаазын фиде буюу цагаатгал мөнгийг өгөх нь зайлшгүй үүрэг бус гагцхүү шашин сайшаана. Энэ сүүлчийн хоёр хүлээн зөвшөөрөгдөхгүй бол багадаа л садакагийн буян бий болж нүглээ ариутгахад тусална. Имам-и Мүхамммед ийн айлдсан бөлгөө. Межма-үл-энхүрд хэлэхдээ /Тачаал хүсэл ба чөтгөрийг даган намаазаа үл үйлдсэн амьдралын төгсгөл рүү үүндээ гэмшин /намааз үйлдэж каза хийж эхэлсэн / хүний каза хийгээгүй намаазын искатыг гэрээслэх нь шашинд тохирохгүй гэгдсэн ч шашинд тохирно Мустасфад хэмээн бичээстэй бөлгөө.

Жила-үл-күлүб/д хэлэхдээ / Боолын эрх нь өр шир, даатгал, дээрэм хулгайн төлбөр ба арилжин худалдах шалтгаанаар өгөх ба зодох шархдуулах, шударга бусаар хэрэглэх гэх мэт бие махбодын эрх ба хараах, тохуурхах, гүтгэлэг гэх мэт зүрх сэтгэлийн эрхүүд юм/гэв.

Гэрээслэсэн өөд болоочийн эд хөрөнгөний гуравны нэгийг искатын өглөг /кифает/ хийж байгаа бол вели энэ эд таваараар фиде буюу цагаатгал мөнгө өгөх хэрэгтэй. Өглөг /Кифает/ хийхгүй байгаа бол гуравны нэгээс илүүг өвлөгч хандив өгөх нь шашинд тохирохыг Фетх-үл-кадирд бичжээ. Энэ мэтээр фарз болох хаж хийлгэхээр гэрээслэвэл өвлөгч юм уу өөр хэн нэгэн хажийн мөнгийг бэлэглэвэл шашинд тохирохгүй. Өөд болооч үхээгүй байхад гэрээслэлгүйгээр өвлөгч өөрийн мөнгөөр искат хийвэл эсвэл хаж руу явбал өөд болоочийн өр төлөгдөх болно. Өвлөгчөөс бусдын мөнгөөр эд нар шашинд тохирохгүй хэмээгчид байгаа ч /Дүрр-үл-мүхтар/ ба / Меракыл-фелах/ мөн /Жила-үл-күлүб/ номыг зохиогчид болно гэцгээв.

Цагаатгал искатыг буудайн оронд гурил ба нэг са арвай хурма үзэмээр тооцоолж эдгэр ч өгч болно. /Яагаад гэвэл, эд нар буудайгаас илүү үнэ хүндтэй болох тул ядуу хүнд илүү ач тустай юм./ Бүгдийг орлуулж үнэ цэнэтэй алт эсхүл мөнгө ч өгч болно /Цаасан мөнгөөр искат хийхгүй/ Сежде-и тылаветэд фиде буюу цагаатгал мөнгө өгөх

хэрэггүй.

Искат ба деврийг хэрхэн хийх вэ?

Фидйе мөнгө өв хөрөнгийн гуравны нэгийг давж байвал өвлөгчид зөвшөөрөөгүй бол асрамжлагч гуравны нэгээс илүүг зарцуулж болохгүй. Кынйе номноо өгүүлэхдээ бүхий л насныхаа намаазын төлөө эд хөрөнгөнийхөө гуравны нэгийг өгөхийг гэрээслэсэн өөд болоочийн өртэй ч бай авлагатай хүн гэрээслэл хийхийг зөвшөөрлөө ч гэсэн гэрээслэл хийх нь шашигнд үл тохирно. Яагаад гэвэл, ислаамын шашин эхлээд өрөө төлөхийг зарлиглаж байна. Өрөө төлөхүйг авлагатай хүний зөвшөөрлөөр хойшлуулж болохгүй.

Бүх намаазын искатаа гэрээслэсэн хүн хэдэн насандаа нас барсан гэдэг нь мэдэгдэхгүй бол орхисон өв хөрөнгийн гуравны нэг нь намаазын искатд хүрэлцээгүй бол энэхүү гэрээслэл шашинд тохирох болно. Өв хөрөнгийн гуравны нэг нь искатад хүрэлцэж илүү гарвал энэхүү гэрээслэл хүлээн зөвшөөрөгдөхгүй сулд тооцогдоно. Яагаад гэвэл эд хөрөнгийн гуравны нэг нь искатд хүрээгүй цагт гуравны нэгээр искат хийгдэх намаазын тоо хэмжээ тодорхой болдогоос гэрээслэл нь энэхүү намаазын хувьд үнэн мөн болно. Үлдсэн намаазын гэрээслэл хүчин төгөлдөр бус өөрөөр хэлбэл хоосон үг болно. Гуравны нэг нь илүү гарах үед амь нас өөрөөр хэлбэл намаазын тоо хэмжээ тодорхой болохгүй тул гэрээслэл нь хоосон сул болно.

Намаазын искатад гэрээслэл хийх өөд болоочийн эд хөрөнгө огт үгүй эсвэл гуравны нэг нь гэрээслэлд хүрэхгүй бол эсвэл огтоос гэрээслээгүй байж асрамжлагч нь өөрийнхөө эд хөрөнгөөрөө искат хийхийг хүсч байгаа бол Девр хийнэ. Гэхдээ асрамжлагч девр хийх зайлшгүй хэрэгтэй биш. Девр хийхийн тулд асрамжлагч нэг сарын эсвэл нэг жилийн искатын тулд хэрэгтэй алтан зоосны үнэтэй эсвэл таван нэгэн газарт бугуйвч бөгж эсвэл мөнгөнд тооцогдох мөнгө зээлж авна. Өөд болооч эрэгтэй наснаасаа арван хоёр жил эмэгтэй бол есөн нас хасч хэдэн жилийн өртэй болохыг нь тооцно.

Нэг өдрийн зургаан намаазын тулд арван кило нэг нарны жилийн тулд гурван мянга зургаан зуун жаран килограмм буудай өгөх хэрэгтэй. Жишээ нь нэг кило буудай зуун наян төгрөг болох цагт нэг жилийн намааз искат, зургаан мянга таван зуун наян найм эсвэл товчоор зургаан мянга зургаан зуун төгрөг болно. Нэг алтан лира-/долоон грамм хорин сантиграмм болох ба / зуун хорин лира болох цагт нэг жилийн намаазын искатын тулд тавин тав эсвэл

болгоомжлон жаран алт хэрэгтэй болно. Өөд болоочийн асрамжлагч таван алт зээлж авбал энэ ертөнцөд үл шунан тачаагч шажин номоо мэдэх хайрлах хэдэн тооны жишээ нь дөрвөн ядуу олдвол /Эд фитра өгч үл чадах өөрөөр хэлбэл садака авах ядуу байх нь шарт юм. Ядуу биш бол искат хүлээн зөвшөөрөгдөхгүй./ Өөд болоочийн асрамжлагч өөрөөр хэлбэл гэрээслэсэн хүн эсвэл өвлөгчийн нэг нь эсвэл эднээс нэгнийх нь төлөөний хүн /Талийгаачийн искат мөргөлийн /салат/ төлөөс болгож энэхүү таван алтыг чамд өглөө гээд таван алтыг нэгдэх ядууд садака зорин хүсээд өгнө. Дараа нь ядуу Авлаа хүлээн авлаа Чамд бэлэглэлээ гээд үүнийг өвлөгчид эсвэл өвлөгчийн төлөөлөгчид бэлэглэж өвлөгч хүлээн авна. Дараа нь дахин үүнд эсвэл хоёрдох ядууд өгөн бэлэг болгож түүнээс буцааж авна. Ийнхүү нэг ядууд дөрвөн удаа эсвэл дөрвөн ядууд нэг нэг удаа өгч авахаар нэг девр/тойрог/ болно. Нэг деврт хорин алтны намаазын төлөөс искат хийгдсэн болно. Өөд болооч эрэгтэй ба жаран настай бол дөчин найман жилийн намаазын төлөө 48х60=2880 алт өгөх болно. Үүний тулд 2880:20=144 дахин девр хийнэ. Алтын ширхэг нь арав бол 72 девр, алтын тоо хорь бол 36 девр хийнэ. Ядуу ширхэгийг арав ба алтын тоо арав бол 48 жилийн намаз цагаатгалын искатд хорин есөн девр хийнэ. Яагаад гэвэл:

Намаз үйлдээгүй он жил Х деврийн тоо юм. Манай жишээнд ойролцоогоор : 48х60=4х 5 144=4х10х 72= 4х 20х 36= 10х 10х 29

Үүнээс үзвэл, намаазын искатд деврийн тоог олохын тулд нэг жилийн алтны тоогоор Өөд болоочийн намааз өрийн жилийг үржүүлнэ. Үүнээс гадна, девр болох алтын тоо ба ядуугийн тоо үржүүлнэ. Нэгдүгээр үржүүлэлт хоёрдох үржүүлэлтэнд хуваана. Хуваалт деврийн тоо болно. Буудай ба алтын цаасан мөнгөний үнэ цэнэ цаг үргэлж ойролцоогоор адил хувиар өөрчлөгднө. Өөрөөр хэлбэл алтны үнэ ханштай буудайн үнэ үргэлж цугтаа багасч эсвэл нэмэгднэ. Энэ талаар искатын хувьд нэг жилийн буудайн тоо хэмжээ өөрчлөгдөөгүйн адил нэг жилийн алтны тоо мөн адил дээр дурдсан жаран алт ч бараг адил болж байна. Үүний тулд искатын тооцоонд цаг үргэлж болгоомжтойгоор:

Нэг сарын намаз искат таван алт

Нэг сарын рамазаны мацагын искат нэг алт юм.

гэж хүлээн зөвшөөрч байна. Девр хийгдэх алтны тоо хэмжээ ба деврийн тоо эндээс гарна.

Намаазыг искат дууссаны дараа үл барих каза хийх хэрэгтэй

мацагийн искатд таван алт дөрвөн ядууд гурван удаа девр хийнэ. Яагаад гэвэл, нэг жилийн өөрөөр хэлбэл, гучин өдрийн мацагийн цагаатгал нь искат нь тавин хоёр хагас кило буудай эсвэл 5, 25 грам алт өөрөөр хэлбэл, 0,73 ширхэг алтан зоос болно. Үүнэээс үзвэл Ханефид нэг алт нэг жилийн мацгийн цагаатгалыг кефарет/ искат хийх ба дөчин найман жилд дөчин найман алт өгөх хэрэгтэй болно. Таван алтаар дөрвөн ядууд нэг девр хийнгүүт хорин алт өгнө. Каза нөхвөр хийх хэрэгтэй мацагийн искат хийсний дараа зекетд дараа нь курбанд хэд хэдэн девр хийнэ.

Нэг андгайн цагаатгалын төлөөнөө өдөр бүр арван ядуу ба шалтаггүй бусниж цагаатгал нь хэрэгтэй болсон нэг өдрийн мацагийн цагаатгалд нэг өдөрт жаран ядуу хэрэгтэй ба нэг ядууд нэг өдөрт хагас са буудайгаас илүү өгөхгүй. Өөрөөр хэлбэл, хэд хэдэн андгайн кефарет цагаатгалыг нэг өдөрт арван ядууд өгөхгүй. Тийм бол андгай ба мацагийн кефарет төлөөст нэг өдөрт цагаатгал хийхгүй. Андгайн гэрээслэл байгаа бол нэг андгайд нэг өдөрт арван ядуу тус бүрт хоёр килограмм буудай эсвэл гурил эсвэл энэ үнэтэй ямар нэг эд таваар алт мөнгө өгнө. Эдгээрийг нэг ядууд арван өдр дараалан өгч ч болно. Эсвэл, нэг ядууд цаасан мөнгө өгч “ Чамайг төлөөлөгч болгосон. Энэ мөнгөөр өдөр бүр өглөө ба орой хоёр удаа арван өдөр гэдсээ цатгаарай чи хэмээх хэрэгтэй. Гэдсээ ийнхүү арван өдөр цатгалгүйгээр кофе, сонины мөнгө хийвэл шашинд тохирохгүй. Хамгийн сайн нь гэвэл, нэг тогоочтой наймаалцаж арван өдрийн мөнгөө тогочид өгч ядуу хүн өдөр бүр өглөө орой хоёр удаа арван өдөр гэдсээ цатгах хэрэгтэй. Зорин хүссэний дараа буснисан мацаг зыхар /нөхөр нь эхнэрийгээ чи миний ээж шиг юм гэх/ цагаатгал ч ийм бөгөөд энэ хоёулангийн хувьд нэг өдрийн цагаатгалын хувьд жаран ядууд нэг өдөр, эсвэл нэг ядууд жаран өдөр хагас кило буудай эсвэл энэ үнийн хэмжээнд өөр эд таваар өгөх, эсвэл өдөр бүр хоёр удаа цатгах хэрэгтэй.

Гэрээслэл үл хийгдэх зекятын искат хийгдэх хэрэгтэй биш. Өвлөгч буюу варисын зекятийн искатын тулд аяндаа девр хийж болохын заалт заавар/фетва/ өгөгдсөн болно.

Девр хийхэд асрамжлагч алтыг ядууст өгөх бүрдээ намаз эсвэл мацагийн искат хэмээн нийет хийх хэрэгтэй. Ядуу ч гэсэн буцааж өгөхдөө бэлэг өглөө гэх хэрэгтэй ба Асрамжлагч хүлээж авлаа гэх хэрэгтэй. Асрамжлагч искат хийж чадахааргүй нөхцөлд байгаа бол

талийгаачийн искатийг хийхийн тулд нэг хүн төлөөлөгч томилох ба искат ба деврийг энэ төлөөний хүн хийнэ.

Имам-и Биргүвийн Васийетнаме хэмээх номонд үүний кадызаде Ахмэд Эфенди тайлбарт өгүүлэхдээ ядуусын өглөгийн хэмжүүрт өмч хөрөнгө эзэмшдэггүй байх нь шарт юм. Өөд болоочийн ах дүү бол шашинд тохирох юм. Ядууд өгөхөд /энэ хүний өдий хэмжээний намаазын искатын тулд үүнд өглөө гэж хэлэх хэрэгтэй. Ядуу хүн Хүлээн авлаа гэх хэрэгтэй ба алтыг авангуутаа өөрийнх нь болохыг мэдэх хэрэгтэй. Мэдэхгүй бол урьдаас заах сургах хэрэгтэй. Энэ ядуу мөн буян хишиг хийж өөрийн хүслээрээ ийн намаазын искатд зориулж төлбөр болгон үүнийг чамд өглөө гээд өөр нэг ядууд өгнө. Тэр ядуу ч гэсэн гардаж аваад Хүлээж авлаа гэх хэрэгтэй. Авмагцаа өөрийн эд хөрөнгө болохыг мэдэх хэрэгтэй. Түр хадгалуулах бэлэг мэтээр авбал девр хүлээн зөвшөөрөгдөхгүй. Энэ хоёрдохь ядуу ч гэсэн авлаа хүлээж авлаа гэж хэлснийхээ дараа шалтгаанаар чамд өглөө гээд гуравдахь ядууд өгнө. Ийнхүү намааз, мацаг, зекят, курбан, садака-и фитр, тахил ба боолын эрх амьтны эрхийн төлөө девр хийх хэрэгтэй. Буруу худал хуурмаг худалдаа нь боолын эрхд багтан ордог. Андгай ба мацгийн цагаатгалд девр хийх нь шашинд тохирохгүй.

Түүний дараа алт ямар нэгэн ядууд үлдвэл буян сайн үйл хийж хүсэл гуйлтаар нь асрамжлагчид бэлэглэнэ. Асрамжлагч аваад хүлээж авлаа гэнэ. Хэрвээ бэлэглэхгүй бол өөрийн эд таваар тул хүчээр авч болохгүй. Асрамжлагч тодорхой тооны алт цаасан мөнгө эсвэл өөд болоочийн эд хогшлоос энэхүү ядууд өгч энэхүү садака буяныг өөд болоочийн сүнсэнд бэлэглэнэ. Өр зээлтэй ядуу хүн ба идэр насанд хүрээгүй хүүхэд девр хийхэд оролцох хэрэггүй. Яагаад гэвэл гарт нь орсон өр зээлээ төлөх нь фарз юм. Энхүү фарзыг хийлгүйгээр алтыг насан өөд болоочийн цагаатгалын тулд хажуу дахь ядууд өгөх нь шашинд тохирохгүй. Девр хүлээн зөвшөөрөгдвөл өөрөө огтоос буян хураахгүй. Түүгээр зогсохгүй нүгэлд орно.

Эд хөрөнгөгүй өөд болооч девр хийхийг гэрээслэвэл асрамжлагч девр хийх нь важиб болохгүй. Өөд болооч цагаатгалаа искат хийх хүртэл эд хөрөнгөө бүгдийг нь өв хөрөнгийнхөө гуравны нэгийг давахгүй байхаар гэрээслэх нь важиб болно. Ийнхүү девргүйгээр искат хийгднэ. Гуравны нэг нь искатд хүрэх мөртлөө гуравны нэгээс бага эд хөрөнгө девр хийхийг гэрээслэвэл нүгэлд орно. Ибни Абидин

тавдугаар боть 273р хуудсанд айлдахдаа: /Бага хүүхэдтэй эсвэл

ядуугаасаа болж өв хөрөнгө хэрэгтэй мөртлөө идэр насны хүүхдүүд номын ёст өвчтөний нафиле болох сайн буян нь гэрээслэхгүйгээр эд хөрөнгөө номын ёст хүүхдүүддээ үлдээх нь илүү сайн юм. Беззазийед бэлгийн талаар өгүүлэхдээ /Эд хөрөнгөө буяны үйлд зарцуулж нүгэлтэй хүүхэддээ өв хөрөнгө үлдээхгүй байх хэрэгтэй. Учир нь нүгэлд тусалсанд тооцогдоно. Нүгэлтэй хүүхэддээ ч гэсэн илүү эд хөрөнгө өгөх хэрэггүй.

Олон тооны намааз, мацаг, зекят, курбан ба андгайн өр зээлтэй боловч үүний тулд өв хөрөнгийн гуравны нэгээс бага эд таваарын девр хийхийг үлдсэн эд таваартай куран-и керим хатм-и техлил ба мевлид уншихыг гэрээслэх нь шашинд тохирохгүй. Үүнийг уншихад мөнгө өгч авагч нүгэлд орно. Кураан-и керим заахад мөнгө өгч авах шашинд тохирно. Уншихад бол шашинд тохирохгүй.

Өөд болоочийн өрд үлдсэн намааз, мацагийг өвлөгч ба хэн нэгэн каза хийхийг шашин сайшаахгүй. Гэхдээ нафиле намаз үйлдэж мацаг барьж буяныг нь сүнсэнд нь бэлэглэх нь шашинд тохирох ба сайн үйл болно.

Өөд болоочийн өрд үлдсэн хажийг гэрээслэгч нь каза хийвэл шашинд тохирно. Өөрөөр хэлбэл өөд болоочийг өр зээлээс чөлөөлнө. Яагаад гэвэл хаж бие болоод эд хөрөнгөөрөө хийх ибадет юм. Нафиле /нэмэлт/ хаж бусдын төлөөнөөс үргэлж хийгднэ. Фарз хажийг зөвхөн нас бартлаа хаж явж үл чадах хүний оронд төлөөлөгч хийнэ.

Межмүүл-энхүрд мөн Дүрр-үл-мүнтекад өгүүлэхдээ, /Өөд болоочийн искатыг оршуулахаас нь өмнө хийх хэрэгтэй./ хэмээв. Оршуулсны дараа ч гэсэн шашинд тохирох нь Күхистанид бичжээ.

Өөд болоочийн тулд намааз, мацаг, зекят, курбан цагаатгалын искатд нэг ядууд хэмжүүр хэмжээнээс нь илүү өгч болно. Тэр бүү хэл бүх алтыг нэг ядууд өгч болно.

Үхлийн өвчтэй хүний үйлдээгүй намаазын фидйег өгөх нь шашинд тохирохгүй. Мацаг барьж үл чадах өндөр настай хүний бариагүй намаазын фиде /цагаатгалын мөнгө/ өгөх нь шашинд тохирно. Өвчтөн намаазыг толгойгоор дохиж үйлдэх нь шашинд тохирно. Ийнхүү толгой дохиж нэг өдрөөс илүү намааз хийж үл чадах өвчтөний үйлдэж чадаагүй намааз нь өршөөгднө. Илааршвал эдгээрийг каза хийх хэрэггүй. Бариагүй мацагийг бие илааршин дээрдсэний дараа барих хэрэгтэй. Сайжралгүйгээр наснаас нөгчвөл энэхүү мацаг нь өршөөгднө.

Наймдугаар бүлэг



• ГУЧИН ХОЁР БА ТАВИН ДӨРВӨН ФАРЗ •

Нэг хүүхэд нас биед хүрэх үед эсвэл нэг кяфир Келиме-и тевхид хэлмэгц өөрөөр хэлбэл Ла илахэ иллаллах Мухаммэдүн рэсулуллах хэмээгээд утгыг нь мэдэж иггэх цагт Мусылмаан болно. Кафирийн бүх нүгэл тэр дороо өршөөгднө. Гэвч, эд нар мусылмаан хүн бүр шиг боломж олвол имааны зургаан болзол нөхцлийг өөрөөр хэлбэл, /амэнтү/г цээжлэх, утгыг нь сурч эдгээрт итгэх мөн /ислам шашны бүгдийг өөрөөр хэлбэл, Мүхаммед алейхисселамын хэлсэн захирамж, хорионы бүгдийг Аллаах мэддэг гэж итгэлээ би/ хэмээх ёстой. Дараа нь боломж олдохын хирээр бүхий л зан ааш тааралдах үйлээс фарз болсныг нь өөрөөр хэлбэл, зарлигдсан хараам цээр бологчийг өөрөөр хэлбэл цээрлэж хорьсоныг мэдэх нь фарз буюу гарцаагүй үүрэг болно.

Эдгээрийг сурах мөн фарз хийж хараамаас зайлсхийх нь фарз болохыг үгүй гэвэл өөрөөр хэлбэл итгэхгүй бол имаан холдно. Эдгээр сурсныхаа нэгийг нь таалахгүй бол үл хүлээн зөвшөөрвөл Муртед/ итгэл сүсгээсээ няцагч/ болно. Мүртед Ла илахе Иллаллах гэж хэлж Ислаамын ёсны зарим тушаалыг үйлдсэнээр жишээ нь намааз үйлдэж, мацаг барьж, хаж тийш явж сайн үйл буян хийснээрээ мусылмаан болохгүй. Энэ сайн үйлийн нөгөө ертөнцөд ямар ч ач тусыг үл үзнэ. Үгүйсгэсэн эсхүл итгээгүй зүйлдээ наманчлан гэмших хэрэгтэй.

Ислаамын номч мэргэд сурч итгэж захирагдах ёстой фарзаас гучин хоёр түүнчлэн тавин дөрвийг нь сонгон авчээ.

• ГУЧИН ХОЁР ФАРЗ •

Иманы болзол: 6
Исламын болзол: 5
Намаазын фарз: 12
Авдестийн фарз: 4
Гүслын фарз: 3
Тееммүмийн фарз: 2
Тееммүмийн фарзыг гурав хэмээгчид ч байдаг. Тэгвэл бүгд гучин гурван фарз болно.

Иманы шарт болзлууд /6/

1. Аллаах цор ганц гэдэгт итгэх.
2. Сахиусан тэнгэрүүдэд итгэх.
3. Аллахын илгээсэн судар номдуудад итгэх.
4. Аллаахын Пайгамбаар буюу элчүүдэд итгэх.
5. Шүүлтийн өдөрт итгэх.
6. Хувь тавьлан өөрөөр хэлбэл, сайн ба муу үйл Аллаахаас үүдэлтэй болоход итгэх.

Ислаамын шарт болзлууд /5/

1. Келиме-и шехадет хэлэх .
2. Өдөр бүр таван удаа намаз үйлдэх.
3. Эд хөрөнгийнхөө зекят ба өглөгийг өгөх.
4. Рамазан сард нэг сар мацаг барих.
5. Боломжтой бол амьдралдаа нэг удаа хаж явах .

Намаазын фарзууд /12/

А/ Гаднахь фарз долоо байна Эдгээрийг шарт ч гэнэ.
1. Абдестгүй байдлаас ангижрах цэвэрлэх.
2. Бохир завааныг цэвэрлэх.
3. Сетр-и аврет.
4. Истикбал-и Кыбле.
5. Вакт.

6. Нийет.
7. Ифтитах ба Тахриме Текбири.

В/ Доторх фарз тав байна. Эдгээрийг рүкн гэнэ.
8. Кыйам.
9. Кырат /уншлага/.
10. Рүкү.
11. Сежде.
12. Каде-й ахире.

Абдестийн Фарзууд /4/

1. Нүүрээ угаах.
2. Гараа тохойтой нь цуг угаах.
3. Толгойнхоо дөрөвний нэгийг месх хийх.
4. Хөлөө шагайтай нь хамт угаах.

Гүслын фарзууд /3/

1. Амаа угаах /мазмара/.
2. Хамраа угаах /истиншак/.
3. Бүтэн биеэ угаах.

Тееммүмийн фарзууд /2/

1. Жүнүбээс эсвэл абдестгүй байдлаас ангижрахын тулд нийет хийх.
2. Хоёр гарыг цэвэр шороонд цохиж нүүрээ месх хийх дахин хоёр гараа шороонд цохиж хоёр гараа гарын алганаас тохойгоо хүртэл арчих.

а. ТАВИН ДӨРВӨН ФАРЗ •

1. Аллаахын ганц гэдэгт итгэх.
2. Халал /цэвэр ариун/ аар хооллох ундлах.
3. Абдест авах.
4. Таван удаагийн намаз хийх.

5. Гусул угаал хийх.
6. Хүнс тэжээл Аллахаас үүдэлтэй гэж итгэх.
7. Ариун халаал цэвэр хувцас өмсөх.
8. Аллаахд найдан итгэн зориглох/тевеккүл/.
9. Байгаа бүхэндээ сэтгэл ханамжтай байх /канаат/.
10. Аллаахд хувь хишгийнхээ төлөө талархах.
11. Хувь тавиланг хүлцэн дагах.
12. Гай гамшигт тэсвэрлэх.
13. Нүглээ наманчлах.
14. Аллаахын төлөө мөргөл хийх.
15. Чөтгөрийг дайсангаа гэж үзэх.
16. Кураан-и керимын заалт зааврыг зөвшөөрөх.
17. Үхэл нь зайлшгүй гэдэгт итгэх.
18. Аллаахын нөхөрт нь нөхөр, дайсанд нь дайсан болох.
19. Аав ээждээ сайн үйл хийх.
20. Сайн үнэний зарлигийг гүйцэтгэх, нүгэлд саад болох.
21. Төрөл саднаа айлчлах.
22. Итгэл даатгалаас тэрслэхгүй байх.
23. Үргэлж Аллаахаас эмээж ферахыг /аальгүй ууртайг орхих.
24. Аллаах ба түүний Элчийг даган захирагдах.
25. Нүглээс зугатаж ибадет хийх.
26. Мусылмаан ноёдыг даган захирагдах.
27. Энэ ертөнцийг хичээл сургамж гэж харах.
28. Аллаахын буйг бодох.
29. Хэл үгээ завхайралтай холбогдох үгээс хамгаалах.
30. Зүрх сэтгэлээ цэвэр байлгах.
31. Хэнийг ч элэглэн шоолохгүй байх.
32. Хараам цээрийг харахгүй байх.
33. Мүмин бүх нөхцөлд үнэнч байх.
34. Чихээ тэрслүү буруу номыг сонсохоос хамгаалах.
35. Эрдэм ном сурах.
36. Жигнэж хэмжих багажаа үнэний дагуу хэрэглэх.
37. Аллаахын зовлонгоос итгэлтэй байж үргэлж айх.
38. Мусылмаан ядууст зекят өгч туслах.
39. Аллаахын нигүүлслээс найдвар тасрахгүй байх.
40. Тачаалын хүсэлд захирагдахгүй байх.
41. Аллаахын төлөө өлсгөлөн хүмүүсмйг хооллох.

42. Хангалттай хэмжээнд хүнс хоолоо олох гэж ажиллах.
43. Эд хөрөнгөнийхөө зекят, ургацынхаа ушрыг өгөх.
44. Сарын тэмдэг цус гарах эхнэрт ойр үл байх.
45. Зүрх сэтгэлээ нүглээс цэвэрлэх.
46. Ихэрхэн сайрхахаас зайлсхийх.
47. Идэр насанд хүрээгүй өнчисийн эд хөрөнгий нь хамгаалах.
48. Залуу хөвгүүдтэй ойр үл байх.
49. Таван удаагийн намаазыг цаг тухайд нь хийж казад үлдээхгүй байх.
50. Мөлжлөг дарлалаар хэний ч эд хөрөнгийг идэхгүй байх.
51. Аллаахаас гадна өөр тэнгэр шүтэхгүй байх.
52. Буруу хурьцан садарлахаас зайлсхийх.
53. Дарс ба согтоох ундаа уухгүй байх.
54. Дэмий хоосон тангараг андгай үл тавих.

• КҮФР БУЮУ ҮЛ ИТГЭХҮЙН ТУХАЙ •

Муу явдлын хамгийн өөдгүй нь Аллаахд итгэхгүй байх, шашингүй үзэлтэн болохуй юм. Итгэх хэрэгтэй зүйлд итгэхгүй байх нь күфр болно. Мүхаммед алейхисселамд итгэхгүй байх күфр болно. Мүхаммед алейхисселам Аллаахын зэргээс авчирч мэдээлдэг бүгдэд нь зүрх сэтгэлээрээ итгэж үг хэлээрээ ярьж хэлэхийг Имаан гэнэ. Хэлэхэд саад гарах үед хэлэхгүй байх нь өршөөгднө.

Имаан бий болохын тулд ислаамын ёсноо күфрийн шинж тэмдэг гэгдэх зүйлийг хэлэх, хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Ислаамын ёсны ахкамаас өөрөөр хэлбэл Ислаамын зарлиг хорионоос нэгийг нь хөнгөлөн үзэх Кураан-и керим ба сахиус тэнгэрүүд аль нэг Пайгамбаар элчийг “алейхимүссалеватү веттеслимат”ийг шоолон элэглэх нь күфрийн шинж тэмдэг болно. Үгүйсгэх өөрөөр хэлбэл сонсныхоо дараа итгэхгүй байх нотлохгүй байх гэсэн үг. Эргэлзэх ч гэсэн үгүйсгэл болно.

Күфр нь гурван төрөл байна.

I Сонсоогүй, бодоогүй тул кафир бологчдийн күфр нь / Күфри жехли/ болно. Жехл нь хоёр төрөл байна. Эхнийх нь амархан юм. Ийм хүн жахил гэдгээ мэднэ. Эдэнд буруу итикат болохгүй. Амьтан мэт болно. Яагаад гэвэл хүнийг амьтнаас ялгагч нь эрдэм ном ба мэдрэхүй бөлгөө. Эд амьтнаас ч дор юм. Яагаад

гэвэл бүтээгдсэн төрлийн утгаар эднээс илүү юм. Хоёрдох жехл нь /Жехл-и мүреккер юм. Буруу гажуу итгэл бишрэл юм. Грекийн философчдынх буюу мусылмаан нарын далан хоёр бидат буюу буруу ёстны бүлэг ил тодоор заасан зүйлд үл зохицох итгэл бишрэл нь ийм болно. Энэ харанхуй байдал урьдынхаасаа бүр өөдгүй юм. Эм эмчилгээ нь үл мэдэгдэх өвчин болно.

II Күфр-и жүхүдийе, күфр-и инади ч гэнэ. Мэдсээр байж зөрүүдлэн кафир болох явдал юм. Ихэрхүү сайрхуугаас эрх тушаалтан болох дуртайгаас эсхүл ичгүүрт нөхцөлд өртөхөөс айх шалтгаанаар гарч ирнэ. Фараон ба түүний нөхөд Византийн хаан Хераклийусийн /Херкүлес/ күфр ийм бөлгөө.

III Күфрийн гурав дахь төрөл нь Күфр-и хүкми юм. Ислаамын ёсны имаангүйн шинж тэмдэг гэх үг хэллэгийг өгүүлэн үйлийг нь хийгч зүрх сэтгэлдээ нотолсон ч гэлээ итгэсэн гэж хэллээ ч кафир болно. Исламын ёсны тушаасан зүйлсийг тазим тазимйг нь тушаасан зүйлийг тахкир күфр гэнэ.

1. Аллах тэнгэр огторгуйгаас эсвэл тэнгэрээс биднийг харж байна хэмээх нь күфр юм.
2. Чи намайг тамлан дарлаж буй шиг Аллаах ч чамайг зовоон тамлана хэмээх нь күфр юм.
3. Ийм нэг мусылмаан миний нүдэнд жүүд мэт гэх нь күфр болно.
4. Худал үгийг Аллаах мэдэж байгаа үнэн гэвэл күфр болно.
5. Сахиусан тэнгэрийг дорд үзэх зүйлийг хэлэх нь күфр болно.
6. Кураан-и керимийг тэр бүү хэл нэг үсгийг нь дорд үзсэн үг хэлэх, нэг үсэг нь ч болов үл итгэх нь күфр болно.
7. Хөгжим тоглож Кураан-и керим унших нь күфр болно.
8. Жинхэнэ Тора болоод Евангели сударт итгэхгүй байвал /Одоо жинхэнэ Тора ба Евангели судар байхгүй/ күфр болно.
9. Кураан-и керимийг дүрмийн гаднах үсгээр унших, Кураан энэ болно хэмээх нь күфр болно.
10. Пайгамбаар элч нарыг доромимлсон үг хэлэх күфр болно.
11. Кураан-и керимд нэр нь заагдсан хорин таван Пайгамбаар элч нараас “алейхимүссалеватү веттеслимат” хэн нэгэнд нь итгэхгүй байвал күфр болно.
12. Олон сайн үйл хийсэн хүнийг Пайгамбаараас илүү сайн хэмээвэл күфр болно.

13. Пайгамбаар Элч нар ядуу зүдүү байсан хэмээвэл күфр болно. Яагаад гэвэл тэд өөрийнхөө хүслээр ядуу амьдарсан.

14. Хэн нэгэн өөрийгөө Пайгамбаар Элч хэмээн хэлбэл үүнд итгэгчид ч гэсэн кафир болно.

15. Нөгөө ертөнцөд болох зүйлийг шоглон шоолох нь күфр болно.

16. Булш ба шүүгдэх өдрийн зовлонд /оюун ухаан шинжлэх ухаанд тохирох биш хэмээж/ үл итгэх нь күфр болно.

17. Ислаамын ёсонд итгэхгүй байх, би Диваажинг Аллаахыг хүснэ хэмээх нь күфр болно.

18. Ислаамын ёсонд үл итгэхийн шинж бэлгэ болох үг шинжлэхүй ухааны мэдлэгийг шашны мэдлэгээс илүү ач буянтай хэмээх нь күфр болно

19. Намаазыг үйлдсэн ч эс үйлдсэн ч хамт гэх нь күфр болно.

20. Зекят өглөг өгөхгүй гэх нь күфр болно.

21. Мөнгөний ногдол хүү халаал байсан ч болоосой гэх нь күфр болно.

22. Мөлжлөг дарангуй ёс халаал байсан ч болоосой хэмээх нь күфр болно.

23. Хараам болох эд хөрөнгийг ядууд өгч буян хүлээх, ядуу нь өгсөн мөнгө хараам болохыг мэдсээр байж өгөгчид буяны дуа унших нь күфр болно.

24. Имаам-и азам Эбү Ханифегийн сургаал номлол /кыйас ижтихад/ нь үнэн биш хэмээх нь күфр юм . Веххабичүүд иймийн тул кафир болж байна.

25. Алдарт сүннетүүдээс аль нэгийг нь үл таалах нь күфр болно.

26. Булш болоод индрийн /минбер/ минь хооронд Равда –и мутаххара Диваажингийн нэг цэцэрлэг байдаг гэх хадис-и шерифийг сонсонгуутаа би минбер чийрс мод /хасир/ ба булшнаас өөр зүйл үзэхгүй байна хэмээх нь күфр болно.

27. Ислаамын мэдлэгт үл итгэх эдгээрийг болоод шашны мэргэн багш нарыг дорд үзэх нь күфр болно.

28. Кафир болохыг хүсэгч хэн нэгэн үүнийг зорин хүссэн тэр агшинд кафир болно.

29. Бусдыг кяфир болохыг хүсэгч хэн нэгэн күфрд дуртай болоод хүсч байгаа бол күфир болно.

30. Күфрийн шалтгаан болдгийг мэдээд хүслээрээ күфр үгсийг хэлэгч күфир болно. Мэдэхгүйгээр хэлж байгаа бол номч мэргэдийн

олонхийн үзэхээр мөн л кафир болно.

31. Күфрийн шалтгаан болох үйлийг мэдсээр байж хийх нь күфр болно. Мэдэхгүйгээр хийлээ ч кафир болно хэмээгч эрдэмтэн мэргэд ч олон байдаг.

32. Бэлхүүсэндээ зүннар гэгдэх христосын санваартны бүсийг бүслэх, күфрт хамаатах зүйл өмсөх нь күфр болно. Наймаачин хүн дайнд ч болов хэрэглэх нь күфр болно. Эдгээрийг хошин шог бусдыг инээлгэхийн тулд тоглоом наргиан болгож хэрэглэх нь ч күфрийн шалтгаан болно.

33. Кафирчүүдийн баярын өдөр тэр өдөрт хамаарах зүйлийг тэд нар лугаа адилаар хэрэглэх, кафирт бэлэглэх нь күфр болно.

34. Ухаантай мэдлэгтэй уран зохиолч гэдгээ харуулахын тулд эсвэл хажуудах хүмүүсээ гайхуулах, инээлгэх, баярлуулах, шоолохын тулд хэлэх үгс буюу тэнгэр эзний эсрэг үгсээс / күфр-и хүкми/ айх хэрэгтэй. Хилэн урин тачаангуйгаар шунаж хэлсэн үгс ч ийм юм.

35. Гүтгэн хачлах хэн нэгэн би гүтгээгүй түүнд байгаа зүйлийг нь л хэллээ би гэвэл ингэж хэлэх нь күфр болно.

36. Хүүхэд байхад нь сүй тавьсан охин оюун ухаан бүрэн идэр насанд хүрэх үед имаан ба ислаамыг мэдэхгүй бол, асуухад хариулж чадахгүй бол эхнэр болох эрхээ алдах ба мюртед болно. Эрэгтэй ч мөн ийм бөлгөө.

37. Нэг мүминийг /шударга бусаар/ алуулсан эсвэл алуулахаар тушаал авсан хүнд зөв зүйтэй зүйл хийжээ чи гэж хэлэгч кафир болно.

38. Зайлшгүй алуулах ёсгүй хүнийг алуулах хэрэгтэй байсан гэх нь күфр болно.

39. Хэн нэгнийг зүй бусаар зодож алсан хэрцгий харгисийг чи зөв хийжээ ингэх нь зөв шударга гэх нь күфр болно.

40. Аллаах мэдэж байгаа чамайг хүүхдээсээ илүү хайрладаг гэж худал хэлэх нь күфр болно.

41. Өндөр албан тушаал бүхий мусылмаан хүн найтаахад үүнийг Йерхамүаллах гэх хүнд дээдсийн эсрэг ингэж хэлж болохгүй гэх нь күфр болно.

42. Үүрэг гэдэгт үл итгэж хөнгөнд үзэж намааз үл үйлдэх, мацаг үл барих, зекят үл өгөх нь күфр болно.

43. Аллаахын нигүүлсэл өршөөлөөс найдлага горьдлого таслах нь күфр болно.

44. Өөрөөр хараам цээр биш хожим гарч ирэх нэг шалтгаанаас болж хараам цээр байх эд таваар мөнгийг харам-ы ли гайрихи гэнэ. Хулгайлж хараам замаар ирсэн эд хөрөнгө ийм болой. Эдгээрийг хараам гэх нь күфр болохгүй Сэг, гахай, дарс мэт угаас хараам болох зүйлсийг харам-ы ли айнихи гэнэ. Эдгэрийг халал буюу ариун гэх нь күфр юм.

45. Хараам гэдэг нь илэрхий мэдэгдэх бүх нүглийг халаал гэх нь күфр юм.

46. Азаан жами фикх ном судар мэт ислаамын шашны үнэлж хүндэлдэг зүйлсийг дорчлон үзэх нь күфр юм.

47. Абдестгүй гэдгээ мэдэх боловч намааз үйлдэх күфр болно.

48. Мэдсээр байж кыблегийн эсрэг талд намааз үйлдэх күфр болно. Намаазыг кыблегийн эсрэг үйлдэх хэрэггүй хэмээгч кафир болно.

49. Нэг мусымааныг муулан хачлахын тулд кафир гэх нь күфр болохгүй, Кафир болоосой гэж хүсч хэлэх нь күфр болно

50. Нүгэл гэдгийг чухалд бодолгүйгээр нүгэл үйлдэх нь күфр болно.

51. Ибадет хийх хэрэгтэй гэдпэгт нүглээс болгооомжлох хэрэгтэй итгэхгүй байх нь күфр болно.

52. Цугласан татварыг султагийн эд хөрөнгө гэж итгэх нь күфр болно.

53. Кафир нарын шашны зан үйл ёслолыг таалах шаардлагагүй байхад зүннар бүслэх, күфр шинж тэмдгүүдийг хэрэглэх эдгээрд дурлан барьж үзвэл күфр болно.

54. Зөвшөөрлөөр нь тийм юм тийм хүнд байна эсвэл байхгүй кафир болоё, жүүд болое хэмээн андгайлсан бол тэр юм тэр хүнд байсан байгаагүй тэр хүн өөрийн зөвшөөрлөөр күфрт унах болно.

55. Буруу хурьцал, шуумарлах, оногдол ашиг хүү, худал хуурмаг гэх мэт бүх шашинд хараам болох зүйлийн тулд халаал байсан болоосой би хийх байсан гэж ерөөн хүсэх нь күфр юм.

56. Пайгамбаар нар алейхимюссалеватю веттеслимат итгэлээ би Адаам алейхисселам Пайгамбаар уу би мэдэхгүй гэх нь күфр болно.

57. Мүхаммед алейхисселамын сүүлчийн Пайгамбаар болохыг үл мэдэгч кафир болно.

58. Нэг хүн Пайгамбаар нарын хэлсэн зөв бол бид аврагдлаа гэвэл кафир болно. /Энэ үгийг эргэлзэх замаар хэлсэн бол кафир болно/

59. Хэн нэгэнд нааш ир намаз үйлд гэвэл тэр хүн үйлдэхгүй гэвэл кяфир болно. Үгүй, чиний үгтэй санал үл нийлнэ. Аллаахын тушаалаар би үйлднэ гэвэл кафир болохгүй.

60. Хэн нэгэнд сахлаа нэг баримаас богино бүү болго Нэг баримаас их бол хус, хумсаа ав, Ресүллүллах саллаллахү теаля алейхи ве селлемийн сүннет юм гэвэл тэрбээр үгүй сахлаа авахгүй гэвэл кафир болно. Бусад сүннетүүд ч ийм болно. /Чиний үгээр үйлдэхгүй харин Ресүллахын сүннет болох тул үйлдэнэ гэвэл кафир болохгүй. Үгүйсгэх зорилготой бол кафир болно.

Хэн нэгэн сахлаа богиносгоход хажуудах хүн юунд ч хэрэггүй гэвэл тэрхүү хэлээчин кафирээс айх хэрэгтэй. /Сахлаа богинисгох нь сүннет юм. Сүннетийг хөнгөлөн үзсэн болно./

62. Хэн нэгэн толгойгоосоо хөлөө хүртэл харир /торго/ өмсвөл өөр хэн нэгэн энэхүү байдлыг ариун болог хэмээвэл күфрээс нь айх хэрэгтэй.

63. Хэн нэгэн кыблегийн эсрэг хөлөө тэнийлгэн хэвтэх, кыбле тийш нулимах эсвэл кыбле тийш шээх гэх мэтээр ямар нэг мекрүхийг үйлдвэл тэр хүнд энэ хийсэн чинь мекрүх юм бүү үйлд гэхэд тэр бээр нүгэл бүр минь ийм хэр байсан ч бол гэвэл түүний күфрээс айх хэрэгтэй.

64. Хэн нэгний үйлчлэгч нь хаалгаар дотогш ороод эзэнтэйгээ мэндлэхэд эзнийх нь хажууд агч нэгэн дуугаа тат. Эзэнтэйгээ мэндчилж болно гэж үү хэмээвэл тэр хүн кафир болно. Гэхдээ түүний зорилго нь зүй ёсын дүрмийг тайлах байсан бол зүрх сэтгэлээсээ мэндчлэх хэрэгтэй гэх нь күфр болохгүй.

65. Имаан нэмэгднэ хорогдно хэмээх нь күфр юм. Гэхдээ төгс төгөлдөр бүрэн мэдэж хэлбэл күфр болохгүй.

66. Кыбле хоёр байна нэг нь Кабе нөгөө нь Күдүс гэх нь күфр юм. Гэхдээ Бейт-и Мукаддес кыбле байсан, дараа нь Кабе кыбле болсон. Одоогийн байдлаар хоёр байна гэх нь ч күфр болно.

67. Хэн нэгэн Ислаамын мэргэн багшид шалтгаангүйгэр үзэн ядан хараавал тэр хүний күфрээс айх хэрэгтэй.

68. Хэн нэгэн хоол идэхдээ ярихгүй байх галыг тавиглагч нарын /межүси/ сайн уламжлал болно гэвэл эсхүл сарын тэмдэг үзэгдэхэд эхнэр лүгээ хэвтэхгүй байх нь галд тавиглагч нарын хамгийн сайн нь гэвэл кафир болно гэлцдэг.

69. Хэн нэгэнд чи мүмин юм уу гэвэл тэр ч Эзэн Тэнгэр

соёрхно /иншаллах/ гэхэд залруулахгүй бол күфр юм.

70. Хэн нэгэн үр хүүхэд нь нас барсан хүнд Аллаахд чиний хүү хэрэгтэй байсан гэх нь күфир болно хэмээжээ.

71. Нэг эм бэлхүүсэндээ хар утас баглавал энэ юу вэ гэхэд нь зүннар юм гэвэл күфир болно.

72. Хэн нэгэн хараам хоол идэхэд Бисмиллах гэвэл кафир болно. Харам-и ли-айнихи тулд өөрөөр хэлбэл сэг, дарс гэх мэт хараамын хувьд ийм бөлгөө. Өөрөө харам үл болох харам-и ли –гайрихи тулд ийм биш бөлгөө. Дээрэмдсэн эд таваарыг идэхдээ бесмеле унших нь күфр болохгүй. Эд таваар өөрөө харам бус дээрэмдэх нь харам юм.

73. Хэн нэгний күфрт зөвшөөрөн хүлцэах күфр юм. Нэг хүнийг харааж Аллах чиний амийг күфр лүү аваачиг гэвэл кафир болох тухайд эрдэмтэн мэргэд санал зөрдөг. Күфртэй эвлэрэх нь күфр юм. Гэхдээ хэрцгий мөлжлөг нүглээс болж зовлонг үргэлжийн ба хүчтэй болог гэх эвлэрэл нь күфр биш юм.

74. Хэн нэгэн Аллаах мэднэ, ийм үйлийг хийгээгүй гэвэл гэтэл тэр үйлийг үйлдсэнээ мэдэж байвал күфир болно. Эзэн Аллаахыг үл мэдэгч гэж үзсэнд тооцогдоно.

75. Хэн нэгэн нэг эмийг гэрчгүйгээр сүй тавьбал тэрхүү эм Аллаах ба Пайгамбаар бидний гэрч гэвэл хоёул кафир болно. Учир нь манай Пайгамбаар саллаллахү теаля алейхи ве селллем" амьд байхдаа гайбыг мэддэггүй байв. Гайбыг мэддэг байсан гэх нь куфр болно. /Гайбыг Аллаах мэднэ. Түүний мэдүүлэгчид мэднэ/.

76. Хулгайлагдсан ба гайб зүйлийг мэднэ хэмээвэл хэлж итгэгч кафир болно. Надад жин мэдээ өгч байна гэхэд мөн кафир болно. Пейгамберүүд жин ч гэсэн гайбийг мэдэхгүй. Гайбийг Аллах ба Түүний мэдүүлсэн нь мэднэ.

77. Хэн нэгэн Аллаахд тангарагдахыг хүсвэл өөр хэн нэгэн би чиний Аллаахд андгайлахыг чинь үл хүснэ ёст үг, нэр төр, хүн чанарт тангараг талбихийг чинь хүснэ гэвэл кафир болно гэжээ.

78. Хэн нэгэн үл таалах нэгнийг чиний дүрс нягуур надад амь авагч мэт гэвэл кафир болно хэмээсэн байдаг. Яагаад гэвэл, амь авагч сахиус тэнгэр /Азрайл алейхисселам/ агуу их сахиус тэнгэр бөлгөө.

79. Хэн нэгэнд намааз үйлдэхгүй байх сайхан гэвэл кафир болно. Хэн нэгэн нэг хүнд алив намааз үйлд гэхэд нөгөөх нь миний хувьд

намааз үйлдэх хэцүү үйл гэвэл кафир болно гэлцдэг бөлгөө.

80. Хэн нэгэн Аллаах тэнгэр огторгуйд миний гэрч гэвэл кафир болно. Яагаад гэвэл, Аллаахд орон байр зааж тохоосон болж хувирна. Аллаах орон зайгаас үл хамаарах юм.

81. Аллаах эцэг гэх нь кафир болно.

82. Хэн нэгэн Расулаллаах саллаллахү алейхиве селлем хооллосны дараа ариун хуруугаа долоодог байсан гэвэл өөр хэн нэгэн үүнийг ичгүргүй хэрэг гэвэл кафир болно.

83. Хэн нэгэн Пайгамбаар алейхиссалатү весселам хар арьстай байсан гэвэл кафир болно. Хар нохойг араб хэмээн дуудах жоомыг хар Фатма хэмээх нь түгээмэл байдаг. Үүнийг тэвчих болгоомжлох хэрэгтэй

84. Хоол хүнсийг Аллаах хайрлан соёхрдог. Гэхдээ боол ч ажиллаж хөдлөх хэрэгтэй гэвэл энэ үг Аллаахаас өөр тэнгэрийг зөвшөөрөхүй юм. Учир нь боолын үйл хөдлөл ч Аллаахаас ирэлтэй бөлгөө.

85. Хэн нэгэн насрани буюу назарей болох нь жүүд болсноос Америк болсон нь, кафир болох коммунист болохоос илүү буянтай гэвэл кафир болно. Жүүд назарейгээс, коммунист христианаас илүү муу гэж хэлэх хэрэгтэй.

86. Кафир болох урван тэрслэхээс дээр гэвэл кафир болно.

87. Эрдэм мэдлэгийн хуралд миний хэрэг гэж юу байх вэ эсхүл эрдэмтэн мэргэдийн хэлснийг сонсоход хэний хүч хүрэх вэ гэвэл эсхүл шашны хууль номыг газар шидвэл санваартан нарын үг юунд ач тустай юм гэвэл кафир болно.

88. Хэн нэгэн күфр хэлбэл нэг хүн ч болов инээвэл инээгч хүртэл кафир болно. Инээх нь зайлшгүй бол күфр биш юм.

89. Хэн нэгэн өөд болооч шейх нарын сүнс үргэлж бэлхэн мэднэ гэвэл кафир болно. Бэлэн болно гэвэл күфр болохгүй. /Эвлийагийн сүнс Аллаах мэт бэлэн болж чадахгүй. Дурсагдсан газраа бэлэн болно. Дурсагдахаас өмнө тэнд байгаагүй юм/.

90. Ислаамын шажныг мэдэхгүй хүсэхгүй гэвэл кафир болно.

91. Хэн нэгэн Адаам алейхисселам буудай идээгүй байсан бол бид буруу мөртөнгүүд болохгүй байсан гэвэл кафир болно. Гэхдээ бид энэ ертөнцөд байхгүй байсан гэвэл күфрийн талаарх түүний бодол күфртэй зөрөлднө.

92. Адаам алейхисселам бөс нэхдэг байсан гэвэл нэг нь ч гэсэн ийм бол бид нэхмэлчний үрс хөвүүд юм байна гэвэл кафир болно.

93. Нэг хүн бага нүгэл үйлдвэл нөгөө нь түүнд наманчил гэхэд тэр хүн юу хийсэн болоод наманчлах юм гэвэл кафир болно.

94. Хэн нэгэн нөгөөдөө алив ислаамын мэргэдэд очъё эсвэл хууль зүй итгэл бишрэлийн сургаал ном судраас уншиж сурч мэдэё гэхэд тэр хүртэл би эрдэм номоор хэрхэх вэ гэвэл кафир болно. Учир нь эрдэм номыг дорд үзэн хөнгөлөх гэсэн үг.

95. Тайлбар ба хууль эрхийн номуудад доромжлон эдгээрийг үл таалагчид муулан хачлагчид кафир болно.

96. Хэн нэгэнд хэний удам билээ, аль шашных вэ итгэл бишрэлийн мезхебийн имаам хэн бэ, үйл үйлдлэгийн мезхебийн имам хэн бэ гэж асуухад мэдэхгүй бол кафир болно.

97. Хатуу хараамыг халаал гэгч кафир болно./Тамхийг хараам гэх нь аюултай бөлгөө/.

98. Бүх шашинд хараам болох халаал болох нь цэцэн мэргэний эсрэг нэгэн зүйлийг халаал болохыг нь хүсэх нь күфр юм. Буруу хурьцал шуумарлахуй, гэдсээ цадсаны дараа идэх хүү ногдол авч өгөх гэх мэт. Дарс халаал болоосой гэх нь күфр биш. Яагад гэвэл, шашин бүрт хараам байгаагүй.

99. Ариун Кураан судрыг үг яриа онигоо тоглоомд оруулах нь күфр юм.

100. Яхьяа нэрт хүнд Йа Яхьяа Хүз-ил –китабе гэвэл кяфир болно. Кураан-и керимийг шоглон доромжилсон болно. Хөгжим бүжиг дуу хооронд Кураан-и керимийг унших ч мөн ийм болой.

101. Одоо ирлээ, Бисмиллахи гэвэл осол цалгай юм. Нэг зүйлийг маш олон тоотой байхыг үзээд Махалакаллах гэвэл утгыг нь үл мэдэх бол кафир болно.

102. Хэн нэгэн одоо чамайг харахгүй хараахын нэрийг нүгэл гэдэг гэвэл осол цалгай болно.

103. Хэн нэгэн Жебрайлыг бяруу мэт шав шалдан болчихож гэвэл осол цалгай бөгөөд сахиус тэнгэрийг элэглэн тохуурхах гэсэн үг.

104. Миний хүүгийнхээ толгойгоор, өөрийнхөө толгой болоод үгээр тангараг талбихдаа жишээ нь хүүгийнхээ толгойгоор андгайлж байна хэмээж күфр хийхээс болгоомжлох хэрэгтэй.

105. Курраан-и керим ба залбирал магтаалыг /мевлид илахи/ хөгжимтэй унших нь күфр юм.

106. Кураан-и керим оршуулгын залбирал /мевлид илахи/ болоод

шашны эх бичвэрийг /салеват-и шериф/ нүглийн чуулган цуглаанд хүндлэн унших нь хараам юм. Зугаа таашаалын цэнгэлийн төлөө унших күфр болно.

107. Сүннетийн дээр унших Азан-и Мүхаммедийг сонсолгүйгээр хүндлэн үзэхгүй бол тэр даруй күфир болно.

108. Кураан-и керимд өөрийн оюун ухаанаар утга оноогч күфир болно.

109. Кураан-и керим ба хадис-и шерифүүдэд илэрхийгээр заасан мюжтехид имаамуудын үг санал нэгтэйгээр мусылмаанчуудын хооронд түгсэн имааны мэдлэг сургаалыг даган зохицон үл итгэх кафир болно. Күфрийн энэ төрлийг Илхад, ийнхүү итгэгч нарыг Мүлхид гэнэ.

110. Кафирийг хүндлэн мэндчилэгч күфир болно.

111. Кафирд хүндлэлийг үг хэлэх жишээ нь дээдэс минь гэх нь күфр болно.

112. Бусдын күфрийг зөвшөөрөн хүлцэгч кафир болно.

113. Күран-и керим бичигдсэн транспарант плакатууд тэнгэрийн эх бичвэрүүд мэт /мүсхаф- и шериф / үнэтэй юм. Тэднийг хүндлэхгүй байх нь күфр юм.

114. Жинүүд лүгээ танилцан мэргэ төлөгчид, одны ордыг харж асуусан бүхэнд хариулагчид ид шидтэн рүү очиж хэлж хийж байгаад нь итгэх зарм үед зөв боллоо ч гэсэн Аллаахаас бусдыг бүхнийг мэддэг, хүссэн бүгдийг хийдэг гэж итгэх күфр болно. /Байгалийн ухаанд үл итгэх нь ийм бус/.

115. Сүнетийг хөнгөнд үзэж үл чухалчилж орхих нь күфр болно.

116. Зүннар гэх христийн санваартны бүсийг бүслэх рүт өөрөөр хэлбэл хэрээс тэмдэг салиб гэгдэх цэх хэрчигдсэн хоёр саваа ба баримал эдгээрийн зурагт итгэх тазим хийх, ахкам-и исламиййег буюу шариат хууль ёсыг заасан шажны ном судраас нэгийг дорд үзэх, ислаам эрдэмтэн мэргэдээс хэн нэгийг нь эсэргүүцэн доромжлон шоолох, күфрийн шалтгаан болох үг хэлэх, бичих, тазим хийхээр зарлиг болсон нэг зүйлийг багачлах гэж тушаагдсан зүйлийг хүндлэх нь күфр юм.

117. Нэг бөөлөгч ид шидтэн ид шидээрээ хүссэнээ мэдээж хэрэг хийнэ ид шид нь зайлшгүйгээр нөлөөтэй гэх нь күфр юм.

118. Мусылмаан өөрийг нь кафир хэмээгчийг эрхэм хүндэт гэхчлэн хүлээн зөвшөөрсөн хариулт өгвөл кафир болно.

119. Хараам гэдэг нь мэдэгдэх тодорхой нэг эд бараагаар жами бариулах, садака өглөг өгөх нь, өөр нэгэн буян хийлгэх нь үүнийхээ төлөө буян хүлээх нь күфр болно.

120. Хэн нэгэн өөрт нь байх хатуу хараам болох эд таваараас садака өгвөл буян найдвал авагч кафир хараам гэдгийг мэдсээр байж өгөгчийг Аллаах зөвшөөрөг гэвэл өгөгч ч гэсэн өөр хэн нэгэн амин гэвэл бүгд күфир болно.

121. Сүй тавих нь хараам болох эмэгтэйтэй гэрлэхийг хараам гэвэл кафир болно.

122. Шар айрагны, тоглоомын газар нүгэл үйлдэх бүлэглэлд радиогоор өсгөгчөөр Кураан-и керим мевлид буюу шашны бичвэр судрыг сонсгож сэтгэл таашаах кафр болно.

123. Кураан-и керимийг хөгжимдөн унших күфр болно.

124. Куран-и керимийг радио болон өсгөгчөөр хэлэх унших нь яг адилыг нь ч доромжилсон күфр болно.

125. Аллаахаас өөр хэнийг ч ямар ч зорилготой байсан Бүтээгч гэх нь күфр юм.

126. Абдүлкадирийн оронд Абдүл койдүр гэх зориудын бол күфр юм. Абдеүлазизийн оронд Абдүлүзейз, Мүхаммедийн оронд Мемо, Хасаны оронд Хасо, Ибрхимийн оронд Ибо гэх нь ийм бөлгөө. Эдгээр нэрийг гутал ба гэрийн шаахай дээр бичих дээр нь гишгэгчдийн имаан нь зайлахаас айх хэрэгтэй.

127. Абдестгүй болохыг мэдээд намааз үйлдэх сүннет болох нэг үйлийг таалахгүй байх нь күфр юм. Сүннетийг чухалд үл тооцох нь күфр юм.

128. Харанхуй бүдүүлгүүд Ариун номч нарыг /Эвлия/ бүтээгч гэж бодохоос эмээдэг тул бид тюрбег нурааж байна гэх нь күфр болно.

129. Бусдын ялангуяа өөрийн үр хүүхдийнхээ кяфир болоход шалтгаан бологч кафир болно.

130. Буруу хурьцал ба шуумарлахыг соёрхогдсон гэх нь күфр болно.

131. Нассаар өөрөөр хэлбэл айет ба хадисаар санал нэгтэйгээр өгүүлсэн хараам цээрийг чухалд үл тооцох нь күфр болно.

132. Их нүглийг үргэлжлүүлэх зүтгүү байх нь күфр лүү хөтлөн авачна. Намаазыг үл чухалчлах нь күфр юм.

133. Дээр нь бичиг тэр бүү хэл үсэг байх цаасыг бүтээлэг

залбирлын дэвсгэрийг /сежжаде/ газар тавих/доромжлохын тулд дэлгэх эсвэл хэрэглэх/ күфр болно.

134. Эбү Бекр-и Сыддык ба Омар –үл- Фарүк радыйаллахү теаля анхүмийн хилафетд эрх байхгүй байсан гэх нь күфр болно.

135 Аллаахаас тусдаа алив нэг үхсэн хүнээс алив нэг зүйл хүлээх нь күфр болно.

136. Хурдан өгөгч деде хэмээх нь маш муухай бөгөөд күфрийн шалтгаан болно.

137. Өөд бологчийг газарт булах фарз болох тул энэхүү фарзыг үл чухалчлан үйлчлэл асралаас зугатагчийн эрдэм шинжлэх ухааныг зааж үхэгчдийг оршуулах хуучирч хоцоргдсон ёс юм. Будда, бярман, коммунист, кафир нар шигээр үхэгсдийг шатаах илүү сайн гэгчийн имаан нь зайлах ба мүртед болно

138. Аллаахын Асрамжлагч /Вели/ нараас үхсэн ба амьд нэгийг хэл хэлмэр, зүрх сэтгэлээрээ үгүйсгэх нь куфр болно.

139. Ариун номлогч нарт /Эвлия/ эрдэм мэдлэгээрээ нөлөө үзүүлэгч нарт дайсангах нь күфр юм.

140. Ариун номлогч нарт цэвэр тунгалаг шинж чанар байна гэх нь күфр юм. /Цэвэр тунгалаг шинж зөвхөн Пайгамбаар нарт байна/

141. Эрдэм номыг дотроос нь үл хүртэгч имаангүй одох аюултай. Үүнээс хүртэхийн хамгийн доод нь энэхүү эрдэмд итгэх явдал юм

142. Күүраан-и керимийг шашны мэргэдээс хэн нь ч уншаагүй хэлбэрээр унших, утга ба үгийг эвдээгүй ч гэлээ күфр юм.

143. Христийн санваартан нарын ибадетд хамаарах зүйлийг хэрэглэх нь күфр юм.

144. Ямар нэгэн үйл явдлыг өөрөө өөртөө болоход итгэх амьтдын нэг эстээс дээд бүтэцтэн рүү эцэстээ хүн болж хувирсан гэж хэлэх нь күфр юм.

145. Намаазыг мэдсээр байж үл үйлдэж каза хийхийг үл бодон үүний төлөө зовлонд унахаас үл айгч хүн Ханефи мезхебт ч кафир юм.

146. Кафир нарын ибадетүүд ибадет болгон хийх жишээ нь христийн сүмд эгшиглэх орг мэт хөгжмийн зэмсэг хонх хэнгэргийг самид дугаргах мөн ислаамын шашны кафирийн шинж тэмдэг гэж тооцох зүйлийг зайлшгүй гарцаагүй бусаар хэрэглэх нь күфр юм.

147. Асхаб-и кырамыг хараагч мюльхид нь күфр.

148. Кафирийн зургийг дээр газар өлгөх түүнд мэхийх нь күфр.

149. Зураг баримлын эзэнд хэрээс тэмдэгт эсхүл од нар үхэр гэх мэт ямар нэгэн зүйлд Аллахыи шинж байгаа хэмээн итгэж жишээ нь хүссэнээ бүтээнэ, хүссэн болгоноо хийнэ, өвчтөнийг илааршуулна гэж мэхийх нь күфр болно.

150. Гэгээн Айшег эсэргүүцэн янхан хэмээгч хүн эцгийнх нь өмгөөлөл байдагт үл итгэгч кафир болно.

151. Иса алейхисселамын /ерөөн адистсан/ тэнгэрээс буух нь зайлшгүй мэдэгдэж байна. Үүнд үл итгэгч кафир болно.

152. Кураан-и керим ба хадис-и шерифт Диваажинтай цуг баярт мэдээ өгсөн хэн нэгнийг кяфир гэх нь күфр юм.

153. Шинжлэх ухаан туршлагын гадна байх байгалийн ухаантай холбоогүй аят-и керимег байгалийн ухаантай нийцүүлэх гэж оролдох нь Селеф-ми салихин тайлбаруудыг өөрчлөх агуу том гэмт хэрэг юм. Ийм тайлбар орчуулга хийгчид кафир болно.

154. Мусылмаан хэмээгдэгч охин оюун ухаан бүрэн идэр настай болонгуут мусылмааны ёсыг мэдэхгүй бол үндэс угсаагүй кафир болно. Эрэгтэй хүн ч үүнтэй адил.

155. Мусылмаан эмэгтэйн толгой, гар, гуя нь задгайгаар гадагшаа гарах, эрчүүдэд харуулах нь хараам нүгэл юм. Үүнийг чухалд тооцохгүй бол үл анзаарвал имаан холдон зайлж кафир болно.

156. Манай Пайгамбаарын заах фарз хараам гэх мэт нь Кураан-и керимд ил тодоор заасан фарзууд үнэ цэнэтэй юм. Эдгээрт үл итгэгчид, үл зөвшөөрөгчид шашнаасаа холдох ба кафир болно.

157. Рүкү тесбихд /Зы/ аар /азым гэх Раббим их гэсэн үг. Хэрвээ хэлний урдуурх /Зе/ авиагаар азим гэвэл Миний Раб миний дайсан гэсэн болох ба намааз бусниж утга нь өөрчлөгдөх тул күфрийн шалтгаан болно.

158. Куран-и керимийг хөгжимдөн ая дангаар унших хафиз уншигчийг ямар сайхан уншив чи гэх хүний имаан нь зайлах ба кяфир болно. Дөрвөн мезхебд харам болох зүйлийг сайхан гэгч кафир болно. Харин хоолой дуу Кураан-и керимийг унших сайхан гэх нь хүсэгч кафир болохгүй.

159 .Сахиусан тэнгэр болон жинийн оршихуйд үл итгэгч мөн адил.

160. Күран-и керимийн аятүүдэд үг ил тодорхой бүхэнд мэдэгдэх утга байдаг.

161. Ид шид хийхэд күфрийн шалтгаан үг үйлдэл бий болвол күфр юм.

162. Мусылмааныг хөөе кафир гэгч эсвэл мусылманыг масон гэгч коммунист гэгч түүнийг кафир итгэн биширвэл өөрөө кафир болно.

163. Ибадетийг хийгч хэн нэгэн имаан нь бусних эргэлзэж миний нүгэл их, миний ибадет намайг үл аврана гэж бодвол имаан нь хүчтэй болох нь ойлгогдно. Имаан нь үргэлжлэхээс эргэлзэгч кафир болно.

164. Пайгамбаруудын тоог хэлэх, Пайгамбаар биш бологчийг Пайгамбаар болгогч, Пайгамбаарыг Пайгамбаар гэж хүлээн зөвшөөрөхгүй байх нь байж болно. Энэ нь күфр болно. Яагаад гэвэл Пайгамбараас нэгнийг нь хүлээн зөвшөөрөхгүй байх нь бүгдийг нь хүлээн зөвшөөрөхгүй байна гэсэн үг.

Эр эм нэг мусылмаан хүн мэргэдийн үг дуу нэгтэйгээр күфрийн шалтгаан болох мэдүүлсэн нэг үг үйлдлийг күфрийн шалтгаан болохыг мэдээд заналхийлэлгүйгээр хүслээрээ /үнэнээсээ инээлгэхийн тулд хэлж хийвэл утгыг нь бодохгүй байлаа ч имаан нь зайлна. Мүртед болно. Үүнийг күфр-и инади /тэрслүү зөрүүд / гэнэ. Күфр-и инади ба шашнаас тэрслэгч болоочийн урьдах ибадетүүдийн буяныг үгүй хийнэ. Наманчлавал буцаж үл ирнэ. Баян чинээлэг бол дахин хаж руу явах хэрэгтэй болно. Мүртед /Бурхныг үгүйсгэгч/ байхад хийсэн намаз, мацаг, өглөгийг каза хийхгүй. Урьдахыг нь каза хийнэ. Наманчлахын тулд зөвхөн Келиме-шехадет өгүүлэх нь хангалттай биш. Күфрийн шалтгаан болох тэр зүйлээс ч тевбе хийх хэрэгтэй. /Ислаамын ёсноос аль хаалгаар гарсан бол тэр хаалгаар орох хэрэгтэй/ Хэрвээ күфрийн шалтгаан болохыг мэдэлгүйгээр хэлж үйлдвэл эсвэл күфрийн шалтгаан болох нь мэргэдийн хоорондмаргаантай байгаа нэг үгийг мэдсээр байж хэлбэл иман нь холдож сүй бусних нь эргэлзээтэй юм. Болгоомжтойгоор теждид-иман ба сүй хийх нь сайн юм. Мэдэлгүйгээр хэлэхийг Күфр-и жехли хэмээнэ. Мэдэхгүй байх нь шалтаг бус их нүгэл юм. Яагаад гэвэл мусылмаан хүн бүр мэдэх хэрэгтэй зүйлийг сурах нь фарз буюу гарцаагүй юм. Күфрийн шалтгаан болох үгийг алдаа гарган эндүүрч эсвэл утгыг хувирган хэлэгчийн имаан ба сүй үл буснина.

Гэхдээ наманчлан ба өршөөл гуйх нь өөрөөр хэлбэл теждид-и иман хийх нь сайн юм.

Нэг кафир нэг келиме-и тевхид хэлснээрээ мүмин болхын зэрэгцээ нэг мүмин ч нэг үг хэлснээр кафир болно.

Нэг мусылмаан хүн нэг үг ба үйлдэлдээ зуун утгатай бол өөрөөр хэлбэл зуун зүйл ойлгогдвол эдгээрээс нэг нь тэр хүний имаантай болохыг үзүүлбэл ерэн ес нь кафир болохыг үзүүлбэл тэр хүний мусылмаан болохыг хэлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл күфрийг үзүүлэх ерэн есөн утгыг үл харна. Имааныг нь үзүүлэх нэг утгыг харах хэрэгтэй. Энэхүү үгийг буруу ойлгох ёсгүй. Үүний тулд хоёр цэгийг анхаарах хэрэгтэй. Эхнийх нь үг ба үйл хэргийн эзэн нь мусылмаан хүн байх хэрэгтэй. Нэг Франц хүн Кураан-и керимийг магтвал нэг Англи хүн Аллах нэг юм гэвэл эднийг мусылман гэж хэлж болохгүй. Хоёрдугаарт нэг үг ба үйл хэргийн зуун утга байвал гэсэн бөлгөө. Түүнээс биш, зуун үг зуун үйлээс нэг нь имааныг үзүүлбэл ерэн ес нь күфрийг заавал энэ хүнийг мусылмаан гэж хэлнэ хэмээгээгүй бөлгөө. Мусылмаан хүн бүр өглөө орой энэхүү имаан дуаг унших хэрэгтэй:
“АЛЛАХҮММЕ ИННИ ЕУЗҮ ВИКЕ МИН ЕН ҮШРИКЕ ВИКЕ ШЕҮ –ЕН ВЕ ЕНЕ АДЛЕМҮ ВЕ ЕСТАГФИРҮ – КЕ ЛИ-
МА ЛА-АЛЕМҮ ИННЕКЕ ЕНТЕ АЛЛАМҮЛ-ГҮЙҮБ”

“АЛЛАХҮММЕ ИННИ ҮРИДҮ ЕН ҮЖЕДДИДЕЛ ИМАНЕ ВЕННИКАХА ТЕЖДИДЕН БИ КАВЛИ-ЛА ИЛАХЕ ИЛЛАЛЛАХ МҮХАММЕДҮН РЕСУЛУЛЛАХ” гэж тевбе теждид-имаан ба сүй хийх хэрэгтэй.

Имаан үргэлж бидэнд үлдэж биднээс холдохгүйн тулд:

1) Үл үзэгдэх ертөнцөд /гайб/ имаан хийх хэрэгтэй.
2) Үл үзэгдэх ертөнцийг зөвхөн Аллаах ба Түүний мэдээлснийг мэднэ хэмээн итгэх хэрэгтэй.
3) Хараамыг хараам гэж үзэн итгэх хэрэгтэй.
4) Халаалыг халаал гэж үзэж итгэх.
5) Аллаахын гэсгээл үгүй хэмээн итгэлгүйгээр цаг үргэлж айж байх ёстой.
6) Аллаахаас горьдол найдлага тасалж болохгүй.

Итгэл бишрэлээс ухрал болох зүйлийг үгүйсгэх нь наманчлал болно. Итгэл бишрэлээс няцагч хүн наманчлахаасаа өмнө нас нөгчвөл Тамын галд үүрд мөнх зовлон үзнэ. Иймийн тул, күфрээс ихэд айх хэрэгтэй. Бага ярих хэрэгтэй. Хадис-и шерифт Үргэлж

сайн ашиг тустай яригтун. Эсвэл дуугүй байгтун хэмээн зарлигласан билээ. Төлөв буурьтай байх хэрэгтэй, шогч тоглоомч байх хэрэггүй. Оюун ухаан, хүний ёсонд үл зохих зүйлийг үйлдэхгүй байх хэрэгтэй. Өөрийгөө күфрээс хамгаалахын тулд Аллаахд ихэд дуа уншлага хийх хэрэгтэй.

Өдгөө имаан нь байх авч ирээдүйд Имаан холдохын шалтгаан болох зүйлс:

1) Бидаттай байх. Өөрөөр хэлбэл итгэл эмхгүй болох /Эхл-и сүннэт мэргэдийн заасан итгэл сүсгээс маш бага болох хэмжээгээр салагчид гажигчид буюу кафир болно.

2) Сул өөрөөр хэлбэл үйл хэрэггүй итгэл сүсэг.

3) Есөн эрхтнээ зөв хөдөлгөн үйлдэхээ болих.

4) Томоохон нүгэл хийсээр байх.

5) Ислаамын буян хишигт талархахаа болих.

6) Нөгөө ертөнц тийш итгэл сүсэггүй явахаас айхгүй байх.

7) Мөлжин дарангуйлах.

8) Сүннетийн дагуу унших эзани -Мухаммэдиг сонсохгүй байх.

9) Ээж ааваа эсэргүүцэн тэрслэх.

10) Зөв ч гэсэн олон удаа тангараг өргөх.

11) Намаазд биеийн хөдөлгөөнөө өөрчлөх дүрэм журмыг зөрчих.

12) Намаазыг чухал бишд тооцон сурч хүүхэд багчуулд сургахыг чухалчлахгүй байх, намааз хийгчдэд саад болох.

13) Согтууруулах ундаа уух.

14) Мүмин нарыг зовоон тарчлаах.

15) Хуурамчаар ариун номлох, өөрөөр хэлбэл шашны мэдлэг арилжаалах.

16) Нүглээ мартаж ялимгүйд тооцох.

17) Ихэрхэх өөрөөр хэлбэл биеэ тоох.

18) Үжүб өөрөөр хэлбэл эрдэм ном үйл хэрэг минь олон хэмээх.

19) Мунафик байх хоёр нүүртэй байх.

20) Атаархан хорсох шашин нэгт ахан дүүдээ атаархах.

21) Төр засаг болоод багштийнхаа ислаамын ёсонд эсрэг үйл хийх.

22) Хэн нэгнийг танихгүй байж сайн хэмээх.

23) Худал хуурмагт зүтгэн шаардах.

24) Эрдэмтэн мэргэдээс зугатах.

25) Жирвээ буюу сахлаа сүннетийн хэмжээнээс хэтрүүлэн ургуулах.

26) Эрчүүд торго өмсөх.

27) Ховлон гүтгэхээр шаргуучлах.

28) Тэрслүү буруу номтон ч бай хөршөө дарангуйлан зовоох.

29) Дэлхийн үйл хэргийн төлөөнөө ихэд зовж уурлах.

30) Мөнгөний хүү авах өгөх.

31) Онгирон сагсуурах гэж хувцасныхаа ханцуй хормойг хэт уртастгах.

32) Мэргэ төлөг ид шид үзүүлэх.

33) Мусылмаан ба үнэн номын ойр төрөл ах дүүгээ айлчлахаа болих.

34) Аллаахын хайртай хэн нэгнийг үл хайрлах, ислаамын ёсыг бусниулахыг хүсэгчдийг хайрлах /ХУББ-И ФИЛЛАХ БУГД-И ФИЛЛАХ иманы болзол юм./

35) Мүмин ах дүүгээ гурван өдрөөс илүүгээр өшлөн хясах.

36) Буруу хурьцахуйгаа үргэлжлүүлэх.

37) Шуумарласан боловч үл наманчлах.

38) Азааныг хууль ёсны номонд мэдүүлсэн цагт сүннетийн дагуу үл унших, сүннетийн дагуу уншсан азааныг дуулмагц хүндэтгэн сонсохгүй байх.

39) Шашин номыг үгүйсгэгч хараамыг үйлдэгчийг хараад хүч чадал хүрэх боловч эвэргүү яриагаар хорихгүй байх.

40) Эхнэр охины ба зөвлөх эрхтэй эмэгтэйчүүдийн толгой гар хөл ил задгай ганган хээнцэр үнэртэн үнэртүүлж гадагшаа гарах муу улстай уулзахыг зөвшөөрөх.

• ИХ НҮГЭЛ ОЛОН ОЛОН •

/Далан хоёр их нүгэл доорх болно/

1) Шударгуу бусаар хүн алах.

2) Буруу хурьцах.

3) Шуумарлан бандидах.

4) Дарс болоод бүх төрлийн согтууруулах ундааг хэрэглэх.

5) Хулгай хийх.

6) Таашаалын төлөө мансуурах бодис идэж уух.

7) Бусдын эд хөрөнгийг хүчээр авах өөрөөр хэлбэл дээрэмдэх.

8) Худлаа гэрчлэх.

9) Рамазаны мацгийг шалтгаггүйгээр мусылмаанчуудын өмнө идэх.

10) Ногдол ашиг хүү авч өгөх.

11) Ихэд тангараг тавих.

12) Ээж аавдаа тэрслэх эсэргүүцэх.

13) Ойр төрлийн ба номын ёст төрөл саданд, төрсөн газраа айлчлахаа болих.

14) Дайн байлдаанд тулаалданыг орхиж дайснаас зугатах.

15) Шударга бусаар өнчидийн эд хөрөнгийг идэх.

16) Жигнүүр хэмжүүрийг үнэнчэр үл хэрэглдэх.

17) Намаазыг цаг хугацаанаанд нь үйлдэхгүй байх.

18) Мүмин ах дүүгээ гомдоох /Кабег нураахаас илүү том нүгэл юм. Аллаахыг хамгийн ихээр гомдоох, күфрийн дараа хүнийг гомдоох шиг том нүгэл үгүй/.

19) Расулуллаах саллаллахү алейхи ве селлемийн хэлээгүй үгийг хэлэх.

20) Хээл хахууль авлига авах.

21) Аллахын гэрчлэлээс /Хак шехадет/ зугатах.

22) Эд таваарын зекят өглөг ушр/эд хөрөнгө ургацын татвар/ өгөхгүй байх.

23) Хүч нь хүрэх хэн нэгэн шашныг үгүйсгэгчийг нүгэл үйлдээчийг харангуутаа үл хориглох.

24) Амьд амьтныг галд шатаах.

25) Агуу их алдар цуут Курааныг сурсныхаа дараа уншихыг мартах.

26) Агуу их алдар цуут Аллаахын нигүүлслээс горьдлогоо таслах.

27) Мусылман ч бай кафир ч байг хүмүүсээс урван тэрслэх.

28) Гахайн мах идэх.

29) Ресүллүллах ын Асхаб ойр шадар нар буюу “рыдванүллахи теаля алейхим эжмагаас” хэн нэгэнд дургүйцэх, хараан зүхэх.

30) Гэдэс нь цадсанаас хойш үргэлжлүүлэн идсээр байх.

31) Эхнэрүүд эрийнхээ ороос зугатах.

32) Эхнэрүүд нөхрөөсөө зөвшөөрөлгүйгээр зочлохоор явах.

33) Ариун явдалт эмэгтэйг бузар эм хэмээх.

34) Хов жив өөрөөр хэлбэл мусылмаан нарын хооронд үг зөөх.

35) Ичимхий газраа бусдад үзүүлэх /Эрэгтэй хүний/бусдын

ичимхий газрыг харах ч хараам болно.

36) Сэг идэх бусдад идүүлэх.

37) Даатган итгэлээс урван тэрслэх.

38) Мусылманыг далдуур муулах.

39) Атаархах.

40) Агуу их алдар цуут Аллаахаас өөр олон Тэнгэрт бишрэх шүтэх.

41) Худал хэлэх.

42) Сайрхах биеэ тоох ихэрхэх.

43) Үхлийн өвчтэй нэгний өвлөгчөөс эд таваар хулуух.

44) Харамч бөгөөд ихэд өчүүхэн муу болох.

45) Энэ ертөнцөд дурлан тэмүүлэх.

46) Аллаахын зовлонгоос үл гэлмэх.

47) Хараам цээр зүйлийг хараам эсэхэд итгэн бодохгүй байх.

48) Халаал ариун зүйлийг халал гэж итгэн бодохгүй байх.

49) Мэргэ төлгөчдийн мэргэд гайб/үл мэдэх ертөнц/аас мэдээ өгөхүйд итгэх.

50) Шашнаас буцах, шашнаас гарах.

51) Шалтаггүйгээр харь эм болоод охиныг харах.

52) Эмс эрчүүдийн хувцас өмсөх.

53) Эрчүүд эмсийн хувцас өмсөх.

54) Кабегийн харемд нүгэл үйлдэх.

55) Цаг нь болоогүй байхад азаан унших, намаз үйлдэх.

56). Төрийн түшээдийн тушаал хууль цаазанд тэрсэлдэн эсэргүүцэх.

56) Эхнэрийнхээ ичимхий газрыг эхийнхээ ичимхий газар лугаа адилтгах.

57) Найз нөхрийнхөө эхийг хараах.

58) Бие биенээ бууны нүхээр шагайх.

59) Нохойн ялгадас идэх уух.

60) Хийсэн сайн үйлийг толгойд хүндрэх.

61) Эрэгтэйчүүд торго өмсөх.

62) Харанхуй бүдүүлэгт зүтгэн зөрүүд байх/Эхл-и сүннет итгэл бишрэлийг фарз хараам хэрэгтэй бүхий л сургаал мэдлэгийг үл сурах/.

63) Аллаахаас мөн ислаамын ёсны заасан нэрээс өөр зүйл хэлж андгай тавих.

64) Шинжлэх ухаан эрдэм номоос зугатах.

65) Харанхуй байдлыг зовлон гуниг болохыг үл ойлгох.

66) Бага нүглийг дахин үйлдэхээр шургуу зүтгэх.

67) Шаардлагагүй байхад тас тас хөхрөх.

68) Нэг намаазын хугацааг өнгөрөөх, хугацааны хирд бохир /жүнүб/ хэсэх.

69) Сарын тэмдэг шалтгаантай үед эм лүгээ ойртох.

70) Ном судрыг аялан унших /Теганни/ Ёс суртахуунгүй дуу дуулах ая дан хөгжмийн зэмсэг хэрэглэх.

71) Амиа хорлох, өөрөөр хэлбэл өөрийгөө егүүтгэх.

• АРВАН ЗҮЙЛ СҮҮЛИЙН АМЬСГАЛД ИМААНГҮЙ ӨНГӨРӨХ ШАЛТГААН БОЛНО •

1) Аллаахын тушаал цээрийг мэдэж сурахгүй байх.

2) Итгэл сүсгээ Эхл-и сүннетийн итгэл бишрэлээс хамаарч цэгцлэн засахгүй байх.

3) Ертөнцийн эд хөрөнгө алба тушаал нэр алдарт шүлэнгэтэн дурлах.

4) Хүн амьтас болоод өөрийгоо тамлан харгислах.

5) Аллаах сайн сайхан ирэхийн шалтгаан бологчдод талархахгүй байх.

6) Имангүй болохоос үл айх үл гэлмэх.

7) Таван удаагийн намаазыг цаг хугцаанд нь эс үйлдэх.

8) Хүү оногдол ашиг авах өгөх.

9) Шашиндаа үнэч холбоотой мусылмаан нарыг дор өчүүхэн үзэх Эд нарыг хоцронгуй бурангуй гэх мэт зүйлс хэлэх.

10) Садар самуун үг, бичиг, зураг хөрөг хэлэх, бичих, зурах.

• ЭХЛ-И СҮННЕТ ИТГЭЛ БИШРЭЛД ХАМААТАХЫН ТУЛД ДООРХ ЗҮЙЛД АНХААРАХ ХЭРЭГТЭЙ •

1) Аллахын шинж тэмдгүүд гэж байдаг ба бод биеэс нь тусдаа юм.

2) Имаан нэмэгдэхгүй хорогдохгүй.

3) Их нүгэл үйлдсэнээр имаан холдохгүй.

4) Гайбд итгэн сүслэх нь бүхний үндэс суурь юм.

5) Имааны тухайд харьцуулалт гэж үгүй юм.

6) Аллаах Диваажинд харагдна.

7) Аллахд даатгах /Тевеккүл/ иманы шарт болзол юм.

8) Үйл үйлдэл /Ибадетүүд/ иманы хэсэг биш юм.

9) Хувь ерөөлд итгэн сүслэх нь имааны шарт болзол юм.

10) Үйл үйлдлийн дөрвөн мезхебийн аль нэгийг нь дагах нь шарт болзол юм.

11) Асхаб-и кирами ба эхл-и бейти /Гэгээн Мүхаммедийн гэр бүл ах дүү/ болоод Манай Пайгамбаар Элчийн эхнэрүүдийг бүгдийг нь хайрлах нь шарт юм.

12) Дөрвөн халифегийн дээд чанар нь хилафетийн дарааллаасаа хамаарна.

13) Намааз мацаг садака гэх мэт нафиле ибадетүүдийн буянг бусдад бэлэглэх шашнаар зөвшаөөрнө.

14) Мираж нь сүнс санаа ба бие махбод гэж хийгдсэн.

15) Ариун номчдын гайхамшиг нь үнэн болно.

16) Өмгөөлөл зуучлал үнэн болно.

17) Дан гуталтай илж арчих нь шашнаар зөвшөөрөгдсөн болно.

18) Булшны асуулт гэж байдаг.

19) Булшны зовлон сүнс санаа болоод бие махбодод болно.

20) Хүмүүс тэдний үйл хэргийг ч Аллах бүтээнэ. Хүмүүст хүсэл зоригийн хүч /ираде-и жүзиййе/ байдаг.

21) Хүнс тэжээл халаалаас ч болно, хараамаас ч болно.

22) Асрамжлагч нарын сүнс санаагаар хандаж тэдний төлөө Дуа уншлага хийнэ.

• МУУ ЗАН ААШ •

1) Күфр /Тэрслүү/.

2) Харанхуй бүдүүлэг байдал.

3) Буруушаагдахаас гэлмэн айх /Хүмүүсийн муулан хачлах муучлах зэмлэн гоочлоход гомдож үнэнийг хүлээн зөвшөөрөхгүй байх.

4) Магтаалд дурлах /Биеэ тоож магтаалд шимтэх/.

5) Шинээр эхлэх итгэл /Буруу итгэл сүсэг/.

6) Шунал сэтгэлд донслон автах /Уугуул хэрэгцээний хүсэлд амттан хуял тачаалд захирагдах/.

7) Дууриан дагах хийгээд итгэл сүсэг /Үл мэдэх хүнийг дууриах дагах/.

8) Засдаг зан /Үзүүлэх зан. Нөгөө ертөнцийн үйл үйлдлийг хийж энэ ертөнцийн хүсэл тачаалдаа хүрэх/.

9) Тул-и эмел /Хэт холын бодол/ Таашаал жаргалын төлөөнөө удаан амьдрахыг хүсэх/.

10) Харамч байх.

11) Биеэ тоох.

12) Өөрийгөө хэт дорд тавих /Хэтрүү даруу зан.

13) Ужүб /өөртөө хангалуун байх//Хийсэн сайн үйлийг ибадетээ таалах таашаах.

14) Атаа хорсол /Атаархах жөтөөрхөн хорсох нимет түүнээс гарахыг хүсэх.

15) Хыкд /Ихэрхэх//Бусдыг дорд өчүүхэнд үзэх.

16) Хэрүүл үймээн /Бусдад тохиолдох гай зовлонд баясан бахдах.

17) Хижр /Хүнийсэх//Нөхөрлөлийг гээх орхих гомдоллох.

18) Жүбн/Хулчийх/ /Айх хулчийх гэлмэх эрэмгий зориг байх.

19) Техеввүр /Гадаб хатуу чанар хэтэрхий бөгөөд хөнөөлтэй болох.

20) Гадр /Уур хилэн/ /Тангараг гэрээгээ үл биелүүлэх.

21) Хыйанет/Хуурч мэхлэх/ /Мунафик шинж энх тайвныг бусниах үг ба үйлдэл.

22) Амлалтыг бусниах /Амласан үгээ бусниах Хадис-и шерифт /Мунафик шинж тэмдэг нь гурав байна. Худал хэлэх амлалтаа биелүүлэхгүй байх итгэл даатгалд тэрслэх/ хэмээн зарлигласан бөлгөө.

23) Муу бодол нь хараам юм. Нүгэл нь өршөөгдөхгүй хэмээн бодох Аллахыг сүй зан болно. Мүмин нарыг хараам үйлдэгч өөрөөр хэлбэл нүгэлтэн гэж бодох нь муу бодол болно.

24) Эд хөрөнгөнд шунах /Эд таваарт хорхойтон донтох/

25) Тесвиф /Буянт үйлийг хийхээ хойшлуулах/ Хадис-и шерифт /Таван зүйл ирэхээс өмнө таван зүйлийн үнэ хүндийг ойлгогтун. Үхэхээс өмнө амьдралын үнэ цэнийг, өвдөхөөсөө өмнө эрүүл мэндийн үнэ цэнийг, энэ дэлхийд хойд ертөнцийг олж хожихын үнэ хүндийг, хөгшрөхөөсөө өмнө залуу насны, ядуурахаасаа өмнө баян чинээлгийн үнэ цэнийг ойлгогтун хэмээн зарлиглав.

26) Нүгэлтэн нарыг хайрлах /Хамгийн өөдгүй нүгэл фасык нь мөлжин дарлахуй юм. Хараам үйлдэгчийг фасик буюу нүгэлтэн гэнэ.

27) Номч мэргэдэд дайсагнах /Ислаамын эрдэмтэн мэргэдийг шоолон доромжлох нь кюфр юм/.

28) Фитне /Хүмүүсийг зовлон гамшигт унагаах. Хадис-и шерифт Фитне унтаж байхад сэрээсэн хүнийг хараал идэг/.

29) Мудахене ба мүдара /Чадал нь хүрэх мөртөө хараам үйлдэгчид саад тээг үл болох ертөнцийн төлөө шашнаа өгөх нь мудахене /долдой зан/ юм. Шашны төлөө дэлхийгээ өгөгчийг мудара /хуурамч засдаг зан/ гэнэ.

30) Зөрүүд зан ба мүкабере /Үнэн зөвийг сонсонгуутаа хүлээн зөвшөөрөхгүй байх/

31) Гаднах дотнох байдал зөрөх /Мунафик буюу хоёр нүүрлэх дотоод тал гадаад талтайгаа үл зохирох

32) Бодож бясалгахгүй байх /Нүглээ бүтээгдэгч нар болоод өөрийгөө бодож эргэцүлж чадахгүй байх/

33) Мусылманыг хараах.

34) Мусылманд муухай нэр хоч оноох.

35) Шалтагийг үгүйсгэх.

36) Кураан-и керимийг буруу тайлбарлах.

37) Хараам үйлдэх гэж зүтгэх шаргаах.

38) Далдуур хачлан ховлох Гайбет.

39) Үл наманчлах.

40) Эд хөрөнгө алба тушаалд шунах тачаах. “Муу зангаас зайлсхийж сайн аальтай болохыг хичээх хэрэгтэй” Хадис-и шериф номноо өгүүлрүүн : Ибадет бага хийх нэг зүтгэгч сайн зангаараа шүүгдэх өдөр дээд зиндаанд хүрнэ./ /Ибадетийн хамгийн хялбар хамгийн ач тустай нь бага ярьж ааш аяг сайтай байх явдал болно. /Өөрөөс нь холдогчдод ойртох тамлан мөлжигчдийг өршөөх өөрт нь юу ч үл өгөгчдөд хийх сайн үйл нь сайхан ааш болно/.

Есдүгээр бүлэг

• СҮРЕ БА ДУАГ •

Сүре ба дуаг латин үсгээр бичиж болох уу?

Сүре болон дуаг латин үсгээр бичих бидний оролдлого амжилт олоогүй билээ. Латин үсгээр ямар ч байдлаар тэмдэгт тавилаа гээд сүре дуаг зөв уншиж чадах боломжгүй. Эдгээрийг Кураан-и керим дэх үсэг лүгээ адилаар уншиж чадахын тулд мэдэх хүнээр уншуулж дахин дахин дасгах хэрэгтэй. Энэхүү дасгал заавал хэрэгтэй тул мэдэх хүнд шууд Кураан-и керимийн үсгүүдийг таниуилж заах дээд боломжийг олгоно. Энэхүү агуу их буян нь энэ ертөнц болон нөгөө ертөнцөд ирэх ач тусыг хадис-и шерифүүд ба фыкх ном судруудад удаанаар өгүүлэх ба буян их гэдгийг зааж байна.

Тиймээс мусылмаан бүр үр хүүхдээ жами руу Кураан-и керимийн дамжаанд илгээж Кураан-и керимийн үсгүүдийг эдгээрийн хэрхэн уншихыг сайтар зааж энэхүү агуу буянд хүрэхээр чармайх хэрэгтэй. Манай Пайгамбаар саллаллахү алейхи ве селлем айлдаруун: / Та нар бүгдээрээ сүрэг хариулагч мэт. Малчин хүн мал сүргээ хамгаалдаг лугаа адил та нар ч гэсэн гэртээ өөрийнхөө тушаал дор буй бүхнийг Тамаас хамгаалах хэрэгтэй. Тэд нарт Мусылмааны ёсыг заах хэрэгтэй. Зааж сургахгүй бол бурууг нь үүрнэ хэмээв. Бас нэг удаа зарлиг болруун: /Олон мусылманы үр сад эцгээсээ болоод Вейл нэрт Там руу явна. Яагаад гэвэл эдгээрийг эцэг нь зөвхөн мөнгө хожиж тух таваараа байх шуналд унаж зөвхөн энэ ертөнцийн үйл хэргийн хойноос хөөцөлдөж үр хүүхэддээ мусылмааны шажин суртахуун Кураан-и керимийг заагаагүй юм. Би иймэрхүү эцгүүдээс хол хөндий байдаг. Тэд нар ч надаас алс зайдуу бөлгөө. Үр хүүхэддээ шажин номоо заагаагүй хүмүүс тамд орно хэмээв. Мөн айлдаруун: /Үр хүүхэддээ Кураан-и

керим

заагч Кураан-и керимийн багш нарт, илгээгч нарт зааж сургасан Кураан-и керимийн үсэг бүрийн төлөөнөө арван удаа агуу их Кабег айлчлах буян оногдох ба шүүгдэх өдөр толгойнд нь төрийн титэм өмсгөнө. Бүх хүн харж атаархна./ Түүнчлэн айлдал болруун: Нэг мусылман хүний үр хүүхэд ибадет хийхэд хураасан буяны хэмжээ эцэгт нь ч оногдно. Хэн нэгэн хүүхэддээ нүгэл сургавал энэ хүүхэд хэдий хэр нүгэл үйлдэнэ аавд нь төдий хэр нүгэл оногдно хэмээв.

Кураан-и керимийг уншихад арван зүй ёс хэрэгтэй:

1) Абдест авч кыблегийн эсрэг талд хүндлэн унших.

2) Удаанаар утгыг нь бодож унших хэрэгтэй. Утгыг нь үл мэдэгч гэсэн удаан аажим унших хэрэгттэй.

3) Уйлж охилж унших хэрэгтэй.

4) Аят бүрийг зөв гэж үзэж өөрөөр хэлбэл зовлонгийн аятыг уншихдаа айн гэлмэж өршөөлийн тухай аятуудыг хүсч мөрөөдөж алдаагүй, төгсийн тухай аятуудыг тесбих хийж унших хэрэгтэй. Кураан-и керим уншиж эхлэхдээ Эзү ба Бесмеле унших хэрэгтэй.

5) Өөрт нь рийа өөрөөр хэлбэл үзүүлэлт сэргэвэл эсхүл намаазыг үйлдэгчид саад болох бол удаан хоолойгоор унших хэрэгтэй. Хафиз уншигч нар мүсхаф/номын хуйлмал/ ыг хараад унших нь цээжээр уншихаас илүү их буян болно. Яагаад гэвэл, нүд ч гэсэн ибадет үйлдэх болно.

6) Кураан-и керимийг сайхан дуугаар унших дүрмээр унших хэрэгтэй. Үсэг ба үгийг эвдэж аялж дуулах нь хараам юм. Үсгүүд хэлбэрээ алдахгүй бол мекрүх болно.

7) Кураан-и керим Аллаахын үг хэл бөгөөд түүний шинж тэмдэг эхлэлгүй нь юм. Амнаас гарах үсэг гал хэмээхтэй адил. Гал гэх амархан. Гэхдээ галд хэн ч тэсч үл чадна. Энэхүү үсгүүдийн утга ч ийм юм. Энэхүү үсгүүд бусад үсэгтэй адил бус. Энэхүү үсгүүдийн утга илрэн гарвал долоон давхар газар долоон давхар тэнгэр тэсч үл чадна. Аллаахү теаля өөрийн үгийнхээ агуу ихийг гоо сайхныг энэхүү үсгийн дотор хадгалж хүмүүст илгээсэн бөлгөө.

8) Кураан-и керимийг уншихын өмнө үүнийг хэлсэн Аллаахын агуу ихийг бодох хэрэгтэй. Кураан-и керимд хүрэхэд цэвэр гар хэрэгтэй болдог адил түүнийг уншихад цэвэр зүрх хэрэгтэй. Аллаахын агуу ихийг ойлгохын тулд Түүний шинж чанаруудыг бүтээснийг нь бодох хэрэгтэй. Бүхий л бүтээгдэгчийн эзэн өмчлөгч болох нэг мөн чанарын үг хэлмэр болохыг бодож унших хэрэгтэй.

9) Уншихдаа өөр зүйлийг бодохгүй байх хэрэгтэй. Хэн нэгэн нэг цэцэрлэгт явж байхдааа үзэж харсныгаа бодохгүй бол тэрхүү цэцэрлэгт зугаалсан болохгүй. Кураан-и керим ч гэсэн мүминчүүдийн зүрх сэтгэл зугаалах газар юм. Түүнийг уншизгч түүндэх хачирхалтай болоод мэргэн цэцнийг ч бодох хэрэгтэй.

10) Үг бүрийг уншихдаа утгыг нь бодож ойлгох хүртлээ дахин давтах хэрэгтэй.

Намаазын үеийн дуаны агуулга:

• СУБХАНЭКЭ •

Аяа Аллаах минь Чамайг бүхий л алдаа дутагдлаас цэвэрлэнэ. Бүхийд төгс төгөлдөр шинж чанараар бүртгэнэ, тодорхойлно. Чамд талархна. Чиний нэр алдар үлэмж дээд бөлгөө. /Мөн чиний алдар цуу бүгдийн дээр юм. Чамаас өөр Эрхэт тэнгэр байхгүй билээ.

• ЭТТЭХИЙАТҮ •

Бүх төрлийн хүндлэл Тэнгэр эзний залбирал бүхий л сайн сайхан Аллаахд хамаатай Аяа Неби Аллаахын буян энх тайван нигүүлсэл элбэг дэлбэг байдал чамд ногдог. Аллаах цор ганц гэдгийг гэрчилнэ би, Мүхаммед алейхисселам Түүний боол бөгөөд элч нь гэдгийг гэрчилнэ би .

• АЛЛАХҮМЕ САЛЛИ •

Аяа Аллаах минь Ибрахим алейхиссеам ба гэр бүлийг нь өршөөн нигүүлсэнтэй алдилаар Бидний Хүндэт Мүхаммед Алейхисселам ба гэр бүлийг нь энэрэн нигүүлсэгтүн. Гарцаагүй чи магтагдан алдаршигч бөлгөө

• АЛЛААХҮМЕ БАРИК •

Аяа Аллаах минь Ибрахим алейхиссеам ба гэр бүлд нь элбэг буян хишиг соёрхсоны адилаар Бидний Хүндэт Мүхаммед Алейхисселам ба гэр бүлд нь элбэг буян хишиг соёрхогтун. Гарцаагүй чи магтагдан алдаршигч бөлгөө.

• РАББЕНА АТИНА •

Аяа Эзэн Тэнгэр минь Энэ ертөнц болон нөгөө ертөнцөд бидэнд ач буян өг, бид нарыг галын зовлонгоос өмгөөл. Аяа нигүүлсэгчдийн оройн дээд нигүүлсэгч чиний өршөөл энэрлээр...

• КУНУТ ДУА •

Аяа Аллаах минь Бид чамаас тусламж хүснэ. Чамаас өршөөл эрнэ. Чамаас буян номын зам хүснэ. Чамд имаан хийнэ. Чамд наманчлан, чамд даатган найдна. Бүхий л буянаар чамайг магтна бид. Чиний буян хишгэнд чинь талархан эсэргүү тэрслүүг үл хийнэ бид. Чамд тэрслэгчдийг хаяж орхино бид.

Аяа Аллаах минь Зөвхөн чамд ибадет хийж намазз үйлдэж чамд гүйж хоргодно. Өршөөл нигүүлслийг тань найдан итгэж урин, хилэнгээс чинь аюун гэлмэнэ. Яагаад гэвэл чиний хилэгнэл үнэнийг халхлах кафир нарт заавал хүрнэ.

• НЭР ТОМЬЁОНЫ ТОЛЬ •

Абдест-хэсэгчилсэн угаал.
Аллахо азим уш шан- Агуу их алдар цуут Аллах.
Аллахю теаля- Их Эрхт Тэнгэр, Эзэн Тэнгэр.
Важиб- зайлшгүй үүрэг.
Гүсул -бүрэн угаал.
Жайз- шашинд тохирсон.
Ибадет- мөргөх залбирах.
Иман- итгэл сүсэг.
Истигфар- өршөөл хүсэх.
Итикат- итгэл бишрэл.
Каза -намаз орлох нөхөх намаз.
Келиме-и шехадет -гэрчлэл үг.
Кефарет -цагаатгал төлөөс.
Күран-и азым уш-шан- Агуу их алдар цуут Кураан.
Кыйам- зогсоо намаз.
Кыйамет – шүүгдэх өдөр.
Мекрүх- таагүй.
Мезхеб –дэг сургууль.
Мубах- зөвшөөрөгдсөн.
Мукеллеф – үүрэгт.
Мустехаб - сайшаагдсан дэмжигдсэн.
Муртед- шашнаас тэрслэгч.
Муфсид- шашинд хуульчилсныг зөрчих юмс хийгээд үйлдэл.
Нафиле- нэмэлт намаз.
Нийет- зорин хүсэх.
Пайгамбаар Аллаахын элч
Руку –бөхийж мөргөх.
Салл Аллах ве селлем- Түүнийг мэндчилэн хүндэтгэе.
Сежде- Газар мөргөх.
Сүхуб- номын хуйлмал.
Сүннет – домог хуучд тохирох, уламжлалт дүрэм журам.
Суннет-и муэккеде- давтахдага дууриах зан заншил.
Тахримен мекрүх- хэрэгтэйг үлдээх.
Теганни- Ариун судрыг уншихдаа аялан уянгалуулах.
Тееммүм – усгүй газарт хийх цэвэрлэгээ.

Теждид-и иман -итгэл сүсгээ шинэчлэх.
Тензихен мекрүх- хүлцэн уучилсан.
Тевеккүл- Аллахд даатгах.
Тешеххүд-сууж мөргөх намаз.
Тилавет- Күран-и керимийн эх бичвэрийг унших.
Үшр-эд хөрөнгө ургацын татвар.
Фарз- гарцаагүй үүрэг.
Хадис-и шериф –Мухаммедийн ариун сургаал үгс.
Хаж –Мекке дэхь каб руу аялах.
Халаал –ариун.
Хараам - цээр.
Эдэб -ёс зүй, журам дүрэм.